

Улсын бүртгэлийн  
дугаар .....

Аравтын бүрэн  
Ангиллын код

Нууцын зэрэглэл:  
Б

Улсын захиалгат төсөл  
Гэрээний дугаар : Шу Уз 2020/08

**БАТЛАН ХАМГААЛАХЫН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

**“ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ, ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ  
СЭРГЭЭН ТОДОРХОЙЛОХ ЗАМААР ҮНДЭСНИЙ  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”**

Захиалгат төслийн тайлан  
2020-2022

**Төслийн удирдагч:** Ч.Сосорбарам- доктор (Ph.D), дэд профессор

**Санхүүжүүлэгч байгууллага:** БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн сан

**Захиалагч байгууллага:** БХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл  
БШУЯ-ны ШУТБИХХЗГ

**Тайлан өмчлөгч:** Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний  
хүрээлэн. 13300 Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-  
р хороо, Нянтайсүрэнгийн гудамж, Улаанхуаран.  
Утас: 453942, Факс-70150173, Цахим хаяг:  
<http://www.mids.gov.mn>; [mids@mndu.gov.mn](mailto:mids@mndu.gov.mn)

Улаанбаатар хот  
2023

Улсын бүртгэлийн  
дугаар .....

Нууцын зэрэглэл:  
Б

Аравтын бүрэн  
Ангиллын код

Улсын захиалгат төсөл  
Гэрээний дугаар : Шу Уз 2020/08

**БАТЛАН ХАМГААЛАХЫН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

**“ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ, ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ  
СЭРГЭЭН ТОДОРХОЙЛОХ ЗАМААР ҮНДЭСНИЙ  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”**

Захиалгат төслийн тайлан  
2020-2022

<b>Төслийн удирдагч:</b>	Ч.Сосорбарам- доктор (Ph.D), дэд профессор 2023 оны ..... р сарын .....-ны өдөр
<b>Төслийн зөвлөх:</b>	Б.Даш-Ёндон–Философийн хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор
<b>Төслийн гүйцэтгэгч:</b>	Ж.Болдбаатар–Түүх Угсаатны Зүйн хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, академич, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Н.Жалбажав–Шихихутаг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн захирал, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор (Ph.D), профессор С.Янжинсүрэн - Ерөнхийлөгчийн Тамгын газрын Бичиг баримт, хяналт шинжилгээний газрын дарга, доктор (Ph.D), профессор С.Цэдэндамба–Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D), профессор Б.Хэрлэн-Удирдлагын академийн багш, доктор (Ph.D), дэд профессор Х.Орхончимэг-БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), дэд профессор Д.Идэшноров-ҮБХИС-ийн сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D) С.Байгалмаа-ҮБХИС-ийн НХТ-ийн багш, магистр Ж.Батдолгор-ҮБХИС-ийн НХТ-ийн багш, магистр Я.Энхцэцэг-ҮБХИС-ийн НХТ-ийн багш, магистр Н.Оюундэлгэр-ҮБХИС-ийн НХТ-ийн багш, магистр
<b>Санхүүжүүлэгч байгууллага:</b>	БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн сан
<b>Захиалагч байгууллага:</b>	БХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл БШУЯ-ны ШУТБИХХЗГ
<b>Тайлан өмчлөгч:</b>	Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн. 13300 Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-р хороо, Нянтайсүрэнгийн гудамж, Улаанхуаран. Утас: 453942, Факс-70150173, Цахим хаяг: <a href="http://www.mids.gov.mn">http://www.mids.gov.mn</a> ; <a href="mailto:mids@mndu.gov.mn">mids@mndu.gov.mn</a>

Улаанбаатар хот  
2023

## ГАРЧИГ

<b>УДИРТГАЛ</b> .....	4
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ, ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ТАЛААРХ ОНОЛЫН АСУУДАЛД</b> .....	8
1.1 Үндэсний ой санамжийн тухай үндсэн ойлголт, мөн чанар .....	9
1.2 Үндэсний ой санамж онол, арга зүйн зарим үндэслэл .....	17
1.3 Үнэт зүйлс, нөлөөлөгч хүчин зүйлс .....	34
Бүлгийн дүгнэлт .....	50
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ТӨРТ ЁС БА МОНГОЛЧУУДЫН ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ, ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ</b> .....	55
2.1 Дэлхийн улс орнуудын төрт ёс ба ой санамж .....	55
2.2 Монголын түүхэн үеүд дэх үндэсний ой санамж .....	64
2.3 Монгол төрийн бодлого, төрийн албаны үнэт зүйлсийн уламжлал .....	80
Бүлгийн дүгнэлт .....	103
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛЧУУДЫН ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ, ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ</b> .....	104
3.1 Монголчуудын үндэсний ой санамж, үнэт зүйлсийн төлөв байдлын шинжилгээ .....	104
3.2 Үндэсний ой санамж ба үндэсний аюулгүй байдал .....	112
3.3 Даяаршил, үндэсний аюулгүй байдал түүний оюуны дархлаа .....	137
Бүлгийн дүгнэлт .....	151
<b>ДҮГНЭЛТ</b> .....	153
<b>САНАЛ, ЗӨВЛӨМЖ</b> .....	156
<b>ЭШЛЭЛ АВСАН ЭХ СУРВАЛЖ, НОМ ЗҮЙ</b> .....	164

## УДИРТГАЛ

Монголчууд ардчилсан шинэчлэлийн үед монголын төр, ард түмэн шинэ үндсэн хуулиа боловсруулан баталж, хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулах үйлсийг эхлүүлээд даруй 30 жил болсон. Өнгөрсөн гучин жилд хүний эрх чөлөөг тунхагласан Монгол Улсад бүтээж, хөгжүүлсэн нь ч бий алдсан, засах залруулах зүйл ч олон байна. Монгол төр бүрэн эрхээ хэнээс ч хамаарахгүй өөрөө эдлэх болсон хэдий ч түүний бодлого, үйл ажиллагаа нь олон зууны гайхамшигтай түүхтэй төрийн уламжлалаас суралцахгүй, бусдыг даган, шинэ юм болгоныг дуурайдаг байдлаар үргэлжилж байна хэмээн судлаачид дүгнэх болсон. Бидэнд үндэсний ой санамж, үнэт зүйл хэмээх ухагдахууныг тодорхойлох хэрэгцээ шаардлага тулгарч байна. Судлаачид бид Чингис хааныхаа билиг сургаалаас суралцах чармайлтаа үндэсний ой санамжаараа дамжуулан өөрийгөө таньж мэдэж, ухамсарлах гэсэн оролдлоготой хамтруулж, үнэт зүйлсээ тодруулан, түүгээрээ олон нийтээ нэгтгэн удирдаж, нэгэн зорилгын доор улс орныхоо хөгжлийг цэгцлэх үйл хэрэгт тус нэмэр болох гэсэн зорилгыг тавилаа.

**Сэдвийн үндэслэл:** 1990 онд монголчуудад өөрийн түүх, үзэл бодол оюун санаагаа цэгцлэх, өөрийнхөөрөө бодож тунгаах, ирээдүйгээ төсөөлөх боломж, таатай нөхцөл бий болсон. Интернационалч, эв хамтын үзэлтэй гаднын улс төр, эдийн засгийн нөлөөнд байсан монголчууд хуучин үзэл суртлаа хурдан таягдан хаясан хэдий ч тэрхүү цаг үеийг ашиглан өөрийн толгойгоор бодож, хийх зүйлээ амжиж ухааралгүй дахиад л тухайн үед дэлхий дахины шилдэг гэх шинэ суртлыг шууд хүлээн авч иргэний ардчилсан нийгэм байгуулахаар 30 жил оролдлоо. Байгалийн баялгаа зарж, байгаль орчноо сүйтгэн байж дотоодын нийт бүтэгдэхүүнээ өсгөж, төсөв хөрөнгөө нэмэгдүүлсэн хэдий ч баян ядуугийн ялгаа ихэсч, дунд давхарга өсөж хөгжсөнгүй, ардчиллын амин чухал сүнс хуулийг дээдлэх биелүүлэх үйл ажиллагаа нийгэмд бий болоогүй хэвээр байна. Өнөөдөр олон нийт бүх юм санаснаар болоогүйг ухаарч, аливааг шүүмжилж, алдаа дутагдлаа өөрөөсөө биш төр, засгаасаа эрсэн орчин бий болж, нийгмийн тогтвортой байдал алдагдах дотоод, гадаадаас ч өндөр болж байгаа нь иргэд, олон нийт өөрийгөө шинэ орчинд таньж мэдээгүй буюу товчхондоо “өөрийгөө ухамсарлаагүйтэй” шууд холбоотой.

Өнөөдөр бидэнд үндэсний ой санамж, үнэт зүйлсийн төлөвшлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээний үндсийг тодорхойлох шаардлага тавигдаж байна.

**Сэдвийн судлагдсан байдал:** “Үндэсний ой санамж”-ийн талаар тухайлан судалгаа явуулсан байдал одоогоор дутмаг байна. Тус төслийн ажлын хүрээнд Б.Даш-Ёндон, Н.Жалбажав нар “Үндэсний ой санамж”-ийн утга учир, нийгмийн оюун санааны амьдралд эзлэх байр суурь, үүрэг ач холбогдолыг харьцуулан судалж, философийн талаас бичсэн бол, академич Ж.Болдбаатар түүхэн үеүд дэх үндэсний ой санамж”-ийн асуудал, доктор С.Янжинсүрэн “Дэлхийн улс орнуудын төрт ёс ба ой санамж” доктор Ч.Сосорбарам “Үндэсний ой санамж ба үндэсний аюулгүй байдал”, Н.Жалбажав “Даяаршил, үндэсний аюулгүй байдал түүний оюуны дархлаа талаас нь судалгааны өгүүлэлүүд бичсэн.

Монгол Улсад 1990 оноос хойш ялангуяа шинэ мянганы эхээр үнэт зүйлсийн талаар судалдаг байгууллага, судлаачид цөөнгүй бий болжээ. ШУА-ийн Философийн

хүрээлэн, Удирдлагын академи, МУИС, СУИС, Стратеги судалгааны хүрээлэн дээр эрдэмтэд, судлаачид энэ чиглэлээр ажиллах болсон байна.

Энэ талаарх философичдын судалгаа Ц.Цэцэнбилэгийн 1998 онд хамгаалсан “Монголын залуусын уламжлалт ба орчин үеийн үнэлэмжүүд”, Ц.Баатартогтохын 2000 онд хамгаалсан “Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал” хэмээх диссертациуд бий. Энэ онолыг доктор Ц.Гомбосүрэн философийн сурах бичгүүдэд оруулсан бол Г.Чулуунбаатар, Д.Мандах зэрэг зохиогчид уг асуудлыг зохиол бүтээлдээ хөнддөг.

Нийгмийн философийн чиглэлд Д.Даш-Ёндон өөрийн бүтээлүүдээ нэгд, Сэтгэлгээний өөрчлөлт, хоёрд, Сэтгэн бодох, танин мэдэх болон нийгмийн үнэ цэний тухай, гуравд, Үндэсний өөрийгөө ухамсарлахуйн тухай, дөрөвд, Монголын хөгжлийн философийн үндэслэлүүд асуудлуудыг дэвшүүлжээ.

Ц.Гомбосүрэн философи, нийгэм, нийгмийн философийн тухай интеграл ойлголтын талаар судалжээ. Г.Чулуунбаатар, С.Цэдэндамба, Б.Энхбайгаль нар тогтвортой хөгжил, урт хугацааны хөгжлийн асуудлуудаар санал, санаа дэвшүүлж байсан бол соёлын философийн талаар Ш.Ганхуяг, Ү.Нямдорж, Т.Дорждагва, Ж.Төмөрбаатар зэрэг судлаачдын бүтээлүүд хэвлэгджээ. Ц.Ганболд “Ардын уламжлал ба эх оронч үзэл”, Ц.Бүжидмаа, Д.Ванчигсүрэн, В.Энхболд, сүүлийн үед С.Даваадулам, О.Нэмэхханд, Т.Нэмэхжаргал, Б.Галиндэв<sup>1</sup> зэрэг судлаачид боловсролын философи, эх оронч үзэл, шашны ухамсрын талаар судалгаа хийж байна. 1990-ээд оноос хойших нийгмийн амьдралын өөрчлөлтийг даган бидний үнэт зүйл, үнэлэмжийг янз бүрийн сэдэв бүхий социологийн судалгаануудад тодорхой хэмжээгээр туссаар ирсэн. Үүнд:

ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн 1999, 2013 онд хийсэн судалгаа<sup>2</sup>, 2015 онд СЭЗДС-ийн багш судлаачид “Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгаа”<sup>3</sup>, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Социологи, нийгмийн ажлын тэнхим, Антропологи, археологи, Улс төр судлал, Шашин судлал, Боловсрол, Сэтгэл судлалын тэнхимүүд хамтран 2015 онд судалгаа хийжээ.

2017 онд Удирдлагын академийн Б.Хэрлэн нарын багш, судлаачид “Монголчуудын үнэт зүйлсийг Шварцын аргачлалаар тодорхойлох нь”<sup>4</sup> сэдэвт судалгааны ажилдаа 56 үнэт зүйлийг 10 бүлэгт нэгтгэсэн Шварцын аргачлалыг ашиглажээ.

2019 онд СУИС-ийн багш судлаачид (Ч.Алтанцэцэг, Р.Дарьхүү, Ж.Долгорсүрэн, Г.Чулуунбаатар, А.Цанжид, М.Золзаяа) “Монголчуудын үнэт зүйл”<sup>5</sup> хэмээх үнэт зүйлсийн үндэсний өв, соёл, уламжлалын талыг нь онцолсон томоохон судалгааны ажил гүйцэтгэсэн байна.

Тус төслийн хүрээнд бид үндэсний ой санамж, үнэт зүйлс, үндэсний аюулгүй байдлын уялдаа холбоо, бэхжүүлэх арга замын талаарх олон нийтийн үнэлэмжийг

<sup>1</sup> Б.Галиндэв “Монголын нийгмийн өөрчлөлтийн үе дэх дэх ёс суртахууны асуудлууд” диссертаци. УБ., 2010 он

<sup>2</sup> Г.Чулуунбаатар., Д.Даш-Ёндон “Монголын нийгмийн өөрчлөлт” ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ., 2013.т.1

<sup>3</sup> “Монголчуудын үндэсний үнэт зүйл” судалгааны тайлан. СИУС. УБ., 2015.т.2

<sup>4</sup> Б.Хэрлэн. Төрийн албаны үнэт зүйлс: тулгамдаж буй асуудлууд.УБ.,2018.т.1-86

<sup>5</sup> “Монголчуудын үнэт зүйл” СУИС-ийн судалгааны тайлан. УБ., 2019.т.14

тодорхойлох зорилгоор 2022 онд Улаанбаатар хот, 21 аймгийн иргэд, нийгмийн төлөөлөл болсон 18 хүнээс социологийн судалгаат авч тайлан<sup>6</sup> бичсэн.

**Судалгааны ажлын зорилго:** Улс, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын оюуны дархлааг бүрдүүлэгч чухал хүчин зүйлийн нэгэн болох үндэсний ой санамж, үнэт зүйлсийн мөн чанарын онолын асуудлыг тодорхойлох, төрт ёс ба монголчуудын үндэсний ой санамжийн түүхэн уламжлалыг судлах, монголчуудын үндэсний ой санамж, үнэт зүйлсийн өнөөгийн байдалд шинжилгээ хийж цаашид үндэсний ой санамж, үнэт зүйлсийг тодорхойлж, үндэсний аюулгүй байдлын бэхжүүлэх асуудлыг судлахад оршино.

**Судалгааны ажлын зорилт:**

1. Үндэсний ой санамжийн үндсэн ойлголт, онолын үндэслэлийг гаргах;
2. Гадаадын зарим орнууд болон Монгол үндэсний ой санамжийн түүхэн уламжлалыг судлах;
3. Монгол төрийн бодлого, төрийн албаны үнэт зүйлсийн уламжлалыг судлах;
4. Монголчуудын үндэсний ой санамж, үнэт зүйлсийн төлөв байдлын шинжилгээ хийх;
5. Үндэсний ой санамж, үнэт зүйлсийг тодорхойлж, үндэсний аюулгүй байдлын бэхжүүлэх асуудлыг тодорхойлох;

**Судалгааны объект:** Үндэсний ой санамж, үнэт зүйлс

**Судлах зүйл:** Үндэсний ой санамж, үнэт зүйлсийг сэргээн тодорхойлох замаар Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх асуудал

**Судалгааны ажлын шинэлэг тал:** Үндэсний ой санамжаар дамжуулан өөрсдийгөө ухамсарлах буюу үндэстнээрээ оюун санааны дархлаагаа бататгах, үндэсний үнэт зүйлсийг сэргээн тодорхойлох замаар үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх асуудлыг тодорхойлох оролдлого хийсэн нь судалгааны ажлын шинэлэг тал гэж үзэж байна.

**Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол:** Судалгааны ажлын үр дүн нь Үндэсний ой санамж, үнэт зүйлсийн талаарх судалгаануудыг нэгтгэн шинжлэх ухаан судалгаа, төр захиргааны бүх шатны байгууллагууд, ялангуяа батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд баримтлах онол, арга зүйн үнэ цэнэтэй судалгааны материал болно гэж үзэж байна. Мөн Монгол Улсын бүх иргэдэд үндэсний ой санамж, үнэт зүйлсийн талаарх судалгааны санал, зөвлөмж боловсруулсанд тус судалгааны ажлын ач холбогдол оршино.

**Судалгааны ажлын агуулга:**

1. Үндэсний ой санамж, үнэт зүйлсийн онолын асуудалд
2. Төрт ёс ба үндэсний ой санамжийн түүхэн уламжлал
3. Монголчуудын үндэсний ой санамж, үнэт зүйлсийн өнөөгийн байдал ба үндэсний аюулгүй байдал гэсэн үндсэн 3 бүлэг, 9 дэд бүлэгтэй, ашигласан бүтээлийн ном зүй гэсэн хэсгүүдтэй хийж гүйцэтгэв.

**Судалгааны ажлаас гарсан үр дүн:**

---

<sup>6</sup> Монголчуудын ой санамж, үнэт зүйлсийн төлөв байдлын шинжилгээ.БХЭШХ социологийн судалгааны тайлан.УБ.,2022

Судалгааны ажлын багийг эрдмийн зэрэг, цолтой мэргэшсэн судлаач, эрдэмтдээр бүрдүүлж, төслийн хүрээнд дараах 7 чиглэлээр судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

*1. Судалгааны ажлын ерөнхий арга зүй аргачлал*

Судалгааны ажлын бүтцийн ерөнхий төлөвлөгөө, арга зүйн удирдамжаа БХЭШХ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар 2020 оны 6 дугаар сард оруулж батлуулсан.

*2. Эрдэм шинжилгээний хуралд илтгэл өгүүлэл хэлэлцүүлсэн, хэвлүүлсэн байдал:*

2020 онд Б.Даш-Ёндон. Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэдийн ухамсарлалын үүрэг.<sup>7</sup> Н.Жалбажав. Үндэсний эв нэгдлийг хангах, эе эвээ хичээх сэтгэлгээг төлөвшүүлэх арга зүйн үндэс, Ч.Сосорбарам Үндэсний үнэт зүйл, ой санамжийг сэргээх нь эх оронч үндэсний үзлийг дээдлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үндсэн зарчим.<sup>8</sup> өгүүлэлүүдийг бичиж хэвлүүлсэн. 2021 онд Б.Даш-Ёндон “Үндэсний ой санамж”<sup>9</sup>, Ж.Болдбаатар “Дундад эртний болон дундад зууны үеийн үндэсний ой санамж”<sup>10</sup>, Н.Жалбажав “Цэргийн байгуулалт ба үндэсний ой санамж”<sup>11</sup>, Ч.Сосорбарам, С.Цэдэндамба “Монголын төрийн албаны сургалтын уламжлал”<sup>12</sup>, Х.Орхончимэг “ Үндэсний ой санамж ба батлан хамгаалах боловсрол”<sup>13</sup> Н.Жалбажав, С.Байгалмаа “Төрийн хууль цааз ба үндэсний ой санамж”<sup>14</sup>, Ч.Сосорбарам, Н.Оюундэлгэр “Үндэсний ой санамжийг хадгалж өвлүүлж ирсэн өмнөх түүх уламжлал”<sup>15</sup> өгүүлэл ҮБХИС-ийн “Цац” сэтгүүл 2021 №20/43/.ISSN2313-8076.т.106-111, Ч.Сосорбарам, Н.Жалбажав “Үндэсний ой санамж ба монголын хууль, эрх зүйн уламжлал”<sup>16</sup> өгүүлэлүүд, 2022 онд Ч.Сосорбарам “Үндэсний ой санамж ба Үндэсний аюулгүй байдал”<sup>17</sup>, Н.Жалбажав, Ж.Батдолгор “Даяаршил ба Үндэсний аюулгүй байдлын оюуны дархлаа”<sup>18</sup>, С.Цэдэндамба “Монгол төрийн албан хаагчдын эрхэмлэл: уламжлал, шинэчлэлийн

<sup>7</sup> Б.Даш-Ёндон. Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэдийн ухамсарлалын үүрэг. Хүн амын оюуны дархлааны асуудал. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. МЦНХ. УБ.,2020.т.5

<sup>8</sup> Ч.Сосорбарам Үндэсний үнэт зүйл, ой санамжийг сэргээх нь эх оронч үндэсний үзлийг дээдлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үндсэн зарчим. Хүн амын оюуны дархлааны асуудал Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. МЦНХ. УБ.,2020.т.40-48

<sup>9</sup> Б.Даш-Ёндон .Үндэсний ой санамж.Үндэсний ой санамжийг сэргээн тодорхойлох нь сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл. УБ.,2021.т.4-15

<sup>10</sup> Ж.Болдбаатар.Дундад эртний болон дундад зууны үеийн үндэсний ой санамж. Үндэсний ой санамжийг сэргээн тодорхойлох нь сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл.УБ.,2021.т.16-29

<sup>11</sup> Н.Жалбажав.Цэргийн байгуулалт ба үндэсний ой санамж. Үндэсний ой санамжийг сэргээн тодорхойлох нь сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл .УБ.,2021.т.30-36

<sup>12</sup> Ч.Сосорбарам, С.Цэдэндамба.Монголын төрийн албаны сургалтын уламжлал. Үндэсний ой санамжийг сэргээн тодорхойлох нь сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл. УБ.,2021.т.37-43

<sup>13</sup> Х.Орхончимэг. Үндэсний ой санамж ба батлан хамгаалах боловсрол. Үндэсний ой санамжийг сэргээн тодорхойлох нь.УБ.,2021.т.44-51

<sup>14</sup> Н.Жалбажав, С.Байгалмаа “Төрийн хууль цааз ба үндэсний ой санамж”. ҮБХИС-ийн “Цац” сэтгүүл 2021 №20 /43/.ISSN2313-8076.т.89-93

<sup>15</sup> Ч.Сосорбарам, Н.Оюундэлгэр “Үндэсний ой санамжийг хадгалж өвлүүлж ирсэн өмнөх түүх уламжлал” ҮБХИС-ийн “Цац” сэтгүүл 2021 №20 /43/.ISSN2313-8076.т.106-111

<sup>16</sup> Ч.Сосорбарам, Н.Жалбажав, “Үндэсний ой санамж ба монголын хууль, эрх зүйн уламжлал” илтгэл. Монгол улсын Их Хурлын Тамгын газар, Шихихутаг Их сургууль. Эрх зүйн шинэтгэл ба Монгол улсын хөгжил сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.,2021.т.118- 133

<sup>17</sup> Ч.Сосорбарам“Үндэсний ой санамж ба Үндэсний аюулгүй байдал”. “Үндэсний ой санамж ба Үндэсний аюулгүй байдал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.УБ.,2022.т.

<sup>18</sup> Н.Жалбажав, Ж.Батдолгор. Даяаршил ба Үндэсний аюулгүй байдлын оюуны дархлаа. “Үндэсний ой санамж ба Үндэсний аюулгүй байдал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.УБ.,2022.т.

асуудалд”<sup>19</sup>, Х.Орхончимэг, Б.Байгалмаа, Я.Энхцэцэг, Н.Оюундэлгэр. “Монголчуудын үндэсний ой санамж, үнэт зүйлсийн төлөв байдлын шинжилгээ”<sup>20</sup> илтгэлүүдийг хэлэлцүүлсэн.

### *3. Эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг, хурал зохион байгуулсан байдал:*

#### *Хэлэлцүүлэг*

-2021 оны 12 сарын 03-нд ҮБХИС-ийн “Сүбэйдэй” хурлын танхимд “Үндэсний ой санамжийг сэргээн тодорхойлох нь” сэдэвт хэлэлцүүлгийг Түүх, Археологийн хүрээлэнгийн тэргүүлэх эрдэмтэн Ж.Болдбаатар, Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба, Философийн хүрээлэнгийн судлаачид, БХЭШХ-ийн судлаачид, ҮБХИС-ийн Нийгэм Хүмүүнлэгийн тэнхимийн багш нар хамтран зохион байгуулсан.

-2022 оны 5 сарын 19-нд ҮБХИС-ийн БХЭШХ-ийн Их эе хурлын танхимд Ерөнхийлөгчийн тамгийн газрын дэд дарга С.Янжинсүрэн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба, Философийн хүрээлэнгийн тэргүүлэх эрдэмтэн Ц.Цэцэнбилэг, СУИС-ийн багш Ө.Гандулам, БХЭШХ-ийн эрдэмтэн судлаачид, ҮБХИС-ийн Нийгэм Хүмүүнлэгийн тэнхимийн багш нар оролцож “Монголчуудын үнэт зүйлсийн асуудалд” сэдвээр хэлэлцүүлэг, ярилцлага хийсэн.

#### *4. Эрдэм шинжилгээний хурал*

-2022 оны 10 сарын 18-нд ҮБХИС-ийн “Сүбэйдэй” хурлын танхимд “Үндэсний ой санамж ба Үндэсний аюулгүй байдал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг ҮАБЗ, Ерөнхийлөгийн тамгын газар, Батлан хамгаалах яам, Соёлын яам, Удирдлагын академи, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Монгол цэргийн нэгдсэн холбоо, ШУА-ын Түүх, угсаатны зүйн хүрээлэн болон Философийн хүрээлэнгийн судлаач, эрдэмтэд, ОУССХ-дипломатууд, МУИС, БИС, ШУТИС-ийн төлөөллийг оролцуулан тус тус зохион байгуулсан.

#### *5. Социологийн судалгааны тайлан*

“Үндэсний ой санамж, үнэт зүйлсийг сэргээн тодорхойлох замаар Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нь” сэдэвт төслийн хүрээнд анкетын асуулгыг Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн иргэдийг хамруулан 1907 хүнээс, нийгмийн салбаруудаас төлөөлөл болгон 18 хүнээс үндэсний ой санамж, үнэт зүйлсийн тухай ойлголт, үнэлэмж, өнөөгийн байдал, эдгээр нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хэрхэн нөлөөлөх талаар экспертийн судалгаа авч социологийн судалгааны тайлан бичсэн.

#### *6. Хамтын бүтээл*

“Үндэсний ой санамж, үнэт зүйл” нэг сэдэвт бүтээл хэвлэгдэж гарсан байна. Тус бүтээл удиртгал, 3 бүлэг, 18 хавсралт, эшлэл авсан ном, бүтээлийн жагсаалт бүхий нийт 492 тал, 41,1 хх ISBN 978-9919-0-0463-7 бүрдэж байна. Сэдэв, агуулга, бүтцийн хувьд Үндэсний ой санамжийн судалгааг өөрийн улсын эрдэмтэд, судалгааны байгууллагын шинжилгээ, дүгнэлтийг үндэслэн тодорхойлох оролдлого хийсэн.

#### *7. Судалгааны тайлан*

---

<sup>19</sup> С.Цэдэндамба. “Монгол төрийн албан хаагчдын эрхэмлэл: уламжлал, шинэчлэлийн асуудалд”. “Үндэсний ой санамж ба Үндэсний аюулгүй байдал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.УБ.,2022.т.

<sup>20</sup> Х.Орхончимэг, Б.Байгалмаа, Я.Энхцэцэг, Н.Оюундэлгэр. “Монголчуудын үндэсний ой санамж, үнэт зүйлсийн төлөв байдлын шинжилгээ”. “Үндэсний ой санамж ба Үндэсний аюулгүй байдал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.УБ.,2022.т.



“Үндэсний ой санамж, үнэт зүйлсийг сэргээн тодорхойлох замаар үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нь” сэдэвт судалгааны ажлын тайланг 3 бүлэг, 9 зүйлтэй, ашигласан бүтээлийн жагсаалт бүхий 163 хуудастай ажлуудыг тус тус гүйцэтгэсэн.

**Тайлангийн бүтэц хэмжээ:** Уг судалгааны тайлан нь Удиртгал, 3 бүлэг, 9 дэд бүлэг, дүгнэлт, эшлэл авсан эх сурвалж, ном зүй, 163 хуудаснаас бүрдэнэ.

Судалгааны ажлыг доктор (Ph.D), дэд профессор Ч.Сосорбарам удирдаж удиртгал хэсэг, бүлэг хоорондын уялдаа холбоо, хэл найруулга, ерөнхий дүгнэлтийг хийж гүйцэтгэсэн. Нэгдүгээр бүлгийн I зүйлийг доктор (Sc.D), профессор Б.Даш-Ёндон, нэгдүгээр бүлгийн II зүйлийг доктор (Ph.D), профессор Н.Жалбажав, нэгдүгээр бүлгийн III зүйлийг доктор (Ph.D), дэд профессор Ч.Сосорбарам, хоёрдугаар бүлгийн I зүйлийг доктор (Ph.D), профессор С.Янжинсүрэн, хоёрдугаар бүлгийн II зүйлийг доктор (Sc.D), профессор Ж.Болдбаатар, доктор (Ph.D), дэд профессор Ч.Сосорбарам, хоёрдугаар бүлгийн III зүйлийг доктор (Ph.D), дэд профессор Ч.Сосорбарам, доктор (Ph.D), профессор С.Цэдэндамба, гуравдугаар бүлгийн I зүйлийг доктор (Ph.D), дэд профессор Х.Орхончимэг, магистр С.Байгалмаа, Ж.Батдолгор, Я.Энхцэцэг, Н.Оюундэлгэр, гуравдугаар бүлгийн II зүйлийг доктор (Ph.D), дэд профессор Ч.Сосорбарам, гуравдугаар бүлгийн III зүйлийг доктор (Ph.D), профессор Н.Жалбажав, ашигласан бүтээлийн ном зүйг доктор (Ph.D) Д.Идэшноров нар тус тус гүйцэтгэсэн.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ, ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ТАЛААРХ ОНОЛЫН АСУУДАЛД

## 1.1 Үндэсний ой санамжийн үндсэн ойлголт, мөн чанар

Үндэсний ой санамж гэдэг нь тухайн үндэстний оюун санааны амьдрал дахь нэгэн чухал үзэгдлийг тухайлбал оюун санааны тусгаар тогтнолыг агуулсан сэтгэл зүйг илэрхийлдэг онцгой маягийн ойлголт юм. Үндэсний ой санамж тухайн үндэстний түүхийн явцад бүрэлддэг бөгөөд уг үндэстний философи, үзэл суртал, шашин, ёс суртахуун, зан заншил, эрхийн ухамсарт нь шингэсэн байдаг. Ийм учраас үндэсний ой санамжийн асуудлыг судалж, сурталчлан, цагийн аясаар бүдгэрүүлэхгүй байх нь тухайн үндэстэн өөрийнхөөрөө тохинон хөгжих нэн чухал субъектив нөхцөл болдог байна.

“Үндэсний ой санамж” гэдэг ойлголтыг шинжлэх ухааны янз бүрийн салбар, чиглэлээр судалж болох нь дээр дурдсанаас харагдаж буй. Философи шинжилгээний үүднээс үзвэл үндэсний ой санамж бол үндэстэн өөрийгөө ухамсарлахуйн түүх, шинж байдал, явц юм. Энэхүү түүх, шинж байдал, явц нь тухайн үндэстэн оршин тогтнож мандан бадрах, бууран доройтох, сэхэж сэргэхийн диалектикаас бүрддэг. Үндэстэн өөрийгөө ухамсарлахдаа энэ диалектик явцыг зөв тусгаж, зөв тусгаснаа ой санамждаа бат авч явах ёстой.

Монголчууд тодорхой шалгуураар (нийтлэг хэл, газар нутаг, соёл, улс төрийн байгууламж, эдийн засаг гэх мэт) үзвэл бүр Чингис хааны үед үндэстэн болж төлөвшсөн байна. Үүнээс үзвэл эдүгээг хүртэл монголчууд бидний амьдралд шинэчлэл, уламжлалыг хосолсон залгамж чанарын хууль үйлчилсээр байна. Одоогийн манай Монгол бол “Даяар Монголын ариун голомт” мөн. Энэ дөрвөн үг Монгол Улсын ард иргэд бидний үндэсний ой санамжийн агуулга, учир холбогдлыг тодорхойлж байх ёстой. Энэ дөрвөн үг Монгол үндэстэн өөрийгөө ухамсарлахуйн гол үндсэн чиглэлийг зааж байна. Үндэстэн өөрийгөө зөв ухамсарласан тэр дүр төрх нь үндэсний ой санамжийн “алтан хайрцаг”, тухайн үндэстэн ямагт “дотроо бодож явах” ёстой тэр зүйл нь.

“Өөрөө өөрийгөө танигтун” гэсэн эртний грекээс уламжлалтай, дэлхий дахинаа тархсан танин мэдэхүйн энэ зөвлөмжийг зөвхөн хувь хүнд хамааруулаад зогсохгүй, бүхэл бүтэн үндэстэнд ч холбогдуулан үзэж судалж болно. Үндэстнүүд бий болсноос хойш өөрийгөө сайтар ухаарсан хэсэг нь л шалгаран үлдэж газар нутгаа эзэгнэн, төр улсаа төвхнүүлэн амьдарсаар өдийг хүргэжээ. Үүнийг гярхай ажигласан Г.В.Ф.Гегель “Тэд өөрөө хэн бэ, юу хүсдэг вэ гэдгээ мэддэг ард түмэн л түүхээ бичиж чаддаг” гэжээ. Ийм ард түмний нэг нь монголчууд бид бөлгөө. Монголчууд мянга мянган жилийн арвин баялаг түүхтэй бөгөөд өгсөж уруудахын ээдрээ нугачаатай замыг туулсаар өдгөө үндэс угсаагаа хадгалан, туурга тусгаар улс гэрээ сахин амьдарч байна.

Үндэстэн өөрийгөө зөв ухамсарлахын нэг чухал эх сурвалж нь тухайн үндэстний цадиг түүх болой. Ард түмэн түүхээ мэдэхгүй бол “ойд төөрсөн (амьдардаг) сармагчин лугаа адил”, “харанхуй буданд төөрсөн эрвээхэй мэт” гэх зэргээр онож хэлсэн мэргэн цэцэн санаа манай монголчуудын дунд өнө эртнээс яригдсаар иржээ. Тэгэхдээ энд үнэн зөв тайлбарлагдсан, үнэн зөв дамжуулагдсан түүхийг хэлж буй нь ойлгомжтой хэрэг. Бид түүхээ бичихдээ жишээ нь “Монголын байлдан дагуулалт”

гэхийн оронд “Монголчуудын цэрэг дайны түүхэн гавьяа” хэмээн хэлж баймаар. Түүхийг будилуулж, гуйвуулбал үндэсний ой санамжийг булингартуулна. Үндэсний ой санамж бол тухайн үндэстнийг сахин харгалзагч, зөвлөгч, багш нь юм.

Үндэсний ой санамж бол нэгд, Үндэстэн өөрийгөө өөрөөсөө хамгаалах; хоёрд, Үндэстэн өөрийгөө гадаадын түрэмгийллээс хамгаалах гэсэн хоёр чиглэлээр яригдах ёстой. Энэ хоёр чиглэлийн аль алинд нь холбогдуулан тунгаах үүднээс К.Марксын хэлсэн дараах үгийг санацгаая. Тэр бээр “Хүүхэн хүн аль тохиолдсон балмад этгээдэд хүчиндүүлчихгүйн тулд соргог байдгийн адилаар үндэстэн ч гэсэн бас ганц ч хором алмайрч болохгүй... Гурван үл бүтэх этгээд ямар аргаар 36 сая хүн амтай үндэстнийг гэнэдүүлж, ямар ч эсэргүүцэлгүйгээр олзлон авч чадахыг бас тайлбарлах хэрэгтэй юм”<sup>21</sup> гэжээ. Үндэстэн гэнэдэхийн шалтгаан нь дотоодын зөрчил тэмцэл, эрх мэдэлтнүүдийн мэхлэлт, хуйвалдаан, урвалт, улс төрийн тодорхой хүчний хууль бус балмад үйл ажиллагааны арга заль юм.

Үндэсний ой санамж бол урьд өмнө өрнөж байсан тухайн үндэстэнд учир холбогдол бүхий томоохон үйл явдлыг сэргээн тунгааж ашиглах сэтгэцийн үйлдэл юм хэмээн санагдаж байна. Энд эргэн дурсахуйн асуудал ч холбогдоно. Үйл явдал түүхийн явцад янз бүрийн хэлбэр, байдлаар давтагдаж болно. Хор хөнөөлт үйл явдал давтагдахад хүрвэл үндэсний ой санамж олон нийтийг сэтгэцийн цочрол, сэтгэлийн хөөрлөөс хамгаална. Цочрол, хүсэшгүй нөлөөллөөс хамгаалахын тулд үндэстэн холбогдох ой санамжаа сэрээх хэрэгтэй болно. Ашиг тустай томоохон үйл явдал давтагдахад хүрвэл урьд өмнөх үеийнхээс нь санаа авахын тулд үндэстэн мөн л холбогдох ой санамжаа сэргээх хэрэгтэй болно. Муугийн муу хорыг мартаж болохгүй. Сайны сайн тусыг ч бас мартаж болохгүй ээ.

Үндэсний ой санамж ба үндэстний адилсахуй. Монгол үндэстэн бол “өөртэйгөө адилсан бүхэллэг” юм. Энэ адилсал нийгмийн харилцааны явцад бүрэлдэж, батжин бэхэжсэн, тогтворжсон нэгдэл юм. Энэ талаасаа Монгол бол үндэстэн улс мөн.

Үндэстэн хэдийгээр тогтворжсон нэгдэл боловч цаашдын гадаад, дотоодын элдэв нөхцөл байдал дахь нийгмийн харилцааны явцаас хамааран “өөрийгөө алдах” буюу “адилслаа алдах” ноцтой гаж замд орж болно. Ийм гажилтаас сэргийлэх гол арга зам нь үндэстэн өөрийгөө үндэстний адилсахуйгаар ухварлах ой санамж юм. Үндэстэн өөртэйгөө адилсалд байх чадвар нь түүний оршин амьдрах, өөрийгөө хадгалан хөгжих, уусаж мөхөхгүй байхын гол баталгаа болно. Үндэстний өөртэйгөө адилсахуйг төр нь бодлогодоо ямагт тусган баталгаажуулж байх ёстой. Улс орны нийгэм эдийн засаг, улс төр, эрх зүй, соёл боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн бодлого дор, ер нь хөгжлийн бодлого дор үндэснийхээ онцлогийг сайтар судлан зөв зүйтэй тусгаж байх нь төрийн бодлогын амин гол болж байх ёстой.

Үндэстний өөртэйгөө адилсахуй нь бат бэх байхад үндэсний бахархлаа гүнээ ухамсарлаж түүнээ хамгаалах нь нэн чухал үүрэгтэй. Үүнд холбогдуулж түүхээс нэг зүйлийг эргэж саная. Монголын их бичгийн хүн Ванчинбалын Инжиннаши (1877-1891)-ийн “Хөх судар” хэмээх алдарт бүтээлд байгаа нэг чухал санааг жишээ болгон дурдъя. Түүний бичсэн нь “Дундад улсын Хятад ар газрын монголыг эгнэгт хүний тоонд оруулахгүй, ерийн адгуус болбоос дөрвөн хөлтэй тул хэвтээгээр явмуу.Ар

<sup>21</sup> К.Маркс., Ф.Энгельс “Түүвэр зохиол” I боть.УБ.,т. 443

газрын хүн гагц хоёр хөлтэй болоод босоогоор явах нь адгуус малаас баахан өөр буй заа. Бусад зүйлийн үйлс явдал, зан авьяас нь шууд мал адгуус болой”<sup>22</sup> хэмээн басамжлан доромжилдог байжээ хэмээн эртний үеийн хятад бичээчийн “Ган Цзянь” номд бичжээ. Инжиннашийн хэлж буйгаар хэдэн хятад үсэг мэддэг монгол хүн “Ган Цзянь”-ийг үзээд цөм үнэн хэргийг хэлжээ хэмээн... даруй тэр “Ган Цзянь”-ий муушаан доромжилсон үгсийг баримтлан, хүний зүг (хятадуудад хандан, Б.Д) манай монгол ийм, манай монгол тийм хэмээх нь маш олон”<sup>23</sup> байжээ. Манжийн дарлалын үеийн Монголын ноёд, тайж нар манжуудад бялдуучилж, үндэс угсаагаа жигшин өвдөг сөгдөж байсан нь тэрхүү монгол хүний л хийж байсан ажил билээ. Үүнийг бид ой санамждаа авах нь эдүгээ ч чухал учир холбогдолтой болоод байна.

В.Инжиннаши тэр үеийнхээ иймэрхүү монголчуудад хандан “Чиний тэр хоёр нүд бүлтийж байгаад, өөрийн уг үндэсний түүх бичиг ба цадиг судраа үл үзэн, урьдас дээдсээ, угсаа эшээ үл мэдэн, хүн бөгөөд үндсээ үл мэдэх нь адгуус буюу. Тайж бөгөөд өвөг юүгээн үл мэдэх нь мал буюу. Нүд буй бөгөөд түүх юүгээн үл үзэх нь сохор номин буюу. Мэдэлтэй бөгөөд язгуураа үл сэтгэх нь гахай буюу”<sup>24</sup> хэмээн бухимдан бичжээ. Монголчууд бид бусдын нөлөөнд автаж өөрсдийгөө, улс орноо доорд үзвээс ирээдүйгээ алдах нь тэр буюу.

Үндэсний ой санамж, үндэсний бахархал аль аль нь бие биегүйгээр бүрэн бүтэн байж чадахгүй, бие биеэ баяжуулж байх ёстой. Бахархал үгүй ой санамж байна гэвэл энэ нь хөндий хоосон үг яриа болно. Үндэсний бахархал бол тухайн үндэстний сэтгэлийн цөм, дуудлага нь төдийгүй ухааных нь уриа лоозон юм. Өвөг дээдсийнхээ алдартнуудын дурсгалыг хүндэтгэх нь ч үндэсний бахархал, ой санамжид чухал байр суурь эзэлдэг. Иймд түүнийг гутаах нь өвөг дээдсийнхээ өмнө нүгэл үйлдэгчдийн айж ичсэн зан авирын илрэл болдог. Үг дуугардаггүй, үр хойчтойгоо элдэв юм булаацалддаггүй дурсгалыг нурааж буулгах гэх нь ч ёс суртахууны томоохон согог юм.

Үндэсний ой санамж ба соёлын өв. Дорно дахиныг судлаач, Оросын эрдэмтэн Н.Я.Бичурин 200 жилийн тэртээд монголчууд хурим найрын үедээ тойрч сууцгаан “уртын дуугаа аяархан дуулна; энэ дуу нь нэн тааламжтай, бүр ч сэтгэл догдолмоор. Гэхдээ нэг л уйтгартай, их тал хөндий газар тэднийг бодлогошролд оруулж буй мэт байдаг. Чимээ аниргүй, сүртэй цэпийсэн энэ их уудам тал хөндий бол монголчуудад байгалиас заяасан бодлогошролын сүм бөлгөө”<sup>25</sup> хэмээн бичжээ. Сайх эрдэмтэн манай уртын дууны ая утга, ааг шимийг ингэж гүн нарийн ухаарчээ. Бид бүхий л өв соёлоо ийм гярхай сэтгэлгээгээр нарийвчлан судлан сурталчлах нь үндэсний ой санамжаа хурцлан тодруулахад чухал ач холбогдолтой.

Аливаа үндэстэн, ард түмэн соёлын өвөө хадгалж, хамгаалж, хөгжүүлэхийн үндэс суурь нь уламжлал хэмээх үзэгдэл юм. Уламжлалын талаар их философич Г.В.Ф.Гегель: «...уламжлал бол шилжимтгий бүхний дундуур явж, яг л ариун нандин гинж мэтээр улиран урсаж, сунан тэнийж байдаг юм. Уламжлал нь өмнөх үеийнхний бүтээсэн бүхнийг хадгалж, бидэнд дамжуулан өгдөг амуй... Уламжлал бол хэлбэр, дүрсийн хувьд мөнхөд өөрчлөгдөн хөдлөхдөө уугуул хуульдаа ямагт захирагдаж,

<sup>22</sup> Хөх судар. Тэргүүн дэвтэр. УБ., 2009 он.т.73

<sup>23</sup> Хөх судар. Тэргүүн дэвтэр. УБ., 2009 он.т.76

<sup>24</sup> Хөх судар. Тэргүүн дэвтэр. УБ., 2009 он.т.50

<sup>25</sup> Н.Я. Бичурин “Монголын тухай тэмдэглэл” Орч. Б.Даш-Ёндон. УБ., 2019 он.т.108

огтхон ч дэвшил гаргадаггүй байгалийн урсгал явц шиг, олсон зөөсөн юмаа бат хамгаалан сахиж, тэгснээрээ түүнээ үр удамдаа хадгалж, багасгаж цөөлөхгүйгээр тэдэндээ дамжуулан өгдөг гэрийн эзэгтэй мэт төдий зүйл биш ээ. Ийм эзэгтэй биш, уламжлал бол хөдөлгөөнгүй баримал буюу уламжлал бол амьлаг бөгөөд эх авсан газраасаа цаашлан холдох тусмаа улам өргөсөн тэлдэг хүчит урсгал ус лугаа адилаар өсөн нэмэгдэж өрнөдөг... Шинжлэх ухаан, оюуны үйл ажиллагааны салбарт үе бүхний бүтээсэн зүйл бол өв мөн. Эл өвийн өсөлт нь өмнөх бүх үеийнхний ариглал хадгалалтын үр дүн. Хүн төрөлхтний бүх үеийнхэн амьдралын замаа туулахад нь тэдэнд тусалсан, байгалийн агаад оюун санаа (дух)- ны гүнээс тэдний олсон бүхнийг талархалтайгаар, баяр хөөртэйгөөр байрлуулан хадгалсан ордон өргөө юм. Энэхүү өвлөлт бол өвийг хүлээн авах ч, эдгээр өвд эзэмшигдэх ч явдал амуй. Өв бол дараагийн үе нэг бүрийн амин сүнс, түүний оюун санааны субстанции мөн. Ямар нэгэн байдлаар энэ үеийн нь дадал зуршил, зарчим, тогтсон бодол, баялаг нь болсон субстанции мөн» хэмээн бичжээ.<sup>26</sup>

Үеэс үе дамжин ард түмний маань бүтээж ирсэн үндэсний өв соёл: монголчуудын зан заншил, ардын аман зохиол, дуу хөгжим, бүжиг наадам, зүйр цэцэн үг, үлгэр домог, ерөөл, оньсого, туульс найраглал, тууж хүүрнэл зохиол зэрэг нь ардын сургаал, амьдралын сургамжийг агуулсан, монголчуудын маань сэтгэлийн гүн эрмэлзлийг илэрхийлсэн үндэсний ой санамжийн асар том ай сав, үнэт эрдэнэс юм. Энэ үнэт эрдэнэс буюу үзэл санааг шинэ нөхцөлд ч гэсэн улам дэлгэрүүлэн хөгжүүлж байхгүй бол мартагдан бүдгэрэх аюултай. Цаашилбаас, өнө эртнээс уламжилсан үндэснийхээ сэтгэгчид, зохиолчдын түүх, нийгэм шинжлэл, гүн ухаан, уран зохиол, шашин суртахууны бүтээлүүдийг улам улам хайн олж илрүүлэх, тайлбарлаж хэвлэн нийтлэх ажлыг зохион байгуулалтайгаар идэвхжүүлэх нь чухал.

Үндэсний соёлын өвийг ойлгон хамгаалах үйл үйлдэл, эх оронч үзэл хоёрыг салгашгүй. Энэ хоёрын аль аль нь үндэс угсаа, газар орноо бишрэн баяссан хүний мэдрэмж, тийм хүний сэтгэхүй, тийм хүний оршихуй, тийм хүний гүн хайр юм. Алив ард түмэнд эх оронч үзэл төлөвшихөд ардын аман зохиол (соёлын өв) чухал үүрэгтэй. Эх оронч үзэл бол ард түмний оюун санаагаар бүтсэн сайн сайхан бүхнийг агуулдаг бөгөөд ард түмний ухаан бодлын амжилт бүхнийг хайрлан хамгаалахад оршдог.

Үндэсний ой санамж ба улс орон өөртөө дүйж хөгжихүй. Үндэсний ой санамж гэдэг ойлголтыг зүгээр л үндсэрхэх үүднээс судалдаггүй. Үндэсний ой санамжийг судалж, бататгах нь Монгол Улс өөртөө дүйж хөгжих нэн чухал субъектив хүчин зүйл юм. Өөртөө дүйж хөгжихүй гэдэгтээ бид монголоо алдахгүйгээр Монгол монголоороо байж, монголоороо хөгжье гэсэн утга бүхий санаа хэлж байгаа юм.

Үндэсний ой санамж баттай байсан цагт бид Монголоо гадаадын нүдээр бус өөрийн төрөлх нүдээрээ харж хөгжин цэцэглэх болно. “Хэн ертөнц рүү ухаалгаар харж байна, ертөнц ч түүн рүү сайнаар харна. Энэ хоёр нь бие биеэ нөхцөлдүүлж байдаг”<sup>27</sup> гэсэн Г.В.Ф.Гегелийн үгийг бид өөрийгөө төрөлх нүдээрээ харахын зайлшгүйд холбогдуулан бодоцгоох нь чухал. Бид өөрийнхөө ертөнц рүү ухаалгаар харах ёстой. Тэгвэл бидний ертөнц бидэн рүү сайнаар харах болно.

Философийн өргөн утгаар хэлбэл, хөгжил хэмээх нь амьд организмын оршин

<sup>26</sup> Г.В.Ф.Гегель “Философийн түүхийг шинжихүйн оршил” УБ., 2020 он.т.21-22

<sup>27</sup> Г.В.Ф. Гегель “Философия историй” М., 2000, с.447

тогтнох арга юм. Эл арга нь амьд организм гадна талтайгаа шүтэлцэн өөрөөсөө задран салаалж дэлгэрэн, өөрийгөө баяжуулан чингэхдээ өөрийгөө хадгалж дэвшин дээшлэх үйл явц юм. Энэ үйл явцыг агуулахгүйгээр организм амьд оршин байж чадахгүй. Энэ үйл явц нь зогсвол амьтай бүхэн мөхнө. Ингээд бодохлоор, хөгжил нь амь, амьдралтай салшгүй холбоотой байна. Нийгэм ч, улс орон ч, үндэстэн ч нэг ёсны амьд организм билээ. Тэгэхдээ ухамсартай байдгаараа шим ертөнцийн бусад амьд организмаас эрс ялгаатай.

Ийм болохоор улс орон, үндэстэн амьд байя гэвэл ямагт урагшлан давшиж, хөгжин цэцэглэж байх ёстой, Тэгэхдээ өөртөө дүйж, өөрийнхөө адилсахуйг хадгалж, өөртөө дүйж байгаа бол жинхэнэ хөгжил, жинхэнэ адилсахуй болно. Өөрийгөө алдчихвал тэр нь хөгжил биш, түүний мөн чанарынх нь мөхөл болно. Монгол төрийн бодлогод гадаадыг дуурайх, гадаадад хэт шүтэх санаа хавчуулагдаад байвал бид өөрийгөө, цондон болно.

Монгол монголоороо хөгжих ёстой. Монгол орон, Монгол үндэстэн өөрийн онцлогтой нь хэн бүхэнд илэрхий. Түүнийг аль нэгэн гадаад орон лугаа адил болгох гэх хэрэггүй. Тийм болгол гэвэл монголыг төрөл арилжуулах, ингэхлээр үгүй болгох хэрэгтэй болно. Энэ дэлхийд АНУ АНУ-аараа, Орос оросоороо, Хятад хятадаараа, Лаос лаосоороо байхыг хүсэж байна, тэгж ч чадаж байна. Дэлхийн бүх улс орны аль нь ч аль нэгтэйгээ адилсах лоозон тавихгүй байгаа. Бид өөрийгөө танихаас залхуурч өрөөлийг даган дуурайх гэх хэрэггүй. Платон “Захидлууддаа” “Бусдын хэлийг (санаа төрхийг нь, Б.Д.) дуурайдаг тийм төрийн байгууламж мөхдөг”<sup>28</sup> гэсэн бол Эзол «Янцгаах гэсэн харцага» гэдэг ёгт үлгэртээ харцага адуу дуурайж янцгааж сурах гээд уугуул дуу хоолойгоо гээжээ гээд “Бидэнд нийцэхгүй юмыг дуурайх нь бидний уг чанарыг гээгдүүлдэг ажгуу”<sup>29</sup> хэмээжээ. Монголчууд зүйр цэцэн үгэндээ “Хэрээ галуу дуурайж хөлөө хөлдөөх” гэснийг энд нэмээд хэлчихье. Хэрээ галуу дуурайх гэж давхиад галуу болж чадалгүй, харин өөрөө эрхтэн дутуу болчихжээ. Гэтэл бид өдгөө боловсролын тогтолцоо ялангуяа түүнийхээ агуулгыг саармагжуулчхаад удаж байна. Үүнээ засаж залруулахтай холбон бодож Г.Д.Ф.Гегелийн нэгэн санааг тунгааж үзье. Тэр бээр “Бодит байдалд хэрэглэгдэж байгаа ойлголтыг бид боловсрол гэж нэрлэдэг. Яагаад гэвэл боловсрол цэвэр хийсвэр байдлаар яригддаггүй, харин аливаа төсөөллийн янз бүрийн агуулгатай нэгдмэлээр илэрдэг юм”<sup>30</sup> гэжээ. Эндээс ямар утга гарч байна вэ? гэвэл, боловсролын тухайд “цэвэр хийсвэр байдлаар (өөрийнхөө улс орныг харгалзаагүй. Б.Д) яригддаггүй”. Харин тухайн нийгмийнхээ хэрэгцээг яг онож тусгасан сургалт олгосон эрдэм мэдлэгийг л боловсрол гэнэ хэмээсэн утга. Ингээд бодохлоор, үндэстэн өөртөө дүйж хөгжихөд төрийн бодлогоор иргэддээ олгож буй боловсролын агуулга, шинж чанар нэн чухал ач холбогдолтой байна.

Социал танин мэдэхүй буюу өөрийнхөө нийгэмшилтийн бүхий л асуудал, агуулгыг ойлгож авах нь боловсролын голт зүрх нь юм. Энэ утгаар нь Гегель “Боловсрол бол гэгээрэл хэмээгч амуй. Боловсролыг чөлөөт (өөрийн гэсэн. Б.Д)

<sup>28</sup> Б.Даш-Ёндон “Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж” эмхэтгэл. I-III боть, УБ., 2011 он, I боть.т.274

<sup>29</sup> Б.Даш-Ёндон “Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж” эмхэтгэл. эмхэтгэл. I-III боть, УБ., 2011 он, II боть.т.814

<sup>30</sup> Г.Д.Ф.Гегель. Соч, т.10. лекций по истории философий. Кн. М., 2018, с.7



сэтгэлгээгээр олж авах ёстой, тэр нь хувийн итгэл үнэмшил юм<sup>31</sup> гэх зэргээр хэлжээ. (Байгалийн шинжлэлд өөр өнцгөөс яригдана). Социал танин мэдэхүй Өрнөдөд Өрнө дахиныг өөрийг нь таних, социал өөрчлөлтийг нь удирдах зорилготойгоор анх үүссэн. Ийм болохоор Өрнийн судлаачид өрнийн бус нийгмүүдийг өөрийгөө судалдаг тэр л аргаараа шинжиж үздэг байна. Тэгээд үүнээ үнэмлэхүй түгээмэл үнэн гэж даваадуулдаг аж. Ийм учраас бид өөрийнхөө нийгмийг судалж танихдаа өрнийн аргыг анхаарах хэрэгтэй ч гэсэн өөрийгөө өөрийнхөө арга ухаанаар шинжиж судлах нь чухал юм. Үүнд манай боловсролын агуулгын, нийгэм шинжээчдийн том хариуцлага оршино.

Үндэсний ой санамж ба улс төрийн тогтвортой байдал Улс төрийн тогтвортой байдлын асуудал үндэсний ой санамжид чухал байр эзлэх учиртай. Улс төрийн тогтвортой байдал бол нийгэм адилсахуйгаа хангаж хадгалах нөхцөл, хүчин зүйл юм. Янз бүрийн социал субъект хийгээд улс төрийн хүчнүүдийн тэнцэтгэлийг барих үндсэн дээр иргэний зохицлыг хангадаг. Улс төрийн бодлого, социал амьдралын хүрээнд үүссэн асуудал, зөрчлийг зохих хуульд заасан механизм, арга хэрэгслийн тусламжтайгаар хуулийн дагууд шийдвэрлэдэг нийгэм л улс төрийн тогтвортой байдлаа хангаж чадна гэж судлаачид үздэг байна. Засгийн эрхийн төлөөх хууль лсны бус тэмцэл ил, далд шинжтэй байж болох бөгөөд аль нь ч нийгмийн улс төрийн тогтвортой байдлыг сарниан нурааж, нийгмийг задралд оруулах, тогтворжилтын дотоод эв нэгдлийг хөнөөж, эцэстээ улс төрийн аюултай донсолгоонд хүргэж болдгийг дэлхий дахинаа түүхэн туршлага харуулжээ.

Явдал учир иймийн тул дэлхийн янз бүрийн улс орнуудад тогтвортой байдлаа хангах тусгай хөтөлбөрүүдийг дэвшүүлэн хэрэгжүүлдэг туршлага ч байдаг аж. Улс төрийн тогтвортой байдлаа хангах асуудал дэлхийн аль ч улс орны төрийн анхааралд байсаар байна. Манай Монголд ч ялгаагүй. Манайд улс төрийн тогтворгүй байдалд хүргэх гэсэн оролдлого гарсаар байгааг бид анхаарахгүй байж боломгүй. Хаашаа хамаагүй гүйгсэд, учир зүггүй дайрагсад ийм мулгуу явдлаа “улс төр хийж байна” гэгцгээх явдал газар авсаар буйд сайн юм огт байхгүй. Ийм байдлыг нь хараад байхад манай Монголд улс төрийн амьдралд албан тушаал эрхлэн оролцогчдыг монгол хэлээрээ “улс төрч”, “улс төрийн зүтгэлтэн” гэж ангилан үзмээр санагдахад хүрч байна. Эндээс, “улс төр хийж байна” хэмээн хууль зөрчин ёс суртахууны хэм хэмжээг зөрчин дураар авирлагчид өөрсдийгөө “улс төрчид” гэдэг бололтой. Энэ “Улс төрч” гэдэг нь энд ч нэг ийм, тэнд ч нэг тийм болж явдаг байна. Харин “Улс төрийн зүтгэлтэн” бол хууль номын дагуу ёс зүйг сахиж, шударга ёсыг баримтлан улс орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө ард түмнээ уриалан зүтгэгч юм. Мулгуудаад байдаг Улс төрчийн нүдээр бол тэд эрх мэдэлд хүрэх тоглоомын талбай нь хөөрсөн түмэн юм. Ухаалаг, эх оронч улс төрийн зүтгэлтний хувьд бол улс орноо зөв авч явах түшиг тулгуур нь ард түмэн юм.

Эрхэнд гарагсад ард түмнээ, улс орноо тархиндаа багтааж, сэтгэн бодож, хичээж зүтгэхгүй зөвхөн хувь биеэ, өөрийн байр сууриа бэхжүүлэхэд ажил хэргээ чиглүүлээд байвал нийгэм, улсдаа юу ч бүтээж чадахгүй. Ийм хүсэл шунал хувь этгээдэд өөрт нь гай зовлон тарьж, улс орныг нь доройтуулсан түүх дэлхий дахинаа олонтоо тохиолдсон ажгуу.

Үндэсний ой санамж ба “Орчин үе” хэмээх ойлголт. “Орчин үе гэдэг бол соёлын

<sup>31</sup> ГД.Ф.Гегель. Соч, т.10. лекций по истории философий. Кн. М., 2018, с.8

хийгээд улс төрийн онолын философийн ойлголт... Орчин үе бол субъектив эрх чөлөө агаад нийгмийн дэг ёс гэсэн нэгдмэл хоёр асуудал юм. Түүн дэх (орчин үеийн, Б.Д) бүх юм “санаандгүй”, түүн дэх бүх юм “нөхцөл байдлын урсгал”-аас, хүмүүсийн дур зорго тэмцлээс хамаарна. Чухам энэ утгаар, энэ шалтгаанаар орчин үе хэмээх нь “дотоод”-доо ардчилал лугаа төрөл нэг юм”<sup>32</sup> гэж Оросын зарим судлаач тэмдэглэж байгааг анхаарахгүй өнгөрч болмооргүй.

Дэлхий дахиныг “ганц туйлтай” болгох гэсэнтэй холбогдсон хэт их гүрнүүдийн өрсөлдөөн, дунд зиндааны томоохон улс орнууд чадвал их гүрний зиндаанд хүрэх, ядвал одоогийн хүч чадлаа хадгалж, доошоо орчихгүйн төлөө зүтгэж буй жижиг буурай улс орнууд тэсэж үлдэн өөрийнхөөрөө хөгжин дэлхий дахинаа байр сууриа хадгалахын төлөө тэмцэж байгаа нь манай ертөнцийн энэ эрин цагийн өөрөөр хэлбэл орчин үеийн гол шинж тэмдэг болж байна.

Ийм үед монголчууд бидний ирээдүй, хувь заяа биднээс өөрсдөөс маань хамаарах болно. Энэ асуудал түрүүнд бидний хэлсэн үндэсний ой санамжийн үндэстэн гадна талаасаа хамгаалах гэсэн хоёр дахь чиглэлд холбогдоно. АНУ-ын Ерөнхийлөгч асан Дж.Буш 2003 оны 11-р сарын 6-д “Даяар ардчилсан хувьсгалын аргаар” энх тайвныг тогтооно хэмээн хэлсэн гэж хаа нэгтэйгээс уншсанаа санаж байна. Өрнө дахины иймэрхүү маягийн бодлого, зорилго “санаандгүйгээр”, “нөхцөл байдлын урсгал”-аас хамааран хэрэгжихэж болох ажээ. Энэ далд санааг хэрэгжүүлэхээр зоригсдын эсрэг Америкийн эрдэмтэн Чанг Ха Жүн “Шатнаас түлхэх хөгжлийн стратеги”<sup>33</sup> номдоо юу хэлсэн байгааг шууд эшлэн дамжуулъя.

«“Олон улсын стандартыг дагахгүй бол сүйрнэ” гэсэн үзэл санаа бол салхины чиг дага гэсэн үг лүгээ адил. Гэтэл тэр санаа хэр зэрэг үнэ цэнтэй вэ? Ер нь бол хөгжиж буй орнууд хөгжингүй орны 100, 150 жилийн өмнө ашиглаж байсан институцийг (бүхий л арга хэмжээг, Б.Д) дуурайн хэрэгжүүлж болохгүй...” (205-р тал); “...бид хөгжингүй орон болон олон улсын хөгжлийн бодлогын байгууллагуудын хүсэж буйгаас тэс өөр хөгжлийн бодлогын төслийг боловсруулах хэрэгтэй”; “Бүх улсын мөрдөх ёстой хамгийн гайхалтай” бодлого гэж огт байдаггүй” (208- тал); “...сүүлийн үеийн бүх улсад (бага жижиг улс орон гэсэн үг болов уу, Б.Д) Англи, Америк маягийн институцийг хэрэгжүүлэхийг шаардаж байгаатай адил хэлбэрээр хэрэгжүүлж болохгүй. Улс бүрийн эдийн засгийн хөгжлийн үе шат, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ерөнхий нөхцөл байдлыг харгалзан үзэж ямар улсад яг ямар институци хэрэгтэй, ашигтай болохыг судлахаас илүүтэйгээр бодит оролдлогыг (онцолсон нь минийх, Б.Д) хийх хэрэгтэй” (209-р тал) хэмээн бичсэн байна. Эдгээр санааны үндсэн утгыг бид асуудал шийдэх бүхэндээ харгалзаж байх ёстой буй заа.

Явцуурч болохгүй, задгайрч болохгүй. Үндэстэн дэлхий дахины амьдралын ерөнхий хэлхээ холбооноос гадуур байж болохгүй, гадуур байж чадах ч үгүй. Ямарваа юманд явцуурах (зөвхөн өөрийгөө бөөцийлэх гэж оролдох), задгайрах (хэнийг л бол хэнийг дагах) явдал байж болохгүй. Философийн үүднээс бол энд тусгай (тухайн улс орон), ерөнхий (дэлхий дахин) хоёрын харьцааг бодолцох, тооцох асуудал гарч ирнэ. Тусгайгийн ойлголт тухайн юмс, үзэгдлийн онцлог байдал, өвөрмөц шинжийг тусган илэрхийлдэг, ерөнхийгийн ойлголт нийтлэг талыг нь харуулдаг. Үндэсний ой санамжийн асуудлыг судлахдаа ийм бодит байдлыг

<sup>32</sup> “Новая философская энциклопедия” М., “Современность”

<sup>33</sup> Чанг Ха Жүн “Шатнаас түлхэх хөгжлийн стратеги” Орч. Т.Жамбалцэрэн. УБ., 2018 он



гарцаагүй харгалзах учиртай. Тусгайг нь хэтрүүлж бодвол явцуурахад хүрнэ, ерөнхийг нь хэтрүүлбэл задгайрахад хүрнэ. Тэгэхдээ тусгай нь ерөнхийгөөсөө илүү амилаг, илүү баялаг, тухайн юмны үнэнд илүү ойрхон байдгийг заавал харгалзах учиртай. Энд сэтгэлгээ тусгайгаас ерөнхий рүү дээшилбэл ерөнхийг харгалзсан хэрэг болж үнэнд бүүр ч ойрхон очно. Энэ харилцаанд гол зүйл онцлогоо ухамсарлахад оршино.

Үндэсний ой санамж явцуурах, задгайрах хоёр туйлшралаас ангид байж, тэдгээрийн дундаж дээр тогтож байвал зохино. Явцуурваас ой санамж худгийн мэлхийн үлгэрт хүргэнэ. Худгийн мэлхий тэнгэрийг цооногийнхоо нүхний хэмжээнээс илүүгээр харж чаддаггүй гэнэ. Задгайрваас олон юмны дотор будилан харанхуйд орчихсон зулын эрвээхэй мэт болж төөрөлдөн нисэж аль харагдсан галд нь орж шатдаг гэнэ. Улс орны, үндэстний бодлого болгоомжгүй үйл үйлдэлд автвал ийм эрвээхэйн үлгэрт хүргэж болно.

Үндэсний ой санамж нэг үе “унтаж”, нэг үе “сэрж” байх ёсгүй. Ямагт сэрүүн тунгалаг байж улс орныхоо оюуны манаанд соргоогоор зогсож байх лстой.

Жич: Үндэсний ой санамжийн асуудлыг судлахад “Үнэт зүйл”, “Түүхэн сургамж”, “Оюун санааны дархлаа”, “Үндэсний аюулгүй байдал” гэсэн ойлголтууд яригдах учиртай бөгөөд тэдгээрийг эл төсөлд оролцогч бусад судлаачид авч үзсэн байна.

## 1.2 Үндэсний ой санамж онол, арга зүйн зарим үндэслэл

Голч санаа, түлхүүр үгс:

- Ой санамж, төрөл, түвшин;
- Үндэсний ой санамж;
- Үндэсний ой санамж ба түүх;
- Үндэсний ой санамж илрэх, хэрэгжих орчин;
- Төрийн бодлогын үнэт зүйлс;
- Нийгмийн ой санамж.

Ой санамж (оросоор память, англиар memory)-ыг байгаль, нийгмийн шинжлэх ухаанууд (тухайлбал, хүний анатоми, физиологи, сэтгэл зүй, мэдрэл судлал, социологи, антропологи, философи, логик) өөр өөрсдийн судалгааны объект болгон нарийвчлан судалдаг байна.

Эрдэмтэн, судлаачдын дийлэнхи нь энэ бол хүнийг сүүн тэжээлт, сээр нуруутан амьтдаас онцгойлдог ухамсрын илрэх дээд хэлбэр мөнийг нотолдог ч халим загасны уураг тархи, араатны популяци (олонлог буюу зохион байгуулалттай сүрэг гэх мэт)-уудын үйлдэл, уураг тархины үйл ажиллагаанд хийсэн судалгаа, туршилтууд нь ой санамж зөвхөн хүнд заяагдмал зүйл төдийгүй дээр дурдсан адгуусан амьтны зарим үйлдэл (сүрэг араатны ан гөрөөний зохион байгуулалт, нутаг орноо таних, олох мэдрэмж гэх мэт) үнэхээр гайхашралд хүргэсэн дүгнэлтүүдэд хүргэдэг байна. Ан хийж буй арслан, чоно, цөөврүүд, ирвэсийн сүргийн зохион байгуулалт (отолт, бүслэн хаах, дайралт хийх гэх мэт) эсхүл сүрэглэн буй сармагчин, гөрөөс зэрэг амьтадын зохион байгуулалт бүр хүний ой тойнд оромгүй уран, нарийн байдаг шүү дээ. Алсын алс харь оронд галт тэрэг, усан онгоц зэргээр ачигдан хүргэгдсэн Монгол морь нутагтаа гүйн ирсэн домог гэмээр яриа ч бий. Харийн орноос тэр олон гол мөрөн, төмөр зам, хот суурин, араатан, хүн амьтны зүгээс учрах саад бэрхшээлийг яаж туулсан, нутгаа яаж олсон зэрэг нь санаанд багтамгүй.

Одоохондоо тайлагдаагүй оньсого мэт эдгээр үзэгдлийн учрыг тайлж, тайлбарлах нь сэтгэл, мэдрэл судлаачдын ой санамж судлалд нэгэн чухал нээлт болох нь дамжиггүй.

Биологич, физиологич, сэтгэл болон мэдрэл судлаач эрдэмтэн, судлаачдын хийж буй дүгнэлтээр бол хүний ой санамж, хүний уураг тархинд өрнөх маш нарийн, нийлмэл процессуудын цогц болох нь тодорхой байна. Оросын физиологич И.П.Павлов ой санамжийг хүний уураг тархи, түүнийг эд эсүүдэд мэдрэхүй (таван мэдрэхүй)-гээр дамжин өрнөх тусгалын процесс гээд түүний физиологийн үндсийг “чанарын нөхцөлт” рефлекс гэж тайлбарлажээ.

И.П.Павловын сургаалаар чухамхүү нөхцөлт рефлекс нь хүнд (субъектэд) туршлага (мэдээлэл) хуримтлагдах үндэс болдог бол мэдрэлийн эсүүдийн нийлэмж (уялдаа, харилцан үйлчлэл, нөлөөлөл) буюу ассоциаци нь ой тогтоолт (ой санамжийн) сэтгэл зүйн үндэс нь болдог байна. Бодит орчин, түүнээс мэдрэхүйгээр дамжин уураг тархи, түүний эсүүдэд нөлөөлөл үзүүлснээр (өнгө зүс, төрх, үнэр, амт зэрэг хүртэхүйн мөн таашаал, дургүйцэл, айдас хүйдэс, сэтгэл ханамж гэх зэрэг сэтгэхүйн нөлөөлөл) уураг тархинд болзолт рефлекс түүнд тулгуурлан ой санамжийн процессууд (тогтоох, санах, сэргээн таних, бас мартах, тэдгээрийн нийлэмж) өрнөдөг байх нь. Тэгэхлээр ой санамжийн үндсэн процесс нь:

- Ой санамж нь объектив бодит байдлын уураг тархинд хуулбарлагдан буусан, хадгалагдсан шинж чанар гэх үндэстэй юм. Ой санамж нь авсан мэдээллийг санах, туршлага, зан үйлийн хэлбэр хуримтлагдахын нөхцөл болно. Энэ бол мэдээлэл орж ирэх процесс бөгөөд зориудын ба зориудын бус гэж ангилдаг байна. Зориудын–ямар нэгэн зорилгын үндсэн дээр оюуны хүч тэвчээр гарган, тогтсон арга барил хэрэглэн тогтоохыг хэлнэ. Үүнийг ухамсартай цээжлэн санах гэж ангилан авч үздэг байна. Ухамсартай санамж тухайн зүйлийнхээ агуулга учрын олох логик холбоон дээр тулгуурлан тогтоох; цээжлэн тогтоох–гадаад холбоос дээр тулгуурлан олон давтахад бий болно. Зориудын бус–Тодорхой зорилгогүйгээр тогтоохыг хэлнэ. Энэ нь ихэвчлэн гадаад юмс үзэгдлийн гэнэтийн нөлөө хүчтэй зочирлын улмаас үүсдэг ажээ.

Шигтгээ:

- Сэргээн санах гэдэг нь хуулбарлагдан буусан, хадгалагдсан дүрс, шинж төлөв уураг тархинд “эргэн буух”, идэвхижин сэргэх процесс;
- Таних гэдэг нь нэг төрлийн сэргээн санах процесс юм. Танихын тулд сэтгэхүйн дүрслэл, сэтгэх, эргэцүүлэл зэрэг сэтгэхүйн процессуудын нийлэмж (ассоциаци) явагдана;
- Мартах гэдэг нь уураг тархинд хуулбарлагдсан, хадгалагдсан зүйлүүд (мэдлэг, мэдээлэл, туршлага гэх мэт) арчигдан арилах үйл явц гэнэ. Нэг ёсондоо хүний ой санамж хэрэггүй зүйлээс ангижрах процесс бөгөөд уураг тархины дээд гадарт бий болсон сааталтай холбоотой ажээ.

Энэ бүхнээс үзэхэд хүний ой санамж, түүнийг хадгалах “сав” нь болсон уураг тархи нь хуримтлагдсан (хуулбарлагдан буусан, хадгалагдсан) мэдлэг, туршлагаа сэргээх, таних, тэдгээрийг амьдралдаа хэрэглэх, ашиглах, нийгэмтэйгээ, байгаль эхтэйгээ, хүмүүстэй харьцах чадвар, соёлыг бий болгох гайхамшигт чанартай ажээ.

Хэрэв хүнд ой санамж гэдэг “бурхны хишиг” заяагаагүйсэн бол бидний ой ухаан өлгийтэй хүүхдийнх шиг үлдэх юм байна. Хүмүүс ой ухаанаа хөгжүүлж чадвал 60 наслахдаа наад зах нь 3 дээд сургууль төгссөн, 6-аас доошгүй гадаад хэл сурч, нэвтэрхий толины 100 мянган томъёолол (өгүүлэл, мэдээлэл)-ыг санаж, сэргээж чадах тооцоо ч байдаг ажээ.

И.П.Павлов нарын Оросын физиологичид ой санамж тодорхой давтамжтайг нотолсон нь бий. Энэ нь ой санамж хэдхэн (1-3) секундээс (хормоос) жил сараар, насан туршид үргэлжлэн хадгалагдах шинж чанартай байдагтай холбоотой ажээ.

Ой санамж ихэнхдээ түр зуурын юм шиг. Оч үсрэх мэт гэнэт орж ирээд нүдэнд чинь сэхээ авах завдалгүй үзэгдээд эхэлдэг ажээ. Түүнийг шууд хянах боломжгүй. Тэр ч бүү хэл санаж буй зүйлээ мартагч гээд чаддаггүй байна. Хүний тархи утгатай зүйлсийг хадгалахаас биш, архив, эсвэл компьютерийн санамж шиг бүх зүйлийг хадгалдаггүй. Бас ой санамжийн “олон нууц”-ын нэг нь ой санамж танил, эсхүл танил бишийг ялгасны дараа хоёр дахь шийдэл гаргадаг нь: чухал бусаас чухлыг ялгах “чадвар” ажээ.

Зарим судлаачид ой санамжийн төрөл, зүйлүүдийг ангилан авч үзсэн байдаг.

Ой санамжийг дотор нь дүрслэх ой, үгийн ба утгын, хөдөлгөөний, сэтгэлийн мэдрэмжийн ой санамж гэж ангилдаг байна.

Дүрслэх ой санамж нь юмыг хараад нүдлэх, сонсох, амтлах, үнэрлэх зэрэг таван үндсэн мэдрэх эртхний тусламжтайгаар ой санамж нь хүмүүсийн мэргэжлийн онцлогтой ихээхэн холбоотой байдаг байна. Жишээ нь: Эмч хүн ойролцоогоор 250-300 өвчтөнийхөө нэрийг тогтоодог бол нэхмэлийн үйлдвэрийн ажилчид бараан өнгийн 40-өөд янзын утсыг тогтоодог байна.

Үг, сэтгэлийн хөдөлгөөнийг тогтоох ой санамж: жүжигчин, багш хүмүүст илүү байхад шатрын хөлөг дээрх хүү, боднуудын байрыг тогтоон цээжлэх талаар шатарчин хүмүүс илүү байдаг юм. (Жишээ нь: Дэлхийн шатрын аварга байсан Михайл Таль тоглосон бүх л бүтэн өргүүдээ цээжээр буулган тайлбарладаг байжээ.)

Үгсийн ба утгын ой нь санаа бодол тогтоох ой юм. Үг утгын ойд дохионы систем их үүрэгтэй бөгөөд энэ төрлийн ой амьтанд огт байхгүй юм.

Хөдөлгөөний ой нь алхах гишгэх, бичих, зурах, хэмжих, хөдөлмөрийн дадал эв дүй, спортын ба бүжгийн хөдөлгөөн зэрэгт их хэрэг болдог юм. Хүн бүрд ийм ой санамж бий боловч хүний бие махбодын төрөлхийн онцлог, бас хөдөлгөөний дасгал сургууль хийж байснаас ихээхэн шалтгаалдаг байна.

Сэтгэлийн мэдрэмж, хөдөлгөөнийг тогтоох, сэргээх ой нь хүний сэтгэлийн өөрчлөлтийн эерэг ба сөрөг хөдөлгөөнийг тусган авдаг юм. Баярлах, бахдах, гайхах, сэтгэл ханах, хайрлах дурлах, уйтгарлах, гомдох зэрэг сэтгэлийн хөдөлгөөнийг хүн багаас хүлээн авч чаддаг бөгөөд заримд нь бүр насан туршид нь хадгалагддаг. А.П.Чехов нь “хэнэггүй зан бол сэтгэлийн саа өвчин мөн” гэж тун сүрхий онож хэлсэн байдаг.

Ой санамжийн зарчмууд: Сэтгэл судлаачдын тогтоосон ой санамжийн зарчмууд гэж байдаг. Эдгээр зарчмууд нь бидний ой санамжийн чанарыг тодорхойлдог бөгөөд эдгээрийг баримтлахад тусгай дасгал хийгээгвй ч гэсэн бидний цээжлэх чадвар үлэмж нэмэгддэг байна. Хэд хэдэн зарчим байдаг. Тухайлбал:

Сэтгэл санаа тайван байх ёстой бөгөөд ямар нэгэн зовиуртай өвчингүй байна. Мэдрэхүйн эрхтнүүдийн жигд оролцоог хангах хэрэгтэй. Дүрс энгийн бөгөөд аль болох тодорхой байх ёстой. Мэддэг зүйлтэйгээ нийлэмж үүсгэж сурах шаардлагатай. Хошин, өвөрмөц мэдээлэл амархан санагдана. Сайн төсөөлөх нь ой сайн байхын нэг үндэс. Дугаарлах нь дэс дараалал болон эмх цэгцтэй байдлын үр ашгийг нэмэгдүүлдэг.

Билэгдэл ашиглаж тогтоосон мэдээлэл сайн хадгалагддаг байна.

Тод, олон өнгийг ашигласнаар ямар ч сонирхолгүй зүйлийг сонирхолтой болгон тогтоож болдог ажээ.

Дэс дараа болон эмх цэгцтэй байх нь ямар ч мэдээллийг хайж олоход чухал үүрэгтэй гэж үздэг байна.

Эерэг утгатай, тааламжтай дүрс тогтоож санах нь сөрөг утгатай дүрс тогтоож санахаас хавьгүй дээр байдаг ажээ.

Хэтрүүлэг хэрэглэн хэт томруулж эсвэл хэт жижигрүүлж, хэлбэр, өнгө, дуу авиаг нь өөрчилснөөр дүрсийг тогтооход хялбар болгодог байна.

Дээр дурдсаныг үзэхэд ой санамжийг дараах байдлаар томъёолж болох байна.

Ой санамж нь мэдрэхүйгээр дамжин хүний ухамсар (оюун ухаанд)-т хуулбарлагдан, дүрслэгдэн буусан объектив бодит байдлын тусгал бөгөөд
--

хадгалагдах, эргэн санагдах, танигдах шинж чанартай ажээ. Энэ бол хүний мэдэрсэн, ухаарсан зүйл, юмс, үзэгдлийг оюун ухаандаа хадгалах, сэргээн санах, таних чадвар гэх үндэстэй юм.

Судлаачид онцлог, өвөрмөц болон нийтлэг шинж чанарыг нь үндэслэн ой санамжийг:

- Бодгалийн (хувь хүний);
- Хамтын буюу олонлогын (гэр бүлээс аваад нийгмийн бүлэг давхарга, хүн амын угсаатан, ястны олонлог хүртэл);
- Улс үндэстний гэж ангилан авч үздэг байна. (Хамтын ой санамжийн дээд түвшин)

Бодгалийн буюу хувь хүний ой санамжийн “нууцын” цаад утгыг тайлахад Австри, Герман гаралтай мэдрэл судлаач Эрих Кандел, З.Ш.Фройд нарын “Доод би” (ID), “Би” (EGO) болон “Дээд би” (SUPER EGO)-ийн үзэл баримтлал, онолын таамаглал чухал үүрэг гүйцэтгэжээ.

З.Ш.Фройд нарын үзэл баримтлалаар ой санамжид “Ухамсарлахуйн өмнөх” буюу “Оюуны бус” төрөлх мэдрэмжийн зүйлүүд (өлсөх, цангах, дурлах, тачаадах, өнгө зүс, үнэр амтыг ялгах, таних, орон зай, цаг хугацааны мэдрэмж, баримжаалал гэх мэт) тодорхойлох (математик тооцоогоор 60-80%) үүрэгтэй байдаг ажээ.

Харин хүн бол байгалийн зүйлээс гадна нийгмийн зүйл болохыг бид мэднэ. Хүн сүрэглэн амьдрах, тэгэхдээ хүрээлэн буй орчинд дасан зохицохоор үл барам байгаль, орчныг өөрийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн зохицуулж орших чадвартай ажээ. Энэ нь хүнийг, хүн сүргийг араатны сүргээс (популяциас) ялгарах гол онцлогуудын нэгэн нь юм. Хүний хамтлагийн үндсэн хэлбэр нь гэр бүл, овог аймаг, үндэстэн, ястан, улс үндэстэн, үндэс угсааны нийгэм, гэр бүл байдаг бөгөөд тэдгээрийн гишүүн нь байж нийгэмшин аж төрснөөр хүмүүний ой санамж хамтын (олонлогийн) шинж чанарыг шингээн төлөвшдөг байна. Ийнхүү бодгалийн ой санамж “нийгэмших”, хамтын шинж төлвийг олоход хамтран аж төрөхийн хэрэгцээ шаардлага, тэдгээрийн хөгжлийн тусгал болсон зан заншил, нийгмийн ёс зүй, ёс суртахуун, улмаар төр ёс, хууль цааз, тэдгээрийн түүх, уламжлал голлох үүрэг гүйцэтгэдэг байна. Хүний олонлог хувьсаж хөгжсөөр улс, үндэстнүүд төлөвшин тэдгээрийн түүх, соёл, иргэншил, үнэт зүйлс нь бүрддэг. Ой санамж ч үүнийг даган үндэстний (үндэсний) бөгөөд улам нийлмэл, нарийн шинж төлвийг олсоор байх.

Ой санамж “нийгэмшил”-ийн хандлагаар “урагшлах” алхам бүрт нийтлэг, түгээмэл, олдмол шинж нь тодорсоор харин бодгалийн давтагдашгүй өвөрмөц, заяагдмал өнгө аяс нь бүүдгэрэх жам ёс илэрнэ. Гэхдээ хүний оюун ухаанд инстинктийн буюу заяагдмал зүйлүүд тухайлбал өдөр дутмын амьдралын бодит хэрэгцээ (орон байр, хувцас хэрэгсэл, хоол хүнс улмаар сайн сайхны буруу, зөвийг ухаарч мэдрэх, бие сэтгэлийн таашаал авах, хайрлах, дурлах, шунах гэх мэт) ухаарал, мэдрэмж нийгмийн оюун санааны (биднийхээр “Хамтын ой санамж”-д) шийдвэрлэх үүрэгтэй байх нь зайлшгүй. Гагцхүү нийгэм (хүний олонлог) хөгжихийн хэрээр хүний заяагдмал хэрэгцээ шаардлагын агуулга өөрчлөгдөн хүний боловсрол, хүмүүжлийн (олдмол) үүрэг, ач холбогдол өсөн нэмэгдэх нь нийгмийн хөгжлийн бодит зүй тогтол юм.

Хамтын ой санамжийн онол, арга зүйн хувьд Maurice Halbwach (Английн философич, социологич) нарын судалгаа ихээхэн сонирхол татаж буй ажээ. Тэдний судалгаагаар хамтын ой санамж нь нийгмийн бичил (ажил, мэргэжлийн хамт олон, байгууллагын хүрээний гэх мэт) ухамсрын нэгэн илрэл, тусгал нь бөгөөд төлөвшил, хөгжилд тэдгээрийн ашиг сонирхол, оршин тогтнохуйн болон хөгжлийн байдал төлөв, чиг хандлага зэрэг тухайн хамт олны дотоод хүчин зүйл мөн төр, нийгэм, нийгмийн бусад бүлэг давхаргатай ямар харьцаанд байгаа буюу нийгэмд эзлэх байр суурь, нийгэмд зонхилж буй суртал ухуулга, тухайн бүлэг давхаргын ашиг сонирхлын цар хүрээ, нийт улс үндэстний ашиг (бүх нийтийн) сонирхолд нийцэж буй эсэх зэргээс үлэмж хамааралтай ажээ.

Мөн тухайн бүлгийн оршин буй нийгмийн ухамсрын төлөв байдал (стресс, тэнцвэр тогтвор, тогтворгүй байдал, хямрал) хүмүүсийн амьжиргааны чанар байдал ихээхэн нөлөө бүхий хүчин зүйлд тооцогддог байна. Зарим судлаачид ой санамж нь дээрх болон бусад хүчин зүйлээс шалтгаалан “худал хуурмаг” эсхүл төөрөлдсөн байх магадлалтай ажээ. Учир иймд ой санамжийн бодит төлөв байдлыг шинжлэх ухаанчаар тогтоох, нийгмийн ухамсарт үзүүлж буй бодит нөлөөллийг тогтооход нийгмийн амьдралын бүх хүрээ, тэдгээрийн харилцан хамааралд цогц (PESTLE) шинжилгээ хийх учиртай юм байна. (PESTLE гэдэг нь улс төр, эдийн засаг, нийгэм (социал орчин) хууль эрх зүйн орчин, байгаль экологи гэсэн утга, үгнүүдийн товчлол).

Ой санамжийн төлөвшил, хувьсалд тухайн олонлог (гэр бүл, ургийн бичиг, үндэс угсаа, улс үндэстний түүх гэх мэт) түүх, түүх бичлэг, мөн үнэт зүйлс, уламжлал, туршлага, сургамж (нийгэм, түүхийн, ахуй амьдралын гэх мэт)-ын зүйлүүд чухал нөлөөтэй. Иймээс бидний судалгаанд түүх ба ой санамж, ой санамж ба үнэт зүйлс гэх мэт учир шалтгааны уялдаа холбоо чухал байр суурьтай байх болно. Тухайлбал түүхийг өрөөсгөл, улс төржсөн байр сууринаас мушгин гуйвуулах зэрэг нь дээр дурдсан “төөрөлдсөн ой санамж”-ийн магадлал үүсэх нигууртай ажээ. Дээр дурдсанаас үзэхэд бодгалийн ой санамж нийгэмших, хамтын ой санамж төлөвших нь нарийн нийлмэл үйл явц болох нь тодорхой байна. Хувь хүний (бодгалийн) уураг тархинд хуулбарлагдан, дүрслэгдэн буусан объектив бодит байдлын тусгал болох хадгалагдах, сэргээн санах, таних, мартах үйл явц нь нийгэмшсээр хамтын туршлага, сургамж буюу түүх соёл, амьдрах, оршихуй арга ухаан буюу хамтын ой санамж төлөвших үр хөврөлийг агуулдаг байна. Нийгмийн ахуй буюу амьдран оршихуйн орчин хийгээд бодит хэрэгцээ шаардлага, тэдгээрийн тусгал болон нийтийн ухамсар, сэтгэхүй нь ой санамж лавширах, эсхүл бүүдгэрэх учир шалтгаан болдог байна.

Хамтын ой санамжийн дээд төвшин нь улс үндэстний ой санамж болдог байна. Нэгэн зүйлийг онцлоход ой санамжийн аль ч түвшинд (бодгалийн, хамтын, улс үндэстний) заяагдмал нь олдмолоо, ухамсарлагдаагүй нь ухамсарлагдсанаа үүсэх, бүрэлдэх, төлөвших, хувьсах гол үндэс, эх сурвалж нь болдгийг, иймээс судлаачид улс, үндэстний ой санамж нь юуны өмнө байгалийн (биологийн), нийгмийн, экологийн хүчин зүйлтэй холбоотойг онцолдог байна. (Зигмунд болон Анна Фройд гэх мэт)

Үндэсний ой санамж нь хүмүүний олонлог (улс, үндэстэн гэх мэт)-ийн ёс суртахууны өнгө аястай, эх орон, ард түмнээ хайрлах, тухайн олонлогийн шашин шүтлэг, ертөнцийг үзэхүй, оршин тогтнохуйн ашиг сонирхол зэрэг нийтлэг зүйлийг шингээсэн. Тиймээс улс, үндэстнийг эвлэлдэн нэгтгэх, нягтруулах оюуны хүчин зүйл болдог байна. Ой санамжийн бүх түвшинд олон улсад түгсэн үг хэллэгээр бол сэдэл

буюу стимуляцийн зүйлүүд чухал үүрэгтэй гэх үндэстэй юм. Эдгээр нь дээр дурдсан амьдрах, оршихуйн бодит хэрэгцээ, шаардлагаас үүдэн гардаг бөгөөд сэтгэл ханамж, таашаал, хөөрөл эсхүл уйтгар гуниг зэрэг сэтгэхүйн төлөв байдалд хамааралтай юм. Тухайлбал улс орны хөгжил дэвшил, амьжиргааны чанарын сайн (эерэг) өөрчлөлт, мөн улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд аюул, заналхийлэл учрах зэрэг нь ой санамжийг өдөөх, хөгжөөх учир шалтгаан болох жишээтэй. Энэ нь иргэд, нийгмийн бүлэг давхарга, үндэстэн, ястны эв нэгдэл, эх оронч үндэсний үзэл хүмүүжил, үндэсний бахархал сэргэн бадрах зэрэг хэлбэрээр илэрдэг байна.

Ой санамж төлөвших, нийгэмших үйл явц нь жам ёсны боловч нийгмийн үзэгдэл болохуйн хувьд удирдлага, жолоодлогод өртөх (удирдлагат) үйл явц юм. Учир нь нийгмийн ухамсар, сэтгэхүйн бүхий л үзэгдэл (таашаал, сэтгэл ханамж, гутрал, жигшил, дургүйцэл, хөөрөл баясал, улмаар хандлага гэх мэт) объектив хүчин зүйлүүдийн нөлөөний үр дагавар хэдий ч мөн тэдгээрийг удирдлага, зохицуулалтын (албадлага, урамшлын гэх мэт) арга хэрэгсэл, тогтолцоогоор тодорхой үр дүнд чиглүүлэн залж удирдах бүрэн боломжтой. Энэ тогтолцоо, удирдлагын арга хэрэгсэлд:

- Төрийн бодлого зохицуулалт (юуны өмнө хууль, эрх зүйн);
- Соён гэгээрүүлэлт, боловсрол, хүмүүжлийн;
- Эдийн засаг, нийгмийн арга хэрэгслүүд байна.

Тухайлбал “Монгол Улсын иргэдэд эх оронч үндэсний үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” гэх мэт.

Бидний судалгааны ажлын нэг зорилго нь Монгол Улсын иргэдийн үндэсний бахархал, ой санамж, үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хөгжүүлэх төрийн бодлого, үйл ажиллагааны онол, арга зүйн үндсийг боловсруулах хэрэг болно.

*Тайлбар: Зигмунд Шломо Фройд (1856-1939) хэмээх Австрийн сэтгэл судлаач, психологич хүний ой санамжийн цаад утгыг тайлбарлах зорилгоор “Ухаангүй”-н хүч чадлын тухай 4 ном бичсэн (1899-1905), хүний “ухаангүй” нь “ухаан”-аа, ухамсарлаагүй нь ухамсарласнаа хэрхэн хянадаг тухай тайлбарлахын тулд гурван хэсэг психийн (сэтгэхүйн) төсөөллийг гарган тавьж, хүний амин сүнс нь: “Доод би”, “Би”, “Дээд би” гэсэн жолоодлогын гурван төвтэй байдаг гэж тайлбарласан. Үүнд: “Доод би” нь хүний сэтгэхүйн (психийн) хөдөлгөх үндсэн элемент болох “ухаангүй” хэмээх ойлголттой дүйдэг. Жишээлбэл, өлсөх, тачаадах, хорсох, үзэн ядах, итгэх, дурлах гэх мэт. Харин “Дээд би”-ээр зарчим, идеал, үүрэг, үлгэр жишээ, ертөнцийг үзэхүй зэрэг боловсрол хүмүүжлээр олж авдаг зүйлсийг илэрхийлжээ. Энэ хоёрын дунд жинхэнэ “Би” орших ба дээрх хоёрынхоо эсрэг үргэлж тэмцсээр ирсэн ядуухан амьтантай зүйрлэжээ .*

*Дэлхийд нэртэй ой санамж судлаач Эрик Рихард Кандел (1929 онд төрсөн), Австри гаралтай, Америкийн мэдрэл судлаач, 2000 оны Нобелийн шагналтан. Тэрбээр “Мэдрэлийн мэдлэгийн салбарын зарчмууд” бүтээлээрээ З.Ш.Фройдын хүний ой санамжийн үзэл санааг хөгжүүлэн хүний ой санамж, дурсамж гэж юу вэ? гэдэг асуултанд хариу өгөхийг зорьжээ. Фройд нарынхаар ой санамжгүйгээр бид (хүмүүс Н.Ж) өөрсдийн намтар ч үгүй, бас ухаарах амьдрал ч үгүй байхсан. Ойлгох гэдэг нь ямар нэг зүйлийг таньдаг*

*(мэддэг) зүйлтэйгээ холбох мэт. Таньдаг зүйлс нь зөвхөн ой санамжид хадгалсан зүйл ажээ.*

Үндэсний ой санамж нь: хүмүүс тэдгээрийн олонлог (улс, үндэстэн ястан, өрх гэр бүл гэх мэт)-ийн намтар, түүх, оршин амьдрахуйн хэв маяг, ёс зүй, ёс суртахуун, үнэт зүйлсийн чиг баримжаа зэргээр илэрдэг байна.

Хүн төрөлхтөний, улс үндэстний түүх, мэдлэгийн сан хөмрөг, үнэт зүйлс ийнхүү ой санамжаар дамжин бүрэлдэн тогтож, үеэс үед уламжлагдан хөгжиж, баяжиж, өргөжин тэлж байдаг ажээ.

Товчоор хэлэхэд үндэсний хэл, соёл иргэншил, түүх, төрт ёс, хууль цааз, ертөнцийг үзэхүй, шашин шүтлэг, аж төрөх арга ухаан зэргээр үеэс үед уламжлагдан хадгалагдах иргэн, төр, нийгмийн аж төрөх, оршин тогтнох, хөгжин дэвших арга ухааныг үндэсний ой санамж гэх үндэстэй байна.

Өөрөөр хэлбэл: Үндэсний хэл, оюуны болон биет соёл (утга зохиол, дүрслэх урлаг, дуу хөгжим, нийгэм, төрийн байгууллага, төр ёс, хууль цааз, ёс зүй, ёс суртахуун, зан заншил, ертөнцийг үзэхүй, шашин шүтлэг, монгол аж төрөх арга ухаан гэх мэт)-ын үеэс үед уламжлагдан залгамжлагдах төр, нийгэм, иргэний хэргийг залж удирдах, хөтлөх арга ухааны үнэт зүйлсийн цогцыг үндэсний ой санамж гэх үндэстэй байна.

Энэ бол улс үндэстний дангаарших болон даяаршихын оюуны зохицол (гармони) нь юм.

*Шигтгээ: Үндэсний ой санамж нь түүхэн тодорхой үзэгдэл гэж үзэж байна. Учир нь түүхэн тодорхой орон зайд (нөхцөлд) объектив болон субъектив хүчин зүйлийн нөлөөн дор үндэсний ой санамж сэргэх, хурцлагдах бас ч бүүдгээрэх магадлалтай юм.*

*Эдүгээ үндэстний ой санамжийг хурцлах эсхүл бүүдгээрүүлэх гол хүчин зүйл нь их, бага улс, үндэстэн, ястан бүрийн нийгмийн амьдралын бүх хүрээг хамран өрнөж буй даяаршлын үйл явц болж байна.*

*Бид даяаршлыг хөрөнгө, капитал, техник, технологи, ажиллах хүчин, оюун ухааны үнэт зүйлсийн хил хязгааргүй урсгал (шилжилт хөдөлгөөн), соёл иргэншлүүдийн харилцан нөлөөлөл гэх утгаар томъёолж, тодорхойлж буйтай санаа нэгтэй байна.*

*Бид даяаршлын үеийн соёл иргэншлүүдийн шүтэлцэл (харилцан нөлөөлөл)ийг:*

- Зэрэгцэн орших (харилцан нөлөөлөл, нэвчин шингэх, уусах үйл явц)*
- Зөрчил тэмцэл, харилцан үгүйсгээлийн үйл явц гэсэн 2 чиг хандлагад нь авч үзэж буй.*

*Соёл иргэншлийн зөрчил тэмцлийн нэг үндэс суурь нь үндэстэн ястны ертөнцийг үзэхүй, шашин шүтлэгийн зөрүү гэх үндэстэй байна.*

*Энэхүү зөрчил тэмцэл нь нөлөөлөл, оршихуйн орон зайн төлөөх өрсөлдөөн, үгүйсгэл үзэн ядалт, дайн, зэвсэгт мөргөлдөөн (хүчирхийлэл) гэсэн хэлбэрээр*



*илэрч байна. Зарим талаар үндэстэн ястны өс хонзонгийн зүйлс зөрчил тэмцлийн нэг эх сурвалж болж буйг ч үгүйсгэхгүй байна.*

*Даяаршил хоёрдмол үр дагавартайг газар газрын эрдэмтэн судлаачид санал нэгтэй тэмдэглэж байна. Үүнд:*

- Хөгжлийг хурдасгах, улс үндэстнүүдийг ойртуулах;*
- Хөгжлийг зөрүүг ихэсгэх, баян, ядуугийн ялгарлыг улс орнуудын хооронд ч (буурай болон ядуу, хөгжсөн, баян, чинээлэг улс орнуудын), тухайн улс орны дотоодод ч хурцлах, нэмэх нигууртай ажээ. Үүнээс гадна бага, буурай улс орнуудын соёл, иргэншлийн оршин тогтнохуйд заналхийлэх, үндэстэн ястны өвөрмөцийг алдагдуулах магадлалтай ажээ.*

Ой санамжийг тээх, уламжлуулах гол хүчин зүйл бол иргэн, төр, нийгмийн үнэт зүйлс юм. (Доктор Б.Хэрлэнгийн судалгаа)

Нийгэмд социал шинэ бүтэц, давхаргажилт бий болж олон зүйл ашиг сонирхол, олон ургалч үзэл дэлгэрч буй зэрэг нь үнэт зүйлсийн хандлага, чиг баримжааг өөрчилж, үнэт зүйлсийн талаар нэг мөр нэгдсэн ойлголтод хүрэх бараг л боломжгүй болгож байгаа.

Гэхдээ улс, үндэстэн, ястан гэх хүмүүний олонлогт нийтээрээ бий болгосон, бүрдүүлсэн, нийтээрээ бахархах, нийтээрээ хүлээн зөвшөөрдөг, оюун санаа, үйлдэл, үйл ажиллагаандаа чиг баримжаагаа болгодог, дагаж мөрддөг, эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйл байна.

Үнэт зүйлс гэдэг ойлголтыг бид үнэлэгч субъектын хувьд объектын (үнэлүүлж буй юмс үзэгдэл гэсэн утгаар нь) нийгмийн, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн ач холбогдол гэсэн утгаар нь тааруулж хэрэглэж буй билээ. Өөрөөр хэлбэл үнэт зүйлс хэмээх философийн болон соёлын ойлголт нь үнэ цэнтэй биет тодорхой юмсыг бус харин абстракт (хийсвэрлэсэн) сэтгэлгээний үүднээс тухайн юмс, үзэгдэл (жишээ нь түүх, бахархал, эх оронч үзэл хүмүүжил гэх мэт)-ийн үнэт чанар, ач холбогдлыг илэрхийлж буй юм.

Тухайлбал нийгэмд, тухайн улс үндэстэнд нийтээрээ хүлээн зөвшөөрдөг, оюун санаа, үйлдэл, үйл ажиллагаандаа дагаж мөрддөг нийтлэг нийгмийн зүйлүүдийг л үнэт зүйлс хэмээн ойлгож болох юм.

*Шигтгээ: Монголын ард түмний үнэт зүйлс:*

- ❖ Мянга мянган жил бүтээгдэн дархлагдсан “хорвоод хосгүй, дахин давтагдашгүй” соёл иргэншил, түүний үндэс нь болсон нүүдлийн мал аж ахуй, Монгол аж төрөх арга ухаан, монгол ахуй, амьдралын хэв маяг;*
- ❖ Монголын ард түмний хүсэл зориг, сонголтын үр дүн нь болох Монгол Улсын нийгмийн байгуулал, Үндсэн хуульт ардчилсан төрийн тогтолцоо, төр улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал;*
- ❖ Монголын ард түмний оюуны их соёл, ой санамж, монголчуудын хэл сэтгэлгээ, утга зохиол, яруу найраг, дуу хөгжим, шинжлэх ухаан, сурган боловсруулах, хүмүүжүүлэх, төлөвшүүлэх арга ухаан гэх мэт;*
- ❖ Монгол Улсын иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөө;*
- ❖ Монгол Улсын иргэдийн эх оронч үндэсний үзэл, хүмүүжил;*

- ❖ *“Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Арван буянт номын цагаан түүх”, “Болор тууль” зэрэг Монголын түүхийн эх сурвалж бичгүүдэд болон дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын хөдөлмөрийн үр дүнд бичигдсэн (бүтээгдсэн) Монголын үнэн бодит түүх;*
- ❖ *Монгол Улсын (Монгол Улсын иргэний) олон улсын нэр хүнд, байр суурь зэргийг хамруулж байгаа болно.*

Нийгмийн шинэчлэлийн явцад үнэт зүйлсийн чиг баримжаа өөрчлөгдөж буй нь зүй тогтолт (жам ёсны) үйл явц гэлтэй.

Учир нь шинэчлэлийн зорилгоос шалтгаалж хүний ухамсар, үйлдлийн сэдэл нь болж байдаг идеал буюу туйлын хүслэн, үзэл санаа, ертөнцийг үзэхүй, төдийгүй аж төрөхүйн хэв маягт өөрчлөлт гардаг. Тухайлбал: Монгол Улсын иргэдийн эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйлсийн цөм нь хуучин цагт (1921 оноос өмнө) бурханы шашин байсан бол цаашдаа, яваандаа нийтээрээ тэгш жаргах эв хамтын нийгмийг байгуулах, нийтийн хамтын хөдөлмөрийн үзэл санаа болж хувирсан билээ.

Гэхдээ л гачигдах, дутагдах юмгүй сэтгэл хангалуун аж төрөх материаллаг ашиг сонирхол (хөрөнгөжих, бэл бинчинтэй байх гэвэл илүү ойлгомжтой биз) хэдийгээр үзэл сурталд хязгаарлагдаж, дарагдсаар авч амьдралынх нь нэг утга учир байсныг огт үгүйсгэх аргагүй бизээ. Монгол хүн өмчлөх эрхтэй болсноос хойш эд материалын анхдагч хэрэгцээгээ (идэж уух, өмсөх зүүх, орон байр, унаа машин гэх мэт) хангах нь амин чухал болсон тул үнэт зүйлсийн чиг баримжаанд өмч хөрөнгөтэй болох, баяжиж, эд мөнгийг эд мөнгийг дээдлэх сэтгэлгээ зонхилох болов гэдэг нь үндэслэлтэй л дүгнэлт байх.

Тэр ч бүү хэл үйлдвэржсэн орны ажиллагсдын хөдөлмөрлөх сэдэл нь эн тэргүүнд материаллаг хэрэгцээгээ хангах хэрэг байдаг бөгөөд зөвхөн үйлдвэржсэний дараах нийгэмд л материаллаг бус сонирхол хүний үйлдэл, үйл ажиллагааны сэдэл болох эхлэл тавигддагийг эрдэмтэд, судлаачид нотолсон байдаг. Бүтээх, туурвих, өөрийгөө илэрхийлэх, өөрийгөө хөгжүүлэх, төгөлдөржүүлэх нь ийм сэдлийн гол агуулга нь болдог ажээ. (Монголын нийгмийн өөрчлөлт.УБ.,2008он.110-111 дэх талд.)

Гэхдээ энэ бол маргаантай дүгнэлт. Хүн төрөлхтөн үйлдвэржээд үйлдвэржээд материал баялгийн хахаж цацсан байдалд хүрч чадах эсэх, бас хүний хэрэгцээ хөгжил, танин мэдэхүйгээ дагаж өөрчлөгдөж байдаг “шунал, хүслийн яндашгүй далай” мэт зэргийг бодолцвол хүний “материаллаг” хэрэгцээ ханаж цадах нь юу л бол. Дээр дурдсанаас дүгнэхэд Үнэт зүйлс бол мөн түүхэн, тодорхой үзэгдэл болох нь тодорхой байна. Тэдгээрт улс, үндэстэн бүрт, түүхийн бүхий л үйл явцад зөвхөн материаллаг чиг баримжааны зүйл зонхилдог гэвэл өрөөсгөл ойлголт болох бизээ.

Аливаа юмс үзэгдэлд “ноён нуруу”, “үндэс суурь” гэж байх, үнэт зүйлсэд ч энэ хамаатай асуудал. Улс үндэснийх нь хөгжил дэвшил, тусгаар тогтнол, аюулгүй байдал, нэр төр энэ бүхэн аль ч улсын шударга иргэн бүрийн сэтгэл зүрхэнд хадаатай (энэхүү ухамсар, мэдрэмж Фройд нарынхаар ухамсарлагдсан сэдэл) үеэс үед уламжлагдан амьдралынх нь утга учир, ноён нуруу, чиг баримжаа нь болдог байна.

Нийгэм-эдийн засгийн хямрал, бэрхшээл, нийгмийн хөгжлийн чиг баримжаа болон аж төрөхүйн зорилго, зорилт (жишээ нь иргэний эрх, эрх чөлөө, нэр хүнд, нийгэмд эзлэх байр сууриных нь баталгаа болсон өмч хөрөнгөтэй болох гэх мэт)-ын чиг баримжаа, хэв маягийн өөрчлөлт, төр засгийн бодлогын нөлөө, нэр хүнд зэрэг

хүчин зүйлээс хамаарч мөнөөх З.Ш.Фройд, нобелийн шагналт Э.Р.Кандел нарын “Хүний амин сүнс”-ийн “Доод би”, “Би”, “Дээд би” гэсэн жолоодлогын гурван төвд өөрчлөлт гарч хүний псих (сэтгэхүйн)-ийн хөдөлгөх үндсэн элемент болох “ухаангүй” нь буюу инстинктийн зүйлүүд даваймгайлах нь ч байдаг ажээ.

Өмч хөрөнгө, эрх мэдэл, албан тушаалд шунахайрах, хээл хахуульд автах, амин хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдөхийн нэгэн “нууц”, учир шалгаанаа эндээс эрэлтэй мэт. Бас чөлөөт зах зээлийн өрсөлдөөн хүний амин хувийн (инстинктийн) ашиг сонирхлыг хурцлах хүчин зүйл мөнийг бодолцох учиртай.

Монгол Улсын иргэдийн хувьд тэдний амьдралынх нь утга учир болсон гэр бүл, орон гэр, өмч хөрөнгө, эрх, эрх чөлөө, шашин шүтлэг, ёс заншил, нэр төр, нийгэмд эзлэх байр нь үнэт зүйл нь мөн гэх судлаачид ч цөөнгүй.

Бидний хийж буй нэг дүгнэлт бол Үндэсний ой санамж нь улс үндэстний үндэсний ухамсрын цөм болохыг (цаад утгаараа) нотлож буй хэрэг юм.

Монгол хүний оюуны ертөнц бол дахин давтагдашгүй өвөрмөц өнгө төрхтэй (хорвоогийн үндэстэн, ястан бүрийн л нэгэн адил) бөгөөд хүн төрөлхтөний оюуны их соёлын нэгэн охь дээжис юм.

Монголчуудын үндэсний ухамсар, ой санамж нь сэргэн мандсан, хорвоод хосгүй, эгэлгүй чанар нь тодорсон цаг үе бол суут богд Чингис хаан, түүний үндэслэн байгуулсан Их Монгол Улсын үе байжээ. Гумилевын хэлснээр тэр бол Монголчуудын дотоод их энергийн (эрчмийн) эрин байжээ.

Тал нутгийн сурвалжитны хөвгүүн Тэмүүжинд Мөнх хөх тэнгэрээс заяасан ухаан бодол, мэргэн ухаан, сүр хүчээрээ “Дэлхийн хамаг хаадын орой нь байж, хүчирхэг хосровчуудын тухай бичигдсэн болгоныг, Фараонууд (Египтийн хааны цол хэргэм), кесариудын (Юлий Цезарийн нэр) тухай он дарааллын бичиг, эртний сурвалж бичгүүдийг судлах гэж зүдрэлгүй өөрийн хар толгойгоороо хууль, дүрэм тогтоон мөрдүүлсэн юм. Улс орнуудыг эзлэн авсан арга, дайсныхаа сүр хүчийг мөхөөдөг чадварын тухайд гэвэл тэр нь түүний төрөлхийн соргог ухаанаараа сайтар бодож, боловсруулдгийн хүч, өргөн дэвшүүлсэн дотно нөхдийнх нь тус байлаа.” (Жувейни “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” номондоо ийнхүү бичиж үлдээжээ.)

Персийн түүхч Рашид-ад-дин Судрын чуулгандаа “Ирээдүйд таван зуу, мянга, арван мянган жилд ч хэрэв нарт хорвоод төрж, хаан төр барих удмынхан минь аль ч улс түмэнд хэрэглэхээр Чингис хааны ёс суртахуун, засаг хуулийг өөрчлөлгүйгээр сахивал тэдний гүрэнд мөнх тэнгэрээс аврал бууж, тэд хэзээ ямагт баяр баясгалантай, аз жаргалтай байх болно. Орчлонгийн ихэс ч тэдэнд хишгээ хүртээж, дэлхийн хүн ам ч тэндээ наминчлан залбирсаар, урт удаан наслан, амьдралын сайн сайхан бүхнээр жаргах болно” хэмээжээ.

Чингис хаан, тэр үеийн Монголын элитүүдийн суу билиг, ном сурах онцгой чадвар авхаалж, ой санамж, сэргэлэн ухаан нь Барууны эрдэмтдийн байнга татаж байдаг ер бусын үзэгдэл болно” гэж Германы эрдэмтэн Удо Б.Баркман бичсэн байдаг.

Ийнхүү Чингис хааны сод ухаан, шударга ёс, өгөөмөр сэтгэл, эр зориг зэрэг ёс суртахууны эрхэм чанар ертөнцийн эгэлгүй удирдагч болгосон бөгөөд зуун зууны туршид түүний зохион байгуулах, удирдан жолоодох мэргэн ухаан, “алд бие минь алжааваас алжаатугай, ахуй төр минь бүү алдраг” алтан сургаал, түүний бодож боловсруулсан хууль цааз нь монгол үндэстэн, монгол төрийн ой санамжийн чиг баримжаа нь болсоор иржээ.

Монголын ард түмний ой санамж, үндэсний ухамсар нь түүхийн өгсөж уруудах их нугачаат замд улс үндэсний бутрал, доройтол, манжийн ноёрхол зэрэг хатуу ширүүн сорилыг туулж гарсан “хатуужиж хатаагдсан” ухамсар болно.

Тухайлбал Монгол хүний амьдралын хэв маяг, ертөнцийг үзэхүй (бурхан шашин, марксизм-ленинизм, интернационализм гэх мэтээр) хэдэнтэй хугарч нугарсан, манжийн ноёрхлын болон хэлмэгдүүлэлтийн жилүүдэд Чингис богдын удам угсааны үндэсний лидерүүд, ноёд дээдэс, үндэсний сэхээтнийг хомроглон устгасан, хэлмэгдүүлсэн зэрэг нь Монголын үндэсний ой санамжид учирсан (тохиосон), нөхөшгүй гарз, хохирол байв. Учир нь сэхээтэн (Чингисийн удмын ноёд бол засаглагчид, төр, цэргийн зүтгэлтэн нар байсан тул удам дамжсан сэхээтэн гэх үндэстэй) нар оюуны соёл, үндэсний тусгаар тогтнол, эх оронч үзэл, ой санамжийг тээгчид, хууль цаазыг бүтээгчид, төр, цэргийг засагчид, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэгчид байдаг.

Чингис богдын удам угсааг хүйс тэмтрэх, үндэсний сэхээтнийг хомроглон устгахын жинхэнэ эзэд нь харийнхан байсан бөгөөд далд цаад санаа зорилго нь Монголчуудын үндэсний ухамсар, бахархал, эв нэгдлийн үзэл санаа, тусгаар оршин тогтнох, хөгжин дэвжих хүсэл эрмэлзэл, чадавхийг нухчин дарах, үгүй ядахдаа л сулруулах хэрэг байжээ.

Үндэсний ой санамж нь тухайн улс, үндэстний ухамсар, сэтгэлгээний онцлог, өвөрмөцөд суурилдагийг бид дахин онцолж байна. Дотоод, гадаадын эрдэмтэн мэргэд (Гумиловынхон, Перс, Хятад, Оросын болон Өрнө дорнын нэртэй бусад судлаачид гэсэн утгаар)-ийн өв санд монгол хүний сэтгэлгээ, ухамсрын сайн, мууг нь ч тэмдэглэн үлдээсэн нь цөөнгүй.

*Шигтгээ. Дундад зууны үеийн монголчуудын тухай тусгайлан нилээд дэлгэрэнгүй дурьдсан нь Плано Карпинийн “Монголчуудын түүх” хэмээх зохиол юм. Тэнд: “Бидний ярьж байсан хүмүүс буюу Татарууд, лам санваартанч, хар хүн ч ялгаагүй дэлхийн бусад газрын хүмүүсээс илүү гэмээр өөр өөрийн эзэндээ үнэнч, тэд нараа хүндлэн биширдэг бөгөөд тэднээс буцан урвах нь бараг үгүй. Тэдний хооронд аман хэрүүл үгүй хэзээ ч зодолдоггүй ажээ. Хоорондоо дайсагнах, зодолдох, нэг нэгнээ алах, эсвэл шархдуулна гэж үгүй. Дээрэмчин ба хулгайч байхгүй учраас үнэт эдлэл байгаа гэр ба тэрэгний хаалга үүд нь хэзээ ч цоожгүй, онгорхой байна. Хэрэв айлын мал нь алга болвол олж харсан хэн ч байсан тэр газраа орхин эсвэл томилогдсон тусгай хүмүүс дээр олсон малыг аваачин тэндээс эзэд нь алдсан малаа сураглаж олж авах боломжтой ажээ. Бие биенээ хүндэлж найрсаг байх ба ... нэг нэгэндээ атаархах зан байхгүй, тэдний хооронд түүхийн маргаан бараг байхгүй. Бие биенээ жигшиж, зэвүүцэхгүй, харин ч ядарч байгаа нэгэндээ тусалж, чадах ядахаараа дэмжинэ”<sup>34</sup>. Иймэрхүү утга агуулгатай ишлэлүүдийг XII ба XIII зууны үеийн монголчуудын тухай бичсэн гадаадынхны ном зохиол, замын тэмдэглэлүүдээс олныг үзэж болно. Мэдээж алс холоос мэдэхгүй газар, танихгүй хүмүүстэй уулзсан аянчин, гийчид, монголчуудыг өөлж, муулж бичсэн зүйл бас байлгүй яахав. Гэвч ерөнхийдөө тэр үеийн монгол хүний зан, чанарыг ихэвчлэн сайнаар үнэлсэн байдаг.*

<sup>34</sup> Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 2006. 25 дахь талд.

*Монгол хүний тухай гадаадынхны ойлголт XVIII ба XIX зуун хийгээд ялангуяа XX зууны үед нилээд өөрчлөгдсөн, ерөнхийдөө мөхөж, сөнөж байгаа үндэстний төлөөлөгчид, ядуу зүдүү амьдралтай бөгөөд нэн бүдүүлэг, соёлгүй, бас иргэншээгүй гэж үзэх нь даваймгайлах болсон байдаг.*

*Бараг хоёр зуугаад жил манж гүрний зах хязгаар нутаг байсан Монголчууд, ялангуяа их говиос арагшаа орших ар ба ойрод Монгол хийгээд ар халхууд XX зууны эхэн болж ирэхэд тэр цагийн дэлхий нийтийн хөгжлөөс мэдээдэм, хоцрогдож, ядуу зүдүү амьдрал, аж ахуйтай болсон нь үнэнтэй. Энэ талаар хамгийн тодорхой өгүүлсэн судалгааны бүтээлүүдийн нэг болох ЗХУ-ын эрдэмтэн, академич И.Майскийн “Орчин үеийн монгол” бүтээлийг үзэхэд тодорхой. Зохиолч өөрийн бүтээлд XIX зууны эцэс, XX зууны тэргүүн хагаст монгол хүний бие бялдар, зан төрх, ёс суртахууныг нягтлан судалжээ. Тэнд бичсэн нь “Монголчууд ... зан төрх назгай, ... залхуурах, зүгээр суух хоёр дээр нь Монгол хүн ажил хийх дургүй, ... Хэрэв та монгол хүнтэй баасан гаригт тэмээн хөсөг хөдөлгөхөөр тохиролцсон бол тэр хөсгийг миний нөхөр нямд юм уу ирэх даваа гаригт л авч ирнэ гэж маш итгэлтэй найдаж болно. Та ... хожигдлоо гэвэл ... яарах юу байх вэ?, жилд өдөр мундсан биш, яарвал даарнаа хө ... гэнэ.”<sup>35</sup>*

Монгол хүн “халуун цустай”, хувирамтгай, цочмог түргэн зантай, эрх дураараа бас “залхуу”, аминчхан гэх мэтээр бичсэн, дурдсан ч бий. Гэхдээ л тал нутгийн эрэлхэг, дайчин, эрэмгий нүүдэлчдийг ухамсар, зан авирын сайн сайхан нь давамгайлж, өөд нь татаж хүн төрөлхтөн хэмээх цэцгийн мандлын нэгэн сор нь болгосоор иржээ. Монгол хүний ухамсар, үндэсний ой санамж ийнхүү хэдэнтээ “хугарах нугарах” эрсдэлтэй тулгарсан ч үндэсний хэмээх онцгой шинж чанар нь өвөрмөцөө гээлгүй зах зээлийн нийгэмтэй золгов.

*Шигтгээ: Монголчуудын ухамсар сэтгэлгээний эдгээр онцлогийг хураангуйгаар илэрхийлбэл:*

- *Монгол хүний “унасан газар, угаасан усан”-даа татагдах, хайрлан хамгаалах, сүсэглэн бишрэх өвөрмөц ухамсар сэтгэлгээ;*
- *Монгол хүний эрх чөлөөг эрхэмлэгч сэтгэлгээ. Уудам хээр нутагтаа өвсний сор, усны тунгалагыг даган эрх дураараа нүүдэллэгч Монгол хүн бусдын боол болсноос баатрын ёсоор үхсэн нь дээр гэж сэтгэдэг нэгэн ажгуу (хөдөөгийн Пэрлээ абугай);*
- *Монгол хүний эе эвээ хичээгч сэтгэлгээ. Алангуа эхийн домог, “Цувж явсан барнаас цуглаж суусан шаазгай дээр”;*
- *Монгол хүний бие сэтгэлгээний зориг, тэвчээр, тэсвэр хатуужил, дасан зохицох чадвар. Төв Азийн өндөрлөг, чулуурхаг хөрс, эрс тэс хатуу ширүүн уур амьсгал Монгол хүний эрэмгий дайчин чанар, эр зориг, тэсвэр хатуужлыг нөхцөлдүүлсэн гэх үндэстэй;*

<sup>35</sup> Ч.Майский.Орчин үеийн Монгол /Автонит Монгол XX зууны засаг дээр/.УБ.,2001он.46-49 дэх талд.

- *Монгол чин шударга зан чанар, хүний эцэг дээдэс, төр, хууль цааз, сахилга дэг журмыг эрхэмлэн сахин, хүндлэн дээдлэх ухамсар сэтгэлгээ, зан заншил;*
- *Монгол хүний зовж зүдэрсэн нэгэндээ туслах, дэмжих элгэмсэг, энэрэнгүй сэтгэлгээ;*
- *Зарим эрдэмтэн судлаачид (О.Пүрэв, Р.Содномцэрэн гэх мэт) Монгол хүний эрдэнэт мал сүргээ (5 хошуу малаа) хайрлан хамгаалах, өсгөн үржүүлэх, ашиглах арга ухааныг бусад улс үндэстнийхээс илүү өвөрмөц, онцлог бүр заримдаа “хүмүүнчлэн хайрлах”-тай зүйрлэн тэмдэглэсэн нь бий<sup>36</sup>.*

Монгол хүний эдгээр болон бусад эрхэм нандин зан чанар, ухамсар сэтгэлгээний үнэт зүйлс нь Монголын гал голомт, Монгол Улс хэмээх туурга тусгаар өрх айл түүхийн өгсөж уруудах их нугачаат замын хатуу ширүүн сорилтыг туулж ашид мөнх оршихуйн оюуны дархлаа нь болж иржээ. Тэгэхлээр ухамсар, сэтгэлгээний эрхэм чанарууд нь улс үндэстний оршин тогтнох, хөгжин дэвжихийнх нь оюуны амьд хэлхээс, аргамж холбоог бүрдүүлдэг байна.

Эрдэмтэн судлаачдын зохиол, бүтээлээс үзэхэд үндэсний ой санамж хэрэгжих /төлөвших, хадгалагдах, тээгдэх, уламжлагдах гэсэн утгаар/ хүрээг дараахаар тодорхойлж болох байна. Үүнд:

- Монгол Улсын төр, түүний байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагаа (төрийн ой санамж);
  - Иргэн, иргэний нийгэм, түүний байгууллага, нийгмийн үндэс болсон өрх, гэр бүлийн орчин (нийгмийн ой санамж).
1. Өрх, гэр бүлд иргэн өсч бойжин, нийгмийн гишүүн, төр улсын иргэн болох үндэс тавигдана;
  2. Чухамдаа нийгэмд хүмүүний ой ухааны хамаг олдмол зүйлүүд болох боловсрол, хүмүүжил төлөвшинө. Хүн хүссэн хүсээгүй нийгмийн хөдөлмөрийн хуваарьт татагдан орж амьдралын арга ухаан, ертөнцийг үзэхүй, итгэл үнэмшил, хандлага, зарчим нь, улмаар нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндээ олж авна.
  3. Төр бол ой санамж хадгалагдах, үйлчлэх, уламжлагдах гол хүрээ нь гэж үзнэ. Чухамдаа төр, түүний байгууллага, албан тушаалтан нар улс үндэснийхээ язгуур, нийтлэг эрх ашигт хэр үнэнч байна, үндэсний төр ёсны уламжлалыг сахиж буй эсэх, үүрэг хариуцлагын уялдаа холбоо, ялангуяа төр ёсны үнэт зүйл бий эсэх, хэр уламжлагдаж сахигдаж буй эсэх зэрэг улс үндэсний оршихуй, хөгжлийн нэг амин асуудал болдог байна.

Төрийн бодлого нь улс орны нийт иргэн (хүн ам)-ий дийлэнхийн язгуур ашиг сонирхол, хүсэл эрмэлзлийг агуулж ард түмнийхээ санаа бодлыг илэрхийлж байдаг. Төр нь байнга, тогтмол үйл ажиллагаа явуулдаг институт учраас бодлого, үйл ажиллагаа нь уламжлал, залгамж чанар, дэг ёс (төр ёс), үнэт зүйлс, үндэсний үзэл санаа (үзэл баримтлалд) суурилж байдаг.

<sup>36</sup> О.Пүрэв (Sc.D), профессор; Р.Содномцэрэн (Ph.D). Монгол эх оронч үзэл амин чанарыг боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах, үнэлэх асуудал: Өнөөгийн нийгмийн хөгжилд хүний оюун санааны хүчин зүйлийн гүйцэтгэх үүрэг.УБ.,2017он.49-59 дэх талд.

Монгол Улсын төрийн бодлогын үнэт зүйлс:

1. Эв нэгдлийн үзэл санаа. (Алангуа эхийн домог);
2. Тусгаар тогтнолын үзэл санаа;
3. Хууль дээдлэх ёс;
4. Шударга ёс;
5. Холч, голч шинж чанар буюу “Их малгайн бараа харах ёс”.

Монгол Улсын төрийн бодлогын үнэт зүйлс:

1. Эв нэгдлийн үзэл санаа. (Алангуа эхийн домог)

Чингис Богд:

“Бие бөх болбоос ганцыг яльюу  
Эе бөх болбоос олныг яльюу”

Жувейни:

Чингис хаан хөвгүүд, дүү нартаа ямагт эв найртай байж, бие биедээ тус дэм өгч, эв эеэ бэхжүүлэхийг чармайх хэрэгтэй гэж үргэлж, захиж сурган, яавал эвтэй байж болдог үлгэр жишээг таниулдаг байлаа. Сургаал, үлгэр домог (жишээ нь, Алангуа эхийн домог Н.Ж) ярьж... “Та нар багцалсан сум мэт байх ёстой...Ганц хоёроороо бол амархан хугарах сум, ийм олон болбол хэнд ч дийлдэхгүй...Тийм учраас та нар бие биеэ дэмжин эв найрамдалтай байх юм бол дайсан хэдий хүчирхэг ч гэсэн та нарыг ялж дийлэхгүй...” гэх мэтээр сургадаг байсныг “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” хэмээх бүтээлдээ тэмдэглэн үлдээжээ.

Төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл баримтлалын нэгэн үндэслэгч Францын философич Ш.Луй Монтесьеке 1748 онд “Хуулийн амин сүнс”-дээ Монголчуудыг “эвсэг” хэмээн бичжээ<sup>37</sup>.

2. Тусгаар тогтнолын үзэл санаа

Монгол Улсын тусгаар тогтнол, монголын ард түмэн, төрийн үнэт зүйлсийн охь манлай дээжис нь мөн. Бид төр, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын үнэ цэнэ ач холбогдлыг сайн мэднэ. Энэ бол Монголын ард түмэн, төр засаг гадны хэний ч дарамт, шахалтгүйгээр дотоод, гадаад бодлогоо тодорхойлж хэрэгжүүлэх үндэсний хийгээд олон улсын эрх зүйгээр баталгаажсан эрх дарх билээ. Тусгаар тогтнолын эрх ашигт нийцүүлэн төрийн хэрэгт зүтгэхийн учрыг Богд Чингис хаан:

“Алд бие мину алжааваас алжаатугай  
Ахуй төр мину бүү алдартугай  
Бүтэн бие мину зовбоос зовтугай  
Бүрэн улс мину бүү самартугай” хэмээн сургажээ<sup>38</sup>.

3. Хууль дээдлэх ёс

Б.Чимид:

Хууль дээдлэх ёсон засаг төр барих урлаг, хүн зон амар жимэр амьдрахуйн арга юм. “Чингис хааны од гялалзаж тэр хүмүүс тушаал, зарлигийг дагах болсноор хатуу тогтоосон засаг ёсын (хууль ёсны Н.Ж) тусламжаар тэрээр хүмүүсийг удирдан захирах болов” гэснийг санахад илүүдэхгүй. Чингисийн билиг сургаалд “хатуу чанд, яв цав байдалтай бол хамаг улс бат бэх болой”<sup>39</sup>.

<sup>37</sup> Ш.Л.Монтесьеке.Хуулийн амин сүн.Тэргүүн дэвтэр.Монсудар.УБ.,2008он.313 дахь тал.

<sup>38</sup> Д.Лүндээжанцангийн энэхүү номонд байгаа “Тусгаар тогтнол-улс, үндэстний үнэт зүйлсийн охь дээжис мөн” өгүүллэгийг үзнэ үү. Номын 171-195 дахь талд.

<sup>39</sup> Эрэнджен Хара-Диван. Чингис хаан түүний үлдээсэн өв. УБ.,2003.Мон судар.15 дахь тал. Б.Чимэд. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс.УБ.,2006.150 дахь талд.

#### 4. Шударга ёс

Академич С.Нарангэрэл: Ёс суртахууны нандин чанарын тэргүүн зэрэгт шударга ёс тавигдсаар ирсэн. Түүнийг хоёр дугаар зэрэгт тавьбал яах бол?

Шударга бус явдал газар авна. Хэн шударга бусыг бусдаас ичгүүр сонжуургүйгээр үйлдэнэ. Тэр нийгэм төрд тэргүүлэх байр суурийг эзэлбэл улс гүрэн ямар болдог билээ.

Эрээ цээргүй нь хойморт заларч, чадалтай нь хатавчинд суудаг... “Шударга ёсыг Монгол гэрийн тоонотой адилтгаж болно. Тооногүй гэр Монгол гэр болж чадахгүйтэй адил аливаа хүнд авъяас мэдлэг байгаад ч шулуун шударга, ариун явахгүй бол хүний мөс чанараа алдана. Шударга ёс алдагдвал улс орон ч өөдлөн дэвжихгүй. Чингис хаан шударга удирдлага бүхий засаг төрийг цогцлоосон. Энэ тухай алдарт аялагч Марко Поло “Чингис хааны засаглал шулуун шударга, хүн ардаа энэрэнгүйг үзсэн бусад орны хүн ард түүнтэй өөрсдөө ирж нийлэн нэгдсээр байв” гэсэн гярхай ажиглалт хийжээ<sup>40</sup>.

Хуулиа дээдэлдэг, төр улсын хэргийг хуулиар, шударга ёсонд нийцүүлэн засан тохинуулдаг нь Монголын төр ёсны олон зууны түүхэн уламжлал, төрийн үнэт зүйл, төрийн ой санамжийн чухал эх сурвалж, ноён нуруу нь юм.

Чингис Богд Хархорумыг Улсын нийслэл, худам монгол бичгийг төрийн бичиг болгож, “Их засаг” хэмээх төрийн гол хуулийг дагаж, мөрдөхийг зарлигдан Их хуралдай, Сэцдийн зөвлөлөөр төр улсын их хэргийг хэлэлцүүлж, төрийн нуруу төвшин, чин шударга байхын үндсийг тавьжээ.

Их засаг хууль нь Монгол төрийн хууль цаазын гол эх сурвалж, ой санамж, үнэт зүйлсийн чухал эх сурвалж ажгуу. (Д.Лүндээжанцан) Учир нь “Их засаг”-зөвхөн тэнгэрт тэтгэгдсэн ихэс дээдсийн ашиг сонирхолд төдийгүй, эзэнь гүрний нийт албат, иргэдийн эе эвийг хичээх, шударгыг хүсэмжлэх сэтгэлгээ, ёс заншилд тулгуурласан жинхэнэ жам ёсны хууль байсан юм.

Хуулийг тогтоож батлахаас гадна ягштал даган мөрдүүлж, улс гүрэн даяараа эе эв, энх амгалан, шударга ёсыг тогтоож чадсан “Шулуун шударга, чадал эрдэмтэй, цэцэн ухаантай хэнийг ч байсан итгэл өгч төрийн хэргийг тушааж, улсыг засахад зүтгүүлэх нь “Бадрах төрийн бат оршихуйн нэг үндэс болдог” тухай, мөн “Өглөө хэлснээ үдэш нь, үдэш хэлснээ өглөө нь няцагч туйлбаргүй зантан, бусдыг бүү хэл өөрийгөө захирч эс чадагч ичгүүргүй явдалтан, эд хөрөнгө, эрх мэдэлд ташаарагч шунахай, зальхай, харгис, журамгүй хэнд ч болов төрийн хэрэг бүү даалга” гэсэн Их засгийн үзэл санаа, Богдын зарлиг эдүгээ төрийн хэрэгт ус, агаар лугаа чухал, сургамжтай юм. Шударга ёсны энэ сургаал, сургамж Монгол үндэстэн, Монгол төрийн ой санамжийн чөмөг, ноён нуруу нь болон уламжлагдах учиртай ажгуу.

#### 5. Холч, голч шинж чанар буюу “Их малгайн бараа харах ёс”

Энэ нь улс үндэснийхээ язгуур эрх ашигт нөлөөлөх дотоод, гадаад хүчин зүйлийг тунгаан бодож, хийг гаргаж бясалгасан “үүдэн бий болсон (болох Н.Ж) асуудлыг (үр дагаврыг Н.Ж) даамай эргэцүүлэн сэтгэж, давхар ухамсарлан бодож алсыг харсан төрийн холч (тогтвортой), голч бодлого (оновчтой Н.Ж), бодлого шийдвэр гаргах” арга ухаан юм<sup>41</sup>.

<sup>40</sup> С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шаштир.УБ.,2014 он. 31 дэх тал.

<sup>41</sup> А.Хишигдаваа.ШУА.Философи, социологи эрхийн хүрээлэн. Монгол төрийн бодлогын үнэт зүйлсийн уламжлал, хэрэгжилт. Философи эрх зүйн судлал.ХХII боть.225-232 дахь тал.



Энэ бүхнээс үзэхэд иргэн нь нийгэм, төр засаг, гэр бүлдээ хүлээсэн үүрэгтээ үнэнч байх, өөрөөр хэлбэл төр нь төр шиг байж улс үндэснийхээ нийтлэг эрх ашгийг эрхэмлэн ард олныхоо сэтгэлийг таньж өршөөл нигүүлсэнгүй хандах нь үндэснийхээ ой санамжаа хадгалагдах нэн чухал нөхцөл болой.

Д.Сүхбаатар “Ардын эрхт хэмжээт цаазат засаг байгууламж нь дээдэс хэмээн доодсыг учиргүйгээр эзэрхэн дарлах ба доодос нь мөн түүний эрх сүрд дарагдаж, зовон зүдрэх зэргийн эзэрхэг ёсыг халж, ард олонд эрх чөлөө олгон амгалан тохинуулахын учир болой”<sup>42</sup>.

Иргэн нь нийгэм, төр, ард түмний өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа гүнээ ухамсарласан байх, тэр нь аливаа үйлдэл, үйл ажиллагааныхан дотоод сэдэл нь болох нь нийгэм оршин тогтнох, хөгжин боловсрох чухал нөхцөл нь болдог ажгуу.

*Академич С.Нарангэрэл “Үүрэг (Тэрбээр ёс суртахууны үүргийг журамт үүрэг хэмээжээ.) бол аливаа хүмүүний хийх ёстой үйлдэл мөн. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, эх эцгээ энэрч асрах, хөдөлмөрлөх, хууль, дэг журам биелүүлэх, татвар төлөх, эх орон, байгаль орчноо хамгаалах гэх зэрэг үйлдлийг зохих ёсоор хэрэгжүүлэхэд үүргийн агуулга оршино” гэж тодорхойлжээ*<sup>43</sup>.

*Хариуцлага нь тухайн хүмүүн нийгэм, төр, түмэн олныхоо өмнө хүлээсэн үүргээ чин шударгаар биелүүлсний (эс биелүүлсний) төлөө сэтгэл санаа (оюуны), эд материалын хувьд авах таашаал, урамшуулал, нийгэм, төр, бусад иргэдээс хүртэх үнэлэмж (магтаал, сайшаал, шан харамж, ял зэмлэл гэх мэт)-ийг багтаадаг. Өөрөөр хэлбэл хариуцлага нь хууль тогтоомж (Жишээ нь, төрийн алба хаагч-иргэн хуулиар зарлиг, тушаал, дүрэм журмаар зохицуулагдсан үүргээ биелүүлсэн /эс биелүүлсний/ )-ий нь бодит үр дүн /өр төлөөс/ нь гэх үндэстэй байна.*

Монгол Улсын Үндсэн хуулинд (Арван долдугаар зүйл) иргэний үүргийг:

1. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:
  - 1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;
  - 2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
  - 3/ хуулиар ногдуулсан албан татвар төлөх;
  - 4/ эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.
2. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэж тодорхойлжээ.

Судалгааны багийн зарим судлаачид (доктор Ч.Сосорбарам нар) үндэсний ой санамж илрэх (үйлчлэх) нэг хэлбэр бол нийгмийн ой санамж гэж үзэж байгаа болно.

Бидний үзэж буйгаар нийгмийн ой санамж үйлчлэх хүрээ нь гэр бүл, иргэний нийгэм бүхэлдээ гэх үндэстэй байна.

<sup>42</sup> Философи эрх зүйн судлал.ХХII боть.229 дэх тал.Дам ишлэв.

<sup>43</sup> С.Нарангэрэл.Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шаштир.УБ.,2014 он.49 дэх тал.

Нийгэм, гэр бүлийн үйлчлэлийн нөлөөн дор хүний ертөнцийг үзэхүй, үзэл бодол, ашиг сонирхол, ерөөс хүний мөс, ноён нурууны үндэс бүрдэнэ. Нийгмийн хөдөлмөрийн хуваарийн дагуу хүн боловсрол, мэргэжил эзэмшин нийгэмшин амьдрахуйн утга учир, нийгмийн ёс зүй, ёс суртахууныг ухааран нийгэм, нийгэм, хүмүүний хамтлаг (олонлог) болон хүрээлэн буй бодит байдалд хандлага нь тодорч нийгмийн гишүүн болон төлөвшинө. Өөрөөр хэлбэл хүн нийгэмд хүмүүжинэ, боловсорно, төлөвшинө.

Нийгэмд хүмүүсийн төрөл бүрийн бүлэг давхарга (үндэс угсааны, ажил мэргэжлийн, нас хүйсний, ашиг сонирхлын гэх мэт) үүсч тэдгээрийн үзэл бодол, ертөнцийг үзэхүй, нийгмийн хөдөлмөрийн хуваарийн (ажил мэргэжлийн) нийтлэг зүйлүүд: үзэл бодол, чиг хандлага, сүсэг бишрэл, ашиг сонирхол, улмаар байгалийн ой санамжийн нийгэмшлийн бодит үр дүн болох үндэсний ой санамж төлөвшинө.

Олонх эрдэмтэн, судлаачид нийгмийн ой санамжийг тухайн олонлогийн (түүний дотор үндэстэн, ястан, улс орны /төр улсын гэвэл арай оновчтой томъёолол болох биз/) түүх, соёл иргэншил, үнэт зүйлс, туршлага, сургамжтай холбон судалдаг байна. Тухайн улс, үндэстний түүх, соёлын зүйлүүд: утга зохиол, дуу хуур, барилга, архитектур нь үндэсний ой санамжийн бодит тусгал нь ажээ.

Үүний зэрэгцээ үндэсний оюун санааны үнэт зүйлс, чиг баримжаа нь болж байдаг үндэсний ухамсар, сэтгэлгээ, түүний өвөрмөц онцлог нь үндэсний ой санамжийн ёстой чөмөг нь болдог байна. Энэ бүхнээс үзэхэд нийгмийн ой санамж нь тухайн улс үндэстэн, хүмүүний хамтлагийн түүх, туршлага, сургамж, соёлын цогц тусгал гэх үндэстэй байна.

### 1.3. Үнэт зүйлс нөлөөлөгч хүчин зүйлс

Үнэт зүйлийн тухай ерөнхий ойлголт

Үнэт зүйлийг философи, социологи, антропологи, психологи, аксиологи, соёл судлал, ёс зүй зэрэг нийгэм, хүмүүнлэгийн ухаанууд өөр өөрийн судлах зүйлийн онцлогтой холбоотойгоор авч үзсэн байдаг.

Тухайлбал, сонгодог философи болон үнэт зүйлийг судалдаг шинжлэх ухаан буюу аксиологийн онолд субъектээс объектод хандсан харилцаа түүнээс үүдэж үүссэн хэм хэмжээт үйлийн цогцыг үнэт зүйл гэж үздэг. Энэ нь хүмүүний мэдрэмж, хэрэгцээнд тулгуурласан амьдралыг чиглүүлэх, идэвхжүүлэх, утга төгөлдөр болгож хөтлөх хүч мөн бөгөөд энэ нь үнэт зүйл юм.<sup>44</sup>

Социологийн шинжлэх ухаанд үнэт зүйл гэдэг бол 1. Нийгмийн субъект (хувь хүн, нийгмийн бүлэг, нийгэм бүхэлдээ)-д төлөвшиж тогтсон эрхэмлэн хүндэтгэдэг үзэл бодол, итгэл үнэмшлийн цогц, 2. Бодит үйл явдлыг үнэлж цэгнэх шалгуур, 3. Амьдрал, үйл ажиллагааны утга учрыг тодорхойлох хүчин зүйл, 4. Нийгмийн харилцан үйлчлэлийн зохицуулагч<sup>45</sup>, ёс зүйд хэвшүүлэх хэм хэмжээ, мөрдөх учиртай нийтлэг жишиг гэж үзэх, сэтгэл зүйд хүмүүсийн итгэл үнэмшил, мотивацын зорилго, эрмэлзэл гэж үзэх, соёл судлалд соёлуудын хэв шинжийг тодорхойлогч хүчин зүйлсийн нэг гэж үзэх хандлага давамгайлж байдаг.<sup>46</sup>

Үнэт зүйлс гэдэг ойлголтыг бид үнэлэгч субъектийн хувьд объектын (үнэлүүлж буй юмс үзэгдэл гэсэн утгаар нь) нийгмийн, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн ач холбогдол гэсэн утгаар нь тааруулж хэрэглэж буй билээ. Өөрөөр хэлбэл, үнэт зүйлс хэмээх философийн болон соёлын ойлголт нь үнэ цэнтэй биет тодорхой юмсыг бус харин абстракт (хийсвэрлэсэн) сэтгэлгээний үүднээс тухайн юмс, үзэгдэл (жишээ нь түүх, бахархал, эх оронч үзэл хүмүүжил гэх мэт)-ийн үнэт чанар, ач холбогдлыг илэрхийлж буй юм.<sup>47</sup>

Аливаа үндэстний үнэт зүйл нийгмийн хөгжлийн түүхэн урт удаан хугацааны туршид тухайн улс үндэстний онцлог, туулж өнгөрүүлсэн түүх, ой санамж, оршин амьдарч буй газар нутаг, байгаль цаг агаарын нөхцөл зэрэгт тулгуурлан үүсэх аж. Иймд үндэстний үнэт зүйлс нь тухайн үндэстний санаа бодол, итгэл үнэмшил, үйлдэл, хүсэл, зорилго, тэмүүллийн илэрхийлэл байдаг учраас тэдний хөгжил дэвшилд болон ирээдүйг бүтээхэд нь тусалдаг.

Үнэт зүйл гэдэг бол хүмүүсийн ойлголт, хандлага, зан үйлд нөлөө үзүүлж байдаг хүсэмжит төлөв байдлын талаарх концепц буюу үзэл баримтлал юм. "...хувь хүний болоод нийгмийн хувьд хүсүүштэй амьдралын хүсэл зорилго, зан үйлийн талаарх харьцангуй тогтвортой итгэл үнэмшил"<sup>48</sup>.

Эрхэмлэх зүйл (эрхэмлэл). Хүмүүс их төлөв нийтээр зөвшөөрдөг, үйл хөдлөлдөө дагаж мөрддөг нийтлэг жишгүүд байдаг бөгөөд чухам тэдгээрийг үнэт зүйлс буюу эрхэмлэх зүйлс гэнэ. Эрхэмлэх дээдлэх ёс гэдэг үг хүмүүс зан үйлдээ удирдлага

<sup>44</sup> "Монголчуудын үнэт зүйл" СУИС-ийн судалгааны тайлан. УБ., 2019 он, 33-р тал

<sup>45</sup> "Монголчуудын үнэт зүйл" СУИС-ийн судалгааны тайлан. УБ., 2019 он, 13-р тал

<sup>46</sup> Монголчуудын үнэт зүйлсийг Шварцын аргачлалаар тодорхойлсон нь. Удирдлагын академи. УБ., 2017 он, 11-р тал

<sup>47</sup> Ч.Сосорбарам., Н.Жалбажав "Үндэсний ой санамж ба монголын хууль, эрх зүйн уламжлал" -"Эрх зүйн шинэтгэл ба Монгол улсын хөгжил" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2021 он, 118-133-р тал

<sup>48</sup> Rokeach, Milton. 1973. p.5

болгодог эрхэм дээд үзэл санаа (туйлын зорилго, чин хүслэн), итгэл үнэмшил, тогтсон жишгүүд байдгийг зааж байна <sup>49</sup> гэх мэтээр гадаад, дотоодын судлаачид тодорхойлсон нь бий.

Үндэсний үнэт зүйл нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд оюун санааны дархлааны үүрэг гүйцэтгэж байх учир түүнийг зөв тодорхойлж, олон нийт ялангуяа хүүхэд залуучуудыг чиг баримжаагаа олох арга замд нь чиглүүлэг болох чухал шаардлага тулгарч байна.

### Хууль эрх зүйн орчин

Монгол Улс 1990 оноос хойш үндэсний язгуур ашиг сонирхол (эрх ашиг) гэх ойлголтыг үндсэн хууль, холбогдох үзэл баримтлалуудад тусгах болсон. Энэ талаар төрийн бодлого, үйл ажиллагаанд хэрхэн туссаныг авч үзье.

Монгол Улсын “Үндсэн хууль”-ийн: Нэг. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд:

1.1.2. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

1.1.4. Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн.

1.1.6. Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.

1.2.1. “Эх оронч үндэсний үзлийг дээдлэх” гэж тодруулсан байдаг.

3.3.3.2. Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ.

Мэдээллийн аюулгүй байдал бүлгийн 6.1.1.-д Үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орны хөгжлийг дэмжих, үндэсний үнэт зүйлийг хэвшүүлэх, нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдал нэн чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хуульд:

3 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт

3.2. “Үндэсний язгуур ашиг сонирхол”-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

Эдгээр хууль, үзэл баримтлалд үндсэн зарчим (Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх), язгуур ашиг сонирхол (тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө

<sup>49</sup> Б.Сайнхишиг “Монголын нийгмийн өөрчлөлт” 2013 он

баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил), амин чухал дархлаа (үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх) гэх мэт үгээр тунхагласан бөгөөд эдгээр зарчим, язгуур ашиг сонирхол, амин чухал дархлааны агуулга нь эрхэмлэх зүйл, үнэт зүйл гэх ухагдахуунтай шууд холбоотой гэж ойлгож болно.

“Алсын хараа-2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал»-д Монголын үндэсний үнэт зүйлсийг “Хүн ёс, хүн чанар, хууль ёс, мэдлэг боловсрол, ёс суртахуун, тэгш байдал, шударга ёс, эрх чөлөө, эв эе, эрдэм, эв дүй, иргэдийн оролцоо, нийтэд ил тод байх, эрхэмлэх шүтээн, бишрэл, итгэл үнэмшил, эрүүл мэнд, хариуцлагатай байдал, бүтээлч чанар, өөртөө итгэлтэй байдал зэрэг хувь хүний болон нийгмийн үнэт зүйлсийг олноор дурдаж болох боловч тусгаар тогтнол бүхий ЭХ ОРОН, газар нутаг, тэнд оршин суугч МОНГОЛ ХҮН, үндэстний дахин давтагдашгүй шинж чанарыг хадгалах НҮҮДЛИЙН АХУЙ түүнээс урган гарсан ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛ, УРЛАГИЙН БҮТЭЭЛ, орчин үетэй хөл нийлүүлэн хөгжих УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨГС ЗОХИЦОЛ-гүйгээр дээрх бүгд ухвар мөчид болох юм. Нөгөөтээгүүр хувь хүний болон нийгмийн түвшний үнэт зүйлс нь үндэсний онцлогтой нягт уялдаж, эх орны эрх ашиг, монгол хүний онцлог, нүүдлийн ахуй, түүх, соёл, урлагийн бүтээлдээ уламжлал, шинэчлэлийн тэнцвэрт харьцаанд шингэн сүлэлдэж ҮНДЭСНИЙ ИЖИЛСЭЛ-ийг бүтээх учиртай” гэж тодорхойлжээ<sup>50</sup>. Үүнд:

Эдгээр тодорхойлолтууд судлаачдын байр суурьтай адилхан боловч эдгээрийг нарийвчлах, илүү тодорхой болгох шаардлага байгаа нь харагдаж байна.

Үнэт зүйлсийн хувьсал өөрчлөлт

Түүх сөхвөл, Эзэн Чингис хаан “Мөнх тэнгэрийн хүчин доор” уриа, үзлээр дэлхийг эзэгнэх, улс орныхоо аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагааг эхлүүлж, амжилттай хэрэгжүүлж, түүний билиг сургаалд үндэслэсэн “Их засаг” хуулийг дээдэлдэг, өндөр ёс суртахуунтай ард түмэн бий болгож байсан бол түүнийг залгамжилсан дараагийн хаад удирдагчид Богд эзэн Чингис хааны үйл хэрэг, сургаал хуулийг үргэлжлүүлэх зорилготой төрийн бодлогоор иргэдээ манлайлан удирдаж иржээ.

Хубилай хааны үеэс “Их засаг” хуулийг хүн амын олонх (төр барьж буй монголчуудаас хэдэн зуу дахин олон) болсон суурин иргэдийн хуультай нэгтгэн боловсруулж хэрэглэх болсон. Энэ нь Юань гүрний төрт ёсонд “Мөнх тэнгэрийн хүчин дор” гэх үү Күнзийг дагах уу гэх үл ойлгогдох байдал үүсэж, хаан төрийн залгамжлал ордны олон үндэстний нолд, хатад, тайган нарын элдэв хуйвалдаанаар тодорхойлогдох болсноор монголчуудын хүч суларч Бээжин хот төдийгүй өөрсдийн бий болгосон Шанду хотоос ч хөөгдөн тал нутагтаа буцаж ирсэн билээ.

Феодалын бутрал ч гэдэг газар тариалангийн нийгмийн харилцаа задрах болсон дундад зууны үед монголын нүүдэлчин ахуйд суурин иргэншилд зохицуулсан төрийн хууль, журам үйлчлэхээ байж, шинэчлэх боломжийг Мин улсын дайралт, дотоодын зөрчил тэмцэл олгохгүй байсаар, эзэн хаанаа Их хуралдайгаар баталгаажуулж чаддаггүй байдал нь зах хязгаарын нолд төрийн эрхийг булаан авах хүртэл хаан төрийг хямраасан түүхтэй. Энэ үеийг Батмөнх Даян хаан, Мандухай цэцэн хатны хамт даван гарч, төр засгаа бэхжүүлж, дэг журмыг тогтоож эв нэгдлийг бий болгосон гавьяатай. Түүнийг залгамжилсан хаадаас Түмэн засагт хаан хууль ёсыг дээдлэх,

<sup>50</sup> “Алсын хараа-2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал” УБ., 2019 он, 90-р тал

төрийг удирдах, ард нийтийг ёс суртахуунтай болгох талаар чармайн зүтгэж байсан байдаг.

Лигдэн хаан, Халхын Цогт тайж нар Хубилай хааны төрийн уламжлалыг даган Төвөдийн хаан Цамбыг дагалддаг улааны урсгалыг (хувраг хүн эхнэр авч болдог) дэмжиж байсан бол Алтан хан, Халхын Автай сайн хан нар Төвөдөөс шарын шашныг оруулж ирэхээр идэвхтэй зүтгэсэн нь эцэстээ шашнаар ард иргэдээ нэгтгэх биш харин хаан төрөө олон ноёд дэмжихгүй байх, эсэргүүцэн байлдах үүд хаалгыг бий болгож тусгаар тогтнолоо алдах нэг шалтаг шалтгаан болгосон юм.

Манжийн эзэрхийллийн үед монголчууд “түмэн зүйлийн амьтны тусын тулд” гэх шашны үзлээр номхон хүлцэнгүй хүмүүжиж, айл бүрээс бүрэн дуунаар гарч ирдэг бүрэн зэвсэглэсэн, морьтой монгол цэргийн тал нь лам болж, хүн ам, гэр бүлийн харилцаанд ч сөргөөр нөлөөлөх болсон. Хэдийгээр “Халх журам”-аа багагүй хугацаанд Халхын ханлигууд дагаж байсныг Манжийн эрх баригчид болиулж, өөрсдийн боловсруулсан хуулиа тулгах болсон нь “монголын хууль гурав хоног” гэх мэт хууль дээдэлдэггүй, шашинд нэвтэрхий орсон иргэдийг бий болгосон түүхтэй.

1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн “Шашин, үндэс угсаагаа аврах” уриа үнэт зүйлсээр иргэдээ дагуулсан бол 1921 оны хувьсгалчид “Тусгаар тогтнолоо сэргээх” уриагаар эхэлж 1924 оны үндсэн хуулиар “Эв хамт нийгмийг байгуулах”. “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн” гэсэн уриа үнэт зүйлстэй болсон нь 1990 он хүртэл үргэлжилсэн билээ. Хэлмэгдүүлэлтийн аймшгийг туулж, эх орончид, сэхээрсэн болгоноо нухуулсан ард иргэд маань “Төрийн минь сүлд өршөө” гэж өглөө бүр залбирдаг уламжлалаа сахисаар иржээ.

Доктор С.Цэдэндамба тухайн үеийн албан хаагчдын эрхэмлэх зүйлийг судалж “Хүмүүнд төр эрхэм Төрд хүмүүн эрдэнэ” гэсэн уриа доор...

1. ...аймаг, хошуу, сум, баг, арван гэрийн даргад... ард олны зовлон зүдүүрийг нэвтэрхий мэдэх, олны тусыг бодох бөгөөд цэвэр шударга, чадвал бичиг үсэгт боловсронгуй, өөр өөрийн оролдсон явдлыг магадаар бүрэн чадах хүнийг сонгож томилбол зохионо.

2. урьдах зүйлд дурдсан бүхий л тушаалтанд ...ураг төрлийг нүүрчлэх, ...эд ашигт шунах зэргээр зусарч бялдууч, ховдог авлигач, хааш яаш хүнийг сонгох зэргийн гэм өдүүлэх аваас сонгосон сонгогдсон холр этгээдийг ...хууль ёсоор яллан...

3. олон харьяат газрын... тамгын газрын... албан хаагчид ба төлөөлөгчдийн суух орон гэрийг өөр өөрийн нутгийн харьяат газраас бэлтгэвэл зохино.<sup>51</sup> гэснийг тодруулжээ.

Шашин үндсэнд харшлах харгис ёсыг цэвэрлэж.., төр шашныг үнэн сэтгэлээр бататган мандуулж, үндэс язгуурыг алдагдахгүй сахих ба дотоод засгийг үнэн сэтгэлээр сайжруулан засамжилж; ...амь бие, эд хөрөнгийг өчүүхэн ч харамсан хайрлахгүй зүтгэх.<sup>52</sup> гэх мэтээр хуульчилж байжээ.

1990 оноос ардчилал, хүний эрхийг эрхэмлэсэн уриа эрхэмлэх зүйлсийг богино хугацаанд шинэ “Үндсэн хууль”-аараа тунхаглах, хууль эрх зүйн орчныг бий болгох зорилтыг монголчууд хэрэгжүүлж чадаад, үндэсний эрх ашиг, тусгаар тогтнолоо эрхэмлэсэн гадаад бодлогоо монгол төр амжилттай хэрэгжүүлж ирлээ.

Нийгэм, улс төр, эдийн засгийн өөрчлөлтийг дагаад мөн орчин үеийн технологийн

<sup>51</sup> Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм. 1923.03.23

<sup>52</sup> Намын хүмүүсийн дагаж явах тангаргийн бичиг

хөгжлөөс үүдэн нийгмийн харилцаа, үнэт зүйлс ихээхэн өөрчлөгдөж байна.

Өнөөдөр гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн бидний нийгмийн харилцаа, үнэт зүйлс ихээхэн өөрчлөгдөж баян ядуу, хот хөдөө цаашлаад улс төрийн үзэл бодол, нийгмийн гарал байдал, шашин шүтлэг зэргээрээ ялгаа зааг ихээхэн гарах болжээ. Энэ нь яваандаа үнэт зүйлсийг бүдгэрүүлж, нийгмийн оюун санаа, эв нэгдэлд эрсдэл үүсгэж болзошгүй юм.

Системийн хандлагын үүднээс авч үзвэл энэ нь нийгмийг тогтворжуулагч үндсэн элементүүд эмх замбараагүй байдалд орвол систем хямрах аюултай. Иймд онолын зүй тогтлоор элементүүдийн тогтвортой байдлыг хангах шаардлага нь эдгээрийн холбоо хамаарлыг судлах, тодорхойлох чухал ач холбогдолтойг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд бидний ялангуяа өсвөр залуу үеийнхний эх оронч үзэл, эх орноороо бахархах бахархал ихээхэн өөрчлөгдсөн нь даяаршил, мэдээллийн хөгжил, техник, технологийн дэвшлийн хурдац хүн төрөлхтний ахуй амьдрал, нийгмийн харилцаанд эерэг, сөрөг ихээхэн нөлөө үзүүлснээс болжээ. Эдүгээ бид ардчилал, зах зээлийн тогтолцоонд нийцэхүйц үнэт зүйлийг үндэсний хэмжээнд хангалттай түвшинд төлөвшүүлж чадаагүй байна. Өөрийн гэх үнэт зүйл ч тодорхойгүй байна. Үүний шалтгааныг судлаачид:

1. Соёлын хэт хожимдол (Хөгжил дэвшлийг хангахдаа материаллаг болон материаллаг бус соёлыг аль алиныг төлөвшүүлэх хэрэгтэй байдаг. Гэтэл бодит байдал дээр материаллаг тал түрүүлж өөрчлөгдөж, материаллаг бус зүйлс хоцорч үлддэг. Үүнийг соёлын чиглэлээр судалгаа хийдэг судлаачид соёлын хожимдол (cultural lag) хэмээн тодорхойлдог байна.)

2. Соёлын түрэмгийлэл (cultural imperialism),

3. Бие хүний үнэт зүйлийн тодорхойгүй байдал<sup>53</sup> хэмээн үзжээ.

Өнөөгийн нийгмийн сэтгэл зүйд гурван үндсэн хандлага бий болсон гэж философичид үздэг байна<sup>54</sup>. Үүнд:

-Монголыг монголоор нь байлгах буюу үндэснийхээ эрхэмлэлийг нээлттэй нийгмийн нөхцөлд ч хадгалан хамгаалах хандлага юм.

-Үндэсний эрхэмлэлээс хүн төрөлхтний үнэт зүйлсийг дээдлэх буюу эрс өөрчлөлтийн хандлага

-Үндэсний эрхэмлэлийг нээлттэй нийгмийн нөхцөлд дасган зохицуулж өрнөдийн нийгмийн үнэт зүйлтэй хослуулан хөгжүүлэх чиг хандлага байна гэжээ.

Энэ цаг үед үндэсний ой санамж, үнэт зүйлсийн асуудлыг үндэсний уламжлал, үндэсний соёл, үндэсний эрх ашиг, даяаршил, ардчилал, ондоошил, ижилсэл гэсэн олон хүчин зүйлийн огтлолцол дээр авч үзэх нь зүйтэй юм байна. /Зураг №1/

Үнэт зүйлсийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлс

1. Даяаршлын нөлөө

Дэлхийн улс орнууд улам бүр интеграцчилагдаж, тэр хэр хэмжээгээрээ илүү тогтвортой хөгжих нөхцөл бүрдэнэ гэж үздэг судлаачид бий.

Зах зээл, үндэстэн улсууд ба технологи интеграцчилагдаж байна. Үүнд:

• Мэдээлэл, хөрөнгө капитал, үйлчилгээ, барааны дэлхий даяарх урсгал хурдацтай өргөжиж байгаа...

<sup>53</sup> Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгааны тайлан. СЭЗДС. УБ., 2015 он, 4-5-р тал

<sup>54</sup> Г.Чулуунбаатар., Д.Даш-Ёндон “Монголын нийгмийн өөрчлөлт” ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ., 2013 он, 185-р тал



- Олон улсын эдийн засгийн харилцан хамаарал гүнзгийрсэн
- Нутаг дэвсгэр, хил хязгаарын байдал өөрчлөгдсөн
- Үндэсний засгийн газрууд валютын наймаачид, олон улсын хөрөнгө оруулагчид, үндэстэн дамжсан корпорациудын өмнө хүчгүйдэх болсон
  - Дэлхийн соёл, соёлын нөлөө хүн бүрд хүрэх болсон

Даяаршлын үр дүнд ихэнх үйлдвэрийн бүтээгдэхүүний бүтэц зөвхөн нэг улсынх байхаа больсон бөгөөд түүнийг бүтээсэн санхүүгийн бүтэц хөрөнгө оруулалт ч хэнийх вэ гэдэг нь бүр тодорхойлоход хэцүү болсон бол хүмүүсийн аливааг ойлгох байдал, итгэл, үзэл бодол ба дур таашаал дэлхийн хаана байгаа гэдгээс хамааралгүй улам бүр адилхан болж байна.

Дэлхийн мэдээлэл, холбооны нэгдсэн сүлжээ бий болж, аялал жуулчлал, харилцан солилцоо өсөхийн хэрээр хүмүүсийн хэрэглээ ижилсэж, амьдралын хэв загвар ойртож байна. Ялангуяа хоол хүнс, хувцас, гэр ахуй, сонсох хөгжим, үзэх кино, чөлөөт цагаа өнгөрөөх хэлбэр улам бүр адил болж байна. Англи хэл улам бүр түгээмэл болж байна.

Ерөнхийдөө Монгол Улс сүүлийн гурван арван жилд хангалттай нээлттэй байж сайн ч даяаршигдлаа. Монгол Улс 2016 оны байдлаар:

- хүний хөгжлийн индексээр 188 орноос 92,
- аз жаргалын индексээр 140 орноос 136,
- өрсөлдөх чадварын индексээр 138 орноос 102,
- логистикийн гүйцэтгэлийн индексээр 160 орноос 108
- амьдралын чанарын индексээр 192 орноос 107
- байгаль орчны багц үзүүлэлтээр 140 орноос 111
- бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр 190 орноос 64 дүгээр байр

тус тус эзэлж байгаа нь бас тийм ч хангалттай үзүүлэлт биш бөгөөд даяаршлын үр дүн тааруухан байна гэсэн мэдээ юм.

Мөн ихэнх глобалчлагдсан орнуудын төрийн албан хаагчдыг бодвол хаагдмал орнуудын төрийн албан хаагчид хээл хахуульд илүү автагддаг болох нь тогтоогдсон байна.

Даяаршлын эерэг талаас гадна сөрөг нөлөөллийн үр дүнд сүүлийн 30 шахам жилд дэлхийн өнцөг булан бүрд 30 гаруй өнгөт хувьсгал буюу хувьсгал хийх оролдлого гарчээ. Социалист систем задарснаар капиталист ертөнцийн баячууд дангаар баяжиж, үүний үр дүнд баячууд нь хурдан баяжиж, ядуучууд нь улам хурдан үгүйрэв.

“Forbes” сэтгүүлийн 2018 оны үнэлгээгээр манай гарагийн хамгийн баян хүний жагсаалтад 72 орны 2208 тэрбумтэн оржээ. Сүүлийн 40 жил буюу “ардчилсан тэсрэлт”-ийн үед энэ ялгаа 2 дахин нэмэгдсэн.

Ямар ч гэсэн өнөөгийн зөрчилт болон хямралт олон үзэгдэл дэлхийн баялаг өчүүхэн цөөнх санхүүгийн элитийн гарт төвлөрсний улмаас бий болсон эд хөрөнгийн шударга бус байдлаас үүдсэн нь нэн тодорхой байна.

Даяаршлын эринд хүмүүнлэгийн харилцааны зах хязгааргүй тэлэлт, соёлын харилцан “уусалт, шингэлт”, мэдээллийн хүчирхэг давлагаанд хөл алдлалгүй үндэснийхээ соёл иргэншлийн өвөрмөц, дахин давтагдашгүй онцлог, үнэт зүйлсээ хадгалан хамгаалах нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой болж байна.

Эдүгээ хүнийг нийгэм эдийн засгийн хөгжлийн төвд тавихгүй, хүний хөгжилд



хүрэлцэхүйц хөрөнгө оруулалт хийхгүй бол үндэсний соёл иргэншлийн үнэт зүйлсээ хадгалан хамгаалах, аюулгүй байдлаа бэхлэх боломжгүй болсон цаг үе юм.

## 2. “Даяаршил” ба “ондоошил дангааршил”

(Даяаршил, үндэсний хэв шинжийн харилцан хамаарлын хүчин зүйлийг харгалзах) Нобелийн шагналт, Дэлхийн Банкны эдийн засагч асан Америкийн нэртэй эдийн засагч, глобалчлалыг зартай эсэргүүцэгч Жозеф Стиглиц “Хил хязгааргүй болсон өнөөгийн дэлхий ертөнцөд бараа, үйлчилгээ чөлөөтэй урсаж байгаагийн нэгэн адил бусад сөрөг зүйлүүд ч чөлөөтэй урсаж байна” гэж онцолсон байдаг.

Ийм учраас ардчилах, даяаршихын зэрэгцээ тэдгээрийн сөрөг хүчин зүйлүүдээс өөрийгөө хамгаалахын тулд өөрийгөө мэдэх, онцлогоо хадгалах шаардлага гарч ирдэг, тулгардаг бөгөөд Л.Түдэв гуайн хэлснээр “ондооших” асуудал тулгамдаж байгаа нь өнөө үед тодорхой боллоо.

Монголын зонхилох философичид Д.Даш-Ёндон үндэсний өөрийгөө ухамсарлахуйн тухай, Н.Хавх монголын онцлогтой философийн шинжлэх ухааны бий болгох чиглэлээр ажиллаж байжээ. Д.Бямбасүрэн 1994, 2000 онд хэвлүүлсэн “Орчлонгийн хүрд” бүтээлдээ монголчууд ...христос, лал, күнзийн алинд ч уусахгүй, үл тэрслэх тэгээд тэдгээрийн аль дэвшилттэйг нэгтгэж чадах гүн ухааны хүчтэй үзэлтэй байх өвөрмөц үзэл, онол дэвшүүлсэн байдаг<sup>55</sup>. Мөн Г.Лувсанцэрэн 1994 онд бичсэн “Төв үзэл, төвшин бодол” бүтээлдээ монголдоо тохирох үзэл хэрэгтэйг сануулжээ. Д.Мандах<sup>56</sup> “Монголчууд ...асуудалтай тулгарах бүрдээ төрөлх газар нутаг, төр ёсон, хэл соёлдоо тулгуурлан гарах арга ухааны олдог” гэсэн нь бий. Ялангуяа түүх соёлын хувьд өвөрмөц онцлогтой, түүхэн хувь заяагаараа сүлжилдсэн хоёр их хөрштэй хүн амаараа хамаагүй бага манай орны хувьд энэ нь амин чухал асуудал юм.

Судлаач Ж.Бор, Д.Баатар<sup>57</sup> нар “...Бид хятадаар дамжин даяарших юм бол... хүчирхэг хятадын бүрэн хараат байдалд орж улс төр, эдийн засаг асар ихээр хээл хахуульжиж, мафичлагдах өндөр магадлалтай, Хэрэв оросоор ...дамжих юм бол эдийн засаг маань хэт улс төржих, хүнд сурталжих магадлалтай”. “Орос Улс Монгол Улсын аюулгүй байдлын баталгаа юу гэдэгт өнөөдөр шулуухан хариулах аргагүй ч Орос Улс нь Хятадын нөлөөг Монголд саармагжуулах ач холбогдол бүхий тийм баталгаа болж болох юм.”

Даяаршил нь дэлхийн их бага улс орон бүрийн нийгмийн амьдралын бүх салаа мөчирт нөлөөлж байгаа энэ цаг үед иргэд ялангуяа өсвөр залуу үеийнхэнтэй зохиох эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх ажлын тогтолцоог хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөх шаардлага хэрэгцээ бий болсныг иргэд төдийгүй улс төрчид хэлж ярьцгаах болжээ.

Нийгмийн харилцааны шинэ нөхцөлд үндэсний үзэл, бахархлыг тэдэнд өвлүүлэх, тэдний оюун санаа, сэтгэл зүйд зөв дархлааг бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа талаар эрдэмтэн судлаачид, иргэдээс төр засгийн байгууллагад санал хүсэлтээ тавих явдал эрс нэмэгдсээр байна.

Ингэж нийгэмд гүн гүнзгий өөрчлөлт явагдаж хүмүүсийн үзэл бодол, амьдралын

<sup>55</sup> Г.Чулуунбаатар., Д.Даш-Ёндон “Монголын нийгмийн өөрчлөлт” ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ., 2013 он, 185-р тал

<sup>56</sup> Д.Мандах “Монголын өнөөгийн улс төрийн өөрчлөлт иргэншлийн төлөвшлийн харилцан хамаарлын асуудал” диссертаци. УБ., 1998 он, 127-р тал

<sup>57</sup> Ж.Бор., Д.Баатар “Монголын аюулгүй байдал” УБ., 2016 он, 132-133-р тал

хэв маяг, үнэт зүйлийн чиг баримжаа эрс өөрчлөгдөж байгаагаас хуучин тогтолцоонд үйлчилж байсан хүмүүжил, боловсролын тогтолцоог хүмүүнлэг, ардчилсан иргэний нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх үйл ажиллагаа доголдож, шинэ гэсэн зүйл болгоныг туршсаар, туршсаар учраа сайн олохоо байсан байдал боловсролын салбарт ч харагдаж байна. Монгол хэл, монголын түүхийн сургалтын цаг бүх шатны сургуульд хангалтгүй байгаа ба саяхан төрийн сайд байсан хүн ч “Монголын түүх”-ийн хичээлийг заах хэрэггүй гэж мэдэгдсэн байдаг.

Нийгмийн нэг тогтолцоо, нэг үзэл суртлын ноёрхлоос нөгөө тогтолцоо, олон ургалч үзэл сурталд шилжих үед амьдралын хэв маяг, зорилго, нийгмийн үнэт зүйлсийн үнэлэмжид зарчмын өөрчлөлт гарч байгаатай уялдуулан иргэдийн эх оронч хүмүүжлийн тогтолцоог шинэ нөхцөл байдалд зохицуулан өөрчилж чадаагүйгээс үйл ажиллагаа нь нийгмийн хэрэгцээ, шаардлагыг тэр бүр хангаж чадахгүйд хүрч байна.

### 3. Ардчилал.

Монгол Улс сүүлийн 30 гаруй жилд хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах үйлсдээ багагүй амжилт олж олон улс орнуудаар хүлээн зөвшөөрөгдөөд байгаа билээ.

Ард түмэн өөрийн эрх чөлөөг зөвхөн хуулийн ноёрхол түүн дотроо парламент, засгийн газар хоёр нь хуулийн ноёрхол дор орших үед л эдэлж чадна. Гэхдээ нийгмийн амьдралыг ардчилах, шүүх засаглалыг бие даасан хараат бусаар ажиллуулах, төрийн албыг намуудын харьяаллаас гаргах, төрийн эрх мэдэл бодитой хуваагдаж, харилцан үр нөлөөтэй хяналт тавьж чаддаг тогтолцоог бүрдүүлэх зэрэг олон асуудлууд Монголд тулгамдсан хэвээр байна.

Ардчиллын үед эрх баригчид “Хатуухан гараар юм хийе” гэхээр нөгөө тал нь либералуудтай нийлээд “хүний эрх зөрчлөө” гээд босоод ирдэг учир төр хүчирхийлж ч чадахгүй, эрх чөлөөг ч олгож чадахгүй байдалд ордог зүй тогтол өөрийн толгойгүй олон буурай улс оронд сөргөөр нөлөөлж байна.

Мөн зарим судлаачид “Ардчиллын нэрээр төрийг багасгах “тураах” буюу Дэлхийн банк, Олон улсын Валютын сангийн удирдлага зөвлөгөө- гөөр төрийн зардлыг танаж хасах, улсын үйлдвэрийн газруудыг хувьчлах зэрэг хөтөлбөрийг гурав дахь ертөнцийн орнуудад хэрэгжүүлсэн олонх улс орнууд ДБ, ОУВС-ийн дарамтын дор импортын татварыг бууруулснаар үндэсний зах зээлээ гадаад өрсөлдөөнөөс хамгаалах боломжгүй болов. Үүний улмаас олон орны эдийн засгийн өсөлт зогсож, экологийн сүйрэл нөмөрч, нөөц нь багассан. Үр дүнд нь Африкийн Либериа, Руанда, Сьерра-Леон, Сомали, Судан, Арабын ертөнц, Ази, Латин Америк, Дорнод Балкан, Кавказ, Дундад Ази зэрэг маш олон бүс нутгуудад “чадваргүй төр” (failed states) газар сайгүй бий болов.” гэх нь бий.

Нобелийн шагналт Штиглиц<sup>58</sup> “...Монгол нь цочир эмчилгээ, эрс хурдан хувьчлалын бодлогын бүтэлгүйтлийн нэг жишээ юм. Либералчлал, хувьчлалыг хэт хурдан хийснээс ихээхэн хохирол амссан. “...Баялгийн хясланг ерөнхийд нь байгалийн асар их баялагтай орнууд ихэнхдээ хүмүүс нь ядуурдаг, улс нь өсөж, хөгждөггүй, баялгийн өгөөж харьцангуй цөөн хүнд ноогддог гэдгээр тодорхойлж болно.” “Financial times” цахим сонины шинжээч Дэвид Пилинг “...Катар найман тэрбум ам.доллараар эдийн засгаа тэтгэж чадсан. Харин монгол яах нь одоогоор мэдэгдээгүй байна. ...гаднаас зургаан тэрбум ам.доллар татаж, дэлхийн томд

<sup>58</sup> Штиглиц.Ж. “Хөгжил ба байгалийн баялаг” форум дээр хэлсэн үг УБ., 2018 он

тооцогдох алт, зэсийн уурхайг ашиглалтад оруулсан билээ. ...Монгол Катар шиг болохоор зүтгэж байгаа ч Нигери шиг болох боломж бас байгааг анхаарах хэрэгтэй.

Өнөөдөр хөгжингүй болон гуравдагч ертөнцийн орнуудын баян ядуугийн зааг ялгааг ихсэж гуравдагч ертөнцийн орнуудын ихэнх нь ядуурч байна.

Манай нийгэмд сайн ажиллавал сайхан амьдрах бололцоо бий гэсэн хүмүүс 1998 онд 25.3 хувийг эзэлж байсан бол 2013 оны үед нэмэгдээгүй байсан байдаг.

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн 5 тэнхим хамтран 2015 онд судалгаа хийжээ.<sup>59</sup> Үүнд:

Өнөөдрийн Монголын нийгмийг цагаан буюу гэгээтэй, сайхан өнгөөр 29.5 хувь нь, дөрвөн хүн тутмын нэг нь улаан эргэлдсэн өнгөөр бараг таван хүн тутмын нэг нь хар түгшүүртэй өнгөөр тус тус дүрсэлжээ.

Судалгаанд оролцогчдын 41.8 хувь нь улс төрийн намууд ард түмний ашиг сонирхлыг илэрхийлж чадахгүй, 33.3 хувь нь зарим талаар илэрхийлж байна хэмээжээ. Улс төрийн намууд тэдний эрх ашгийг хамгаалдаг эсэх талаар огт мэдэхгүй хүмүүс 17.2 хувийг эзэлж байна.

“...Ардчиллын үеийн улс төрийн амьдралын гол субъект болсон намууд нь үзэл баримтлалаасаа илүү эрх мэдэл, эд хөрөнгөнд дулдуйдсан бүлэглэлүүдийн нөлөөлөлд автаж, нам дамнасан улс төр, эдийн засгийн олигархууд улс орны бүх эрх мэдлийг барьж, бодлогыг тодорхойлж авлига, хээл хахууль газар авч, шударга ёс алдагдаж, иргэд, сонгогчдын улс төрийн намуудад итгэх итгэл урьд өмнө байгаагүйгээр алдагдаж байна. 2018 оны 3 дугаар сард “Сант марал сан”-ийн хийсэн судалгаагаар иргэдийн 87.3 хувь нь төрдөө, улс төрчдөд итгэх итгэлгүй болсон байна.

Судлаач Д.Ганхуяг<sup>60</sup> “Өнөөгийн УИХ-д 11 тэрбумтан, 58 том бизнесийн төлөөлөл байгаа нь манай УИХ төрийн байгууллага биш, хууль тогтоох шийдвэр гаргах байгууллага биш, харин олигархи бизнесийн тохиролцоо, зөвшилцөл, хуйвалдаан, зэрлэг өрсөлдөөний талбар болон хувирсныг илт харуулдаг. Ийм бүрэлдэхүүнтэй УИХ үндэсний болон ард түмний эрх ашгийг илэрхийлэх ямар ч боломжгүй.”

Сайд нар буюу улс төрчид төрийн албанд эхлээд хамаатан саднаа, дараа нь мөнгөтэй буюу дээрх илгээсэн хүмүүсийг, гурав дахь бүлэгт нуудгайгаа оруулдаг болсныг ажлаа хийж байгаа болон ажлаас халагдсан төрийн албаныхан ил, тод ярих болов.

Төрийн удирдлага, төрийн албаны тогтолцоо төлөвшөөгүй бол төрийн ой санамж охорхон байж улс орноороо хүний үгээр буруу тийшээ будаа тээх, төр засаг шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлаж шийдвэр гаргадаггүй бол зорилго зорилт нь хэрэгждэггүй түр зуурын болж эдийн засгаа сүйрүүлэх, мэдээллийн технологид суурилсан сангүй бол авлигалд идэгдэх, иргэд төрөө дээдлэхгүй байж нийгмийн ёс суртахуун доройтох эрсдэл өндөр байдаг.

*Монголын төрд, монголчуудад үндэсний хөрөнгөтнүүдээ дэмжих дэмжлэг бага байдгаас үндэсний компаниуд төрд, олон түмэнд үргэлж адлагдаж байдаг байдлаасаа болж тэд төрийн алба руу хүмүүсээ бэлтгээд илгээх болов.*

Уг нь төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар гадаад, дотоодын олон санаачилга, төслийн үр дүнг төрөөс дэмжиж ажил хэрэг болгох цаг нь болсон. Засаглалын чадамж нь төрийн ой санамжаар өөрөөр хэлбэл төр хир зэрэг

<sup>59</sup> Ж.Болор. МОНЦАМЭ: Эдийн засгийн байдлыг дордож байна гэж 45,4 хувь нь үзжээ. (2015.02.11)

<sup>60</sup> Систем хийгээд антисистемийн тухай

өөрийн ухаанаар сэтгэдэг, шийдвэр гаргадаг нөхцөл, боломжоор хамгийн гол нь төрийн түшээдийн мэдлэг чадвараар тодорхойлогдох учиртай.

Эдгээрээс харахад өнөөдөр намууд бие биеэ, Ерөнхийлөгч, 76 гишүүн төдийгүй бүх төрийн түшээдээ муу муухайгий нь дуудсаар байгаад Монголд Улсад өнгөтэй өөдтэй зүйлгүй болж тэр байдлаараа иргэд маань өөрсдийнхөө амьдралыг хар бараанаар төсөөлж, залуу үе нь гадагшаа явах талаар л бодож мөрөөдөж явдаг нийгмийн гажуудал нэгэнт бий болжээ.

Ардчилал бол өөртөө хүн төрөлхтний нийтлэг үнэн зүйлсийг агуулдаг ч тухайн үндэстэн улсын тодорхой нутаг дэвсгэр дээр өөрийн сэтгэлгээ зан заншлыг дээдлэн орших нь зүйн хэрэг. Мөн бусдыг дуурайсан хуулсан тогтолцоо нь удаан хугацаанд орших чадваргүй<sup>61</sup>. Бие даасан буюу тусгаар тогтносон ардчилал нь өөрийгөө хамгаалах дархлаатай байх ёстой.

Доктор Б.Галиндэв “Таны бодлоор ардчилсан нийгэм гэж юу вэ? гэсэн асуултад “Амиа бодогчдын, өрсөлдөгчдийн нийгэм. Надад өмч хөрөнгө, эрх мэдэл, нэр төр хэрэгтэй. Гагцхүү энэ бүхнийг би өрсөлдөж байж л олж авна. Ийм үед хүний төрөлх араншин болох амиа бодох зөн совин байнга үйлчилнэ гэсэн үг. Социалист нийгэм бол хүний амиа бодох үзлийг хүчээр дардаг байсан<sup>62</sup>. Ерөөс ардчилсан нийгэм амиа бодсон, эд материал, нэр хүндийн төлөө нийгэм юм бол үлдсэн онгорхой орон зайг нь соён гэгээрлээр л нөхөхөөс өөр замгүй. Монголчууд бид амиа бодохоос илүүтэй нийгмийн үнэт зүйлээ боддог, бусдыг боддог өргөн ухаарал руу явах хэрэгтэй болж байна.”

*Ганцхан баримт дурдахад, 1989 онд улсын хэмжээгээр ердөө 1900 гэмт хэрэг бүртгээгдсэн байна. Гэтэл 2017-2018 онд улсын хэмжээгээр тус бүр 32 мянган гэмт хэрэг бүртгээгджээ. Ухаандаа Монголд гарч байгаа нийт гэмт хэргийн 50 хувь нь хулгай, 30 орчим хувь нь архины хамааралтай гэмт хэргүүд эзэлж байна. Өдөрт 150-200 гэр бүлийн хүчирхийлэл бүртгээгддэг. Энэ юу гэсэн үг вэ, нөгөө ёс суртахууны доройтол, уналт чинь айлын гэрт ороод ирчихсэн байна. Мөн ёс суртахууны үнэт зүйлсийн эрэмбэ алдагдсан. Ямар ч монгол хүнд эхлээд эх орон нь хамгаас үнэт зүйл байх болов уу хоёр дахь нь хөдөлмөр гэдэг ч юм уу Гэтэл өнөөдөр бүхний дээр мөнгө залрах болсон.*

Манай улсад ардчиллын үнэт зүйл хэр зэрэг төлөвшиж байна? гэхэд хариуцлага хүлээх байдал, шударга үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилт, тайлагнах ёс, иргэдийн оролцоо зэрэг ардчиллын үнэт зүйлүүдийг судалгаанд оролцсон 10 хүн тутмын 4-6 нь хангалтгүй гэж үнэлсэн.

Улс төрийн ухааны доктор О.Хатанболд<sup>63</sup> “Энгийнээр бол ардчилал гэдэг өөрөө хариуцлагатай байдал, эрх үүргийг мэддэг, хүний эрхийг дээдэлдэг, зөвшилцдөг, хуулийг дээдэлдэг, хүн хүний харилцааг эрхэмлэдэг нийгмийн тогтолцоо. ...Гаднын улс орон, олон улсын байгууллагууд Монголын ардчиллыг гажиг ардчилал буюу flow демокрасу гэж ярьдаг. Стандарт бус ардчилал гээ л дээ, энгийнээр.

...Ард түмэн өөрөө мэдлэгтэй, боловсролтой, хариуцлагатай, эрх үүрэгтэй тэгээд зөвшилцөж чаддаг, аливаад оюун дүгнэлт өгч чаддаг байж гэмээн бидний хөгжүүлж,

<sup>61</sup> Ё.Гэрэлчулуун “Төр ба үндэстнийг бэхжүүлэх нь” 2007.03.02. Мэдээний дугаар: #49102

<sup>62</sup> М.Мөнхзориг “Б.Галиндэв: Монголчуудыг гедонист үзэл баримтлалтай гэж дүгнэжээ.” -"Соёмбо" сонин. 2022.03.18

<sup>63</sup> О.Хатанболд: /ШУА-ийн Философийн хүрээлэн. Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтан/ Монголчуудын аливааг аргацаах гэсэн сэтгэлгээ нийгмийг ч, ардчиллыг ч сулруулж байна.

бэхжүүлэх гээд байгаа ардчилал оршин тогтноно. Дээрээс нь бидний эрж хайгаад байдаг тунгалаг нийгэм, тунгалаг төр бий болох ёстой. Тэрийг бүрдүүлэхийн тулд шийдвэр гаргах, бодлого боловсруулах түвшин дэх иргэд бидний оролцоо хамгийн чухал.

...Хэрэв ардчилал ухарч байгаа нь ажиглагдаж байгаа бол шалтгаан нь нөгөө л авлига, албан тушаалын хэрэг байгаа шүү дээ. Ардчиллын олон индикатор бий.

Авлигын түвшин нэмэгдээд л байвал ардчилал гажуудалтай л байна шүү дээ. Хариуцлагын тогтолцоо сул, төсвийн ил тод байдал муу, иргэдийн оролцоо хумигдмал байгаад байвал ардчилал өөрөө ухрахаас аргагүй байдалд орж байгаа юм

Түүнээс биш манай ардчиллыг нураах гээд байгаа, энд тэндээс нөлөөлөх гээд байгаа юм алга. Бид өөрсдөө л шуудайд хийсэн эвэр шиг байгаа байдал хэн нэгэнд өгөөш болчих вий.

...Нийт ард иргэдийн хувьд улс төрийн соёл, зөв зохистой мэдлэгийг түгээх ёстой. Ардчиллын зохистой үнэт зүйл, мэдлэгийг бий болгох ёстой. Түүнээс биш ардчилал гэдэг зүйл дандаа эрх, эрх чөлөөгөөр хэмжигддэг юм биш, Та ардчилсан иргэнийхээ хувьд юунд яаж оролцох, ямар үүрэг хүлээх вэ гэдэг зүйл чухал. Бидэнд дутагддаг зүйл гэвэл бүрэн, төгс төгөлдөр гүйцэтгэл. Монголчууд гүйцэтгэл сул хүмүүс юм. Үүнээсээ болоод нэг хууль баталлаа гэхэд дандаа нэмэлт өөрчлөлт оруулдаг байх жишээтэй. Юмыг дандаа аргацаах гэсэн сэтгэлгээ нь одоо хүртэл салдаггүй” гэсэн залуу эрдэмтний байр суурь зөв, бодуштай ажээ.

Ардчилсан намаас УИХ-д сонгогдсон гишүүн асан Я.Эрхэмбаяр “Бид ардчиллаас хувь үг хэлэх, шашны зэрэг олон эрх чөлөөг авсан мөртөө хууль дээдлэх, ёс зүй барих зэрэг нөгөө гол зарчмыг нь аваагүй учраас нийгэм хариуцлагагүй байна”.

Соёл Урлагийн Их Сургуулийн судалгаагаар <sup>64</sup> ардчиллын үнэт зүйлсийн төлөвлөс:

- хариуцлага хүлээх байдал 58.4 хувь
- шударга үйл ажиллагаа 58 хувь
- хуулийн хэрэгжилт 57 хувь

тайлагнах ёс 51.6 хувь хангалуун бус гэж хариулсан бол хангалттай гэсэн нь 2-оос 4, дунд зэрэг гэсэн нь 30 орчим хувь байсан байна.

Доктор, профессор Ц.Тогоо хэлэхдээ “Эдүгээ Монгол Улсад даяаршил, ардчилал, зах зээлийн харилцааны нөлөөн дор нийгмийн шинэ бүтэц, давхраажилт төлөвшин нийгмийн оюун санааны амьдралын цоо шинэ орчин нөхцөл бүрдэж байна. Ардчилсан нийгэмд зах зээлийн чөлөөт өрсөлдөөн, олон ургалч үзэл бодол, хүний эрх, эрх чөлөөний баталгаажилт, нийгмийн социал ялгарал, ахуй амьдралын хэв маяг, үнэт зүйлсийн чиг баримжааны! хувьсал өөрчлөлт нь эх оронч үзэл, хүмүүжил, иргэдийн соён гэгээрүүлэлт, үүрэг хариуцлагын тогтолцоо зэрэг нэгдэх, зангидах хүчин зүйлстэй уялдахгүй, зохицуулалт үгүй бол нийгмийн оюун санааны задралд хүргэх эрсдэлийг тээж байдаг” гэжээ.

Түүнчлэн хэлэлцүүлгийн үеэр доктор Б.Энхмандах “Өмч хувьчлал, хувийн өмчийг сэргээсэн нь хүмүүсийн үзэл бодол, үнэт зүйлсийн өөрчлөлтийн суурь гол шалтгаан” гэдгийг тодруулсан байдаг. Тэгэхээр нийгмийн социал шинэ бүтэц, давхраажилтыг ч энэ цаг үед эх оронч үндэсний үзлийг даяаршил, ардчиллын эрин үетэй холбогдуулан

<sup>64</sup> “Монголчуудын үнэт зүйл” СУИС-ийн судалгааны тайлан. УБ., 2019 он, 61-р тал



судлах шаардлага тулгарч байна.

Мөн доктор Н.Жалбажав “Нийгмийн амьдралын бүх салаа мөчирт (эдийн засагт, нийгмийн улс төрийн тогтолцоонд, хүмүүсийн харилцаанд гэх мэт) ардчиллын хэм хэмжээг түгээх, сахиулах, нийгмийн бүлэг, давхаргын гармони буюу зохицлыг хангах, нийгмийн шинэ соёлыг төлөвшүүлэхэд ихээхэн хүндрэл бэрхшээлтэй тулгарч онол, арга зүйн хувьд ч, практикийн хувьд ч шийдэх шинэ, шинэ асуудал хөврөх болов”<sup>65</sup>. Үүнтэй холбоотойгоор “Нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийн гажиг”-ийн тухайд их ярьж бичих болов.

Үндэсний үнэт зүйлсээ үндэсний онцлогоо буюу үндэсний ижилсэл, ой санамждаа суурилж байж энэхүү даяаршил, ардчиллын үед тодорхойлох зайлшгүй шаардлагатай бид тулгарч байна.

Даяаршлын хүчийг үр дүнтэй ашиглан үндэстнийхээ онцлог, давуу талыг хадгалж иргэний нийгмийг хөгжүүлж, төрөө бэхжүүлэн эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь тусгаар тогтносон ардчиллын агуулгыг тодорхойлдог байна.

Хамгийн гол нь Аристотелиос эхлэлтэй “Хүнээр биш Хуулиар засаглах” гэсэн ардчиллын амин гол зарчмыг одоо болтол бид хэрэгжүүлж чадаагүй явна.

Даяаршил ардчиллын үед эдийн засгийн бага буурай орны хувьд төдийгүй манай орны түүх, газар зүйн байршил, хоёр их хөрштэйгөө харьцуулсан хүн амын тоо зэргийг харгалзвас “ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ” зайлшгүй чухал болох нь харагддаг.

Үндэсний Identity (ижилсэл, адилтгал).

Үнэт зүйлс, эрхэмлэх зүйлсээ тодорхойлохын тулд юуны түрүүн “үндэсний ижилсэл-Identity” буюу өөрийгөө мэдэх ойлгох суурь судалгаа тодорхой байх ёстой бололтой.

Соёл иргэншлийн хувьд монголчууд өөрийгөө нүүдэлчний гэх үү, буддын гэхүү ер нь бусдаас онцгой ялгарах юу билээ. Тэгвэл энэ нь орчин үеийн даяаршлын сорилтыг тэсэх үү, шинэ нөхцөлд дасан зохицохын тулд уламжлал, шинэчлэлээ хэрхэн хослуулах вэ, тэгвэл бид хэн болох вэ зэрэг асуудлууд гарч ирж байна.

Энэ цаг үед монгол хүн хэн болох, бусадтай харьцуулбал ямар түвшний үндэстэн болох, яагаад хэсэг судлаачид хоцрогдсон үндэстэнд<sup>30</sup> бүр зарим нь сөнөж болзошгүйд оруулаад байна вэ?

Доктор Даш-Ёндон “Өөрөө өөрийгөө танигтун” гэсэн эртний грекээс уламжлалтай, дэлхий дахинаа тархсан танин мэдэхүйн энэ зөвлөмжийг зөвхөн хувь хүнд хамааруулаад зогсохгүй, бүхэл бүтэн үндэстэнд ч холбогдуулан үзэж судалж болно. Үндэстнүүд бий болсноос хойш өөрийгөө сайтар ухаарсан хэсэг нь л шалгаран үлдэж газар нутгаа эзэгнэн, төр улсаа төвхнүүлэн амьдарсаар өдийг хүргэжээ. Үүнийг гярхай ажигласан Г.В.Ф.Гегель “Тэд өөрөө хэн бэ, юу хүсдэг вэ гэдгээ мэддэг ард түмэн л түүхээ бичиж чаддаг” гэсэн байдаг.

Түүхэн талаасаа монголчууд нүүдэлчдийн ахуйн сайн, муу талуудыг уламжлан авч яваа бөгөөд олон ч удаа гадаад, дотоодын нөлөөлөл, дарамтаар нөлөөлөгдөж (деформацлагдаж) явсаар өнөөгийн үндэсний онцлог, ижилслээ олсон байдаг.

Түрэгийн Культегин зэрэг хаадын өнөөгийн Монгол Улсад хадгалагдан үлдсэн

---

<sup>65</sup> Н.Жалбажав “Нийгмийн шинэтгэлийн зарим гажиг” (Тухайлбал, Ч.Даваадаш “Монголын нийгмийн шилжилтийн зарим онцлог” УБ., 2017 он; З.Т.Голенкова “Даяаршлын нөхцөл дэх шилжилтийн нийгмийн гажиг, шилжилтийн нийгэм: шинэтгэл, соёл иргэншлийн асуудлууд” УБ., 2012 он; Д.Дагвасүрэн “Монголын капитализмыг яаж хүмүүнлэг болгох вэ?” УБ., 2016 он

хөшөөний бичээснүүд дээр суурин иргэншлийн эд агуурсын нөлөөлөл нь нүүдэлчдийн улс үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хэрхэн сулруулдаг талаар хойч үедээ бичиж үлдээсэн нь бий.

Их богд Чингис хааны тогтоосон хууль, ёс зүйг монголчууд хэрхэн дагаж байсан талаар дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн элч, жуулчдын тэмдэглэлд тодорхой бичигдсэн байдаг билээ.

Юань гүрний үед монгол хүмүүс дэлхийг захирч аль шилдэг иргэд нь төр удирдах хэрэгт оролцож байсан түүх ч бас бий.

Монголчуудын сайн сайхан уламжлал, эв нэгдлийг сэргээх талаар Батмөнх даян хаан, Түмэн засагт хааны амжилттай үйл ажиллагааг тэмдэглэхийн сацуу тусгаар тогтнолоо алдахад хүргэсэн дараагийн үйл явдлууд, шашны хэт хамаарал зэрэг нь өнөөдөр ч сургамжтай хэвээр байна.

XIX зууны үед Оросын Прежвальский нарын судлаачид, жуулчдын тэмдэглэн үлдээсэн бичгүүдэд монголчуудын сайн муу талыг тухайн үедээ соёлжсон улсын байр сууринаас харж бичсэн нь өнөөгийн бидэнд өөрийгөө ойлгон мэдэхэд чухал сурвалжууд болдог. Шашинд хэт орсон монголчууд түүнээсээ салаад коммунист үзэл суртлын нөлөөнд орж шашны ёс суртахууны бүхий уламжлалаа таягдан хаяж, оросоор дамжуулан европын соёлд суралцах гэж ядаж байгаад зах зээлийн харилцааны орчинд орж, амьдрах гэж чармайж байна.

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбарын эрхлэгч асан доктор Ц.Цэцэнбилэг “Манай хүрээлэнгийн зүгээс “Үндэсний ой санамж” судлагдаж байсан асуудал. Гэхдээ судалж байхдаа үндэсний адилтгал identity гэсэн тал дээр судалж байсан” гэсэн байдаг.

Судлаач Т.Сайнжаргал “Identity”-г “үндэстний амин чанар” гэж орчуулжээ. Мөн судлаач IDENTITY гэсэн үгэнд “ижил төстэй, адилхан” гэсэн утга бий гэсэн байна.

Тэр бээр “Үгний үндсэн утгыг зөвхөн өөрийн ойлгосноороо тайлбарлаж шинэ утга зүүж болохгүй. Учир нь үг, хэл хэн нэг хүний бус харин үндэстний өв, олон мянган жилээр шигшигдэж, шижир алт мэт тунаж тогтсон үндэстний нийтлэг баялаг. Түүний дархлааг бид эвдэж болохгүй. Шинэ үг зохиож, хэвшүүлж бололгүй яах вэ. Тэгэх ч ёстой. Гэхдээ тэр шинэ үг хэллэг монгол хэлний ариун нандин чанарыг буртаглаж болохгүй. Монгол сэтгэлгээг эвдэж болохгүй” гээд судлаачид үндэсний ялгарал, ОНДООШИЛ, заримдаа бүр ИЖИЛСЭЛ гэгцгээдэг гэсэн байна.

МОНГОЛ ХҮН-ий талаар ҮАБЗ-ийн шинжээч асан, доктор (Ph.D) Б.Ширнэн “Үндэсний адилсал монголчуудын хөгжлийн түлхүүр”<sup>66</sup> өгүүлэлдээ “Бидэнд Чингисээрээ бахархахаас өөр үндэсний адилслын ямар гайхамшигт жишээ байна вэ?” гэжээ.

Доктор Л.Мөнх-Эрдэнийн монголын ястнуудын талаарх сүүлийн судалгаа нь монголчууд нэг үндэстэй Чингис хааны үеэс бий болсон бөгөөд гаднын нөлөөгөөр өнөөгийн монголчууд олон ястнуудад хуваагдсан нь үндэсний ижилсэл, адилтгалын үүднээс буруу болохыг нотолдог. Энэхүү ястны талаарх байр суурийг судлаачийн хувьд дэмжиж байгаа юм.

Дээр нь биднийг “Муухай монгол хүн амархан шинийг хүлээж авдаг ч гүйцээдэггүй амархан өөрчлөгддөг, хариуцлагаа бүрэн ухамсарладаггүй, хууль хатуу сахидаггүй,

---

<sup>66</sup> Б.Ширнэн “Үндэсний адилсал монголчуудын хөгжлийн түлхүүр” стратегийн судалгаа. 2022 он, №82, 157-р тал

эрх чөлөөг ухамсартай хариуцлага гэж ойлгодоггүй голдуу дур зоргоороо байх явдал гэдэг” хэмээдэг Баабар зэрэг шүүмжлэгсэд бий. Жишээлбэл: Д.Баярхүү судлаач “...монголчууд бид “ажил бол зовлон” гэх философитой явсаар өнөө хүрсэн, тэр хэрээрээ соёлт ертөнцөд очиж чадаагүй явна. ...Монголд хэзээ ч мөнгө босдоггүй, мөнгө бүтээдэггүй явсаар ирсэн мэт. Үеийн үедээ (хулгай хийж авлига л авахгүй бол) амьдрал ахуй нь ердөө сайжирдаггүй. Энэхүү ядуурал, мөнгөгүйдлээ дээдэх “76” руу ял тохчихоод суугаад байна.”

Доктор Б.Галиндэв “Олон улсын судалгаагаар монголчуудыг гедонист үзэл баримтлалтай гэж дүгнэсэн байна. Энэ нь зугаа цэнгэлд дуртай, чөлөөт цагтай байхыг хүсдэг гэсэн үг. Дандаа л тансаг амьдралаар амьдарч, зугаа цэнгэлтэй байхыг хүсэхээс бус хөдөлмөр хийгээд түүнийхээ төлөө шаналж явахыг хэн ч хүсэхгүй байна”.<sup>67</sup>

Японы эрдэмтэн доктор Кимура Аяако “Баруунаас гарах мандах наран” цуврал бүтээлдээ монголчуудын хэв ёсны сайн муу талыг зөв олж тэмдэглээд “Тархины тураал” өгүүлэл бичиж манайхны залхуу, алмай амарлингуй, аминч хомхой, арчаагүй нялзархай, албан савсаг занг хатуу шүүмжилсэн байдаг.

Нөгөө талаас “Тэнгэр язгууртай монгол хүн сэтгэх чадвар сурах харахдаа системчлэн харах чадвартай олон зуун жил харийн дарамтад байсан нь эх орноо гэх эрх чөлөөнд байх дуртай үндэстэн болгосон ер нь сэргэн мандаж байгаа дээшээ үндэстэн” гэх хүмүүс ч бас бий.

С.Зориг агсны хэлсэн хэд хэдэн алдартай эшлэлээс “Японы түвшинд очтол өдий байгаа ч би монгол хүний саруул ухаанд итгэдэг” гэсэн нь чухал юм.

Доктор Д.Өлзийбаатар “Монголоос өөр ард түмэн ийм агуу хоёр хөршийн хооронд хавчуулагдан олон зуун жил байж чадах уу?! Ээ дээ, үгүй л болов уу. Монгол омогшил гэдэг энд л оршино. Бид хаана ч, хэзээ ч, ямар ч нөхцөлд Монгол хэвээрээ. Аль нэг газар, ямар ч улс оронд монголчууд амьдарч, оршин тогтнож чадах нэг өвөрмөц онцлогтой байна. Хоорондоо эвлэдэггүй хэр нь, бие биеэсээ зугтаагаад байдаг мөртөө үндэстний онцлогоо хадгалаад сайн сайхан байгаад байдаг”<sup>68</sup>.

Судлаач П.Дэлгэржаргал “Сэтгэлгээний нэгдмэл байдал улс орны хөгжлийн хамгийн үнэтэй зүйл, энэ бол “тусгаар тогтнолоос” үнэтэй зүйл. Сэтгэлгээний адилсалгүй бол улс орон хөгжихгүй энэ бол харин алдагдвал\_бараг сэргээгдэх боломжгүй.”<sup>69</sup>

Зохиолч З.Дорж “Монголчууд “хэл, хил, мал” гуравтайгаа байхад Монгол монголоороо байна” гээд газар шорооны төлөө тэмцэж байлаа.

Доктор Н.Жалбажав “Монгол хүн, монгол оюун ухаан, монголын түүх, монгол өв соёл, монгол урлаг, монгол ёс заншил, уламжлал бол улс эх орны бахархал, үнэт зүйл байх ёстой.”

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Д.Бум-Очир: Б.Андерсон<sup>70</sup>, Г Аллпорт<sup>71</sup> зэрэг Харвардын судлаачдын бүтээлээс иш татаж үнд эстнийг нэгтгэдэг зүйлс нь төр,

<sup>67</sup> М.Мөнхзориг “Б.Галиндэв: Монголчуудыг гедонист үзэл баримтлалтай гэж дүгнэжээ. -"Соёмбо" сонин. 2022.03.18

<sup>68</sup> Д.Өлзийбаатар: “Та нарын дэргэд еврей нар хүүхдүүд, бид нар нялх бацаанууд” гэсэн юм шүү дээ (2014.05.19)

<sup>69</sup> П.Дэлгэржаргал “Тусгаар тогтнолоос илүү сэтгэлгээний нэгдмэл байдал хамгийн үнэтэй нь” News.mn УБ, 2012.06.07

<sup>70</sup> B.Anderson. Imagined communities. 1983

<sup>71</sup> G.Allport. Personality&social encounter. 1960




улс, хэл, соёл, түүх, угсаа, шашин, иргэншил, ДНХ ... зэрэг дээр үндэсний үнэт зүйл, үндэсний ухамсар юм гээд “үндэстний ижилслийг бүрдүүлэгч үнэт зүйлс”, “үнэт зүйлсээрээ нэгдэгч оюун санаа” гэсэн тодорхойлолтуудыг саяхны илтгэлдээ дурджээ.

Бид цөөхүүлээ биш 3452138<sup>72</sup>-уулаа байна. Бид 8 минут 36 секунд тутамд нэг хүнээр өсөж, жилд 61835 хүнээр өсөж, бид өнөр өтгөн болсоор байна гэсэн үг. Ингэж тооцвол манай ард түмэн 2031 он 4 сая, 2046 онд 5 сая хүнтэй болно. Энэ сайхан цагийг өнөөгийн 60-аас доош настнууд бүгдээрээ үзнэ.

Төр засгийн бодлогод энэ асуудал хэрхэн туссаныг хамгийн сүүлийн үеийн жишээнээс харья. “Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого»-д: “...хувь хүний болон нийгмийн түвшний үнэт зүйлс нь үндэсний онцлогтой нягт уялдаж, эх орны эрх ашиг, монгол хүний онцлог, нүүдлийн ахуй, түүх, соёл, урлагийн бүтээлдээ уламжлал, шинэчлэлийн тэнцвэрт харьцаанд шингэн сүлэлдэж ҮНДЭСНИЙ ИЖИЛСЭЛ-ийг бүтээх учиртай” гэж тодорхойлжээ<sup>73</sup>.

Ерөнхийдөө “үндэсний ижилсэл”-ийн талаарх эрдэмтдийн судалгаа багагүй хийгдэж, төрийн бодлогоор тодорхойлогдож эхэлж байна гэж үзэх үндэстэй.

Төрийн албан ёсны хэл монгол хэлийг хэрэглэх асуудал Баян өлгий аймагт асуудал болоод байсан үе бий. Ирээдүйд энэ асуудал хэрхэх нь бага, дунд сургуульд монгол хэлийг заах, сурахаас шалтгаална.



Зураг №1

Энэ бүхэн нь үндэсний ижилсэл, бахархал, эрхэмлэх зүйлс, үнэт зүйлсийг тодорхой болгоход чухал төр, олон нийтийн үйл ажиллагаа бөгөөд эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн судлаачдыг бий болгох зорилт тавин ажиллах шаардлага байгааг харуулж байна.

<sup>72</sup> 2022.11.13-ны байдлаар

<sup>73</sup> “Алсын хараа-2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал” УБ., 2019 он, 90-р тал.

## Нэгдүгээр бүлгийн дүгнэлт

Үндэсний ой санамж бол түүх туршлага гэдэг дээр төслийн баг санал нэгдсэн. Үндэсний ой санамжийг хадгалж өвлүүлж ирсэн өмнөх өв түүх, уламжлалаас бидний төслийн судлаачдаас<sup>74</sup> дараах дөрвөн зүйлийг тусгайлан онцлон авч үзэж өв түүхийн эрхэмлэх зүйлс (үнэт зүйл) гэж үзэж байгаа юм. Үүнд: Монголын түүхийн өв уламжлалаас

Нэгдүгээрт, “Монголын нууц товчоон” үндэсний ой санамжийн дээд шүтээн

Хоёрдугаарт, “Их засаг” буюу монголын хууль эрх зүйн уламжлал

Гуравдугаарт, Монголын төрөөс газар нутгаа хамгаалах талаарх бодлого, үйл ажиллагааг,

Дөрөвдүгээрт, Төрийн албаны түүхэн уламжлалыг монголын “Өв түүхийн үнэт зүйл эрхэмлэх зүйлүүд” гэсэн дөрвөн зүйлээр тусгайлан авч үзэж судалгаа хийсэн.

Монголчууд “Нууц товчоон” (цаашид “МНТ”) гэх үнэт бичгийн сурвалжаа өөрсдөө бичиж үлдээж чадсанаараа энэ цаг үед үндэстэн улс байх нэг гол тулгуураа олж, үндэсний ой санамжийн гол эх суурь үндсийг тавьсан юм.

1989 онд ЮНЕСКО-ийн Соёлын өвд “Монголын нууц товчоон”-г бүртгэж, монголчууд төдийгүй нүүдэлчин ард түмний үнэт соёлын өв хэмээн үнэлэн тэмдэглэсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн зарлигаар “МНТ”-г өрх бүр хоймроо залсан бол Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2022 оны долоодугаар сарын 11-ий өдрийн 159 дүгээрт Эзэн Богд Чингис хааны суу алдар, агуу их түүхэн үйл хэргийг сурвалжлан судлах, түгээн дэлгэрүүлэх, эрхэмлэн дээдлэх, алдаршуулан мөнхжүүлэх, төрт ёсны үнэт өвийг бэхжүүлэх, эв эеийг бататгах үүднээс “Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” зарлиг гаргасан билээ.

Дээрх улс төрчид, төрийн баримт бичгүүдийн тодорхойлолт, судалгааны байгууллагууд, судлаачдын саналыг үр дүнг нэгтгэн дүгнэхэд:

Нэгдүгээрт - Үнэт зүйл, эрхэмлэх зүйлүүдийг зөв бүлэглэх

Хоёрдугаарт - Үнэт зүйлсийг эрэмбэлэх

Гурав дугаарт - Нэр томъёог жигдлэх шаардлагат байна гэж үзэж байна.

Үнэт зүйл, эрхэмлэх зүйлүүдийг бүлэглэхдээ:

- үндэсний нийтлэг нэг үнэт зүйл,
- үндэсний нийтлэг эрхэмлэх зүйлүүд (төрийн)
- нийгэм соёлын эрхэмлэх, үнэт зүйл гэж ангилж болох юм.

Эдгээр нь үндэсний ой санамжийг хуваасан хоёр үндсэн хэсэгтэй уялдах нь зүйтэй. Соёлын (нийгэм) эрхэмлэх зүйлийг Соёлын тухай хууль, Соёл, урлагийн сургуулийн судалгаанд тулгуурлах, дээр нь өв түүхийн үнэт зүйл буюу Чингис хааны билиг сургаалийг нэмэх нь зүйтэй байна.

Төр, үндэсний эрхэмлэх зүйлүүдийг Үндсэн хууль, аюулгүй байдлын эрх зүйн баримт бичгүүдийн язгуур ашиг, сонирхол гэсэн тодорхойлолтуудад үндэслэж, эрэмбэлэх асуудлыг хүн төвтэй аюулгүй байдлын үзэл баримтлал дээр тулгуурлах нь зөв байна гэж үзсэн.

---

<sup>74</sup> БСШУС-ын Сайдын А/146 тоот тушаалын хавсралт жагсаалтын 11-г үндэслэн “Үндэсний ой санамж, үнэт зүйлсийг сэргээн тодорхойлох замаар үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нь” нэртэй БШУЯ-ны захиалгат төслийн удирдагч Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төвийн дарга асан Ч.Сосорбарам.

Монгол Улсын “Үндсэн хууль”, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хуульд заагдсан зарчим, язгуур ашиг сонирхол, амин чухал дархлааны агуулгыг эрхэмлэх зүйл, үнэт зүйл гэх ухагдахуунтай шууд холбоотой гэж үзээд эдгээрийг эрэмбэлвэл:-тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, -монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох,-үндэсний эв нэгдэл, -хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал,- эдийн засгийн тогтвортой, хөгжил-экологийн тэнцвэрт хөгжил гэсэн дараалал харагдах юм. Мөн иймэрхүү байдлаар , -Эх орон,-үндэс угсаа, бахархал,-үндэсний ашиг сонирхол,-ёс зүй, хууль, -төрт ёсны үзлийг дээдлэх гэсэн үнэт зүйл бүхий жагсаалт ч хууль эрх зүйн үндэслэлээр бичиж болно.

“Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал»-д үндэсний үнэт зүйлс:-Эх орон, -Газар нутаг, -Монгол хүн,-Нүүдлийн ахуй,- Түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээл, -Уламжлал, шинэчлэлийн төгс зохицол гэсэн дараалалтай байна.

Нэр томъёоны талаар. Тус төслийн сүүлийн 2022 оны 10 сарын эрдэм шинжилгээний хурал дээр ШУА-ийн Түүх угсаатны зүйн хүрээлэнгийн захирал доктор Ц.Цэрэндорж хэлсэн үгтээ “Тус төслийн багаас үнэт зүйл, эрхэмлэх зүйлсийн талаарх нэр томъёог жигдрүүлэх, Улсын нэр томъёоны зөвлөлөөр хэлэлцүүлэх талаар ч санал гаргасан. Энэхүү ажил нэгээс илүү олон жил үргэлжлэх олон судалгааны байгууллагын зөвшилцлийн төвөгтэй үйл ажиллагаа учраас энэ удаа манай төслийн баг тодорхой санал гаргах нь зүйтэй гэж үзсэн.

Нэр томъёоны тухайд Монгол Улсын “Үндсэн хууль” болон “Соёлын тухай хууль”-д “Үнэт зүйлс” гэдэг нэр томъёог хэрэглэсэн байдаг. Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлалын 3.3.3.2.-д Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ гэж тодруулжээ.

“Алсын хараа 2050”-д хувь хүний болон нийгмийн түвшний үнэт зүйлс нь үндэсний онцлогтой нягт уялдаж, уламжлал, шинэчлэлийн тэнцвэрт харьцаанд шингэн сүлэлдэж үндэсний ижилслийг бүтээх учиртай” гэж тодорхойлжээ<sup>75</sup>.

ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн 2013 оны судалгаандаа <sup>76</sup> : “Монголчуудын эрхэмлэх, дээдлэх ёсон гэсэн сайхан үгсийг “үнэт зүйл” гэх үгтэй дүйцүүлэн хэрэглэх нь зүйтэй. Хүмүүс их төлөв нийтээр хүлээн зөвшөөрдөг, үйл хөдлөлдөө даган мөрддөг нийтлэг жишгүүд байдаг бөгөөд чухам тэдгээрийг үнэт зүйл буюу эрхэмлэх зүйлс гэнэ. Эрхэмлэх дээд ёс гэдэг үг хүмүүс зан үйлдээ удирдлага болгодог эрхэм дээд үзэл санаа (туйлын зорилго, чин хүслэн) итгэл үнэмшил тогтоосон жишгүүд байдгийг зааж байна” гэжээ.

Аливаа нийгэмд нийтээр хүлээн зөвшөөрсөн, дагаж мөрдвөл зохих нийгмийн зан үйлийн хэм хэмжээ, үнэт зүйлийн чиг баримжааг нийгмийн гишүүдэд эзэмшүүлэхгүйгээр ямар ч нийгмийн систем тогтвортой, хэвийн хөгжиж чадахгүй гэж нийгэм судлаачид үздэг. Нөгөө талаас хүн нийгэмд үйлчилж байгаа эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээ, нийтээр хүлээн зөвшөөрч дагадаг үнэт зүйл, эрхэмнэлийг

<sup>75</sup> “Алсын хараа-2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал” УБ., 2019 он, 90-р тал

<sup>76</sup> Г.Чулуунбаатар., Д.Даш-Ёндон “Монголын нийгмийн өөрчлөлт” ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ., 2013 он, 1-р тал

амьдрал, үйл ажиллагаандаа баримтлах тал дээр төслийн багаас тодорхой санал гаргах оролдлого хийж байна.

Санал. Судалгааны явц, саналуудын үр дүнгээс үзвэл “эрхэмлэн хүндэтгэдэг үзэл бодол, итгэл үнэмшлийн цогц” гэдэг агуулгаар үндэсний хэмжээнд зөвшилцсөн зөвхөн нэг нийтлэг үндэсний “Үнэт зүйл”-тэй байх нь зүйтэй бөгөөд дээр нь өв түүх төрт ёсны, өв соёл нийгмийн одоогийн “Үнэт зүйлс” гээд байгаа нэршлийг “Эрхэмлэх зүйл” гэх саналтай байна. Үүнд:

1. Нийтлэг нэг үндэсний үнэт зүйл:

Үнэт зүйл нь бодит үйл явдлыг үнэлж цэгнэх шалгуур, хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны утга учрыг тодорхойлох хүчин зүйл, нийгмийн харилцан үйлчлэлийн зохицуулагч ч гэдэг үүднээс үндэсний үнэт зүйл нь товч тодорхой, хүн болгон ойлгон дагадаг уриа байх ёстой байдаг. Энэхүү агуулгаар дээрх судалгаанууд үнэт зүйлийн хэлэлцүүлэг, социологийн судалгааг үндэслэн гаргасан “МОНГОЛ МОНГОЛООРОО ХӨГЖИХ” гэсэн нийтлэг нэг үнэт зүйлийг (манай төслийнхний тодорхойлолт) Та бүгдэд санал болгож байна. “Монгол монголоороо” гэсэн нь цаанаа монгол хүнийг цөм болгож, түүх, төрт улс, соёл, уламжлалаа хүндэтгэн, дангааршил, ондоошлын харьцааг зөв байлгах санааг, “хөгжих” гэсэн үг нь даяаршилд зохицох, ардчиллыг эрхэмлэх, мэдээллийн шинжлэх ухаанд суурилах гэсэн утга, агуулгатай юм. Ер нь ардчиллыг “Хууль дээдлэх” гэдэгтэй холбож ойлгож байх нь зөв билээ. “Монгол” гэдэг үгийг дэлхийд Чингисийн монгол гэж ойлгодгийг ч тэмдэглэх нь зүйтэй. Доктор Д.Даш-Ёндон “Үндэсний ой санамж гэдэг ойлголтыг зүгээр л үндсэрхэх үүднээс судалдаггүй. Үндэсний ой санамжийг судалж, бататгах нь Монгол Улс өөртөө дүйж хөгжих нэн чухал субъектив хүчин зүйл юм. Өөртөө дүйж хөгжихүй гэдэгтээ бид монголоо алдахгүйгээр Монгол монголоороо байж, монголоороо хөгжье гэсэн утга бүхий санаа хэлж байгаа юм. Үндэсний ой санамж баттай байсан цагт бид монголыгоо гадаадын нүдээр бус өөрийн төрөлх нүдээрээ харж хөгжин цэцэглэх болно. “Хэн ертөнц рүү ухаалгаар харж байна, ертөнц ч түүн рүү сайнаар харна”. Доктор Н.Жалбажав “Монгол хүн, монгол оюун ухаан, монголын түүх, монгол өв соёл, монгол урлаг, монгол ёс заншил, уламжлал бол улс эх орны бахархал, үнэт зүйл байх ёстой.” гэж үзсэн.

ШУА-ийн Философи, социологи эрхийн хүрээлэнгийн 2013 оны судалгаагаар Монголын нийгмийн сэтгэл зүйд байгаа гурван үндсэн хандлагын<sup>77</sup> “Монголыг монголоор нь байлгах” буюу үндэснийхээ эрхэмлэлийг нээлттэй нийгмийн нөхцөлд ч хадгалан хамгаалах хандлагыг нөгөө хоёр хандлага нь хүн төрөлхтний үнэт зүйлсийг дээдлэх болон үндэсний эрхэмлэлийг нээлттэй нийгмийн нөхцөлд дасган зохицуулах гэсэн бүхий л санаа агуулгыг бидний санал багтаасан гэж бодож байна.

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн захирал, доктор Б.Пүрэвсүрэн<sup>78</sup> 2022 оны 11-р сард “Соёлын боловсролын үр дүн бол үнэт зүйлээ эрхэмлэн дээдэлсэн, эерэг хандлагатай, бүтээлч монгол хүн мөн”, “Айсуй монгол хүн нь эрхэм чанараа гээлгүй, ижилсэл ондоошлоо марталгүй, эх хэлнийхээ өлгийд бойжсон, хүж дэлхийн хүн байх”, “Монголоо хайсан монгол”, “Монголоо ярьсан монгол”, “Монгол хүний хөгжлийн

<sup>77</sup> Г.Чулуунбаатар., Д.Даш-Ёндон “Монголын нийгмийн өөрчлөлт” ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ., 2013 он, 185-р тал

<sup>78</sup> Б.Пүрэвсүрэн “Бүх нийтийн соёлын боловсрол” -“Соёлын бүтээлч үйлдвэрлэл-2022” форум (2022.11.22)-ын илтгэл

бодлого наанадаж даяаршлын болон дангааршлын найрсалд тэмүүлэх явдал юм” гэх мэт дүгнэлтүүдтэй ч нийцэж байна. Мөн “Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого»-д Монголын үндэсний үнэт зүйлсийг “...УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨГС ЗОХИЦОЛ” гэсэн тодорхойлолттой агуулга нь нийцэж байгаа юм.

## 2. Үндэсний нийтлэг эрхэмлэх зүйлс

Монгол Улсын Үндсэн хууль, аюулгүй байдлын үзэл баримтлалд заагдсан үндсэн зарчим (Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх), язгуур ашиг сонирхол (тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил), амин чухал дархлаа (Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх) гэх мэт үгээр тунхагласан бөгөөд эдгээр зарчим, язгуур ашиг сонирхол, амин чухал дархлааны агуулга нь эрхэмлэх зүйл, үнэт зүйл гэх ухагдахуунтай шууд холбоотой, үндэслэл болгох боломжтой гэж ойлгож байна.

Үндсэн хууль, бусад эрх зүйн баримт бичгийн дагуу үндэсний эрхэмлэх үнэт зүйлсийн эрэмбэ<sup>79</sup>:-тусгаар тогтнол, газар нутаг, бүрэн эрх, -ард түмэн, соёл иргэншил,-үндэсний эв нэгдэл, -хүний эрх, эрх чөлөө,-эдийн засаг, экологийн тэнцвэрт, тогтвортой, хөгжил. “Алсын хараа-2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал»-д үндэсний үнэт зүйлсийн эрэмбэ:-Эх орон, -Газар нутаг, -Монгол хүн, -Нүүдлийн ахуй, -Түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээл, -Уламжлал, шинэчлэлийн төгс зохицол. *Н.Жалбажавын үндэстний нийтлэг эрхэмлэх (үнэт) зүйлсэд:* -Улсын тусгаар тогтнол, -Иргэн түүний эрх, эрх чөлөө, -Хууль цааз, -Соёл иргэншил, хэл, үндэсний соёл урлаг,-Байгалиа хамгаалах монгол арга ухаан, өв уламжлал *гэсэн дээрх тодорхой саналуудаас үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурал эсхүл олон нийтийн төлөөлийн чуулга уулзалтаар үндэсний нийтлэг эрхэмлэх зүйлийн эрэмбэ дарааллыг тодорхой болгох нь зүйтэй гэж үзлээ.*

## 3. Өв соёл нийгмийн (ард түмний) эрхэмлэх зүйлс:

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Эдүгээгээс 860 жилийн тэртээ дэлхийн түүхийн мянганы суут хүмүүн Тэмүжин мэндэлж, төрт ёс, түүх соёл, хууль цаазын дор монгол туургатныг нэгтгэн, өнө эртнээс уламжлалтай төрт улсаа сэргээн мандуулж, Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсыг байгуулан, Монголын Эзэнт гүрний сүр хүчийг тунхаглан, монгол үндэстний суу алдрыг бадраасан Эзэн Богд Чингис хаан болон өргөмжлөгдөж, дэлхий дахинд Монголын их амар амгаланг тогтоосон билээ.” гэсэнтэй бидний санал болгож байгаа дээрх өв түүхийн эрхэмлэх (үнэт) зүйлс нийцэж байгаа юм.

Соёл Урлагийн Их Сургуулийн өв соёл, уламжлалын судалгааны үр дүн болох “Эрдэнийн есөн шогол” болон “Монголчууд төдийгүй нүүдэлчин ард түмний соёлын үнэт өв” хэмээн дэлхий дахин ЮНЕСКО үнэлэн тогтоосон болон тогтоогдох ёстой биет болон биет бус өвүүдийг өв соёлын эрхэмлэх зүйл хэмээн бидний судлаачид үзэж, дэмжиж байгаа юм.

<sup>79</sup> Монгол Улсын “Үндсэн хууль”, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хуульд заагдсан зарчим, язгуур ашиг сонирхол, амин чухал дархлааны агуулгыг эрхэмлэх зүйл, үнэт зүйл гэх ухагдахуунтай шууд холбоотой

Соёлын (нийгмийн) эрхэмлэх зүйлс:“Монгол хүн,гэр бүл,төрт ёс,эх нутаг,монгол хэл,эрдэм боловсрол,өв соёл,нүүдэлчний ухаан,ёс суртахуун” гэсэн есөн эрдэнэ, дээр нь Чингис хааны билиг сургааль буюу Өв түүхийн эрхэмлэх дараах зүйлсийг нэмэх саналтай байна.

- “Монголын нууц товчоон” үндэсний ой санамжийн дээд шүтээн
- “Их засаг” буюу монголын хууль эрх зүйн уламжлал
- Монголын төрөөс газар нутгаа хамгаалах талаарх бодлого, үйл ажиллагаа
- Төрийн албан хаагчдын хуульчлагдсан эрхэмлэх зүйлс, уламжлал
- Алтан аргамж гадаад харилцааны бодлого

Ийнхүү үнэт зүйлсээ тодорхойлохын тулд тэргүүлэх эрдэмтдэдээ суурилж, олон судлаачдыг оролцуулж, олон нийтээр хэлэлцүүлэг хийх арга хэлбэрээр судалгааны байгууллагын төлөөллөөс бүрдсэн манай төслийн баг ажиллаж, судалгаа хийлээ.

Үндэсний ой санамж, үнэт зүйл нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх ойлголт оюун санааны дархлааг бий болгох угтвар нөхцөл тул тэдгээрийг зөв тодорхойлж, олон нийт ялангуяа хүүхэд залуучуудыг нийгмийн хөгжлийн чиг баримжаагаа олоход нь чиглүүлэг болох асуудал юм.



# **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ТӨРТ ЁС БА МОНГОЛЧУУДЫН ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ, ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ**

## **2.1 Дэлхийн улс орнуудын төрт ёс ба ой санамж**

Төр улсынхаа болон ард иргэдийнхээ нэгдмэл болон аюулгүй байдлыг хангахад үндэсний ой санамжаа сэргээх, хадгалах, уламжлан хөгжүүлэхэд улс орон бүр анхаарч иржээ. Тийм учраас ой санамжийн агуулсан түүхээ бодитоор авч үзэх, тодорхой зорилго тавьж судлах, архивын баримтуудыг эргэж харах түүний бүрдүүлэлт, хөтлөлтийг сайжруулахад нэн тэргүүнд анхаардаг. Архивгүй улс гэж байхгүй билээ.

Ой санамж ийнхүү бодит эх сурвалжуудаар дамжин уламжлагддаг боловч түүний хэрэглээг бий болгоход нийтээрээ хүлээн зөвшөөрсөн үндэсний үнэт зүйлсийг тодорхойлох нь чухал бөгөөд үүнд албадлага огт хэрэггүй юм. Харин оновчтой арга зүйгээр судлан илрүүлсэн түүхэн нөхцөл байдал, үйл явдлуудын хэлхээ холбоо, өрнөлтийг задлан шинжилсэн судалгаа нэн чухал бөгөөд ингэх нь тухайн үндэстэн, ард түмний атрибутыг тодорхойлоход тусалдаг. Ингэхдээ ард түмнүүдийн газар нутаг, эко системийн онцлог, түүнд зохицон хөгжсөн аж ахуй, товчхондоо соёлыг нь харгалзан үзвэл зохино.

Ийнхүү үнэт зүйлс нь хувь хүний болон нийгмийн амьдралын удирдлагад нөлөөлдөг учраас улс орнуудын төрөөс нь үнэт зүйлсээ тодорхойлж, удирдах арга зүйдээ ашигласаар ирсэн нь олон орны нийгмийн амьдралаас тодорхой байдаг.

Үнэт зүйлийн тухай ойлголтыг цэгцтэй судалж, үнэт зүйлсийг тодорхойлох арга зүйг боловсруулсан Шэлом Шворц (Shalom Schwartz) өрнөдийн нийтлэг 10 үнэт зүйлийг асуулгын багцаар дамжуулан тодорхойлсон байдаг. Өрнөдөд үнэт зүйлийн тухай судалгаанд Шворцын арга зүйг хамгийн өргөн ашигладаг ба асуулгыг улс үндэстнүүд өөр өөрийнхөөрөө баяжуулан боловсруулж үнэт зүйлсээ тодорхойлох судалгааг хийсээр байна.

Цар тахал дэгдэж, халдварын вирус хувьсан өөрчлөгдсөөр дарагдахгүй үргэлжилж, бас дайн дажин дэгдсэн өнөөгийн цаг үед олон улс, олон ард түмэн дотоод, гадаад нөхцөл байдлаа сайжруулан бэхжүүлэх, бие даасан байх, эрүүл байх, аюулгүй байх, эрсдэлээс урьдчилан сэргийлж чаддаг байхад үндэсний үнэт зүйлс чухал гэж үзэж тэдгээрийг тодорхойлохыг хичээж байгаа нь илт байна. Үнэт зүйлс нь нийгмийн оюун санааг нэгтгээд зогсохгүй тухайн ард түмний тусгаар хийгээд бие даасан байдал, газар нутгийнх нь бүрэн бүтэн байдал, зах зээлийнх нь өсөлт, бууралт, тухайн улс үндэстний олон улс дахь нэр хүндэд нийгмийн амьдралыг чиглүүлэгч хэрэгсэл болохынхоо хувьд нөлөөлдөг юм.

Тийм ч учраас ард түмнүүд хэрэглээгээ дотоодоосоо хангах, үндэсний брэнд бүтээгдэхүүн бий болгох, үндэсний тааламжит амт, үнэрээ хадгалах, хэрэглэх чиглэлд тал бүрээр ажиллаж байна. Олон улсад нэвтэрсэн нийтийн хоолны брэнд сүлжээ үйлдвэрлэлд өөрийн үндэсний нэрийн бүтээгдэхүүнийг оруулж байгаа нь ч олон. Энд тухайлбал, солонгосчуудын үндэсний мах бэлтгэх, амтлах арга зүйгээр боловсруулсан “бөлгөгибүргэрийг” нэрлэж болохоос гадна мусульманчууд хоол хүнсний хорио цээрийг сахисан “халал” бүтээгдэхүүн хэрэглэдэг онцгой дэгтэй байдаг. Тийм ч учраас Исламын соёлт ард түмнүүдийн хүнсний зах зээлд нэвтрэх аливаа хүнсний бүтээгдэхүүнийг ислам шашны халал, хармын лс буюу хорио цээрийнх нь

ёсны дагуу бэлтгэн нийлүүлэх учиртай. Халал, хармын ёс нь "Коран судар"-т бичсэнээр уламжлагдан хөгжиж өнөөдрийг хүрсэн бөгөөд одоо халал бүтээгдэхүүн сонгон хэрэглэдэг хүний тоо бараг 2 тэрбум давжээ. Судалгаагаар ойрын ирээдүйд 2050 он гэхэд дэлхийн хүн амын 35 хувь нь энэ соёлын айд хамаарагдана гэсэн хэтийн төлөвийг зурагласан байна<sup>80</sup>. Ингэж үзвэл тэд 3 орчим тэрбумд хүрэх бөгөөд тэр үед нийт хүн төрөлхтөн 9.1 тэрбумд хүрэх болно.

Шэлом Шворцын тодорхойлсон нийтлэг 10 үнэт зүйлийн дотор "Уламжлал" багтсан ба үүнд: Уламжлалт соёл, итгэл үнэмшлээр дамжин өвлөгдөж буй ёс заншил, үзэл санааг хүндэтгэх, бусдын шашин шүтлэг бишрэлийг хүлээн зөвшөөрөх, ойлгох, хүлцэх улмаар уламжлалаар дамжиж байгаа ёс горимыг мөрдөх тухай ойлголт болохыг тодорхойлжээ. Нэг үгээр хэлбэл өрнө дахин уламжлалд үнэ цэн өгч байна. Түүнчлэн уламжлал тэдний оршихуйд эерэг нөлөөтэй гэж үзжээ.

Тэрчлэн Шворцын нийтлэг үнэт зүйлийн тухай онолд үнэт зүйлсэд түгээмэл 6 шинж байх бөгөөд үүнд үнэт зүйл нь итгэл үнэмшил, өөрөө сонгосон зорилт, даван туулах чадвар, стандарт, нөлөөт хүчин зүйл, хөдөлгөгч хүчний шинжтэй бөгөөд хоорондоо харилцан хамааралтай, бие биедээ нөлөөтэй гэж үзсэн байна. Ингэж үзвэл ой санамжид нөлөөлдөг үнэт зүйлс нь хөдөлгөөнтэй, шилжимтгий бөгөөд хүнийг ухамсартайгаар хөдөлгөгч хүч нь болдог байна.

Шашин нь түүх, нийгэм, соёлын үзэгдэл болохынхоо хувьд ийнхүү уламжлалтай нягт холбогддог болохыг Шворцын судалгаа баталгаажуулсан ба шашны ач холбогдол нь уламжлалыг тээдэг, хадгалдаг, дамжуулдаг үүргээр нь тодорхойлогдоно гэж олонх үзэх БОЛЖЭЭ

"Шашны итгэл үнэмшил нь олон төрлийн үнэт зүйлийг бүрдүүлдэг. Ялангуяа сайн, муугийн тухай ойлголт, гэр бүл, гэрлэлт зэрэг нийгмийн үнэт зүйлс нь шашин шүтлэгтэй холбоотой"<sup>81</sup> гэж үзэх нь бий. Өрнө, дорнын аль ч ард түмнүүдийн хуримын ёслол нь шашны үзэл санаа, зан үйл, уламжлалтай сүлэлдсэн байдаг.

Мөн түүнчлэн шашнаар дамжин уламжлагдсан ёс заншил, ёслол хүндэтгэлийн зан үйл нь төрийн ёслол хүндэтгэлд багтсан байх нь ч түгээмэл. Тэр хэрээрээ хүмүүсийн соёлын болон үзэл санаа, итгэл үнэмшлийн нэгдлийг хангаж байдаг юм. Тухайлбал, АНУ-ын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолд ерөнхийлөгчийн тангараг өргөж байгаа шинэ ерөнхийлөгч өөрийн гэр бүл байнга уншдаг "Библи" судар дээр баруун гараа тавьж, "Үндсэн хууль"-аасаа уншиж тангарагладаг бөгөөд Ертөнцийн эзнээс төр, ард түмэн болон "Үндсэн хууль"-аа хамгаалахыг гуйн залбирдаг билээ.

Тэрчлэн Монгол Улс нь төрийн тахилгатай 12 уул, хайрхантай бөгөөд тэдгээрийг тахиж журамтай.<sup>82</sup> Ингэж төр хийгээд шашны ёслол хүндэтгэл синтезлэгдсэн байх нь түгээмэл юм.

Тиймээс ой санамжийг үнэт зүйлээр ялангуяа уламжлалаар дамжуулан хадгалж байгаа зарим орныг жишээг дор авч үзье.

Япон Улс бол хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэгч улсуудын нэг бөгөөд хаант засаглалтай цөөхөн улсын нэг. Япон хүний амьдрал үйл ажиллагаа, японы нийгмийн үзэгдэл, үйл явцыг уламжлал, шашин соёл, зан заншлаас нь салгах боломжгүй.

<sup>80</sup> The Future of World religions: Population Growth Projections. (2010-2050), Pew Research Center, Global Religious Futures project. Apr. 2015. pp.7-8.

<sup>81</sup> <https://www.pewresearch.org/politics/2009/05/21/section-4-religion-and-social-values/>

<sup>82</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 7 дугаар сарын 7-ы өдрийн 32 дугаар Зарлигаар Төрийн тахилгатай уул, овооны тэнгэрийг тайх тахилгын ёслолын журмыг баталсан.



Япончуудын үлгэр домгийг хүн төрөлхтөн шашин соёлтой байх цөөн эх сурвалжийн нэгд оруулдаг юм. Хүн төрөлхтний шашин соёлын уг үндэс, эх сурвалжийг эрж судалсан, бүртгэсэн судалгаа олон боловч XXI зуунд цахимаар бүртгэх хөгжүүлэх арга түгээмэл болж, тэнд япон домог зүйг хэрхэн шашны эх сурвалжид тооцож байгааг үзүүлсэн нь бий<sup>83</sup>. Мөн тэрчлэн япончуудын эртний уламжлалтай шашин шүтлэг, итгэл бишрэл, шашны зан үйл нь тэдний оюун санаа, нийгмийн амьдралд нь тодорхой үүрэг гүйцэтгэсээр байгааг өнөөгийн нийгмийн дүр төрх, үйл ажиллагаа нь нотолж байна.

Япон үндэстний шашин Шинтоизмын шинто (Shinto 神道) гэдэг нь “Шүтээдийн зам” гэсэн утгатай ба энэ шашин олон шүтээнтэй. Шинтоизм уламжлалыг дамжуулдаг, тогтоон барьдаг шашны үүргийг сайн гүйцэтгэдэг Энэ шашинд дэг ёсыг сахих нь чухал бөгөөд япончуудын биеэ авч явах байдалд ч дэг ёс тод илэрнэ. Шинтоизм зан үйл, ёс заншлаар баялаг ба японы төрт ёсонд уусаж уламжлагдсан нь ч олон. Тухайлбал, Японы Эзэн хааныг хаан ширээнд залах ёслолын үйл ажиллагаанд шинтоизм тод туссан байдаг. Япон 1300 гаруй жилийн хаант засаглалын түүхтэй ба одоо 126 дахь Эзэн хааны үе үргэлжилж байна.

Дорно, өрнийн аль ч улс орны түүх, утга зохиол, үлгэр домог, шашны үзэл санаанд хаан хүн бол тэнгэр эсвэл тэнгэрийн эрхэстэй холбоотой, дээд заяатан байдаг нийтлэг өгүүлэмжтэй байдаг юм. Монголчуудын үлгэр домгийн сэтгэлгээгээр бол манай Чингис хаан дээд тэнгэрээс заяатай их хаан билээ. Тэр жишгээр японы ард түмний хувьд Эзэн хаан нь нарыг эрхшээгч шүтээн, нарны бэлгэдэл Аматерасу (Amaterasu Omikami 天照大御神, 天照大御神)-ийн үр сад, хойчийг залгамжлагч юм. Ийнхүү япончууд өөрсдийгөө нарнаас эх үүдэлтэй гэж үзэж нарны дарь эхийг шүтдэг ба Япон буюу Nippon, Nihon (日本) гэдэг нь нарны эх булаг гэсэн утгатай, мөн Их Наран Улс нэртэй байсан ч түүх бий. Япон Улсын төрийн далбаа дээр тэг дугуй, гал улаан нар байдаг. Японы төрийн далбааг нишоки (Nisshoki 日章旗) буюу нарны далбаа эсвэл хиномару (Hinomaru 日の丸) буюу наран дүгрэг гэж нэрлэдэг ба бүхэлдээ наран ургах зүгийн орон гэдэг утгыг илэрхийлдэг гэж тайлбарлах нь бий.

Эрт үед япончуудын амьжиргааны гол эх булаг нь хөдөө аж ахуй, газар тариалан байснаас гадна далай тэнгисээс махан хүнс буюу уургийн хэрэглээгээ хангадаг арлын ард түмэнд тэнгэр бүрхэг, манантай байх нь ургацад болон загасчлахад таагүй бөгөөд нартай өдөр олон байх тусам амьжиргаанд нь ач тустай байх нь зүйн хэрэг. Энэ байдал нь тэд нарыг, байгалийг шүтэх бас нэг бодит үндэс болжээ.

Японы домог зүйн гол дүр Шинто шашны гол шүтээн, нарны дарь эх Аматерасу газрын хаосыг цэгцлэх үүрэг өгч илгээсэн шувуу нь үүргээ умартаж үзэсгэлэнт бүсгүйтэй нөхөцсөн тул араас нь ач хүүгээ газар руу илгээсэн бөгөөд түүний үр сад нь эзэн хаан ажээ. Тиймээс эзэн хааны зарлиг бол нарны үр сад, нарны элчийн зарлиг тул хүн бүр сахин биелүүлэх ёстой. Ийнхүү Аматерасугийн удам угсаа Эзэн хааныг хаан ширээнд залах ёслол нь Шинто шашинтай нягт холбоотой бөгөөд Эзэн хаан бол Япон төрийн тэргүүн, Японы ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч, Японы Дээд шүүхийн дархлаа, Шинто шашны тэргүүн юм.

Эзэн хаанд Аматерасу эхээс уламжлалтай ариун толь, сэлэм, хас тамгыг өргөх Шинтоизм хийгээд японы төрт ёс хоёрын хосолмол зан үйл болох Сокүй но рэй (Sokui

<sup>83</sup> [foundation.org/world-religions-tree.html](http://foundation.org/world-religions-tree.html)

no rei 即位の礼) ёслолыг үйлдэх бөгөөд Эзэн хаан бээр хаан ор залгасан жилээ шүтээдэд талархал илэрхийлж бас эх орон, ард түмнээ даатган залбирдаг Дайжосай ёслол, зан үйлийг үйлдсэнээр сая албан ёсоор Эзэн хаан болдог юм.

Дайжосай ёслолоор нийт япон даяараас шилж сонгосон дээд зэргийн цагаан будаан зоогийг Эзэн хаан, хатан нарт барьдаг ба зоогийн эхэнд хаан, хатан нар японы ард түмэн арвин ургац авч, амар амгалан амьдарч байгаад Амаатерасу эх тэргүүтэй байгалийн юмс үзэгдлийг хариуцдаг шүтээдэд амтат цагаан будаагаар тахил өргөн талархал илэрхийлэхийн сацуу төр улс, ард түмнээ даатган залбирдаг. Эндээс үзвэл Шинто шашны тэргүүн Эзэн хаантанд сонгож өргөсөн цагаан будаа бол шүтээдийн ч тахил болдог байна.

Эзэн хааны гэр бүл нь Амаатерасугийн үр сад хэмээх япон домог зүйн сэтгэлгээг орчин үед уламжлан хадгалж, төр улсынхаа ой санамжийг батжуулж, дангаарчлалыг бэхжүүлж Японы 125 дахь эзэн хаан Акихито (Aki hito 明仁) 1989 оны 11 дүгээр сард мөн түүний хүү Япон Улсын одоогийн эзэн хаан Нарухито (Naru hito 德仁) 2019 оны 11 дүгээр сарын 14-ий өдөр тус тус Дайжосайг үйлдэж Амаатерасу тэргүүтэнд төр, ард түмнээ даатган залбирч, хаанчлалын хугацаандаа цорын ганц удаа үйлддэг энэ зан үйлийг гүйцэлдүүлсэн түүхтэй юм.

Дайжосайд Ерөнхий сайд тэргүүтэй засгийн газрын төлөөлөл болон бусад зочид төлөөлөгчид, ард түмний төлөөлөл оролцдог уламжлалтай. Эзэн хаан Дайжосай үйлдсэн жил ургацын баяр Нийнамэ сай (Niiname- sai 新嘗祭)-г алгасдаг. Японы ургацын баяр нь нийтээр тэмдэглэх баярын өдөр тул 11 дүгээр сард тохиодог энэ баярын өдөр ард нийтээрээ амардаг юм.

Тэрчлэн Хэй аний үеийн буюу Х зууны үеийн "Кимигаё"<sup>84</sup> (Kimigayo) "Эзэн хааны төр" хэмээх шүлэгт 1880 онд Японы хөгжмийн зохиолч, тухайн үеийн эзэн хааны шүүхийн хөгжимчин Хиромори Хаяаши бээр ая зохиосныг 1888 онд "Төрийн дуулал" болгосон бөгөөд цаг төрийн ороо бусгаа байдлаас шалтгаалан японы төр хэдэнтээ эргэсэн боловч "Төрийн дуулал" нь өөрчлөгдөөгүй юм.

Ийнхүү эртний уламжлалт төр хийгээд шашин соёлын холбоо харилцаагаа орчин үед иргэншүүлэн уламжилж, хөгжүүлсээр байгаагийн нотолгоо мөн болно. Тэрчлэн япончууд ой санамждаа тулгуурлан өвөрмөц уламжлалт соёлынхоо шүхэр дор хөгжин цэцэглэсээр байгаа билээ. Япон хүнтэй харилцах, японы зах зээлд нэвтрэхэд япон соёлд суралцахаас илүү арга гэж үгүй.

БНХАУ бол ардыг удирдах арга зүйдээ ой санамжаа удирдлага болгодог юм. Эртний Хятадын Хавар Намар Улсын (Chunqiu 春秋)" үе бол хятадын түүхэн дэх их өөрчлөлт шинэчлэлийн үе байсан гэж үздэг. Учир нь энэ үед Хятадад улс төр, эдийн засаг, соёл зэрэг нийгмийн амьдралын бүхий л салбарт нь томоохон өөрчлөлтүүд гарчээ. Тухайлбал, энэ үед зөвхөн язгууртнуудыг сургадаг, түшмэл багштай төрийн сургуультай зэрэгцэн "хувийн сургууль" хөгжиж эхэлсэн байна. Хувийн сургууль хөгжсөнөөр эрдэмтэн мэргэд хувийн шавьтай болж, ноёд түшмэдийн боловсрол ард олны дунд түгж<sup>85</sup> <sup>86</sup> ард иргэд эрдэм мэдлэг эзэмших суурь тавигджээ. Энэ нь

<sup>84</sup> www.gov.scot Curriculum for excellence: religious and moral education.

<sup>85</sup> Хавар Намар улс нь МЭӨ 770-476 оны хоорондох үеийг хамарна.

<sup>86</sup> Эртний Хятадад хамгийн анхны ийм сургуулийг Күнз үндэслэсэн гэж үздэг.

аажимдаа эртний Хятадад “цэцэгсийг дэлгэрүүлж, эрдэмтдийг цэцлүүлэх” (bai jia zhengming 百家争鸣) нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Энэ үед өсөж өндийн, үзэл номлолоо боловсруулж, үг сургаалаа айлдаж байсан мэргэдийн нэг нь Күнз (Kong zi-孔子) юм. Тэр бээр хятадын ард түмний соёл, сэтгэлгээнд гүнзгий нөлөөлж, хүн төрөлхтний түүхэнд нэр алдраа үлдээсэн сэтгэгч билээ.

Багаасаа эцгээсээ өнчирч, сахилга бат, дэг журмыг эрхэмлэдэг эхийнхээ нөлөөн дор өсөж хүмүүжсэн Күнз бага наснаасаа сургуульд сурсан ба өргөн мэдлэг, өндөр ёс суртахуунтай гэрийн багш болон эхийнх нь нөлөөн дор түүний үзэл санаа бүрэлдэн төлөвшжээ.

Күнзийн сургаал номлол, ёс зүйн сургаал, засаглалын тухай үзэл нь Хятадын төрт ёс, төрт ёсны үзэл санаанд чухал нөлөөтэй явж ирсэн бөгөөд одоо ч сууринд нь бат хадгалагддаг. Тиймээс БНХАУ-д коммунист нам нь Күнзийн сургаалд тулгуурласан үндэсний үзлийг бодлогоор хөгжүүлж төр засгийг удирдах, ардыг засах арга болгон хэрэгжүүлж байна.

Орчин үеийн олонх хятад киноны агуулга нь гэр бүл, эв нэгдэл, бие биедээ туслах, хайрлах, ачлах, асрах, ахмадыг хүндэтгэх, тэдний үгийг сонсож, амьдрал ахуйдаа тусгах тухай байдаг. Энэ агуулга нь Күнзийн сургаалын шууд тусгал юм.

Мөн ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт нь болон их, дээд сургуульд элсэгчдийн элсэлтийн шалгалтад Күнзийн үзэл сургаалын талаар асуулт оруулдаг<sup>87</sup>. Энэ бол Күнзийн сургаал хятад хүний боловсрол, хүмүүжилд эерэг нөлөөтэй гэж үзэж төрөөс нь сонгон авч хэрэглэж байгаа хэрэг юм. Тэгвэл Күнзийн сургаалын агуулга юу вэ?

Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл” “论语” зохиол нь түүний сургаал номлолын агуулгыг илэрхийлэх чухал эх сурвалжийн нэгд зүй ёсоор ордог. Улс төр, ёс суртахуун, сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг олон салбарын үзэл санааг багтаасан энэ зохиол нь Хятадын эртний Хань улсын үеийн нэрт түүхч, зохиолч Бан Гү (班固)-ийн<sup>88</sup> өгүүлсэнчлэн “Күнз шавь нартаа болон бусдад сургаал номлолоо айлдах үед гарсан асуулт хариулт хийгээд хэлэлцэн цэцэлсэн мэтгэлцээн бөгөөд тухайн үед шавь нар нь тус бүрдээ багшаасаа сурч мэдсэнээ тэмдэглэдэг байгаад хожим багшийгаа нас барсны дараа тэмдэглэлүүдээ нэгтгэж эмхэтгэн<sup>89</sup> бүтээсэн бүтээл бөгөөд зохиолын гол агуулга нь ачлахуйн тухай юм.

Судлаачид Күнзийн сургаал, үзэл санааны хамгийн гол ойлголт нь “өршөөл” (仁) гэж үздэг бөгөөд “өршөөл”-ийг үйлдэх, “өршөөл”-тэй байхын суурь нь “ачлал” (孝) буюу аав ээж, ахас ихсээ өргөн тэтгэж, хүндэтгэх явдал гэж үздэг юм.

“Ачлал” нь хятад хүний ахуй амьдрал, уламжлал, зан заншилтай нягт холбогддог

<sup>87</sup> [https://wenku.baidu.com/tfview/9c603e43c381e53a580216fc700abb68a982adc1.html?fr=launch\\_ad&SS-bdtg52&utm\\_source = bdss-WD&utm\\_medium=cpc&utm\\_account=SS-bdtg52&utm\\_term=2&utm\\_content=1&e\\_creative = 64173126303&e\\_keywordid=418335641287&bd\\_vid=7363667432028578575](https://wenku.baidu.com/tfview/9c603e43c381e53a580216fc700abb68a982adc1.html?fr=launch_ad&SS-bdtg52&utm_source = bdss-WD&utm_medium=cpc&utm_account=SS-bdtg52&utm_term=2&utm_content=1&e_creative = 64173126303&e_keywordid=418335641287&bd_vid=7363667432028578575)

<sup>88</sup> Бан Гү (МЭ 32-92) Эртний Хятадын Хань улсын үеийн сайд, түүхч, утга зохиол судлаач. Түүхэнд Күнзийн гол зохиол “Шүүмжлэл өгүүлэл”-ийн гурван өөр хувилбар байсан гэж үздэг бөгөөд өдгөө уламжлагдан ирсэн “Шүүмжлэл өгүүлэл” нь 20 бүлэг, 492 зүйлтэй. Түүнээс 444 зүйл нь Күнз шавь нартайгаа болон тухайн үеийн хүмүүстэй ярьсан харилцан яриа, үлдэх хэсэг нь Күнзийн шавь нарын хоорондын харилцан яриа юм.

<sup>89</sup> 班固汉书艺文志.中华书局.1975.年版

тул хятадын өөрийн болон гадаадын эрдэмтэн судлаачид “ачлал” бол хятадын соёлыг бусад соёлоос ялгах гол онцлог, хятадын соёлыг “хятад соёл” болгож байгаа хамгийн чухал хэсэг гэж үздэг. Тухайлбал, Гегель “Түүхийн философи” зохиолдоо “...Хятад энэхүү ёс суртахууны уялдаа холбоон дээр бий болсон бөгөөд гэр бүл дэх ачлал хүндлэл нь тэдний гол онцлог мөн”<sup>90</sup> гэжээ. Түүнчлэн хятад хэлэнд “百善孝为先 bai shan xiao wei xian” гэсэн хэлц үг бий бөгөөд энэ нь “хамаг сайн үйлийн эх нь ачлал” гэсэн утгатай юм.

Күнзийн үзэл номлолын гол агуулга нь ёс суртахуун байдаг. Иймээс Күнзийн засаглал, улс төрийн тухай үзэл сургаал нь ёс суртахууны сургаалтай нь нягт холбогддог онцлогтой. Юуны түрүүнд Күнз ёс суртахуунаар засаглах (Wei zheng yi de 为政以德)<sup>91</sup> үзэл санааг дэвшүүлсэн бөгөөд тэрээр улс төр, засаглалын үйл хэрэгт удирдагч хүний ёс суртахуун чухал үүрэгтэй гэж үзжээ. Удирдагч хүн ёс суртахуунтай байж, өөрийн ёс суртахуунаар ард олноо үлгэрлэн дагуулах аваас ард олон түүнийг аяндаа тойрон хүрээлнэ гэж үзсэн нь тодорхой байдаг. Тэрээр “Засаглахуйд ёс суртлыг эрхэм болговоос алтан гадас мэт буюу. Өөрөө сууринаа бат сууж, үй олон од ямагт тойрон орчим бөлгөө.”<sup>92</sup> хэмээсэн нь бий.

Күнзийнхээр удирдагч хүний ёс суртахууны нэг чухал тал нь “голч, цэгц” (zheng 正) байдал юм. Хятад хэлэнд “正” хэмээх ханз үсэг нь “цэгц, чанх, тэгш, гол, төв” зэрэг утгыг илэрхийлдэг. Күнз “Засаглал хэмээгч нь төв шударгууг хэлмүй.”<sup>93</sup> гэжээ. Эртний хятадын гүн ухааны дэг сургуулийн нэг болох хуулийн сургаалтнууд (Fa jia 法家) “Ард түмнийг журамлах” буюу хуулиар засаглахыг чухалчилж байсан бол Күнз энэхүү Ш үсгээр удирдагч хүн “өөрийгөө цэгцлэх” тухай санааг дэвшүүлсэн юм. Өөрөөр хэлбэл удирдагч хүн төв, голч байдлаараа ард түмэндээ үлгэрлэх ёстой байна. Улс төрд “засаглах, захирах”-аас илүү удирдагчийн үлгэрлэл чухал гэж үзсэн нь илэрхий байдаг.

Нөгөөтээгүүр Күнз засаглалын үйл хэрэгт хууль цаазаас ёс суртахууныг чухалчилжээ. Энэ нь түүний “засаглалаар хөтөлж, хууль цаазаар цэгцэлбээс эгэл ард гэм ял үйлдэхээс зайлсхийх боловч гэмших сэтгэл эс төрмүй. Ёс суртлаар хөтөлж, ёслолоор цэгцэлбээс эгэл ардад ичингүйрэхүйн сэтгэл төрөх төдийгүй эрхбиш эрхшээн дагамуй.”<sup>94</sup> хэмээснээс тодорхой харагдана. Хууль цаазаар засаглах аваас ард олонд зайлшгүй албан татвар, эрүү шүүлт ногдох бол ёс суртахуунаар засаглаваас ард олон энэрэл хайр хүртэх ажээ. Күнзийнхээр, ард түмэн мөр бүтэн байж, нийгэм амар тайван байх нь улс төрийн гол зорилго мөн бөгөөд зөвхөн эмх журамтайгаас гадна хүнлэг энэрэнгүй, ёс суртахуунлаг нийгмийг бүтээх нь илүү чухал ажээ.

Тэрчлэн Күнз “ард түмнээ эцэг эх мэт үзэх” тухай сургасан бөгөөд энэ нь түүний

<sup>90</sup> 黑格尔. 历史哲学. 上海人民出版社. 1990 年版. 第 232 页

<sup>91</sup> Күнз “Шүүмжлэл өгүүлэл” Засаглахуй хэмээхүй хоёрдугаар бүлэг. Орч. М.Чимэдцэеэ, УБ., 2004 он, 156-р тал.

<sup>92</sup> Күнз “Шүүмжлэл өгүүлэл” Засаглахуй хэмээхүй хоёрдугаар бүлэг. Орч. М.Чимэдцэеэ, УБ., 2004 он, 27-р тал.

<sup>93</sup> Күнз “Шүүмжлэл өгүүлэл” Ян Юань хэмээхүй арван хоёрдугаар бүлэг. Орч. М.Чимэдцэеэ, УБ., 2004 он, 86-р тал.

<sup>94</sup> Күнз “Шүүмжлэл өгүүлэл” Засаглахуй хэмээхүй хоёрдугаар бүлэг, Орч. М.Чимэдцэеэ, УБ., 2004 он, 27-р тал.

засаглалын тухай сургаал дахь хариуцлагын талыг илэрхийлдэг. Гэр бүлд хүү, охин нь эцэг, эхээ өргөн хүндэлж, ачилдагчлан хаан хүн ард олныхоо өмнө “ачлах” хариуцлага хүлээнэ гэж үзсэн байна. Ийнхүү Күнзийн засаглалын тухай үзэлд засаглал хийгээд ёс суртахууныг нэг зүйлийн хоёр тал болгон авч үзсэн нь илт бөгөөд салган авч үзэх боломжгүй. Күнзийн энэ сургаал эртний хятадын улс төрийн сэтгэлгээний гол агуулга болсоор 2000 жилийн турш хятадын улс төрд зарчмын шинжтэй уламжлал болж хадгалагдсаар иржээ.

Улс орнууд өөрийн соёлдоо суурилсан сургалт судалгааг дэмжиж сурган хүмүүжүүлэх арга зүй, үндэстнийхээ ёс зүйн асуудалд уламжлалт шашин, соёлоо хэрэглэх нь түгээмэл юм. Тухайлбал, Шотландын засгийн газраас “Төгөлдөршлийн хөтөлбөр: Шашны ба ёс суртахууны боловсрол” сургалтын хөтөлбөрийг 1980 оноос эхлэн нэвтрүүлсэн байна<sup>95</sup>.

Ийнхүү төгөлдөршил гэдэг үгийг хэрэглэсэн нь Шотландын засгийн газар хүний төгөлдөршил сайжрахуйд шашин тодорхой үүрэгтэй гэж үзсэн ба Шотландын уламжлалт шашин болох Христосын шашны<sup>1</sup> ёс суртахууны! сургаалд тулгуурласан тухайгаа өмнөтгөлд нь бичжээ. Энэ тухай шашны хийгээд ёс зүйн боловсрол нь хүүхэд, залуу үе амьдрал түүний үнэт зүйлс, амьдралын зорилго, утга учрын нэгдэлтэй хийгээд ялгаатай талыг авч үзэж, түүнээс суралцах явдал мөн гэжээ. Шотландын түүх, уламжлалд Христосын шашин зонхилох байр суурьтай тул хөтөлбөрт Христийн шашны агуулгыг тусгасан хэмээн тэмдэглэсэн байна<sup>96</sup>.

Энэ мэтээр улс орнууд ой санамждаа тулгуурлан өөр өөрийн нийгмийн хөгжлийн онол, арга зүйг тодорхойлж, нийгмээ эмхэлж байгаа бөгөөд өөрөөрөө байх эрх чөлөөг эдлэхэд үнэт зүйлс нь тусалдаг болохыг дээрх орнуудын жишээнээс харж болох юм.

Өнөөдөр хөгжингүй орнуудад бүх түвшиндээ төрийн аливаа шийдвэр нийгэмд авч ирэх үр дагавар ялангуяа нийгэмд бий болгож, төлөвшүүлж байгаа эсвэл төлөвшүүлэхийг зорьж байгаа нийтийн үнэт зүйлд төвлөрөх ёстой гэж үзэж, үнэт зүйлээр удирдах тухай ярьдаг. Улс орны, нийгмийн, хувь хүний төвшинд тогтоодог болжээ.

Аливаа улс орон өөрсдийн “Нэн тэргүүний эрх ашгийг хэрхэн авч үзсэнээс ихээхэн хамааралтайгаар үндэсний үнэт зүйл нь тодорхой болж”<sup>97</sup>, үүнийгээ нийтээр хүлээн зөвшөөрч эрхэмлэсэнээр үндэстэн, угсаатны хэв шинж, төлөвшлийг буй болгодог байна.

Тухайлбал, Америкчууд “хувь хүнийг”, Япончууд “бүлэг багийг”, Шведүүд “нийгмийг” тус тус эрх ашгийн нэгдүгээрт оруулж чухалчилдаг. Үүний үр дүнд америк хүнд өөрийгөө илэрхийлэх ур чадвар, “би”-ийн хандлага их, япон хүнд баг, хамт олны шийдвэр, нийтийн хөдөлмөр, зарчим хүчтэй<sup>98</sup>, швед хүнд байгальд ээлтэй, нийгмийн тэгш хүртээмжтэй үйлчилгээ амьдралын баталгаа болж хоорондын харилцаа хамаарал,

“би”-ийн хандлага давамгайлахгүй, нийтийн хэв шинж илүү төлөвшдөг байна.

Ингэж үндэсний тэргүүн эрх ашигт нийцсэн үнэт зүйл ард иргэдийн сэтгэл

<sup>95</sup> www.gov.scot Curriculum for excellence: religious and moral education.

<sup>96</sup> www.curriculumforexcellencescotland.gov.uk Curriculum for excellence: religious and moral education.

<sup>97</sup> Д.Сүрэнчимэг “Байгууллагын соёл ба үнэт зүйл”. -“Монголчуудын үнэт зүйл” цуврал лекц. СУИС. 2018.05.18.

<sup>98</sup> Нобелийн шагналтнуудын айлдвар. Ред. Ц.Гомбосүрэн. УБ., 2010 он, 346-р тал.



ханамж, аз жаргалыг бий болгодог. Үнэт зүйл нь хүний зан төлөв, хандлагыг тодорхойлох, тайлбарлахад чухал ойлголт, хүний амьдрал, түүхийн холбоо хамааралд чухал үүрэгтэй ба хүнд эхлээд гэр бүлээс дараа нь цэцэрлэг, сургуулиас нь төлөвшдөг байна.<sup>99</sup>

Харин улс үндэстнээ нэгтгэн нягтруулагч нь болсон нийтлэг үнэт зүйлс, бахархлаа хөгжүүлж, бэхжүүлж чадвал олон янзын хэл, арьс өнгө, шашин шүтлэг бүхий олон үндэстэн, ястан нэгэн дээвэр дор эв нэгдэлтэй, сэтгэл хангалуун аж төрж болдгийг АНУ-ын туршлага, сургамж бэлхнээ нотолж буй.<sup>100</sup> Соёл Урлагийн Их Сургуулийн хийсэн судалгаанаас харахад:

АНУ-ын үнэт зүйлийн дараалал:-бие даасан байдал,-хувийн амьдрал, нууцлал,-шударга байдал,-тэгш эрх,-албан бус байдал,-өрсөлдөөн,-цаг хугацаа, үр ашиг,-хөдөлмөрийн ёс зүй

Орос оронд сүүлийн 20 жилд эх оронч патриотик үзэл санааг төр засгаас дэмжин хөгжүүлж байна.ОХУ-ын үнэт зүйлсийн дараалал:-эх орон,-нийгмийн эв нэгдэл, иргэншил,-гэр бүл,-хөдөлмөр ба уран бүтээл,-шинжлэх ухаан,-уламжлалт шашин шүтлэг,-урлаг ба утга зохиол,-байгаль,-хүн төрөлхтөн бүх дэлхийн энх тайван ажээ.

БНХАУ-д коммунист нам, төр засгийн бодлогоор күнзийн сургаалд тулгуурласан үндэсний үзлийг төрийн хатуу хяналтаар хэрэгжүүлж чадаж байна.

Цөм үнэт зүйлийн үзлийг бүрэлдүүлж тогтоох нь:

1.Нийгмийн эв зохиорол, тогтвортой байдал, улс орны он удаан, амар амгалан байх явдалтай холбоотой,

2.Нэг үндэстэй, нэг улсын оюун санааны! эрмэлзэл, тэмүүллийг тээдэг.

Үнэт зүйл нь улс орны төвшинд:-хүчирхэг баян,-ардчилсан,-эв зохиоролт

Нийгмийн төвшинд:-эрх чөлөөт,-тэгш шударга,-хуулийн засаглалт

Иргэний төвшинд:-эх оронч, -ажил хэрэгч, -чин итгэлт, эв найртай байх явдал гэнэ.

Европын холбооны үнэт зүйл нь: -хүний хүндлэл,-эрх чөлөө, -ардчилал,-эрх тэгш байдал, -хуульт ёс, -хүний эрх

Их Британийн үнэт зүйл: -ардчилал, -хуульт ёс, -хүндэтгэл ба хүлцэл, -хувь хүний эрх чөлөө, Сингапур улсын үнэт зүйлс

Нийтлэг үнэт зүйл:

-нийгмийн бүлгэмийн өмнө эх орон, хувь хүний дээр нийгэм,

-нийгмийн суурь нэгж болох гэр бүл,

-олон нийтийн дэмжлэг ба хувь хүний хүндлэл,

-зөрчил бус зөвшилцөл

-арьс өнгөний болон шашны эв найрамдал

Ази тивд Япон, Солонгос, Сингапур, Тайланд зэрэг орнуудын хөгжил уламжлал, шинэчлэлийн харилцааг үндэсний онцлогтойгоо зөв холбосноос шалтгаалан өндөр хурдацтай хөгжиж байгааг бид харж байна.

Нийтлэг үнэт зүйлээр үндэстнээ удирдаж хөгжлийн өндөр түвшинд хүрч чадсан Малайз, Сингапур зэрэг орнууд бий. Малайзын Ерөнхий сайд Махатир 1996 онд

<sup>99</sup> “Монголчуудын үндэсний үнэт зүйл” судалгааны тайлан. УБ., 2015 он, 29-р тал

<sup>100</sup>Н.Жалбажав “Үндэсний эв нэгдлийг хангах, эе эвээ хичээх сэтгэлгээ төлөвшүүлэх арга зүйн үндэс” -“Монгол Улсын үндэсний аюулгүй байдал: Хүн амын оюуны дархлааны асуудал” эрдэм шинжилгээний хурал, УБ., 2019 он

“Азийн үнэт зүйлс нь бүх нийтийн чанартай харин Европын үнэт зүйлс нь зөвхөн Европынх” гэж мэдэгдэж байв. Нийтлэг үнэт зүйлээр үндэстнээ удирдаж хөгжлийн өндөр түвшинд хүрч чадсан<sup>101</sup> Сингапурчууд соёл иргэншлийн хувьд “Азийг азичлах” замыг сонгож, өөрсдийгөө зөвхөн “Сингапурчууд” гэх болжээ.

Үндэсний үнэт зүйл ба үндэсний аюулгүй байдал бол нарийн уялдаа холбоотой асуудал юм. Улс орон, үндэсний үнэт зүйлээ тодорхойлсноор түүндээ тулгуурласан нийгмээ нэгдэн нягтруулах аливаа бодлого, шийдвэр гаргаснаар үр дүнгээ өгч цаашлаад энэ нь улс орон хөгжлийн зөв замаа сонгоход баримжаа болдог.

Улсын түүхийг янз бүрээр тайлбарлах нь иргэд олон янзаар мэдээлэл цуглуулж, өөрийнхөөрөө ойлгох боломжтой болгодог бөгөөд тэд түүхийн соёл, нийгэм, улс төрийн агуулгыг өөр, өөрийнхөөрөө ойлгодог. Францад үүнээс болж буюу янз бүрийн цөөнх, цагаачдын олон бүлгүүдийн онцлогийг харгалзаагүйгээс түүхийн үндэсний сургалтын хөтөлбөр хэрэгжиж чадаагүй байдаг. Францын Бүгд Найрамдах Улсын “Эрх тэгш, эрх чөлөөт ахан дүүс” гэсэн үнэт зүйлс нь түүний колоничлолын түүхээс болж олигтой дэмжигддэггүй “парадокс” болсон байдаг.

Түүхэн ой санамж бүдгэрснээс ард түмэн нэгдэн нягтрах үйл явц саармагжиж, үүнээс үүдэн нийгмийн ёс суртахуун, үнэт зүйлсийн чиг баримжаа өөрчлөгдөж, үндэсний аюулгүй байдлыг сулруулахад хүргэдэг. Иймд үндэсний онцлогийг илэрхийлсэн нийтлэг нэг үнэт зүйлийг тодорхойлж, бэхжүүлэх нь төрийн үүрэг юм.

---

<sup>101</sup>

Ли Куаэн Ю “Сингапурын хөгжлийн нууц” УБ., 2015 он

## **2.2. Монголын түүхэн үеүд дэх үндэсний ой санамж**

### **Дундад эртний болон дундад зууны үеийн үндэсний ой санамж**

Үндэсний ой санамж нь уламжлал, шинэчлэлийн улбаанаас үр гарган түүх, хэл, соёлоо мэдэх, хайрлан хамгаалах, өвлөх, залгамжлах хэмээсэн цогц үзэл санаа болой.

Үндэсний (үндэстний) ой санамжийг товчхон, энгийнээр илэрхийлбэл тухайн улс үндэстний түүх юм. Дээр нь ард түмний олон нийтийн дунд хадгалагдан амьд байдаг соёлын өв нэмэгдэнэ.

Чулуун, хүрэл зэвсэг, хадны бичээсээ олон мянган жилийн турш хадгалсаар ирсэн нүүдэлчин монголын түүхч, археологичид сүүлийн үед монголын төдийгүй хүн төрөлхтний түүхэн ой санамжаа сэргээх их үйлсэд хувь нэмрээ оруулахаар чармайн ажиллаж, амжилт ололтоор дүүрэн байгаа билээ.

Академич Болдбаатар "...Үндэсний ой санамж нь монгол угсаатан бүрэлдэж эхэлсэн үе буюу эртний улсуудаас үүдэлтэй. Монголчуудын дээд өвөг Хүннү нар Төв Азийн нүүдэлчдийн түүхнээ анх түрүүн МЭӨ 209 онд төр ёс, хууль цааз эрхэмжийг тогтоон, Монголын төдийгүй нийт Төв Азийн соёл иргэншилд баларшгүй ул мөрийг үлдээж, түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн нь дэлхийн түүхийн нэгэн хуудсыг нээж хүн төрөлхтний ой санамжид үлдэн хоцорчээ. Хүннүгийн төр ёсыг Модун шаньюй МЭӨ 209 онд үндэслэсэн билээ.

"Монгол нутаг бол нүүдлийн соёл иргэншлийн өлгий. Дэлхийн түүхэнд алдаршсан гурван их гүрэн монголын нутагт оршин тогтнож байсан. Хүннү гүрэн үүсгэн байгуулагдсаны 2220 жилийн ойгоо тэмдэглэсэн бол дараагийнх нь Ази Европт хил дамнан оршиж байсан Түрэгийн эзэнт гүрэн. Гуравт нь Монголын их гүрэн. Тиймээс дэлхийн хэмжээнд яригдах тэдгээр улс орнуудын соёлын үнэт олдвор монголын нутагт их бий. Хэдийгээр манай археологийн хөгжил, судалгааны цар хүрээ зэргээс харахад монголын археологи эхлэлийн түвшинд байна гэж болох ч дэлхийн хэмжээнд яригдах гайхамшигтай олдворууд олж байна.

Монголын түүхийн эртний үе нь цаг хугацааны хувьд монгол нутагт хүн амьдарч эхэлсэн үеэс МЭ XII зууныг хамарч байна. Монголын археологичид урьд өмнө зөвхөн Зөвлөлтийн археологичидтой хамтарч ажиллаж байсан бол өнөө цаг үед АНУ, Япон, Герман, Солонгос, Франц зэрэг орны судлаачидтай хамтарсан экспедиц зохион байгуулж, тэдний арга зүй туршлагаас суралцан ажилласны үр дүнд Монгол нутагт 800 000 жилийн тэртээ хүн суурьшин амьдарч ирснийг баттай тогтоолоо.

Бид өвөг дээдсийнхээ түүхийг зөвхөн Хүннүгээс эхлэн тоолох нь бас л учир дутагдалтай хэрэг юм. Сыма Цяньгийн "Түүхэн тэмдэглэл" зохиолд<sup>102</sup> Хүннүгийн дээд өвөг бол Ся нар хэмээн цагаан дээр хараар тод томруун тэмдэглэн үлдээсэн нь буй. Ся ханлигийг залгамжилсан Жоу ханлиг 700 жил оршин тогтоод Цинь улс Хятад гүрнийг түүхэнд анх удаа нэгтгэн захирчээ Ся төдийгүй Жоу, Цинь ханлиг улсууд бүгд нүүдэлчдийн байгуулж эзэрхийлэн захирч байсан төр улсууд байсан нь одоо нэгэнт түүхэн баримтаар тогтоогджээ. НТӨ 2033-НТӨ 1562 он монголчуудын

---

түүхийг бичсэн хятадын 4 их судрын эхнийх нь бөгөөд нийт 130 бүлэгтэйгээс Хүннүчүүд болон Төв Азийн нүүдэлчдийн түүхийг өгүүлсэн 12 бүлэг байдаг гэдгээс 7 бүлгийг нь Г. Элдэв-Очир орчуулан гаргажээ. Хүннүчүүдийн Төв Азийн нүүдэлчдийн тухай хамгийн эртний бичгийн сурвалж нь энэ юм.



өвөг дээдсийн байгуулсан анхны төрт улс болох “Хиан улс” (Хатан голын сав газарт) нийт 471 жил оршин тогтож байсан гэдгийг Өвөр Монголын нэрт түүхч Тайчууд Мансангийн эрхлэн гаргасан “Монгол үндэстний бүрэн түүх” хэмээх 6 боть бүтээлд бичсэн байдаг. НТӨ 1562-НТӨ 1066 он “Хиан улс”-ын халааг түүний дараа тогтсон Бидгүд залган авч, нийт 496 жил оршин тогтножээ. Хиан улсын үед хиад монголчууд хэнээс ч дутахгүй хүчирхэг цэрэгтэй байсан ба сурвалж бичгүүдэд ч Хиад болон хятадуудын хооронд байнга шахуу тулалдаан болж байсан тухай олон баримт мэдээ тусгагдсан байдаг.<sup>103</sup>

Эдгээрээс юуны түрүүн улс, төр засгаа байгуулж байсан Чингис хааны XII зуун, дэлхийд тэргүүлэх болсон Монголын эзэнт гүрний тухай түүхийг дурсахаас эхэлж, алдаж бутарсан дундад зууны түүхэн сургамж, улс орноо нэгтгэн төрөө зассан болон тусгаар тогтнолоо алдсан цаг үе шалтгаан, тусгаар тогтнолоо дахин олж авсан, сэргээн хөгжүүлсэн буурал түүхийн жимээ эргэн харж, тэрхүү түүхэн үеүдийн монгол төрийн засаглал, хууль эрх зүй, төрийн алба, шашин, соёлын түүхийг, тэдгээрийг хамгаалах, хөгжүүлэх гэж зүтгэж байсан биет хүмүүс, түүхээ сэргээхэд оролцсон эрхэм хүмүүсийн талаар ярих хэрэгтэй болно.

Монголчуудын ой санамжийн дээд шүтээн гэгдэх “Монголын нууц товчоон” үүссэн цагаасаа хойш тасралтгүй үргэлжлэн үе үеийн хаад, эрдэмтдийн зүтгэлээр баяжигдан бичигдсээр өнөө үед хүрснээр монголчууд үндэсний ой санамжаа хадгалан авч үлдсэн нь маргашгүй үнэн бас бий.

Ер нь монгол нутагт хүн амьдарч ирсэн тэр цаг үеэс ой санамжийн тухай ярьж болох юм. Учир нь монгол нутагт элбэг Хөнөөлдөн тэмцэж байв”<sup>104</sup> хэмээн нүдэнд харагдаж, чихэнд сонсогдтол дүрсэлжээ.

Ийм эв түнжингүй байдал бусдын зууш болохоос цаашгүй болохыг, Алунгуа эхийн домгийн үзэл санаанаас улбаалан мэдэрч, эв нэгдлийн үзэл санааг ой санамждаа сэргээх болжээ. Тийм талын язгууртны төлөөлөгчдийн дотроос Есүхэй баатрын хөвгүүн Тэмүжин товойн тодорсон байна.

Тэмүжин 1189 онд Хамаг Монголын нэгдлийг дахин сэргээж, олон ханлиг аймгуудын хамгийн хүчирхэг болж эхэлжээ. Тэр бээр 32 удаагийн тулалдаанаар 81 аймаг ханлигийг нэгтгэж, Их Монгол Улсыг байгуулах урьдач нөхцөлийг бүрдүүлжээ.

Улаан барс жил буюу 1206 оны намар цагт Онон мөрний эхнээ Монголын язгууртан дээдсийн их чуулган, Их Хуралдай хуралдаж, Их Монгол Улс байгуулагдсаныг тунхаглан, Тэмүжинг Чингис хаан хэмээн өргөмжилж, Их хааны сэнтийд залжээ. Ингэж МЭӨ III зуунаас үүдэлтэй язгуур монголчуудын мянга дөрвөн зуугаад жилийн шаргуу тэмцлийн зүй ёсны үр дүн, нүүдэлч удмынхны нийгэм улс төрийн хөгжилд гарсан чанарын хувьсал өөрчлөлт, өтгөс өвгөдөөс маань улбаалсан төр ёсны уламжлал, шинэчлэлийн яах аргагүй, гойд содон түүхэн үйл явдал байсныг монгол түмэн ой тойндоо ямагт санаж, бахархан дурсаж, уламжлан хөгжүүлж ирсэн билээ.

Чингис хаан түүнийг залгамжлагчид дорно, өрнө зүгт аян дайн хийж, дэлхийн талыг эзэгнэсэн их гүрэн байгуулжээ.

Их Монгол Улсыг байгуулах үед “Хэн нь хэнийгээ вэ?”, “Хэн өрсөж, хэн хүчирхэг нь хожно” гэсэн зарчим олон улсын харилцаанд үйлчилж байсан. Их хаан өрнө,

<sup>103</sup>Ч.Сосорбарам “Монголын үндэсний аюулгүй байдлын он цагийн товчоон” УБ., 2022 он, 11-р тал

<sup>104</sup>“Монголын нууц товчоон” Улаанбаатар, 1996 он, 245-р тал

дорно руу дайн хийхдээ хэнийг ч эхэлж өдөөгүй, харин найрамдах, чөлөөт худалдаа хийх санал тавьж, найрамдал, энхийг хүсэж очсон элчийг нь алж талж, доромжилсны нь төлөө л дайн байлдаан үүсгэж, эрхшээлдээ оруулж байв. Өдвөл сөдөхөөс аргагүй байдлыг тухайн цагийн олон улсын харилцааны нөхцөл байдал бүрдүүлж байлаа.

Монголын Улсын Ерөнхийлөгч асан, доктор (Sc.D) Нацагийн Багабанди “Дэвшилд шинэчлэл, уламжлалын холбогдол” хэмээх өгүүлэлдээ “Бидний өвөг дээдэс чинагуухаас инагшлуулан бодож чаддаг байсан учраас л өөрийгөө хамгаалж, энэ зорилгоороо тухайн цагийн ойлголтын хэмжээнд дэлхий ертөнцийн ихээхэн газар нутгийг эзлэх хүртэл өөрийн эрхгүй тэмцэж явсан түүхтэй. Тэр үедээ монголчууд бусад орнуудыг учир шалтгаангүйгээр инад талаас нь дайран давшилж, түрэмгийлэн эзэлж байсан гэх үзлийг эдүгээ шударга судлаачид улам бүр няцаасаар байна. Монголчууд хэрэв зөвхөн цуст түрэмгийлэгчид л байсан бол ийм том ялалтад хүрэх байсан уу? Чингис хаан улс гүрнээ хамгаалсан тэмцэлдээ ялж байсны дүнд өөрийгөө ертөнцийг эзэгнэгч гэж мэдрэх түвшинд хүрсэн буй за. тааралдах хадны зосон болон сийлмэл зураг бидний өвөг дээдэс ямар янзтай байсныг төсөөлөх ой санамжийг сэргээж өгнө. Харин үндэсний ой санамж нь Монгол угсаатан бүрэлдэж эхэлсэн үе буюу эртний улсуудаас үүдэлтэй.

Монголчуудын дээд өвөг Хүннү нар Төв Азийн нүүдэлчдийн түүхнээ анх түрүүн МЭӨ 209 онд төр ёс, хууль цааз эрхэмжийг тогтоон, Монголын төдийгүй нийт Төв Азийн соёл иргэншилд баларшгүй ул мөрийг үлдээж, түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн нь дэлхийн түүхийн нэгэн хуудсыг нээж хүн төрөлхтний ой санамжид үлдэн хоцорчээ. Хүннүгийн төр ёсыг Модун шаньюй МЭӨ 209 онд үндэслэсэн билээ.

Хүннү нар мөнх хөх тэнгэртээ бишрэн залбирч, хаан эзнээ тэнгэрээс заяатай, ер бусын хэмээн өргөмжлөн үзэж байв. Иймээс тэд Шаньюйгаа “Чэнли гуту” (Тэнгэрийн хүү)<sup>105</sup> хэмээн нэрлэнэ. Тэрхүү “Тэнгэрийн хүү” хэмээх ойлголт нь монголчуудын ой тойнд олон үед батажсаар, хожим дээд засгийн тухай тулх үзэл, төр ёсоо хүндэтгэх, төрөө бишрэн сүсэглэх шүтлэг болон төлөвшжээ. Саяхан болтол улаан залаат монгол хүн төрдөө нэг мэхэсхийж, тотгондоо бөхөсхийж байсан билээ. Эдүгээ үед үүнийг төрөөс тогтоосон хууль цаазыг хүндэтгэн эрхэмлэх үзлээр ой санамждаа үргэлжлүүлэх ёстой.

Хүннү болон эртний улсуудаас уламжлагдан монголчуудын ой санамжид баттай шингэсэн улс орны тусгаар тогтнолын тухай үзлийн уг язгуур нь “Газар бол улсын үндэс” хэмээх үзэл чухал юм. Модун шаньюй Дунху нартай сайн хөршийн харилцаатай байхын тулд хүлэг сайн морь, хайртай хатнаа найр тавин өгсөн мөртөө хэсэгхэн газрыг нь басамжлах өнгө аястай өгөхийг шаардахад “Газар бол улсын үндэс мөн” хэмээж дорно зүг цэрэглэн, тэднийг номхотгосон нь монгол түмний ой санамжид мөнхөд үлдэж, үндэсний эх оронч үзлийн өнгөрсөн, одоо алсын амин сүнс болсоор иржээ.

Хүннү болон эртний улсуудаас монголчуудын амьдрал ахуй, амьжиргааны гол хэрэгсэл болж ирсэн, үеийн үед ой санамждаа болгоож ирсэн аж ахуйн салбар бол мал аж ахуй юм. Өөрөөр хэлбэл энэ үеэс нүүдлийн сонгодог бэлчээрийн мал аж ахуй<sup>106</sup> бий болж, үеийн үед монголчуудын амь амьжиргааны хэрэгсэл болж иржээ.

<sup>105</sup> Г.Сүхбаатар “Монголчуудын эртний өвөг” Улаанбаатар, 1980 он, 56-р тал

<sup>106</sup> Г.Сүхбаатар “Монголчуудын эртний өвөг” Улаанбаатар, 1980 он, 48-р тал

Адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа хэмээх таван хошуу мал эрхэлж, тэдгээрийг эдэлж хэрэгпэн ашиг шимийг нь хүртэх болжээ.

Мал аж ахуй эрхлэх арга технологи үеэс үе дамжин, ой санамжид хадгалагдан үлдэж, шинэ агуулгаар баяжсаар ирсэн байна. Мал аж ахуй эрхлэх явцад байгаль орчинтойгоо яаж харьцах, түүнийг хайрлан хамгаалах, хямгадах үзэл санаа монголчуудын ой тойнд нь баттай шингэжээ.

X-XII зууны үед монгол нутагт олон арван аймаг, ханлигууд оршин тогтнож, өөр хоорондоо өрсөлдөж тэмцэлдэж байв. Энэ тухай “Монголын нууц товчоон”-ы 254-р зүйлд:

“Одтой тэнгэр орчиж  
Олон улс байлдаж  
Орондоо унтах завгүй  
Олзлолдон булаалдаж байв.  
Хөрст дэлхий хөрвөж  
Хөвчин улс хямралдаж  
Хөнжилдөө унтах завгүй

Македоны Александр, Наполеон хоёрын хэн нь ч өөрийгөө тэгж мэдэрч чадсан гэх аргагүй юм. Чингисээс хойш амьдарч үлдсэн Наполеон “Би Чингис шиг аз заяатай байж чадаагүй” гэж хэлсэн нь дайнд ялагдсаныгаа бус, дэлхийг эзэлж чадаагүйгээ бус, харин дайтахын учир шалтгаан өөрийнх нь хувьд утгагүй. Өөрөөр хэлбэл, чинад талын эзлэн түрэмгийлэх гэсэн аюул занал байгаагүй нөхцөлд түрэмгийлэх дайн хийснээ ухаарснаа илэрхийлсэн үг биз ээ. Ийм ухаарал байгаагүй үед л дайнд ялагддаг.

Чингис хаан өөрийгөө “Замба тивд оршин амьдарч 720 төрлийн хэлээр ярьдаг, 5 өнгийн улс түмний эзэн” боллоо гэж сэтгэж явсан нь чинад талаас учруулж байсан аюулыг сөрөн давсны үр дүн байв. Чинад талын заналхийллийн улмаас л байлдаж байж, дайн хийхээс аргагүй болж байжээ. “Чинад тал дайсагнаагүй бол Чингис, түүний удмын хаадууд тэгж явах ямар ч хэрэггүй гэж хэлбэл түүхийн үнэнд нийцнэ. Чингисийн эзэнт гүрэн дэлхийн тал хагасыг хамарсан хувь заяаны учрал ийм байв”<sup>107</sup> хэмээн Монголын байлдан дагууллын учир шалтгааныг жинтэй дүгнэжээ.

Монголын эзэнт гүрэн өрнө, дорныг улс төр, эдийн засаг, соёлын талаар холбож өгсөн юм. Тэрхүү “Алтан үе”-ийн олон улсын харилцааны философи нь дэлхийн эх газрын их зонхид улс төр, шүтлэг бишрэл, олон үзэл бодлын найралт ёс, нээлттэй чөлөөт байдал тогтоох хандлага бүхий байлаа. Түүхэн цаг үеийн эрхээр энэ гүн ухаан өдгөөгийн олон улсын харилцаанд улам тод томруун илэрч байна.

Ийнхүү монголчууд XIII, XIV хоёр бүхэл бүтэн зуунд хүн төрөлхтнийг манлайлж, монголоор овоглож ирсэн юм. Ийнхүү бүхэл бүтэн хоёр зуунд хүн төрөлхтнийг манлайлж байсан өөр нэг ч үндэстэн гараагүйг түүх гэрчилнэ. Энэ үед хүн төрөлхтөн монголчуудын хурдыг гүйцээж чадаагүй, тэрхүү хурдыг эдүгээгийн интернэтийн хурдтай зүйрлүүлж болох юм. Энэ нь монголчуудын ой санамжид баттай оршин, урагшлах хөгжлийн хурдасгуур болж өгөх ёстой. XXI зуунд бидний монголчууд зэвсэг хангинуулах биш, оюун ухааны хурдаар дэлхий дахинд өрсөлдөх нь чухал. Ийм залуу үе өсөж өндийж байгаа нь үндэсний бахархал, үндэсний ой санамжийн нэгэн тод илрэл юм.

<sup>107</sup> Н.Багабанди “Шинэ зууны өмнөх бодлого, зорилт” Улаанбаатар, 2001 он, 121-р тал

Чингис хаан улс үндэснийхээ язгуур эрх ашгийг туйлаас эрхэмлэж “Алд бие минь алжаавал алжаатугай, Ахуй төр минь бүү алдраг” хэмээх алдарт сургаалаа айлдсан байна. Энэхүү айлдвар нь “Их засаг” хуулийн үзэл санаагаар баяжин хөгжиж, Монголын хууль цаазын хөгжилд олон үе хаван нэвт шингэжээ.

“Айж бэндэн хэрэг хүлээх хэрэггүй  
Айлтгүй үнэнээ хэл”

хэмээсэн төрийн заргач Шихихутугийн зарчмыг Монголын хуульчид ямагт ой санамждаа авч ирсэн билээ.

Гадаадын зарим судлаачид Их Монгол Улсын төрийг төр биш, Чингис хааны суу заль, ухаанд (харизм) тулгуурласан улс төрийн нэгдэл гэж үзэх нь ч бий. Гэтэл хэрэг дээрээ Их Монгол Улс, Монголын эзэнт гүрний төр бол юуны өмнө, хойд, урд хоёр их хөрш гүрнээ үүсгэж, “төр төмбөгөр, ёс ёмбогор” байхын үлгэрийг үзүүлж өгснийг хүн төрөлхтний ой санамжаар тодорхойлогдож байна. Оросын гүн ухаантан Чаадаев, Федотов нар Монголын довтолгооны босгон дээр Орос орон “мянган жил унтаа” байсан юм гэж тэмдэглэжээ. Үнэхээр ч Монголын байлдан дагуулалтын өмнө Орос орон шавар, чулуун хэрэмдээ тусгаарлагдсан жижиг ванлигуудаас тогтож байсан билээ. Евроазийн хөдөлгөөнийг оройлон манлайлагч, гол онолч, Оросын Шпенглер хэмээн алдаршсан Николай Трубецкой “Чингис хааны үйл ажиллагаанд нураан эвдэх эрмэлзэл арай түлхүү байсан хэдий ч түүний бүтээх, зохион байгуулах хүсэл зориг нь үлэмж их, эерэг үзэл санааг түгээн дэлгэрүүлэгч болж байв. Иймд түүхт Орос бол чухамдаа Чингис хааны улсыг залгамжлагч болохыг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй юм”<sup>108</sup> гэжээ. Өнөөгийн оросын нэрд гарсан түүхч Р.П.Храпачевский энэ санааг гүнзгийрүүлэн дэмжсэн байна.<sup>109</sup> Америкийн эрдэмтэн На^епп 1983 онд Чингис болон түүний үе залгамжлагчдын Оросын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг “Орос дахь монголын ноёрхол шууд бус дам хөндлөнгийн шинжтэй байжээ. Оросын хувьсгалын өмнөх буюу хойших үеийн Оросын түүхчдийн хараан бичсэнчлэн монголын ноёрхлын үед орос угсаатны оюун санаа, тэдний визант гаралтай үнэн алдартны шашны аль алиныг нухчин дарсан явдал гараагүй. Монголчууд Орост колоничлон суугаагүй, өөр үндэстэн угсаатан гэж дээрэлхээгүй... Ямар ч атугай Орос орныг Оросын ван нараар дамжуулан захирч байсан. Хэрэв Невийн Александр өрнө этгээдэд Швед, Тевтоны рыцариудтай байлдаж байсан бол монголчуудын эсрэг тулалдаж байсангүй. Харин монголчуудын эзэн эрхийг төвөггүй хүлээн зөвшөөрсөн юм. Монголын эрх баригчид Оросын сүм хийдийг албан татвараас чөлөөлж өөр бусад эрх дарх өгсөн нь үнэн алдартны шашин оросын зүүн хойд хэсэгт сэргэн мандахад асар их үр нөлөө үзүүлсэн юм. ...Оросууд хожим их гүрний нэгэн бүрэлдэхүүн хэсэг болсноос хойш олон талын ашиг олж худалдаа арилжаа хөгжсөн байна”<sup>110</sup> хэмээн бичжээ.

Хятад орон ч саланги тусгаарлагдсан, өөр хоорондоо дайсагналцсан жижиг улсуудаас бүрдэж байсныг түүхэн ой санамж гэрчилнэ.

Чингис хааны үе болон дараа дараагийн монголчуудын амьдрах соёлд бус улс үндэстнийг өөртөө уусгах бодлого хэзээ ч байгаагүй. Ялангуяа Чингис хаанд дан

<sup>108</sup> Николай Трубецкой “Наследие Чингис хана” АГРАФ. М., 2000, с.237

<sup>109</sup> Р.П.Храпачевокили “Военная держава Чингис хана” М., 2005. с.399

<sup>110</sup> Ch.J.halperin “Russia and Mongols Empire-Asian studies” Journal №1, Vol.43, Harvard Univ. 1983. p.239-267. (Russia under the Tatars yoke-Golden Horda)

ганц бусдыг түрэмгийлэн эзлэх, тонон дээрэмдэх өрөөсгөл ганц талын хүсэл зориг, хожим шинэ түүхийн үед том гүрнүүдэд үүссэн шиг дэлхийд ноёрхлын тулд эзлэн колоничлох бодлого байгаагүй болно. Монголын эзэнт гүрний бодлого түүхэн бодит нөхцөл шалтгааны улмаас эзэрхэг түрэмгий шинжтэй байсан ч дундад зууны олон улсын харилцааны эрх зүйн хэм хэмжээг хүндэтгэж байсан төдийгүй түүнийг зарим талаар харьцангуй шударга дэвшилт шинж төрхөөр баяжуулж байсан нь хүн төрөлхтний ой тойнд шингэн үлджээ.

Монголчууд дэлхийн дундад зууны улс төрийн түүхэнд дурсан тэмдэглэхээс аргагүй хэд хэдэн аугаа их хүмүүнийг төрүүлжээ. Үүнд юуны өмнө, үлэмж их Чингис хаан зүй ёсоор орно. Эдүгээгийн судалгаанд Чингис хаан бол монголын төрийн сэцэн билигт зүтгэлтэн, монгол үндэсний гарамгай баатар, аугаа их жанжин, өнөөгийн дэлхий ертөнцийг үндэслэгч хэмээх үнэлгээ илт давамгайлж байна. Сүүлийн 850 шахам жилийн хугацаанд дэлхий дахины түүхэнд гарамгай үүрэг гүйцэтгэснийхээ хувьд нэг ч төрийн зүтгэлтэн Чингис хаан шиг судлаачид, зохиолч, сэтгүүлчдийн анхаарлыг татаж чадаагүй гэж бардаагаар хэлж болно.

Хоёр дахь их хүмүүн бол түүний ач Хубилай сэцэн хаан юм. Судлаачид түүнийг эерэг, сөрөг янз бүрээр үнэлж иржээ. Нэг хэсэг судлаачид хууль бусаар хаан суусан, нийслэлийг Хятад руу шилжүүлсэн, эх нутгаа хөсөр хаясан гэх мэтээр зэмлэн буруутгаж байхад нөгөө хэсэг нь тэр цагийн эрдэм боловсролыг сайтар эзэмшиж, төрийн хэргийг эрдэм соёлоор тохинуулан жолоодож, хууль цааз, ёс журмыг шинэчлэн тогтоосноороо сэцэн хаан хэмээн алдаршсан гэж бичиж байна. Бид нэг талыг хэт баримтлан өрөөсгөл ташимгай үздэг өмнөх тогтолцооны өрөөл татанхай үзлээсээ салах цаг болсон. Хубилай хаан Хархорумд нийслэлээ хэвээр хадгалан, дорно дахиныг захирсан бол ямар сөрөг үр дагавар гарах байсан бэ? гэдэг асуултыг өөртөө тавиад үзье л дээ. Тэгвэл наад зах нь хүчирхэг хаант засагтай үед төвд тэмүүлэх хүч үйлчилдэг жам ёсоор тэр үеийн 100 сая орчим хятадуудаас наад зах нь 2-3 сая хүн Хархорум, ер нь Монгол нутагт ирж суурьших байсан байх. Тухайн тэр цагт монголчууд нэг сая хүрэхтэй үгүйтэй байсан гэсэн судлаачдын тооцоо бий. Энэхүү уусгах аюулыг Хубилай хаан эргэцүүлэн нягталж үзжээ. Мөн Их хаан Шанду, Бээжин рүү нийслэлээ шилжүүлэхдээ Хятад нутагт төрийн төвөө сонголоо гэж бодоогүй Монгол, Хятадын эртний хилийн зааг дээр очиж, дорно дахиныг эзэгнэсэн Их гүрнийг илбэн тохинуулах холч, голч бодлого явуулна гэж тооцоолжээ. Энэ санаа зөв зүйтэй байсныг түүхэн үйл явц нотолж, үндэсний ой санамжид тод хоцорчээ.

Хубилай хааны хүн төрөлхтний төр ёсны сэтгэлгээнд оруулсан томоохон хувь нэмэр бол “Арван буянт номын цагаан түүх” номдоо онол үйлдлэгийн хувьд үндэслэсэн төрийн хоёр ёс буюу хос ёсны үзэл юм. Түүний шашин, төр хоёрыг тэгш явуулах хэмээх нь шашны болон төрийн ёсны хоорондын найралт ёсыг тогтоож, хослон барих явдал болно. Тэр бээр үнэхээр монголчуудын оюун билиг, хүч чадлын эрчимт чанарыг тэнгэр, газрын савслага бүрд хүргэж чадсан их хүмүүн байлаа. Тухайн цаг үе нь ч их хааныг эерэг үнэлж байсныг үндэсний ой санамж түүх шастирын шарласан хуудаснууд нотолно. Тухайлбал, Хубилай бол “Сэцэн хаан”, “Мянган хигээст алтан хүрдийг эргүүлэгч, хотолдоо алдаршсан Чакравардийн их хаган”, Монголын Ашого (Ашоко) буюу Гаслангаас нөхөцсөн хаган гэх мэтээр тэмдэглэж үлдээжээ. Хубилай хааны дэргэд олон жил байсан Венецийн худалдаачин Марко Поло: Хубилай хааныг албат иргэд, газар нутаг, эрдэс баялгийн

хувьд анхны эцэг Адамаас өдгөө хүртэлх ертөнцөд байсан буюу байж болох хамгийн их хүчирхэг хүн хэмээн бичжээ. Хубилай хааны түүхэн үүргийг ултай судалсан академич Ш.Нацагдорж “Эзэлсэн газар нутгаа эрхэндээ оруулсан, хүн ард болон тухайн үедээ олон улсын дунд эзлэх байр суурь, эрх нөлөөгөөрөө Хубилайтай тэнцэх эзэн хаан ертөнцийн түүхэнд урьд, хожид гараагүй. “Хубилай нүүдэл, суурьшлыг зохицуулах тэдгээрийн тэнцвэрийг олох, монголыг монгол хэвээр нь үлдээхийг чармайж, Монголын соёл иргэншлийг уусан хайлахаас аварсан”<sup>111</sup>, академич Ш.Бира “Хубилай хаан Монголын их хаадын дотроос хамгийн удаан хугацаанд хаанчлахдаа монголын эзэнт гүрнийг үнэхээр даяар ертөнцийн их эзэнт гүрэн болгон түвшитгэн захирах талаар асар их зүйлийг бүтээсэн ажээ. Түүний шууд удмын 10 их хаан тодрон заларч, их өвгөөсөө хойш даруй 78 жилийн туршид үйл хэргийг нь үргэлжлүүлэн хаанчилж байсан байна. Үүн дээр Хубилайн хаанчлалын 35 жилийг нэмбээс түүний удмынхан даруй 108 жил монгол даяар ертөнцийн их эзэнт гүрнийг аль нэг хэмжээнд захирч байжээ. Үүнээс гадна их эзэнт гүрэн мөхсөний дараах эхний 20 жилд ч Хубилайн удмын хоёроос доошгүй хаан Монгол орноо захирч байв. Монголын бага хаадын хямрал тэмцэл эхэлсэн 1388 он хүртэл өөрийг нь оролцуулан Хубилай хааны удмынхнаас бүгд 13-аас доошгүй хаад гарч даруй 128 жил тасралтгүй Монгол төрийн тэргүүний сэнтийд заларч байсан явдал бол Хубилай хааны Монголын төрийн түүхэнд ямаршуу байр суурь эзэлдгийг бэлхнээ харуулна. Ер нь Чингис хаанаас эхлээд Монголд түүний Алтан ургийнхны 35-аас доошгүй хаад байсан бөгөөд тэдгээрээс бараг 20-оод нь Чингис хааны ач хүү Хубилайн, бусад нь Чингисийн бусад удам угсааны хаад байсан ажээ. Эцэст нь тэмдэглэхэд Хубилай хаан бол өөрийн өвөг эцэг Чингис хааны хамтад Монголын түүхэнд төдийгүй дэлхийн түүхэнд ч алдаршин үнэлэгдсэн агуу их хаан байсан”<sup>112</sup>, Америкийн нэрт эрдэмтэн Морис Россаби “Хубилай хааны ололт, амжилтыг үгүйсгэх аргагүй юм. Түүний өв богино насалсан авч амьд ахуй үедээ олж авсан амжилт бүтээл нь түүнд өнө мөнхөд үргэлжлэх алдар цууг авчирсан билээ. ...Хубилай хаан бол монгол хүн хэвээрээ үлдэж, хэзээ ч төрөлх араншныгаа орхиогүй юм”<sup>113</sup> гэжээ. Үүнийг эл номд тусгайлан дурдахын учир бол дэлхий дахин, ялангуяа дорно дахины түүхэнд Хубилай хаан болон монголчуудын гүйцэтгэсэн үүргийг үнэн зөвөөр нээн гаргах ач холбогдолтой юм. Хубилай хааныг манай зарим судлаачид, учрыг ойлгоогүй эгэл хүмүүс эх орноосоо урвасан мэтээр ярих нь хөөнд ассан ямаалзгана мэт өнийн бодолгүй хэрэг” гэдгийг ой санамждаа авбал зохино.

Солонгосын нэрт нийтлэлч Ким Жон Рэ “Мянган жилийн түүхэн хүн” хэмээх номдоо “Чингис хаанаас авсан европчуудын цочрол түүхийн хүрдийг эргүүлэх хэмжээний цочрол болсон” хэмээн тун онож тэмдэглэсэн байна. Энэ хүн бас Чингис хааны удирдлагын дор Монголын эзэнт гүрний дэлхий дахины түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, гавьяа, ололт амжилтын нууцыг орчин үеийн “улс орнуудын чөлөөтэй өрсөлдөх чадвар”-ын ойлголтын үүднээс хөндөн үзэж, энэхүү ололт, дэвшлийн үндэс нь “нарийн мэргэжлийн хамтлаг бүрдүүлж, нээлттэй нийгмийн цэргийн олон

<sup>111</sup> Ш.Нацагдорж “Хубилай сэцэн” Улаанбаатар, 1998 он, 96-р тал

<sup>112</sup> Ш.Бира. Хубилай хаан ба даяар ертөнцийн Монголын эзэнт гүрэн буюу “Их язгуур улс”.

“Их Монгол улс, Эзэнт гүрний түүх, соёлын асуудал” Улаанбаатар, 2006 он, 38-39-р тал

<sup>113</sup> Moris Rossabi. Khubilai khan. His life and times. University of California press. Berkeley. Los Angeles. London.



талт стратегийн бодлого явуулж, технологи, мэдээллийн сүлжээгээр ноёлж, улс орноо инженерчилсэн зохион байгуулалтад оруулж чадсан явдал” хэмээн үзэж, энэ нь өдгөөгийн АНУ-ын дэлхийн эдийн засгийг залан чиглүүлж байгаатай агуулгаараа адил төстэй юм”<sup>114</sup> гэжээ. Ингэж соёлт ертөнц монголчуудын дэлхий дахины түүхэнд үлдээсэн ул мөрийг эергээр үнэлж байгаа нь түүхэн ой санамжийн тод илрэл мөн. Чингисийн үеийн монголын хурд, эрч хүч бол аливаа хямралаас гарах, ер нь хөгжил дэвшилд хүрэхийн үндсийн үндэс гэж өдгөө дэлхий дахин ой санамждаа авч байна.

Монголчууд өөрийн шашин суртлыг бусдад тулгаагүй, өөр өөрийн ёс суртал, шашнаа шүтэн амьдрах эрх олгож байсан нь үнэхээр нигүүлсэнгүй, өршөөнгүй сэтгэлээр хандаж байсныг хүн төрөлхтний тэргүүний хэсэг ойн тойндоо авч, эергээр үнэлж байна. Чингис хаан түүний байлдан дагуулал нь эхэн үедээ “даяарчлах” шинжтэй болсон гэж үзэж болохоор байна. Энэ утгаар нь өрнө, томоохон түүхчид тухайлбал, Америкийн эрдэмтэн Жек Ведерфорд “Чингис хаан бол өнөөгийн ертөнцийг үндэслэгч”<sup>115</sup> үнэлжээ.

Монголчууд дорно, өрнийг байлдан дагуулах явцдаа тухайн үед ямар ч оронд байгаагүй цэрэг дайны өвөрмөц соёлыг бүрэлдүүлж, дэлхийн цэргийн стратеги, тактикт үнэтэй хувь нэмэр оруулсныг цэргийн жанжид, мэргэжилтнүүд ой тойндоо шингээн авч, бахархаж судалж байдаг билээ. Чингис хааны есөн өрлөг жанжнууд цэргийн түүхэнд мөнхөд дурсагдсан гавьяатай юм. Ганцхан жишээ татахад, Зэв, Сүбээдэй нарын хийсэн аян дайныг Английн түүхч С.С.Уолкер үнэлэхдээ “Ганибал байлдааны агуу их удирдагчийн хувьд нэр алдар нь Испаний Эбро голын ойролцоогоос эхэлж, Африкийн замд дууссан 10 жилийн турш дахь дайн тулалдааны үндсэн дээр бий болсон бол Каннын ойролцоох тулалдааны нэгэн адил сүр дуулиантай шийдвэрлэх тулалдаанд ямагт байгуулсан. Ганибалын туулснаас илүү өндөр сүрлэг уулсын оргилыг давж түүнээс цааших замыг туулсан хүмүүс бол монголын байлдан дагуулагч жанжин нар байсан гэж итгэлтэйгээр хэлж болох юм. Зэв ноён болон Сүбээдэй баатар нарын Хятадаас Крым хүртэл хийсэн аян дайныг Александр Македонскийн Геллеспонтос Энэтхэг хүрсэн замтай харьцуулахад илүү олонтоо байлдаж тулалдсан, илүү олон цайз балгасыг дайрч авсан аян дайн болсон” гэжээ. Энэ нь цэргийн урлагийн хувьд Чингис хаан төдийгүй түүний баатар, жанжин нарыг дэлхий дахины санан дурсагдах аугаа хүмүүсийн тоонд оруулан үнэлж байгаа хэрэг юм.

Их Монгол Улс, Монголын эзэнт гүрний үед монголчууд соёлын олон гайхамшигийг бүтээсний хамгийн гоц гойд нь “Монголын нууц товчоон” болой. Энэхүү зохиол нь монголын түүх, уран зохиолын дээж, монгол түмний үндэсний ой санамжийн толь бичиг юм. Тухайлж хэлбэл, “Монголын нууц товчоон” түүхэн баримт уянгын халилыг хослуулан, түүхэн өгүүлэмжээ ялгуун жороо морины явдал гүйдэл мэт илэрхийлсэн VIII-XIII зууны монголын түүх, соёл, ёс заншлын төдийгүй дэлхийн түүхийн тодорхой үеийг илтгэн харуулсан нэвтэрхий толь, он цагийн эллийг даасан эрдэнэсийн туурвил, дуун утгын төгс чанар дэлгэрэн бүрдсэн эрт цагийн гайхамшигт сурвалж бичиг бүлгээ.

<sup>114</sup> Ким Жон Рэ “Мянган жилийн түүхэн хүн” (Хойч үеийн Чингис хаануудад зориулав). Улаанбаатар, Сөүл, 1999 он

<sup>115</sup> Жек Ведерфорд “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан” Улаанбаатар, 2003 он

XV-XVII зуун бол Монголын хувьд их төрийн багана хазайсан Батмөнх даян хааныг эс тооцвол төвөөс зугтах хүч үйлчилсэн эмгэнэлт үе байв. Энэ үед “эвлэрвэл хожно, эвдэрвэл мөхнө” хэмээх үзэл ухааныг умартаж ноёд өөр өөрийн эзэмшилд эзэн болох гэж толгой өндийлгөсөн ч Алунгуа эхийн хүүхдүүддээ нэг нэг сум өгөхөд хялбархан хугалдаг шиг амархан бусдын зууш болж, улс үндэстний үнэт зүйл тусгаар тогтнолоо алдаж эхэлжээ.

Эхлээд 1636 онд Өмнөд Монгол, 1691 онд Халх Монгол, 1657-1658 онд Ойрад Монгол Манжийн эрхшээлд орсон байна. Гурвуулаа нэгдсэн бол ямар их хүчирхэг байх нь ойлгомжтой. Галдан бошгот Халх Монголтойгоо нэгдэхийн оронд дайсагнаж байсан боловч ганцаараа манжийн их цэрэгт хэд хэдэн удаа няцаалт өгч байснаас үзэхэд ядаж Түшээт хан Чахундорж, Өндөр гэгээн Занабазар, Цэцэн хантай нэгдэж, Манжийн эсрэг тэмцсэн бол тусгаар тогтнолоо хамгаалж үлдэх боломжтой байсныг хожим ноёд ой санамждаа ойлгож авсан юм. Гэвч хэдийнээ оройтсон байлаа. Хожуу ухаарлаа гэж ийм уршигтайг монгол түмэн тойндоо шингээн сургамж авч үлджээ.

XVII-XVIII зууны үе болж ирэхэд монголчууд хэдийгээр нарийн эрхшээлд орсон боловч нүүдлийн мал аж ахуйгаа улам илүү сонгодог шинжтэй болгон хөгжүүлсэн юм. Тэдний эрхэлж ирсэн үндсэн аж ахуй нь дэлхий дахины аж ахуйн хөгжлийн нийтлэг шинж, түүхэн хандлагыг агуулах боловч, бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх талаар дэлхийн эдийн засгийн түүхэд үнэнхүү бие даасан өвөрмөц арга ухаан, технологи, соёлыг бий болгосныг судлаачид ой санамждаа авч судлан шинжилж байна.

Бэлчээрийн мал аж ахуй бол нүүдэлч монголчуудын хувьд аж ахуйн нарийн мэргэшсэн чиглэл, бие даасан бүхэл бүтэн тогтолцоо болон төлөвшсөн бүлгээ. Эл тогтолцоо нь евроцентризмын үүднээс экстенсив хэмээн олон жил ярьж бичиж ирсэн шиг биш, харин олон зууны турш шалгагдаж, байгаль орчиндоо нарийн зохицсон аж ахуйн бүрдэл, нүүдэлч монголчуудаас буянт мал сүргээ адуулан өсгөх, амьжиргаагаа залгуулах арга ухаан, технологийн цогц илэрхийлэл болж ирсэн юм. Тэрхүү аж ахуйн объект нь монголчуудын нэрлэж заншсанаар эрдэнэт мал сүрэг таван хошуу мал билээ. Бэлчээрийн мал сүрэг нь эрс тэс уур амьсгалтай дөрвөн улирлын хүнд бэрх нөхцөлд биологийн хувьд зохицон амьдарч үр төлөө өгч, нөхөн үрждэг өвөрмөц онцлогтой

Монголчуудын бэлчээрийн мал аж ахуй нь өвсний соргог усны тунгалаг, уулын нөмөр бараадаж, цаг улирлын аясаар нутаг солих “хаваржаа - зуслан - намаржаа - өвөлжөө” гэсэн нүүдлийн амьдралын нэгэн бүхэл бүтэн эргэлтийг буй болгосон байна. Үүгээр нүүдэллэхүй хэмээх үйлдвэрлэлийн бие даасан технологийг боловсруулсан” билээ.<sup>116</sup>

Монголчууд аж ахуйгаа эрхлэн хөтлөх арга, технологи суурьшил, хотжилт, аж үйлдвэржүүлэлт, нэгдэлжүүлэлт зэргээс болж зарим талаас бүдгэрэх хандлагатай болсон боловч эдүгээ дахин сэргэж байна. Ийнхүү нүүдлийн бэлчээрийн амьдрал, бэлчээрийн мал аж ахуйн хүч нөөц хараахан бүрэн шавхагдаагүй бөгөөд шинжлэх ухаан, техникийн дэвшил, экологийн давуу талтай зохистой хосолж чадвал бүр илүү үр өгөөжтэй амьдралын хэв маяг, аж ахуйн тогтолцоог бүрэлдүүлэх боломжтой юм. Монголын нүүдэлчдээс илүү төгс малчныг энэхэн замбуулингаас олоход бэрх. Зуун зууныг өртөөлсөн монгол морин төвөргөөн үргэлжилсээр...

<sup>116</sup>Б.Сумъяа “Монголчуудын нүүдэлчдийн соёл оршихуй, эс оршихуй” Улаанбаатар, 1998 он, 59-р тал



Харийн эрхшээлд байсан XVII-XIX зуунд түүхч, зохиолч зэрэг бичгийн мэргэд үүх түүхээ ном сударт буулгаж, дэлхийн талыг эзэгнэсэн ямар их гүрэн байгуулж байсан өвөг дээдсийн түүхийг ой санамжид нь суулгаж өгч байлаа. Энэ үед Лувсанданзаны “Алтан товч”, “Саган сэцэний “Эрдэнийн товч”, Рашяунцагийн “Болор эрих” зэрэг түүхэн зохиолуудад Их Монгол Улсыг байгуулж, дэлхий дахинд мандаж байсан үеийн хойч үеийн ой санамжид үлдээсэн бол Халхын Цогт хунтайж (1581-1637), Ванчинбалын Инжиннаши (1837-1892), Равжаагийн Хишигбат (1849-1916), Дулдуйтын Данзанравжаа (1803-1856) зэрэг зохиолч яруу найрагчид өвөг дээдсийн түүх болон тухайн цаг үеэ үндэсний ой санамжид тольдон шингээсэн юм. Ялангуяа энд В.Инжиннаши “Хөх судар” роман монголчуудын олон үеийнхний ой тойнд үндэсний бахархлыг төлөвшүүлж, өөдрөг шинэ ирээдүйд уриалж иржээ. Монгол Улсын Ардын багш, ярофессор Ш.Чоймаа “Бид манай үндэсний их сэхээрүүлэгч В.Инжиннашийн эл шалгарсан бүтээлийг цөм чин сэтгэлээр сүслэн, гар гараас дамжуулан бахдан уншиж, бидний өвөг дээдэс бээр зовж зүдэн туурга тусгаар Монгол Улсыг яндашгүй арвин бичиг, соёлын өвтэйгөө бидэнд өмчлүүлэн хоцроосон ач буяныг улам бүр мэдэж, өнгөрсөнд хандах үндэсний бахархлаар омогшихын зэрэгцээ ирээдүйн монголын үндэсний бахархлыг бий болгохын төлөө нийтийн гол зорилгыг хөгжөөвөөс их зохиолчийн хойч үед итгэн найдаж сануулсан тэрхүү бие, хэл, сэтгэлийн гүнээ чилсэн шалтгааныг сая ухаж ухаарч чадсан хэрэг болох билээ”<sup>117</sup> хэмээн бичжээ.

В.Инжиннаши монгол хүн бүрийн улс үндсээ бодох ой санамж нь түүхийн мэдлэгээс шалтгаална гэж үзэж, түүхээ судалж мэдэхийн чухлыг онцлон эрхэмлэж

“Үндсээ үл мэдэх нь адгуус буюу

Тайж бөгөөд өвөг юугаан үл мэдэх нь мал

Нүд буй бөгөөд түүх юугаан үл үзэх нь сохор номин буюу

Мэдэлтэй бөгөөд язгуур юугаан үл мэдэх нь мунхаг гахай буюу”<sup>118</sup> хэмээн бичсэн байна.

В.Инжаннаши энэхүү алдарт бадгийнхаа нэг, гуравдугаар мөрийг бүх нийтэд буюу ард иргэдэд хоёр, дөрөвдүгээр мөрийг нийгмийн удирдлагад хандан хэлжээ. Тухайлбал “Үндсээ үл мэдэх нь адгуус буюу” хэмээхүй нь монгол угсаатан, үндэсний эд эс болсон монгол хүн бүр түүх соёлоо мэдэх ёстой, тэгж эс чадваас адгуус малаас үл ялгагдаж “Нүд буй бөгөөд түүх юугаан үл үзэх нь сохор номин буюу” хэмээхүй нь хүн бүр өнгөрснөө хөөж мэдэж, түүнээс сургамж авч эс чадвал сохор номин мэт юунд үл хүрэхээ, хаа очихоо мэдэхгүй тэмтэчнэ, барьц алдана гэсэн санааг нэн тод илэрхийлжээ.

“Тайж бөгөөд өвөг юугаан үл мэдэх нь мал буюу” хэмээх хоёр дахь мөр нь нийгмийн удирдлагад угсаа залгамжлах ёс ноёрхож байсан үед тайж нар удам угсаа, үүх түүхээ мэдэхгүй бол олныг оройлон удирдаж залах боломжгүй. “Мэдэлтэй бөгөөд язгуур юугаан үл мэдэх нь мунхаг гахай буюу” хэмээхүй нь төрийн түшмэл нарт хандсан бөгөөд түүхээ судалж, сургамж авч байж, олон түмнийг мэдэл, мэдлэгтэй зохион байгуулж чадна. Эс тэгвээс мунхаг гахай мэт гэж сануулжээ. Их бичгийн хүн Инжаннашийн хэдэн зууны тэртээ хэлсэн энэ үг өнөөдөр хэлсэн мэт гүн ач холбогдолтой хэвээр байна. Манай ард иргэдийн их зонхи нь “адгуус”, “Сохор

<sup>117</sup> Ванчинбалын Инжиннаши “Хөх судар” Тэргүүн дэвтэр, Упаанбаатар, 2006 он, 29-р тал

<sup>118</sup> Ванчинбалын Инжиннаши “Хөх судар” Тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 2006 он

номин"-ийн категорид, өнөөгийн УИХ, Засгийн газрын гишүүд бараг бүхэлдээ “мал”, “мунхаг гахай”-н категорид багтаж байгаагаа үл ухамсарлан байгаа нь харамсалтай. Ой санамждаа ямагт авч МЭДЭГТҮН! УХАМСАРЛАГТУН! хэмээн онцлон тэмдэглэж байна. Гэвч тэнгэрт “Оготнын дуу үл хүрэх” гэгч болох буй заа.

### **Монголын ойрх түүхийн үеийн үндэсний ой санамж**

XX зуун бол монголчуудын тусгаар тогтнолын зуун байсныг залуу үе ой тойндоо шингээж, энэхүү тусгаар тусгаар тогтнолоо бататган хамгаалах үйлсэд хүн бүхний хүчин зүтгэл чухал болохыг ой санамждаа ямагт сүншиглэж байх ёстой. Иймээс 1911 оны үндэсний хувьсгал бол 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын эхлэл байсныг ойлгож мэдэх учиртай. Өөрөөр хэлбэл өөр хоорондоо харилцан шүтэлцээтэй салшгүй нэгдмэл үйл явц юм. МАН эдүгээ засгийн эрхэнд байгаа бөгөөд сөрөг хүчнүүд 1911, 1921 оны хувьсгалыг хооронд нь сөргөлдүүлэн 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын түүхэн ач холбогдлыг үгүйсгэх зарим оролдлого хийж байгаа нь хөөнд ассан ямаалзгана мэт явуургүй оролдлого юм. Жанжин Дамдины Сүхбаатар, Солийн Данзан, Догсомын Бодоо, Хорлоогийн Чойбалсан зэрэг хувьсгалын долоон нөхөд болон баатарлаг хөвгүүд амь биеэ үл хайрлан тэмцэж туурга тусгаар Монгол Улсыг байгуулж, өнөөгийн ардчилсан монголын эх суурийг бататган тавьж өгснийг хэнбугай ч үгүйсгэх аргагүй юм. Зарим мэр сэр түүхч гаднын судлаачдын хэтрүүлэн тавьсан зүйлсийг шинээр сэтгэгч болох гэж хөөргөн дэвэргэж байгаа нь үндэсний язгуур эрх ашиг, ой санамжаа умартаж буй хэрэг болой.

1921 оны хувьсгалын үр дүнд хэмжээт цаазат хаант засаг тогтож, үндэсний ардчилсан өөрчлөлтийн замд шилжсэн байна. Энэ үед хамжлагат ёсыг халж, хүний наад захын улс төрийн эрх чөлөөгүй байсан монголчууд хурал цуглаан хийх, үг хэлэх, сонгох, сонгогдох, хэвлэн нийтлэх эрхтэй болж, үндэсний ардчилсан эрх чөлөөтэй, улс орныхоо бүрэн эрхт эзэн гэдгээ мэдэрч эхэлсэн юм,

БНМАУ-ын I их хурал 1924 оны 11 дүгээр сард хуралдаж, анхны "Үндсэн хууль"-ийг батлан, Бүгд Найрамдах Улсыг тунхаглажээ. БНМАУ-ын "Үндсэн хууль"-д хүний эрхийн талаар түүхэн хязгаарлагдмал шинж илэрч байсан боловч эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш эрхтэй болохыг хуульчилж өгчээ. Ийнхүү Монгол Улс эмэгтэйчүүдэд тэгш эрх олгосон дэлхийн анхдагч орнуудын нэг гэдгийг бид ой санамждаа авах ёстой. Түүнчлэн олон улсын жишгийн дагуу Бүгд Найрамдах байгуулалд шилжсэн явдал улс төрийн ардчилсан тод ололт юм. Ийм учраас жил бүрийн 11 дүгээр сарын 26-д Бүгд Найрамдах Улс тунхагласан ойг ёслол төгөлдөр тэмдэглэн бүх нийтээрээ амардаг нь ард түмний ой санамжид энэ үйл явдлын түүхэн ач холбогдлыг бататган үлдээж буй хэрэг мөн.

Манай улсын хувьд 1930-аад он бол шинэ бодлогын үрээр эдийн засгийг сэргээсэн ололттой боловч улс төрийн амьдралын тухайд нэн ээдрээтэй, бүр эмгэнэлтэй өнгөрсөн он жилүүд байв. МАХН-ын VII их хурал (1928)-аар Коминтерн, ОК(б)Н Монголын үндэсний ардчилсан үзэлтнүүдэд цохилт өгч, төрийн эргэлт хийсэн билээ. Чингэснээр Монголд зөвлөлт загварын социализмыг тулган, нөхцөл бололцоо бүрдээгүй байхад барьж байгуулахыг оролдсон нь эцсийн эцэст ард олны дургүйцэл зэвүүцлийг төрүүлж улс орны өмнөд хилээр олноороо дүрвэн гарах, улмаар 14 аймгийг хамарсан лам, ардын зэвсэгт бослого дэгдэхэд хүргэснээр иргэний дайны ирмэгт нэгдэж очсон юм. Энэ нь Монголын нийгэм гүн хямралд

автсаны илрэл байв.

МАХН-ын Төв Хороо, Хянан байцаах Төв Комиссын онц III бүгд хурал (1932) хуралдаж түүний алдаа завхралыг засах шийдвэр гаргасан нь нам, улсын түүхэнд шинэ эргэлтийн бодлого хэмээн алдаршсан билээ. Шинэ эргэлтийн бодлого бол цоо шинэ бодлого биш. 1928 оноос өмнө явуулж байсан үндэсний ардчилсан өөрчлөлтийг сэргээн ялангуяа эдийн засагт эрс өөрчлөлт хийсэн бодлого үйл ажиллагаа байв. Шинэ эргэлтийн бодлогын жилүүдэд баян чинээлэг ардын тоо, дундчуудын хувийн жин эрс нэмэгдэж ирсэн боловч нөгөө л ядуу, дунд ардыг бодох ангичирхах бодлогын уршгаар энэ үйл явц тасалдсан юм.

Мөн шинэ эргэлтийн бодлого тасалдахад 1930-аад оны сүүлчээр бүх нийтийг хамарсан аймшигт хэлмэгдүүлэлт гол түлхэц болжээ. Энэхүү аймшигт хэлмэгдүүлэлтэд өртөөгүй айл байхгүй бөгөөд 30 гаруй мянган хүн хэлмэгдсэнээс барагцаалбал насанд хүрсэн эрэгтэйчүүдийн зургааны нэг нь энэхүү хилс хэрэгт егүүтгэгджээ. Тэдний их зонхийн амийг хороосон байна. Хүн төрөлхтний түүхэнд тохиолдож байсан дайн самуун, улс төрийн яргалалд хүн амын тоотой харьцуулахад ингэж олноороо өртөж байсан монголоос өөр улс бараг үгүй буй заа. Их гүрнүүд бага буурай улсын хувь заяагаар хэрхэн яаж тоглож болдог жигшүүрт үйлдлийг түүх мартаж өсгүй бөгөөд түүхэн санамжид үүрд бичиглэн үлдсэн байна. Мөн 1939 оны Халх голын дайны уршгийн үр дагаврыг ой санамждаа ямагт авч, ялалтын ойг нь хүндэтгэн тэмдэглэн ирсэн юм.

1940-өөд он бол дэлхийн II дайны хүнд жилүүд бөгөөд монголчуудын үндэсний ой санамжид арга буюу хадгалагдан үлдэх хэд хэдэн чухал түүхэн үйл явдал болсон юм. Юуны өмнө эх орны дайны үед Зөвлөлтийн ард түмэнд Монголын ард түмэн ёстой сэтгэл харамгүй тусламж үзүүлсэн юм.

Эх орны дайны жилүүдэд Монголын ард түмэн ЗХУ-д “Хувьсгалт Монгол” танкийн цуваа, “Монгол ард” нисэх онгоцны эскадриль бэлэглэж, дайн дуустал эдгээр танкны цуваа, нисэх онгоцны эскадрилийн хоол хүнс, хувцас хунарыг дааж, Зөвлөлтийн ард түмэнд 32000 морь бэлэглэж, 500000 шахам морийг хямд үнээр худалджээ. Улаан армид туслах олон хэлбэрийн ажлыг өрнүүлсний дүнд 435 сая төгрөгийн үнэ бүхий мал, эд материалын зүйл бэлэглэжээ<sup>119</sup>.

ЗХУ, АНУ, Их Британи гурван гүрний 1945 онд болсон Ялтын бага хурлаас И.В.Сталин шууд санаачилгаар БНМАУ-ын тус улсын тусгаар тогтнолыг дэлхий дахинаар хүлээн зөвшөөрөх эх үндсийг тавьжээ. Улмаар 1945 онд БНМАУ цусан барилдлагатай ах дүү Өвөр Монголын ард түмнийг империалистуудын савраас чөлөөлөх дайнд оролцож, ялалтад томоохон хувь нэмэр оруулснаар хүн төрөлхтний ой санамжид дурсагдан үлджээ.

Үндэсний ой санамжид үүрд дурсагдах өөр нэг түүхт үйл явдал бол 1945 оны 10 сарын 20-д Монголын ард түмэн тусгаар тогтнолын санал асуулга явуулж, 100 хувийн саналаар төр улсынхаа тусгаар тогтнолыг бататган тунхагласан юм. Манай улс 1942 онд анхны их сургууль МУИС-ийг байгуулсан нь боловсролын хөгжлийн гарамгай амжилт байлаа. 1950-аад он бол тус улсад их бүтээн байгуулалт хөгжсөн жилүүд байв. Энэ үед БНМАУ дан ганц мал аж ахуйн орноос хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн орон болон хөгжсөн үндэсний ой санамжид хадгалагдан үлджээ. Монголчууд бүх нийтээр бичигтэй болж ЮНЕСКО-ийн шагнал хүртсэн нь соёл, оюун

<sup>119</sup>История КПСС. Том 5. Книга первая. Москва, 1970, с.328.

санааны амьдралд гарсан ололт үндэсний бахархалт ой санамжид үл мартагдах үйл явдал болсон юм. Түүнчлэн БНМАУ, Европ, Ази олон үндэстэн дипломат харилцаа тогтоосон нь манай улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг дэлхий дахинаар хүлээн зөвшөөрөх болжээ.

Монголчууд энэ үед хөгжлийн философиороо “капиталист биш хөгжлийн зам” гэж томъёолж байв. Энэ нь нүүдэлчин малчин ард олныг хүчээр нийгэмшүүлэх оролдлого байсныг бид ой санамждаа авах ёстой.

1960-1980-аад оны сүүлч бол социалист хөгжлийн замаар замнасан жилүүд байв. Үүнийг зарим улс төрийн хүчнүүд буруу замаар будаа тээсэн хэмээн шүүмжилж байгаа боловч хийсэн бүтээсэн үйлдвэр, барилга байгууламж зэргээр нь авч үзвэл их бүтээн байгуулалтын жилүүд байсан юм. Мөн боловсрол соёл урлаг эрчимтэй хөгжиж, шинэ соёл бий болсон юм.

Үүний хамт үндэсний язгуур соёлоо хадгалах хандлагатай байв. Тухайлбал, Морин хуур, уртын дуу, хөөмий нь үе үеийн монголчуудын ой той, зүрх сэтгэлд шингэн үлдсэн язгуур урлагийн төрөл юм.

Морин хуурын тухай нэрт яруу найрагч М.Цэдэндорж

“Унаган хүлгээ дурсан  
Уран хуураан татаж  
Утгын яруу дуундаа  
Уярч хатуужиж суухдаа  
Хорвоогийн хамаг явдлыг  
Хоёрхон чавхдасаар ярьдаг  
Хосгүй нэгэн овог  
Азийн цээжинд нутагтай  
Жонон хараа амилуулсан  
Жолоо хоёр чавхдас нь  
Бөмбөлзүүлэн тэшээд гарахаараа  
Дөрвөн цагийн гишгэдэлтэй  
Хорвоо гэдэг өргөн  
Хотол гэдэг олон  
Холбож яаж дуулахаараа

Хоёрхон чавхдасанд багтаана вэ?” хэмээсэн нь үнэхээр гайхамшиг.

Ардын уртын дууны аялгуу, айзам морин хуурын хөг аялгуутай нийцэн зохицож, хорвоогийн жаргал зовлон, амьдрал ахуйг тусган, нэгэн өвөрмөц ертөнцийг бий болгож байсан. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин “Зууны манлай” уртын дууч Н.Норовбанзад гуай “Уяхан замбуутивийн наран” хэмээх уртын дууг дуулахад ямар ч үндэсний хүн сонсоод наран авхай ертөнцийн сайн, мууг үл голон гийгүүлж, монголын уудам талд морин дээр ергүүлж яваа мэт сэтгэгдэл төрүүлдэг нь уртын дууны гайхамшиг, алдарт дуучны гайхам ур чадвар юм. Сайх дуучин ертөнцийн мөнх бусыг үзсэн ч түүний дуулсан дуу аливаа үндэсний шинжтэй арга хэмжээний (бөх, морь, сур гм) өмнө, явцад эгшиглэсээр байна. Өнө мөнхийн эгшиглэн бидний ой санамжид үлдсэн нь энэ аж.

Ардын уртын дуу нь говь, талын зэрэглээ, хөвч хангайн сүрийг бадрангуй хөглөж, монгол хүний гүн бодлогошронгуй, тал шигээ уужим тал сэтгэлийн тансаг илэрхийлж, монгол дуу хөгжмийн язгуур урлагийн сүмбэр уул, хураангуйлбаас үг

аяыг бие хэл, сонсголондоо нутлан ширгээсэн монгол түмний уран сайхны соёлын сонгодгийн сонгодог болон төлөвшсөн юм. Түүнчлэн бусад улс үндэстэнд тэр бүр байдаггүй өвөрмөц өнгө дуурьсалтай язгуур урлагийн төрөл бол монгол хөөмий билээ.

Хөөмийн эгшиг эрс тэс уур амьсгалтай, уулархаг нутгийн өнгө аясыг агуулсан шинжтэй байдаг. Хөөмийн эгшигт ардын богино дуу илүү зохицно. Хөөмий орчин үеийн хөгжмийн ая дангаар баяжуулсан манай рок попын залуус дэлхийн тавцан дээр гарч эхэлж байгаа жишээ бол “Хүү” хамтлагийн тоглолт юм.

Энэ нь ардын язгуур урлагийн төрлүүдийн олон үе ой санамждаа авч баяжуулан хөгжүүлж буй үр дүн билээ.

Яагаад хоцрогдов? хэмээх асуулт гарна. Бид ЗХУ, социалист орнуудын тусламжаар олон үйлдвэр, завод байгуулсан. Гэтэл бидэнд өөрсдөө тусламж авч байсан эдгээр орнууд өндөр хөгжилтэй орнуудаас бол хол хоцорсон байсан. Тэдгээр орнууд бас өөрийнхөө хоцрогдсон гэж үзэж байгаа техникээ сэтгэл харамгүй тусламж хэмээн Монголд өгч байсан. Ингэж манай эгэл жирийн ажилчин, албан хаагчид чин сэтгэлээсээ зүтгэн бүтээж байсан ч үр дагавар нь их төлөв талаар болж байсан билээ. Зарим тоймч судлаачид ийм байдлыг Монголын удирдагчдын урагшгүй үйл ажил гэж үзэх нь бий. Гэтэл бид тэр цагийн олон улсын нөхцөл байдлыг тунгаан бодох ёстой.

Монгол Улс хоёр их хөрштэйгөө хил залгадаг нэг ёсондоо хоёр их гүрний бахинд байсан шүү дээ. Харин манай удирдагчид хоёр их хөрштэйгөө ижил тэгш харилцахыг оролдох ёстой байсан байх. Харин 1960-аад онд Хятадад өрнөсөн соёлын хувьсгал гэгч нь сайн хөршийн найрсаг харилцааны нэмэгдэх боломжийг боож хаасан байна. Ер нь бага жижиг орнуудын гадаад бодлого их гүрнүүдийн бодлого үйл ажиллагааны хүрээнээс зайлсхийж гарахад амаргүй байсан гашуун сургамжийг ой тоондоо ямагт шингээж, мэргэн ухаан сийлж байх ёстойг УИХ-ын Засгийн газрын гишүүдэд дахин сануулмаар байна.

Дэлхийн социализм 1980-аад оны эцсээр мухардалд орж, социализмын гол цайз болж байсан ЗХУ нуран унажээ. БНМАУ “перестройка” буюу өөрчлөн байгуулалтын шатыг дамжин, нийгмийн шинэ сонголт хийхэд хүрчээ. Нөгөө талаар монголчууд дэлхий дахины хөгжлийн чиг хандлагыг ой санамждаа соргог тусгаж, хэрэгжүүлэх чадамжийг нотлон харуулна. Монголчууд 1990-ээд онд ардчилал, зах зээлийн замд эргэлтгүй шилжжээ. Даяаршиж буй ертөнцөд хөл нийлүүлэн алхаж байна.

Улс орон, угсаатан үндэстнүүдийн соёл иргэншлийн харилцан нэвчилт, найрсаг зохицлын их давлагаан, хүчирхэг түрэлт нь XXI зууны олон улсын харилцааны өнгө төрхийг тодорхойлох болно. Үүнийг бид “даяаршил” хэмээн томъёолох болов.

Бидний монголчууд нийгэм түүхийн бодит шалтгаанаар хөллөсөн жам ёсны үзэгдэл даяаршилд нийлэн нэгдэж, хүн төрөлхтний бүтээсэн, бүтээх гайхамшгийн сор дээжээс охилон хүртэх ёстой. Тэгж байж сая бид хүчтэй, хүчирхэг болно. Хүчтэй байна гэдэг нь дэлхийн шилдэг ололтыг өөртөө шингээнэ гэсэн үг. Бас ингэж адилсахаасаа дутуугүй ондооших ёстой. “Ондоошно” гэдэг нь уугуул ёс заншил, унаган соёл, төрх, үндэсний өвөрмөц байдлаа хадгалах дархлалтай байна гэсэн үг. Миний энд дурдан буй “ондооших” хэмээх томъёоллыг зарим судлаачид “дангаарших” гэж томъёолжээ. Доктор Н.Багабанди “Даяаршлыг сондгой байдлаар өрөөсгөлдүүлэн авч үзэх хандах нь арга зүйн хувьд алдаатай болно. Дангааршилгүй

даяаршил байж таарахгүй, даяаршилгүй дангааршил ч оршин тогтнох бололцоогүй. Энэ хоёр үйл явц, тэдгээрийг илэрхийлсэн хос ойлголтууд нь эсрэг тэсрэг байж, бие биеэ үгүйсгэдэг ч нэгдмэл цул болж, бас бие биеэ нөхцөлдүүлнэ. Олон улсын харилцаа, хамтын ажиллагаанд эдгээр ойлголтыг хамтад нь авч хэрэглэснээр асуудалд бодитой, оновчтой хандах зөв байр суурь тогтох болно.”<sup>120</sup> Ийнхүү даяаршлын нөхцөлд үндэстний хувьд дасаж зохицох, үлдэж хоцрох, талаар монгол хүн бүр ухаарах хэрэгтэй болж байна.

Ардчилсан өөрчлөлт шинэчлэлийн өнгөрсөн 30 жил бол нийгмийн хөгжлийн жирийн хэмнэлээр авч үзвэл цар далайцаараа лавтайяа нэгэн жарантай тэнцэх хувьсал өөрчлөлтийн он жилүүд байлаа хэмээн зарим улс төрчид, судлаачид бичиж байна. Туулсан замынхаа тоймыг эргэн харахад монголчууд бид хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжилд хэр чадлынхаа хэмжээгээр бага боловч түлхэц өгч, тодорхой хувь нэмэр оруулсан гэж хэлж болох байх. Зарим нэг сургамж, онцлог болох зүйлийг нэгтгэн дүгнэвэл:

-Нийгмийн нэг тогтолцооноос нөгөөд шилжих чанарын өөр шилжилтийг улс төрийн хүчнүүд хүчирхийлэл, зэвсэгт тэмцлийн замаар бус тайван, ухаалаг зөвшилцлийн аргаар хийж болохыг;

-Улс орондоо улс төрийн болон эдийн засгийн эрс тэс шинэчлэлийг нэгэн хамтад хийх боломжтойг;

-Орчин үеийн дэлхий дахины ардчиллын хэм хэмжээ, сэтгэлгээний сүүлийн үеийн ололтыг тусгасан эрх зүйн цогцолбор шинэчлэл хийх боломжтойг;

-Бага буурай улс орон үндэсний эрх ашгаа дээдэлсэн, нээлттэй, олон түшигт, харьцангуй бие даасан гадаад бодлого явуулж болохыг нотолж өглөө.

Монгол оронд ийнхүү ардчилал өөрийн бүтэц, бүрдлээрээ хөгжин боловсорч байгаа боловч түүний чанарыг үзүүлэлтэд зарим согог (defective), хомсдол байсаар байгааг тэмдэглэх ёстой. Үүнд:

-Эрхээ шилжүүлсэн (delegative) буюу төлөөлөгчийн ардчиллын хүрээнд парламентын болон бусад сонгууль хүлээсэн улс төрийн албан тушаалтнууд сонгогдох үедээ толгойдоо багтсан бүхнийг амлаж “хайлсан тугалга мэт” аашилж байснаа хэргээ бүтээсний дараа сонгогчдоо үл тоон, бүхнийг мэдэгч, дур зоргоороо авирлагч болон хувирч, улсын эрх ашгаас хувийнхаа ашиг сонирхлыг үнэмлэхүй дээгүүр тавих нь олонтоо болсон.

-Бүх шатны төрийн байгууллагын ажилтнууд хуулийг мэргэжлийн үүднээс бүрэн дүүрэн, үр ашигтай хэрэгжүүлэх хэрэв алдаа гаргавал тэдэнд хүлээлгэх хариуцлагын механизм илт дутагдаж буй.

-Улс төрийн намууд нийгмийн тодорхой бүлэг, давхаргын эрх ашгийг илэрхийлэхээсээ илүү албан тушаал, ашиг хонжоо хайгч цөөн хүний улс төрийн зэвсэг болон хувирах хандлагатай болсноос иргэд улс төрийн намд үл итгэх, сэтгэл алдрах уур амьсгал бий болсон.

-Иргэд эрхээ илүү мэдэрч үүргээ умартах нь элбэг тохиолдож, миний эрх чөлөө бусдынхаар хэмжигдэнэ гэдгээ тэр бүр ухамсарлахгүй байгаа,

-Хуулийн өмнө хүн бүр тэгш эрхтэй хэмээн Үндсэн хуулиар тунхагласан авч, эрх мэдэл, мөнгө хөрөнгөтэй хүнд илүү үйлчилж байна.

-Авилгалын бүхэл бүтэн тогтолцоо бий болж, улс төр, захиргааны болон шүүхийн

<sup>120</sup> Н.Багабанди “Шинэ зууны өмнөх бодлого, зорилт” Упаанбаатар, 2001 он, 47-р тал

салбарт авилгал илүү газар авах шинжтэй байгаа зэргийг онцлон хэлж болох юм.

Төгсгөлд нь тэмдэглэхэд, үндэсний ой санамжийн хамгийн гол амин сүнс нь төрийн хар хайрцагны бодлогод хадгалагдаж байх ёстой. Тэрхүү бодлогын алсын харааг монголчууд “хар малгайн бараа харах” хэмээн томъёолж байсан. Хар хайрцагны бодлогыг холын ба ойрын гэж ангилан үздэг. Хар хайрцагт байх хамгийн гол бодлого бол хоёр их хөрштэйгөө тэнцвэрийг нь олж ухаалаг харилцах, Жишээ нь: Шинэ засгийн газар байгуулагдаад Ерөнхий сайд, шинэ Ерөнхийлөгч сонгогдоод хоёр их хөршийнхөө хэнийд эхэлж айлчлах вэ? гэдгээс эхлэх хэрэгтэй болов уу. Энэ бүхнийг Үндэсний Аюулгүйн Зөвлөлөөр ярилцаж, хар хайрцагаараа хадгалахыг хадгалж, ил гаргахыг гаргаж байх хэрэгтэй.

Бид хоёр их хөршөө барс арслантай зүйрлэвэл, бид “нохойн гөлөг”- ний л хэмжээтэй юм.

Бар, арслангийн өөдөөс нохойн гөлөг хэчнээн зоригтой дайрлаа гэхэд тэд чичивхийхгүй. Харин яльгүй чичивхийдэг нохойн гөлөг муужран унана. Миний энэ хэлж буй зүйрлэл эвгүй боловч бодитой үнэн юм. Төрийн гурван өндөрлөгт байгаа улс төрийн зүтгэлтнүүд ямар намынх байх нь хамаагүй, тэдэнд намын эрх ашгаас үндэсний эрх ашиг ямагт илүү тавигдах ёстой. Үүнд л төрийн хар хайрцагны бодлого чиглэгдэнэ.



## **2.3 Монгол төрийн бодлого, төрийн албаны үнэт зүйлсийн уламжлал Монголын Үндэсний ой санамж үндэслэгдсэн нь**

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад таатай нөхцөл бүрдэхэд эхний чухал алхам нь монголчуудын түүх үнэн бодитой байх явдал бөгөөд монгол үндэстний амин чухал дархлааны үндэс билээ.

Чингис хаан өөрөө амьд сэрүүн байхдаа бомбын шашны арш Чанчун бомботой уулзахдаа “Манай Хүннүгийн үеэс эхлэн гээд өөрийн улс өвөг дээдэстэй” гэдгийг зааж хэлж байсан байдаг. Монголчуудын үндэсний ой санамж монголчуудын өвөг дээдэс, анхны нүүдэлчдийн төрт улс чухам Хүннү, Сяньбийн үеэс яригддаг.

Монгол Улс үндэстэн төв азийн төвд өндийн босож тулгуур төрөө сэргээж байх үед аюулгүй байдлынхаа гадаад таатай нөхцөлийг бий болгох үндсэн арга нь цэрэг, зэвсгийн арга л байсан.

Харин энэ удаа бид Чингис хааны дэлхийг эзэрхсэн цэрэг дайны жанжны талаас биш хүн төрөлхтний мянганы суут жолоодогч хаан байсан хүний хувьд монголын төрт ёсыг бий болгосон түүхийг, төрийн ой санамжийг үүсгэж хэрхэн баталгаажуулсан талаас бичих гэж оролдох болно.

### **а. Их хуралдай**

Хамаг монголын хаад залгамжлагчаа заавал ургийн дотроос хэн авьяас чадвартайг нь тодруулдаг байсан. Оюун ухаан, баатар зориг, бусдыг дагуулах удирдах чадвар зэрэг олон шалгуураар хаанаа Их хуралдайгаар сонгодог, баталгаажуулдаг ёс журам нь Хамаг монголчууд бусад зэргэлдээх нүүдэлчин Хэрэйд, Мэргид, Найман, Татар зэрэг олон ханлиг, аймгуудаас тодорч, илүү гарах нэг үндэс болсон байдаг.

1206 онд Их Монгол Улсыг байгуулж төр улс нь 1279 он хүртэл цаг үед Монголд нийгмийн давхраажилтын доторх дээш, дооших урт дурын хүмүүсийн хөдөлгөөн, цэргийн язгууртнуудын Их хуралдай, бусдын шашин үзэл бодолд хандах чөлөөт байдал зэрэг үйл зан, байгальдаа ойрхон чөлөөт идэвхтэй сэтгэлгээ ноёрхож байв.

Чингис хааны тэргүүлсэн Их Монгол Улсын сүр хүч нь

а. цэрэг, зэвсэг

б. хууль ёс журам

в. төрийн бодлого, төрийн албаа бэлддэг тогтолцоо

г. үндэсний түүх ой санамжаа цаасан дээр буулгасан гэх мэт олон хүчин зүйлээр тодорхойлогдож байжээ.

Тэр бээр зөвхөн цэрэг, зэвсгийн хүч, зохион байгуулалт төдийгүй хууль, ёс журам, түүх соёлоо хөгжүүлэх нь шинэ тутам улс үндэстний, удаан хугацаанд оршин байлгах төрийн бодлогын чухал үндэс болохыг тухайн үедээ харж хэрэгжүүлж чадсан эрхэм билээ.

б. 1206 онд Их Эзэн Чингис хааны тунхагласан “Их Засаг” хууль.

Чингис хаан улс орноо хуулиар засаглах болж “Их засаг” хуулиа тунхагласнаас хаан төрийн засаглах чадвар улам нэмэгдэж, дэлхийд ноёрхсон монголчуудын давамгайл байдал хоёр зуун жил үргэлжлэх боломж чадавхыг бий болгосон.

в. Төрийн бодлого, төрийн алба

Чингис хаан хуулийг тогтоож батлахаас гадна ягштал даган мөрдүүлж, улс гүрэн даяараа эе эв, энх амгалан, шударга ёсыг тогтоож чадсан “Шулуун шударга, чадал эрдэмтэй, цэцэн ухаантай хэнийг ч байсан итгэл өгч төрийн хэргийг тушааж, улсыг



засахад зүтгүүлэх нь “Бадрах төрийн бат оршихуйн нэг үндэс болдог” тухай мөн “Өглөө хэлснээ үдэш нь, үдэш хэлснээ өглөө нь няцагч туйлбаргүй зантан, бусдыг бүү хэл өөрийгөө захирч эс чадагч ичгүүргүй явдалтан, эд хөрөнгө, эрх мэдэлд ташаарагч шунахай, зальхай, харгис, журамгүй хэнд ч болов төрийн хэрэг бүү даалга” гэсэн “Их засгийн” үзэл санаа, Богдын зарлиг эдүгээ төрийн хэрэгт ус, агаар лугаа чухал, сургамжтай юм.

Их хаан өөрөө зовлон үзэж, буруу зөрүүг сөрж тэмцэн гарч ирсэн хүний хувьд “Их засаг” хуулиараа нэг талаас цэргийн хатуу журам, нөгөө талаас нийгмийн бүх давхаргынханд тэгш үйлчилдэг, дарга удирдагч нь хувийн чадвар авьяасаар сонгогддог зэрэг либерал хандлагыг тогтоож байлаа. Жишээ нь: Чингис хааны байгуулсан улсын дотор алтан ургийн бус шинэ ноёдын давхраа үүсэж, баруун гарын мянгатын ноёдын 65 хувь, зүүн жигүүрийн мянгатын ноёдын 76 хувийг нөхөр, турхгууд эзэлж байсан<sup>121</sup> гэсэн судалгаа байдаг.

Шударга ёсны энэ сургаал, сургамж Монгол үндэстэн, Монгол төрийн ой санамжийн чөмөг, ноён нуруу нь болон уламжлагдах учиртай ажгуу. Энд төрийн үлгэр дуурайллын тухай голлон хэлж байна. Төр дуурайллаа хэчнээн алдана, нийгэм төчнөөн хэмжээгээр эмх замбараагүй байдалд орно. Их Богд Чингис “Хэрэв хаан болчихоод хааны явдлаар явж эс чадваас хаан болж юу хиймүй, шившиг!” гэж айлдсан нь наанаа эзэн хааны тухай ярьж байгаа боловч цаад чанартаа төрийн үүрэг хариуцлага, үлгэр дуурайллыг тодорхойлсон үг юм. Хишигтэн нь монголын бүх ноёд жанжин, аймаг, хүрээдийн удирдагчдын нуган үрсээс бүрдэж байсан нь тэднийг төрийн бодлого, цэргийн хэрэгт нэг талаасаа сургах, хатуужуулах төдийгүй цаад талаараа улс гүрний нэгдэл, төрийн эвийг бэхжүүлсэн Чингис хааны алсыг харсан төрийн бодлогын нэг хэсэг байсан юм.

Энэ мэтчилэн төрөө дээдлэх үзлийг монголчуудад нүүдэлчин тархай бутархай ахуй, хүчтэй хөршүүд нөхцөлдүүлж, Чингис хаан ухаалаг бодлогоороо бэхжүүлж өгсөн.

Үндэсний ой санамжийг хадгалж өвлүүлж ирсэн өмнөх өв түүх, уламжлалаас бидний төслийн судлаачдаас<sup>122</sup> дараах дөрвөн зүйлийг тусгайлан онцлон авч үзэж өв түүхийн үнэт зүйл эрхэмлэх зүйлс гэж байгаа юм. Үүнд:

Нэгдүгээрт, “Монголын нууц товчоон” үндэсний ой санамжийн дээд шүтээн”,

Хоёрдугаарт, “Их засаг” буюу монголын хууль эрх зүйн уламжлал,

Гуравдугаарт, Монголын төрөөс газар нутгаа хамгаалах талаарх бодлого, үйл ажиллагаа,

Дөрөвдүгээрт, “Хишигтэн” төрийн албаны түүхэн уламжлалыг монголын “Өв түүхийн үнэт зүйл эрхэмлэх зүйлүүд” гэсэн дөрвөн зүйлээр тусгайлан авч үзэж судалгаа хийлээ.

<sup>121</sup> Икэуүи Исао “Чингис хаан” 1991 он, 102-р тал

<sup>122</sup> БСШУС-ын сайдын А/146 тоот тушаалын хавсралт жагсаалтын 11-г үндэслэн “Үндэсний ой санамж, үнэт зүйлсийг сэргээн тодорхойлох замаар үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нь” захиалгат төслийн удирдагч ҮБХИС-ийн харьяа Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төвийн дарга, асан Ч.Сосорбарам. “Монгол үндэсний ой санамжийн түүхэн уламжлал” Академич Ж.Болдбаатар, доктор (Ph.D), дэд профессор

## **“Монголын нууц товчоон” бол монголын түүх үндэсний ой санамжийн эх дээд шүтээн мөн**

Монголчууд “Нууц товчоон”-оо (цаашид “МНТ” гэх) тулгар төрийнхөө эхэнд өөрсдөө бичиж үлдээж чадсанаараа энэ цаг үед үндэстэн улс байх нэг гол тулгуураа олж, үндэсний ой санамжийн гол эх суурь үндсээ бий болгосон юм.

Эзэн Богд Чингис хаан Их Монгол гүрнээ байгуулаад “Монголын нууц товчоон”-г бүтээлгэн эхлүүлж Өгэдэй хааны үед дуусгасан байдаг. Уг сурвалжид алтан урагтны түүхийг голлон бичсэн боловч эртний монголчуудын улс төр, нийгмийн байгуулал, хууль цааз, дайн байлдаан, үг хэл, үсэг бичиг, шашин шүтлэг, ёс заншил, овог аймаг зэрэг мэдээллийг багтаасан нэвтэрхий толь, сонгодог бүтээл, үндэсний ой санамжийн шилдэг дурсгал бөлгөө.

Их Монгол Улс байгуулагдсанаар Ази Европыг холбосон морин өртөөг байгуулж дэлхийд өөрсдийн дэг журам, энх тайвныг тогтоож чадсан монголчууд өнөөгийн мэдээллийн нэгдсэн тогтолцооны суурийг тавьсан гэж гадаад, дотоодын түүхчид үздэг билээ.

Чухам энэхүү дэг журмын ачаар Ромоос Гильом де Рубрук, Францаас Плано Карпини, Венецээс Марко Поло нар Европоос Ази тив рүү аялж Монголын Их хаадтай нүүр тулж уулзаж чадсан бөгөөд тэдний “Дорно этгээдэд зорчсон минь”, “Монголчуудын түүх”, “Орчлонгийн элдэв сонин” гэх алдартай бүтээлүүд дэлхийд дахины ой санамжийн дурсгал болон мөнхөрчээ.

Өмнөд Сүн улсаас 1221 онд Монголд ирсэн элч Чжао хун<sup>3</sup>, 1237 онд Өгэдэй хаанд ирсэн элч Пэн Дая, Сюй Тин<sup>4</sup>, 1215 оноос монголын төрд зүтгэсэн сайд Елюй Чуцай<sup>5</sup>, 1223 онд Чингис хаантай уулзсан эрдэмтэн Чанчун бомбо нарын тэмдэглэлүүд ууган чухал сурвалжууд нь харь монголчуудын талаар хүний нүдээр ажиглан сонирхолтой баримтуудыг үлдээжээ. “Юань Улсын судар” Дундад зууны монголын түүхийн томоохон сурвалж болно.

Ингэж «“Монголын нууц товчоон” төдийгүй тухайн үеийн монгол, хятад, түрэг, араб, перс хэлний сурвалж хэрэглэгдэхүүн бие биеэ нөхвөрлөн түүхэн асуудлыг ихээхэн тодорхой болгож байдаг нь тухайн дэлхийн түүхийг ч бичих боломжийг өгч байсан гэдэг.

Чингис хааны эхлүүлсэн үйлийг үргэлжлүүлж Их Юань Улсын үед Хубилай хаан түүхчдийг сонгон цуглуулж тусгай хүрээлэн байгуулан, улсынхаа түүхийг бичүүлж (зөвхөн алтан ургийнханд л уншуулдаг “Нууц товчоон” хааны ордонд байсан гэдэг)

Ил хаадын дэмжлэгтэйгээр Персийн түүхч Ата-Малик Жүвейни “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”-ээ бичиж, Газан, Өлзийт хааны зарлигаар сайд Рашид-ад-Дин, Болод чинсян тэргүүтэй түүхчид “Судрын чуулган” нэрт дэлхийн улсуудын түүхийг туурвиж байсан зэрэг түүхэн баримт нь монголын төр, түүний их, бага хаад түүх бичлэг төрийн ой санамждаа онцгой анхаарч байсныг гэрчилнэ.

“Монголын нууц товчоон” төдийгүй тухайн үеийн монгол, хятад, түрэг, араб, перс хэлний сурвалж хэрэглэгдэхүүн бие биеэ нөхвөрлөн бидний судлан буй асуудлыг ихээхэн тодорхой болгож байдаг.

Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов “Монголын нийгмийн байгуулал” гэдэг номын ... дугаар нүүрт бичсэн нь “Дундад зууны үед нэг ч үндэстэн, монголын адилаар түүхч нарын анхаарлыг татсангүй гэж хэлж болох ба бас “Нууц товчоон”-ы адилаар жинхэнэ амьдралыг тодорхой дүрслэн үзүүлсэн дурсгалт бичгийг нэг ч

нүүдэлчин үндэстэн үлдээсэнгүй гэдгийг тэмдэглэвэл зохино” гэжээ.

“Монголын нууц товчоон”-ы дараа дараагийн “Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх”, “Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл”, “Алтан товч”-ууд, “Эрдэнийн товч”, “Эрдэнийн эрих” гээд үе үеийн түүх бичгийн мэргэдийн туурвил бүтээлүүд нь түүний үргэлжлэл болж нүүдэлчдийн амьдрал, тэмцлийн түүхийн гэрч баримт болон үлдсэн бөгөөд тэдгээрийн агуулга, мэдээллийн үнэ цэн өнөө үед улам бүр өссөөр байна.

“Монголын нууц товчоон” алтан ургийнханд зориулсан нууц, дээр нь үргэлж баяжигдаж байдаг учраас хаан ширээг залгамжлагчид ялангуяа хааны хатангуудын өрсөлдөөн энэхүү бичгийн “цөөхөн байдаг”, “устаж алга болдог” түүхэн бодит шалтаг шалтгаан болдог байсан байх магадлал бий.

“Монголын нууц товчоон”-ы 1254-1258 оны нэмэгдэл дээр Өгэдэй, Толуй хоёрыг харьцуулсан судалгаа хийхэд л хэний талаас бичигдсэн бэ гэдэг нь (Дөргөн, Сорхогтун хатдын өрсөлдөөн) харагддаг хэмээдэг түүхчид бий. Хятадын олон ангит “Хубилай хаан”-ы тухай кинонд хэнийг хаанаар залгамжлуулах тухай асуудлыг хааны үлдээсэн бичигтэй холбон ихэд ач холбогдол өгсөн байдаг.

Хубилай хааны улсынхаа түүхийг хадгалдаг тусгай хүрээлэн ихээхэн нууцлалтай, тусгай журамтай байсан байдаг. Юань Улсын түүхэнд бичсэнээр<sup>123</sup> Туг төмөр хааны цадигийг үндэслэн Ринчинбазар хааны анхдугаар оны цагаан сард зарлигаар “Жин Ши Да Диэн” бичгийг зохиолгожээ. Энэ бичгийг зохиохын тулд Хааны нууц хүрээлэнгээс<sup>124</sup> “Нууц товчоон” Ми Ши-ийг авч Тайзу хааны сүүлээрх явдлыг тэмдэглэх гэсэн боловч Хүрээлэнгийн дэд сайд Я Бу хуа (Ябуху) “Товчоон бол нууцын зэрэглэлд хамаарах бичиг болохоор гаднын хүнээр хуулуулан тархааж болохгүй. Тиймээс сайд миний бие зарлигийг дагаж чадахгүй” хэмээсэнд тэр ёсоор болгожээ. Энэ хэсгээс хоёр зүйл тодорхой байгаа юм. Нэгд, “Нууц товчоон” тэр үед хааны ордонд хадгалагдаж байжээ. Хоёрд, хааны зарлиг хүртэл энэхүү номын нууцлалыг зөрчих эрхгүй байжээ гэсэн чухал мэдээлэл болдог.

Юань улс сүүлийн үед монгол хэл муутай хан хүүдэд зориулж хятад ханзаар буулгасан байх магадлалтай бол Мин Улсын үед монгол хэл мэдэхгүй хятадуудад зориулж хятад үсгийн бүрхүүлд орсон энэхүү монгол үгийг нангиад үсгээр галигласан ном бий болжээ.

Судлаач Болджамьян “Тайваний музейд буй “МНТ”-ы ориг эх ...ханзаар монгол хэлийг галиглан бичээд ард нь хятад орчуулгыг хадсан байдаг гэнэ лээ. Монгол үгийг ханзны дуудлагаар бичнэ гэсэн үг. Хятад хүн түүнийг уншиж чадах ч хэрхэвч ойлгохгүй. Орчуулгыг нь ард нь зэрэгцүүлээд хадсан түүгээр хятад хүн ойлгоно. Монгол хүн ч мэдэхгүй хуучирсан үгээ хятад орчуулгаар нь хөөж мэдэж болдог ийм л гайхалтай... монгол бичгээрээ эхтэй байсан юм байна гэсэн дүгнэлтийг судалсан эрдэмтэд санал нэгтэй баталсан байдаг. Дашрамд хэлэхэд хятад хэлд шамддаг залуус нэн түрүүнд “Нууц товчоон”-оо уншдаг тийм дуураймал энэ ориг хувилбарыг монголдоо гаргах хэрэгтэй юм.” гэжээ.

Монгол үгийг нангиад үсгээр галиглан буулгасан 12 дэвтэр ба 15 дэвтэр гэсэн хоёр хувилбар ном байдгаас арван хоёр дэвтэр бүхий зохиолыг “Е Дэхуйн дэвтэр”

<sup>123</sup>Х.Цогтнаран., Д.Гүн-Үйлс “Монголын нууц товчоон: Барламал болон хуулмал дэвтрүүд, оршил, гаргалгаа” Улаанбаатар, 2017 он, 139-р тал /Ли Вэн тяний цохолбор/

<sup>124</sup>“Хан Лин”-ы1 “Гүе Ши Юань” хүрээлэн

гэдэг<sup>125</sup>.

Монголчууд түүхийн олон зууны нугачаанд түүхийн эх сурвалжуудаа хадгалах явцдаа алдаж эндсэн олон ээдрээтэй үеийг ч туулж гарсан.

“Монголын нууц товчоон” хаадын нууцад байснаа дараа үедээ алтан урагтнуудаар дамжин үргэлжилж өргөө гэрт нь баяжигдан бичигдэж байсан байсан бол хориглож хааж байсан хэцүү цаг үеийг даван туулж өнөө үед Ерөнхийлөгчийнхөө зарлигаар “МНТ”-г өрх бүрийн хойроо залсан нь монголчуудын үндэсний ой санамж бадран хөгжих зам үүдийг нээсэн нь дамжиггүй.

#### “Их засаг” монгол төрийн хууль, эрх зүйн уламжлал

Монголчуудын үндэсний ой санамжийг хадгалж өвлүүлж ирсэн өмнөх түүхэн уламжлал гэхээр юуны түрүүн тэдний улс, төр засгаа байгуулж байсан Чингис хааны XII зуун, дэлхийд тэргүүлэх болсон Монголын эзэнт гүрний тухай түүхийг дурсахаас эхэлж, алдаж бутарсан дундад зууны түүхэн сургамж, улс орноо нэгтгэн төрөө зассан болон тусгаар тогтнолоо алдсан цаг үе шалтгаан, тусгаар тогтнолоо дахин олж авсан, сэргээн хөгжүүлсэн буурал түүхийн жимээ эргэн харж, тэрхүү түүхэн үеүдийн монгол төрийн засаглал, хууль эрх зүйн уламжлалын талаар ч ярих хэрэгтэй болно.

Эд бүгдийн эхэнд монголчуудын ой санамжийн дээд шүтээн “Нууц товчоон” судлалыг түрүүн хэлэлцсэн бол энэ удаа монгол төрийн засаглал, хууль эрх зүйн түүхэн уламжлалыг авч үзэх нь монголчуудын үндэсний ой санамж хэрхэн бий болж мандан бадарсан, буурсан шалтгаан үр дагаврыг харуулахад нэмэр болно гэж үзэж байна.

Ялангуяа “Их засаг”-ийн жишээн дээр монголчууд үндэсний ой санамжаа “яаж бий болгосон” бас “гээж алдсан” болон “сэргээсэн” эрх зүйн түүхэн уламжлал тодорхой харагдах байх.

Үндэсний ой санамж нь төр улс үндэстний түүхээс гадна олон улсын /нийт хүн төрөлхтний/ болон үндэсний хууль цааз, хууль эрх зүйн сэтгэлгээнд нь тусаж шингэсэн байдаг. Хүн нийгэм, хүн, хүн байгаль эх гэсэн гурвалсан харилцааны соёл, хэм хэмжээ, дэг журам бүрэлдэн тогтсон түүх нь хууль цааз, эрх зүйн сэтгэлгээний түүх болно. Энэ түүхэн үйл явцад хүний нийгэмшин амьдрах, хэн нэгний хүч чадал эрх мэдлийн эрхшээлд /эсхүл эрхшээх/ зохион байгуулагдан аж төрөх буюу хүний төрөлхийн “улс төрлөг” мөн чанар илэрдэг бөгөөд үүнийг Аристотель /“улс төр”/, хожим Макс Вевер “Улс төр мэргэжил, хувь тавилан болох нь” /нар/ “Хүний нийгмийн уугуул мөн чанар бол оршихуйн тулд хамтран аж төрөх, хамтрахуйн утга учир нь зохион байгуулалтад” өөрөөр хэлбэл хүн амьдрахын тулд хүмүүний аль нэгэн олонлогт /овог, аймаг, өрх гэр бүл, улс үндэстэн г.м/ харьяалагдан, хууль цааз, ёс журам, зан заншил г.м /багтан засаглагдан засаглаж/ аж төрөхөөс өөр замгүй гэж тодорхойлжээ.

Үүнийг хүний олонлогийн өнгөрсөн, одоогийн нь туршлага, ой санамжид нь суурилсан оршихуйн арга ухаан гэх бөгөөд эрх зүйн сэтгэлгээ гэж ч нэрлэдэг байна.

Хүмүүн, төр, хуулийн бие биеэ нөхцөлдүүлэх энэ холбоог бүр эртний сэтгэгчид

<sup>125</sup> Мөн хятадын Мин Улсын үед бичигдсэн гэх (Мин улсын Хун Ү хааны үед “МНТ”-г олж, 1382 онд хятад хэл дээр Жан Юан-зи, Маша Ихэ (монгол) хоёр орчуулсан гэж Кафаров, хятад түүхээс иш татаж мэдээлсэн байдаг).

Гераклит, Сократ, Платон, Аристотель нар “хүнд төр хэрэгтэй бол төрд өөрт нь хууль гарцаагүй хэрэгтэй”, “хаана хууль байна тэнд төр ёс байна”, “Хуульд захирагддаг байх нь төрийн нэг ёсны атрибут”<sup>126</sup> гэх зэргээр тайлбарласан байдаг ажээ. Учир иймд “Хүний түүх бол улс үндэстний түүх, улс үндэстний түүх бол төрийн түүх, төрийн түүх бол хууль цаазын түүх” болдог учиртай ажээ<sup>127</sup>.

В.Ф.Гегель “Тэд өөрөө хэн бэ, юу хүсдэг вэ гэдгээ мэддэг ард түмэн л түүхээ бичиж хардаг” гэжээ. Үндэстэн өөрийгөө зөв ухамсарлахын эх сурвалж нь тухайн үндэстний цадиг түүх болой. Ард түмэн түүхээ мэдэхгүй бол “ойд төөрсөн сармагчин лугаа адил”, “харанхуй буданд төөрсөн эрвээхэй мэт” гэх зэргээр онож хэлсэн мэргэн цэцэн санаа манай монголчуудын дунд өнө эртнээс яригдсаар иржээ.” гэжээ

Хууль цааз, ёс журмыг эрхэмлэн сахих, төр улс, иргэний гол гол хэргүүдээ хуульд захируулан шийддэг нь монголын ард түмэн, монгол төрийн нандин уламжлал, ой санамжийн нь чухал зүйл нь юм.

Төрийн ой санамжийг сэргээх түүний дотор хууль эрх зүйн уламжлалаа сэргээн эргэн харж, өнөөдрийн хөгжлийн түвшнээс дүгнэх шаардлага байна.

Эдгээр нь бидний судалгааны ажлын зорилго бөгөөд Монгол Улсын иргэдийн үндэсний бахархал, ой санамж, үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хөгжүүлэх төрийн бодлого, үйл ажиллагааны онол, арга зүйн үндсийг боловсруулах хэрэг болно.

Энэ зорилгын хүрээнд төрийн ой санамжийн чухал хэсэг болох монголчуудын хууль эрх зүйн хөгжлийг үндэсний ой санамжтай холбон авч үзье.

#### Монголын хууль, эрх зүйн түүхэн уламжлал

Эртний монголчууд: Монголчуудын өвөг дээдэс, анхны нүүдэлчдийн төрт улс Хүннү, Сяньбийн үеэс өмнөд хөрштэйгөө хил хязгаараа тогтоож, эрх тэгш хилийн худалдааны төлөө тэмцэж байсан нүүдэлчдийн төрийн бодлогын талаар эрдэмтэн судлаачид олонтоо дурдсан нь бий.

Монголчуудын дээд өвөг Хүннү нар Төв Азийн нүүдэлчдийн түүхнээ анх түрүүн МЭӨ 209 онд төр ёс, хууль цааз эрхэмжийг тогтоон, монголын төдийгүй нийт Төв Азийн соёл иргэншилд баларшгүй ул мөрийг үлдээж, түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн нь дэлхийн түүхийн нэгэн хуудсыг нээж хүн төрөлхтний ой санамжид үлдэн хоцорчээ.

Хүннүгийн төр ёсыг Модун шаньюй МЭӨ 209 онд үндэслэсэн билээ. Тэрээр Хүннүгийн шаньюйд өргөмжлөгдөн, 24 аймгаа нэгтгэн захирч, Хүннү гүрнийг үндэслэн байгуулав. Дүнхү нар морь, хатан зэргийг нь гуйж, сүрдүүлж авч амтшаад Хүннүгийн харьяаны говийн нэлээд урт зурвас газрыг найр тавин өгөхийг хүсэхэд Модун шаньюй ихэд хилэгнэн “Газар бол төр улсын үндэс суурь мөн билээ. Түүнийг бусдад өгч яаж болох билээ” хэмээн цэргээ удирдан хөдөлж, дайснаа санаандгүй байхад нь довтлон бут ниргэжээ.” гэж эртний сурвалжуудад бичсэн байдаг. Хүннү нар бүс нутагтаа хүчирхэгт тооцогдох маневр сайтай морьт цэрэг байгуулан эргэн тойрны аймаг, улсуудыг эзлэн авч газар нутгаа өргөтгөн, аюулгүй байдлаа хангаж байв.

-Хүннү нар дээрэнгүй хандаж байсан Хань улс руу довтлон байлдаж дийлээд “Энх ургийн гэрээ” байгуулах болзолтойгоор бүслэлтээс гарган явуулж байсан. Үүний

<sup>126</sup>Платон “Төр улс” 3 боть түүвэр. /орос хэл дээр/ М., 1972, с.198-199

<sup>127</sup>Н.Жалбажав., С.Байгалмаа “Төрийн хууль цааз ба үндэсний ой санамж” Шихихутаг Их Сургуулийн эрдэм шинжилгээний хурал. (2021.11 сар)



дүнд НТӨ 198 оны “Энх, ургийн гэрээ” байгуулагдаж, 50 гаруй жилийн турш Хань улсаас их хэмжээний өргөл барьц авч, торгоны их замыг хянаж байв. Энэ гэрээг хоёр улс хэд хэдэн удаа шинэчлэн баталгаажуулсан байдаг.

-Хүннү гүрэн хүчирхэг үед хил хязгаар нь Хүннү Улсын өмнөд хил нь НТӨ 198 онд Хань Улстай байгуулсан гэрээ ёсоор Цагаан хэрмийн дагуу Ляодун мужаас эхлэн зүүн тийш одоогийн БНХАУ-ын Ганьсу мужийн Ланьчжоу хот хүртэл үргэлжлээд улмаар Нань шань уулыг дамнан Тэнгэр уул хүрч байжээ. Умард хил хязгаарын тухайд гэвэл Эрчис мөрнөөс эхлэн Оросын Алтайн умард бэл, зүүн баруун саяны нурууны ар бэлээр дамнан улмаар Ангар, Ока голын бэлчир хүрч зүүн тийшээ Лена, Витим голуудын эхийг хамран Шилка, Амар мөрний бэлчир хүрч байв.

НТӨ 140 онд Хань улсын хаан ширээнд гарсан У Дигийн үеэс энх ургийн гэрээ тасалдаж, Хань Улсын зүгээс олон тооны цэргээр удаа дараалан Хүннүд довтлохоос гадна Хүннүгийн эрхшээлд байсан баруун хязгаарын олон улс орныг өөрийн талд татах улмаар тэнд эрхшээлээ тогтоох бодлого явуулжээ.

Монголын түрүү төр улсын үе: Монголын түрүү төр улсын үе 1130-аад оноос эхэлж, 1220-оод оны үе хүрсэн. Хабулыг хаан суух хүртэлх үеийг монголчууд овог, аймгийн зохион байгуулалтад оршиж байв.

Монголын дунд үеийн төр улсын түүх Хабул хааны эх суурийг нь тавьсан Монгол Улсаас эхлэлтэй юм. Онон, Хэрлэн, Туул гурван голын монголчуудын улсыг “Хамаг Монгол” хэмээн нэрийдэх нь бий.

Тухайн үед язгууртнууд Их хуралдай хийж эзэн хаанаа өргөмжилж өөрсдийн сонголтоо баталгаажуулдаг ардчилсан шинжтэй ёс журам Хамаг монголчуудад уламжилж тогтжээ. Ингэж хэн ухаантай, чадалтай- гаа өөрийн ургаасаа хаанд өргөмжилж байсан нь улс үндэстэн хүчтэй байх үндэс суурийг тавьжээ.

Монголын түрүү төр улсын үе 1130-аад оноос эхэлж, 1220-оод оны үе хүрсэн. Хабулыг хаан суух хүртэлх үеийг монголчууд овог, аймгийн зохион байгуулалтад оршиж байв.

Их хуралдай хийж эзэн хаанаар өргөмжилж өөрсдийн сонголтоо баталгаажуулдаг Хамаг монголчуудын уламжлал, ёс журмаар өмнөх хааны шууд удмын тайчуудаас бус эрэлхэг, ухаантай зовлон үзэж гарч ирсэн Тэмүжинг Хамаг монголын хаан болгохоор бусад язгууртнууд санал гаргаж, Их хуралдайгаараа өргөмжилж, түүнд үнэнч байхаа тангараглаж байв. Алтан, Хучар, Сача бэхи бүгдээр зөвлөлдөж Тэмүжинд өгүүлрүүн “Чамайг хаан болгоё. Тэмүжин чамайг хаан болгож бид Таны төлөө зүтгэнэ гэж ам алдаж, Тэмүжинийг Чингис хаан гэж нэрийдэж хаан болгов<sup>128</sup>. (Чингис хаан гэх нь тэнгис хаан, далай хаан гэсэн үг бололтой)

Ингэж 1189 онд Монгол Улсын дөрөв дэх хаан болсон Тэмүжин Чингис хаан 1201 онд Гүр хаан Жамухын цэргийг ялж доройтуулсныхаа дараа гагцаар хаан болсон.

Их хаан өөрөө зовлон үзэж, буруу зөрүүг сөрж тэмцэн гарч ирсэн хүний хувьд Их засаг хуулиараа нэг талаас цэргийн хатуу журам, нөгөө талаас нийгмийн бүх давхаргынханд тэгш үйлчилдэг, дарга удирдагч нь хувийн чадвар авьяасаар сонгогддог зэрэг либерал хандлагыг тогтоож байлаа. Жишээ нь: Алтан ургийн бус шинэ ноёдын давхраа үүсэж, баруун гарын мянгатын ноёдын 65 хувь, зүүн

<sup>128</sup>“Нууц товчоон”-ы зүйл 123, 123.

жигүүрийн мянгатын ноёдын 76 хувийг нөхөр, турхгууд эзэлж байсан<sup>129</sup> гэсэн судалгаа байдаг.

Төрөө дээдлэх үзлийг монголчуудад нүүдэлчин тархай бутархай ахуй, хүчтэй хөршүүд нөхцөлдүүлж, Чингис хаан ухаалаг бодлогоороо бэхжүүлж өгсөн. Чингис хаан цэргийн жанжуудын зөвлөсөн үгийг анхааралтай сонсож тэдний санал бодлыг тооцож байж өөрийн шийдвэрээ гаргадаг талаар “Нууц товчоон”-д олонтоо дурсан байдаг.

Монголчуудын олон үеийн түүхэнд төрийн гадаад, дотоод хамаг эрхийг хаан ерөнхийлөн барьж түүний шууд удирдлага (хяналт)-ын дор төрийн гүйцэтгэх ба шүүх эрх мэдлийг хаанаас томилогдсон ноёд, түшмэдүүд эрхлэн хэрэгжүүлж ирсэн уламжлалтай. Тэрээр улс орны олон талт асуудал эрхэлсэн төрийн сайд байсан гэж зарим эрдэмтэд<sup>130</sup> үзжээ. Мухулай хааны тэргүүн шадар сайд байжээ. Түүнчлэн Чингис хааны зарлигаар Боорчи, Зэлмэ, Наяа нарыг цэргийн хэргийг эрхлэх төрийн сайдын тушаалд томилжээ. Мухулай, Боорчи, Зэлмэ, Шихихутуг, Сорхоншир, Сүбээдэй, Зэв, Борохул, Хара Хирүгэ, Чуу мэргэн (Елюй Чуцай) нар Чингисийн үнэнч есөн өрлөг шадар сайд нар нь байв. Их Монгол Улс: Чингис хааны үүсгэн байгуулсан Их Монгол Улс “төр”, “улс” гэдэг ухагдахууныг жинхэнэ байх ёстой утгаар нь дэлхийн олон үндэстэнд ойлгуулж өгсөн гэдэг. Тэр бээр Их хуралдай, Сэцдийн зөвлөл, Их засаг хууль зэрэг нүүдэлчдийн ардчиллын өвөрмөц бүрдлүүдийг анх бий болгож өвлүүлсэн гэдэг.

Эртний Грекийн суут сэтгэгч, их философич, түүхч Аристотель<sup>131</sup> “Политика” бүтээлдээ “Төр бол хүмүүс сайхан амьдрахын тулд хоорондоо тогтоож буй харьцахуйн хамгийн дээд хэлбэр өөрөөр хэлбэл, тийм зорилго бүхий зохион байгуулалтын дээд хэлбэр юм. Харин төрийн байгууламж бол энэ харьцахуйг удирдан хэрэгжүүлэхэд зориулагдсан албан тушаалуудын цогцолбор, эл цогцолборыг бий болгох арга, ур чадварын нийлбэр юм” гэжээ. Тэр бээр гүн ухаантан Платоны хамт дараах төрийн зарчмуудыг ч хэлж байв.

- Төр ард түмний хяналтад байх ёстой
- Төр ард түмэндээ үйлчилж байх ёстой.
- Төрийг захирагдагсдын хариуцлага.

Монголчууд бидний олон зууны турш хууль цаазат, эрх зүйт төртэй улс үндэстэн байж ирснийг илтгэн харуулдаг түүхэн баримтууд олон бий. Тэдгээрээс юуны түрүүн XII зуунд Их Монгол Улс байгуулагдах үеийн Эзэн Богд Чингис хааны минь үндэслэсэн “Их засаг” хууль эхэнд нь байх болов уу.

“Их засаг” хууль бол дэлхийн соёл иргэншлийн түүхнээ бүхэл бүтэн нийгэм, улс төрийн байгуулал бүрэн төлөвшихөд томоохон үүрэг гүйцэтгэсэн эртний Вавилоны Хаммурапийн хууль, Энэтхэгийн Манугийн хууль зэрэг алдартай хуулиудтай эн зэрэгцэхүйн ач холбогдолтой цааз эрхэмжийн нэн чухал баримт бичиг байв.

Анхны тамгатай хуулиудын талаар Тамга дарсан бичмэл эх сурвалж учраас дэлхийн анхны бичмэл хууль гэж 1215 оны Английн хаан I Жон Английн эрх зүйн түүхийн хамгийн чухал баримт бичиг болох Magna Charta англо саксоны эрх

<sup>129</sup>Икэуи Исао “Чингис хаан” 1991 он, 102-р тал

<sup>130</sup>Ч.Далай “Монголын түүх: Их Монгол Улс” (1206-1260) Дэд дэвтэр. УБ., 1994 он, 57-р тал

<sup>131</sup>Аристотель. Политика. (пер. С.А.Жебелов) Сочинения в четырех томах. Т.4, М., 1983, с.481



зүйчид, европын хуульчид үздэг<sup>132</sup>. 1222 онд Унгарын хаан II Андраш өөрийн алтан тамгаар батлагдсан Унгарын язгууртнуудын эрх үүргийг бичсэн бичигдмэл хууль гарчээ<sup>133</sup>.

1206 онд Их Эзэн Чингис хааны тунхагласан “Их засаг хууль”. Монголын “Их Засаг хууль” бол он цагийн хувьд ч, нийгмийн бүхий л давхаргын харилцааг зохицуулж байсны хувьд ч мөн өөрчлөлт нэмэлтийг хийх боломжтой байсны хувьд ч (Шихихутугийн шийдсэнийг цагаан цаасан дээр хөх бэхээр бичиж, ургийн ураг хүртэл даган мөрдөцгөө) гарцаагүй дэлхийн анхны бичигдмэл хуулиудын нэг юм.

Чингис хаан “төр бол эрхэмсэг байдаг”<sup>134</sup>, “сонгогддог”, “хүлээн зөвшөөрөгддөг” гэх эгэл үнэнийг бусад нөхөд, ард иргэддээ ойлгуулах төдийгүй сануулж чадсан нь захирсан улс гүрэн нь олон жил хэвийн оршин тогтнох үндэс болж өгчээ<sup>135</sup>.

Чингис хаан Шихихутугийг “Бүх улсын доторх хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллаж бай” гэж бүх улсын дээд заргач (шүүгч) болгов. Тэр бээр Шихихутугт “Мөнх тэнгэрийн ивээлээр улс гүрнийг тохинуулж байхад чи, үзэх нүд, сонсох чих болж яв. Бидний эх ба дүү нар, хөвүүдэд эсгий туургатны дотроо эзлэх хувийг олгож, хавстан үүдтэний дотроос харьяалах ардыг хувааж өг. Чиний тушаасан үгийг хэн ч өөрчилж үл болно” гэж зарлиг болов. Бас “Нийт улсын өмчийг хувааж заргыг шийтгэж түүнийгээ хөх дэвтэрт бичиж тэмдэглэгтүн. Надтай зөвлөж, Шихихутугийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчилтүгэй” гэж зарлиг болов.

Шигтгээ I. Ч.Жүгдэр абугай: Монгол Улсын төрийн цааз хууль нь “Их засаг” болой. Энэхүү Засаг хуулийг бүр “Чингисийн үеэс тогтоол зааврын хэлбэрээр эмхэтгэгдэж баяжсаар яваандаа хуульчлагдан ирсэн монголын хувь хууль, ардын дадал заншил, үзэл бодол, сургаал ёс буй болгосон байна. Тэр цагийн монголын нийгэмд чухам ийм хууль цааз буй болгох явдал үнэхээр шаардагдан байжээ. Ийм хууль бол нийгмийн бүх хүн, бүх анчид хэрэгтэй төдийгүй юуны түрүүнд хаан ба улс төрд чухал хэрэгтэй байжээ... Хэдий энэ засаг хуульд овгийн байгууллын үеийн зарим үлдэгдэл, өв заншлын зүйл байсан боловч бүхэлдээ феодалын төрийн жинхэнэ хууль мөн байжээ.<sup>136</sup>

В.А.Рязановский “Их засаг”-ийг “Чингис хааны гаргасан тушаал зарлигуудын цуглуулга, нийт монгол аймгуудыг хамарсан нийгмийн шинжтэй ерөнхий хууль” гэсэн бол “Чингис хаан болон Монголын эзэнт гүрний зарлан сонордуулсан хууль дүрэм (захирамж)-үүдийн эмхэтгэл” гэжээ. Тэгвэл Morgan (морган) “Дүрэм тогтоол зарлиг буюу хууль өөрөөр хэлбэл засаг ба билиг хоёрын нэгтгэл”, Эрэнжин Хара-Даван, “Их засаг” нь “Билиг” сургаал, жинхэнэ “Засаг” хууль хоёроос тогтох агаад тэдгээрийн ялангуяа хуулийн өчүүхэн хэсгүүд нь үлдэн хоцорчээ гэх зэргээр бичцгээжээ.<sup>137</sup>

<sup>132</sup> Энэ хууль, эх сурвалж язгууртнуудыг бослогын дараа язгууртнуудын эрх үүрэг, хаантай харилцах харилцаа зэргийг зохицуулж байсан.

<sup>133</sup> Энэ хуулиар II Андраш хаан Унгар, Далмаци, Хорват, Рама, Серб, Галица, Лидомериа улсуудын хаан гэдгээ язгууртнуудаар хүлээн зөвшөөрүүлж, үүний хариуд язгууртнуудын эдлэх эрх (тухайлбал энэ хуулийг зөрчсөн хааныг огцруулах) үүргийг тодорхойлсон эрх зүйн эх сурвалж юм.

<sup>134</sup> Ж.Болдбаатар “Монгол улсын түүх” УБ., 2006 он, 488-р тал

<sup>135</sup> Ж.Болдбаатар “Монгол улсын түүх” УБ., 2006 он, 488-р тал

<sup>136</sup> Ч.Жүгдэр. Монголын нийгэм улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. УБ., 140-р тал

<sup>137</sup> Ц.Минжин. Их Монгол их зарагч Шихихутуг. УБ., 106-р тал.

Шигтгээ II. Түүхчид анхны хэлбэршсэн хуулийг МЭӨ 2100 оны үеийн Шүмэрийн Ур Намму нийтлэлээрээ алдаршсан Хаммураби хааны нэрт хууль руу хүрч ирсэн байна. Хожмын онцлох хуулиуд гэвэл Арван лүндэн, Солоны хуулиуд, Ромын эрх зүйн Арван хоёр хүснэгт болон Жастинианы төрөлжсэн хуулиуд билээ.

Английн хуулиуд нь 1066 оны Норманы байлдан дагуулалтаас өмнө бий болсон ч 1215 оны Магна Картагаар бууриа хатгаж, 1275 болон 1285 оны Вэстминстэрийн нэг, хоёрдугаар хуулиар бодитой хэрэгжин орчин үеийн агуулгатай болж хөгжсөн байдаг. Англи Америкийн хууль нь 1600 оны эхэн үеийн Америк дахь колониудад хэлбэрээ олж улмаар 1787 оны АНУ-ын Үндсэн хуулийн суурийг тавьсан юм.

Их Засаг хуулийг 1206 оны Их хуралдайгаар үндсийг нь баталж, 1210, 1218 онд нэмэлт, өөрчлөлт оруулснаар 1227 онд засварлаж дуусгасан гэж судлаачид үздэг.

Чингис хааны сод ухаан, шударга ёс, өгөөмөр сэтгэл, эр зориг зэрэг ёс суртахууны эрхэм чанар ертөнцийн эгэлгүй удирдагч болгосон бөгөөд зуун зууны туршид түүний зохион байгуулах, удирдан жолоодох мэргэн ухаан “Алд бие минь алжааваас алжаатугай, Ахуй төр минь бүү алдраг” алтан сургаал түүний бодож боловсруулсан “Их засаг” хууль нь монгол үндэстэн, монгол төрийн ой санамжийн чиг баримжаа нь болсоор иржээ.

Их Монгол Улсын төрийн хууль цааз, эрх зүйн эх сурвалж нь “Их засаг хууль” байсан бөгөөд уг хуулиар төрийн хэлбэр, дэглэм, хааны эрх мэдэл, төрийн байгууллагын зохион байгуулалт, эрх, үүрэг, ажиллах журам, засаг захиргааны хуваарь, газар нутаг байгаль хамгаалал, эзэн албатын ёс, алба татвар, ёс заншил, эрүүгийн бодлого, ял ногдуулах ба эдлүүлэх зарчим, журмыг тодорхойлон тогтоожээ. Тухайлбал, Их засагт гадаад харилцааны цааз, цэргийн цааз, шүүх, шашны цааз эдгээрийг бүхэлд нь “төр засах цааз”-д, харин ахуй заншил, иргэд хоорондын харилцаа, сургаал сургамж, тэтгэвэр, тэтгэмж, өмч хөрөнгө, өв, залгамжлал, гэрлэлт, гэр бүл, арилжаа худалдааны шинжтэй хэм хэмжээнүүдийг “иргэний аж байдлын цааз”-д хамруулснаас гадна Их Монгол Улсын төрийн бүрэн эрх, нийгэм төрийн байгууламжийг бэхжүүлэх түүнчлэн хуулиар тогтоосон бүх хэв журмыг гэмт халдлагаас хамгаалах “Эрүүгийн цаазыг тодорхойлон тогтоосон, өөрөөр хэлбэл нийгмийн харилцааг бүхэлд нь эрх зүйн зохицуулалтад оруулжээ.<sup>138</sup>

“Чингис хааны Их засаг хууль/ хуульд:

“Хэрэв хунтайж нар, хаад, цэргийн дарга нар, бусад зохих язгууртнуудын нийтийн зөвлөгөөнөөр л урьдчилан сонгогдоогүй бол хэн ч гэсэн өөрийгөө эзэн хаанаар зарлах эрхгүй, хэрэв зарлаваас цаазаар авч яллана” гэдэг.

Чингис хаан “Төрийг захирагдагсдын хариуцлага”-ын талаар “Их Засаг” хуулийн 21-д. Үүрэгт ажлаа гүйцэтгэж чадаагүй эсхүл хааныг дуудсан үед ирээгүй цэргийн дарга, удирдагчийг цаазална. Энэ нь ялангуяа алс хол нутагт суугчдад онцгой хамаарна. Хэрэв тэдний хэн алдаа онцын гэм хоргүй бол тэд өөрсдөө биеэр хаанд ирж учирлах үүрэгтэй.

“Их засаг хууль” хийгээд Их Монгол Улсын төрийн гадаад бодлого нь хил хязгаарын аюулгүй байдлыг хангах, гадаадын халдлага довтолгооноос сэргийлэх, өрнө дорнын улс оронтой улс төр эдийн засаг, соёлын хэлхээ холбоогоо өргөтгөх, мэдээллийн солилцоог идэвхжүүлэх, улс орноо засан тохинуулах гээд хожим

<sup>138</sup> Ж.Болдбаатар., Д.Лүндээжанцан “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” УБ., 2021 он, 89-90-р тал

хойчдоо төрийн бодлогын “Алтан аргамж” болсон олон санаа шингэжээ. Элчин төлөөлөгчдийн эрх ямба, аюулгүй байдлыг баталгаажуулах, халдашгүй байдлын “Гэрэгэ” тэмдэг олгох зэргээр өнөөгийн дипломат ёсны соёлын төлөвшилтөд монголчуудын оруулсан үнэтэй хувь нэмэр нь юм.

Их засгийн цэргийн цаазад цэргийн алба хаах үүрэг, дайн байлдааны үед баримтлах дэг, тэдгээрийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх ял зэм зэргийг хамгийн өргөн тусгажээ. Тухайлбал:

-эр хүн 20 нас хүрвээс цөм цэргийн алба хаах үүрэгтэй,

-жанжин захирагчаасаа жирийн цэргээ хүртэл дайсангүй цаг үед ч дайны бэлтгэл хийх,

-байлдааны талбарт шархдагсдаа хамаагүй орхиж үл болох,

-хэрэв дийлэгдвэл довтолгоон эхэлсэн байрандаа эргэж ирэх, эс ирвэл алах ялаар шийтгэх,

-дайны үед ганц нэгээр буюу хэд хэдээр оргож босвол алж шийтгэх,

-дайсныг гүйцэд ялахаас өмнө хэн нэг хүн олз ашиг хайхаар явсан байвал хүндээр ялдан залхаа гэх мэтээр заасан байна.

Гуулин улсын сударт буй мэдээнээс үзэхэд “...Цэргийг цэргийн эрдэмд сайтар сурган, бүгдийг гавшгай цэрэг болтол нь хатуужуулах, хүчин буюу данги-? хүнийг ацаглан жинхэнэ цэргийн оронд хүний тоо бөглүүлж, цэргийн алба хашуулахыг хориглох цэрэг хөдөлсөн үед цэргийн олсон хүн мал, бусад бүх эд таваар нь тус тус тэрхүү цэргийнх болох бөгөөд цэргийг харьяалах дарга захиран хурааж авч болохгүй... Иргэдийн хогшлоос өчүүхэн зүйлийг ч дээрэмдэхийг цаазлан хориглоно” гэх зэргээр зохицуулсан байжээ.

Тухайн үед ...иргэд хоорондын харилцаанд заншлын хэм хэмжээг хуулийн заалтаар бэхжүүлэн заавал биелүүлэх шинжтэйгээр мөрдүүлэх явдал дэлгэрсэн байна. Тухайлбал, ямар нэг бусдын эд хөрөнгийг булаан дээрэмдэх буюу булааж авбал уг этгээдийг хайргүй цаазлах, бусдын хадгалуулсан эд зүйлийг гурван удаа үрвэл гэмт хэрэг хэмээн үзэж шийтгэх, олсон эд зүйлсийн хувьд авахаар нуух, байлдааны явцад олж авсан хувцас, эд зүйлс, зэр зэвсгийг эзэнд нь эргүүлж үл өгөх хэрэг үйлдвэл цаазаар авах шийтгэл оногдуулах хуулийн заалт байсныг Сайшаал “Чингис хааны товчоон” номдоо дурдсан байна.

...Ямар ч хүн замд явж байгаад хоол идэж буй явдалтай тохиолдвол мориноосоо бууж, эзэн хүний зөвшөөрлийг хүлээлгүйгээр идэх, ингэж идэхийг үл хориглох, зочин хүн хань нөхдөөсөө илүү идэх, зочилж буй айлынхаа гал тогоо, идээтэй тавган дээгүүр алхахгүй байх, зориуд худал хэлэх, ид шид гаргах, хүмүүстэй хамт хоол идэж байгаад хахах, тогоотой хоол, гал голомт руу нь хутга мэс дүрэх, бусдын үйл хөдлөлийг далдуур тагнах, зодолдож мөргөлдөж буй хүмүүсийн хооронд хөндлөнгөөс оролцохыг хориглох хуулийн заалтууд гаргаж байжээ.

Зан заншлын эсрэг гэмт хэрэгт ус, үнс рүү шээх, хоол идэхдээ хахах, цэргийн дарга ба ноён хүний үүдний босгон дээр гишгэх, галд хутга дүрэх, тогоон дотроос хутгаар мах авах, галын хажууд сүхээр түлээ хагалах, газар дээр сүү бусад идээний зүйл асгах, адгуустай явалдах, худал хэлэх, ов мэх гаргах, хоёр хүний хэрүүл маргаанд хөндлөнгөөс оролцох, бог малыг өрцлөхөөс өөрөөр нядлах, бусдын үйлдлийг далдуур тагнах, худал гэрчлэх зэргийг оруулан ёс заншил түүний горимыг зөрчин ёс суртахууны хэм хэмжээг алдсаных нь төлөө цаазлах зэрэг ял шийтгэлийг

оногдуулж байв.

Эх дэлхийгээ бүхэлд нь хайрлан хамгаалж уул, усаа “амилуулан” шүтэж халдах, хандах зан үйлийн хорио цээрлэлийг тогтоон мөрдүүлж, тэр бүхнээ нийт иргэн, үр хойчдоо ухааруулан мэдрүүлж, амьдрал ахуйгаа байгаль орчинтойгоо нягт хослуулан зохицуулж ирсэн өвөрмөц арга уламжлал юм. Байгаль хамгаалах энэхүү монгол уламжлалыг алдалгүй сахин авч явах нь үндэсний төдийгүй нийт хүмүүнлэгийн ой санамжид хадгалагдах учиртай зүйл юм. Хүн төрөлхтний түүхэнд төрийн хууль цаазад эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг анхлан тусгасан нь “Их засаг хууль” гэх үндэс бас байна. Тухайлбал, Гуулин улсын судраас профессор Сумьябаатарын олсон баримтад “...захирагч хийгээд цэргүүд хүчиндээ дулдуйдан, шинэ дагасан аливаа хот, гацаанаа эмс хийгээд охидтой хүч түрэн гэрлэж болохгүй” хэмээн заасан байна.<sup>139</sup> Эрдэнэт хүмүүний амь бие, эд хөрөнгө, эрүүл мэндийг сахин хамгаалах нь Их засгийн “амин сүнс” нь байсныг онцолбол зохистой. Эдгээрийг зөрчвөл ялын дээд хэмжээ оноохоор хуульчилжээ.

Их хаад маань Аристотелийн “Төр ард түмэндээ үйлчилж байх ёстой” талаарх зарчмыг нэвт шингээсэн дараах сургамж айлдваруудаа үлдээсэн байдаг.

-Чингис хаан “Өтгөсийг хүндэлж, Ядуусыг тэтгэ”.

-Өгэдэй хаан “Хаан хүмүүн болбоос эд хөрөнгө хураахын төлөө санаа зовох нь илүүц зүйл. Хаан хүмүүн бол өөрийн үйл хэргийн үнэт зүйлийг хүмүүсийн зүрхэнд үлдээх ёстой”.

-Мөнх хаан “Олон иргэд үгээгүй байхад би гайхамшигт эрдэнийг хурааж хүсэл ханаваас хэр зохих буюу. Миний олон иргэн эд малаар арвин баяжиж жаргаваас л миний хүсэл ханан жаргамуй”.

-Хубилай хаан “Түшмэд та нар эд ашиг дор бүү шунахайр. Нэрийг бүтээвээс эд ашиг өөрөө ирмүй. Эдэд шунахайрваас гарцаагүй нэр юүгээн буруутгана”.

“Их засаг” бол монголын соёл, иргэншлийн түүхэнд эргэлт гаргасан үед үйлчилсэн нүүдлийн маягийн амьдралын хэв шинжтэй, дэлхийн хэмжээний ач холбогдол бүхий хууль зүйн чухал дурсгалт бичиг мөн. Тэр нь Монголын Нэгдсэн Улсын амьдралд асар чухал үүрэг гүйцэтгэж тус улсын оршин тогтнож, мандан хөгжихийн хууль зүйн үндэс болсон ажгуу” хэмээжээ.

Ийнхүү “Их засаг хууль” болон Их Монгол Улсын хууль цааз нь тухайн нийгмийн зайлшгүй бодит хэрэгцээ шаардлагаас үүдэн гарсан, хүмүүнлэгийн харилцааны олон талыг хамруулан эрх зүйн зохицуулалтад оруулсан шинжтэй байснаараа жам ёсны хууль байжээ.

УИХ-ын дарга асан доктор Д.Лүндээжанцан “Их засаг хууль нь монгол төрийн хууль цаазын гол эх сурвалж, ой санамж, үнэт зүйлсийн чухал эх сурвалж ажгуу. Учир нь “Их засаг” зөвхөн тэнгэрт тэтгэгдсэн ихэс дээдсийн ашиг сонирхолд төдийгүй эзэн гүрний нийт албат, иргэдийн эе эвийг хичээх, шударгыг хүсэмжлэх сэтгэлгээ, ёс заншилд тулгуурласан жинхэнэ жам ёсны хууль байсан юм.”

Энэ хуулийн талаар гавьяат хуульч, доктор И.Дашням дүгнэж хэлэхдээ “Монгол оронд хэмжээгүй эрхт хаан хүний эрх хэмжээ бүрэлдэн төлөвшиж, Их хуралдай, Сэцдийн зөвлөлийг төрийн байгуулалтад өвөрмөц байр эзлүүлэн, яамгүй төрийн сайдыг томилон ажиллуулж, аравтлах системийг засаг захиргаа, цэргийн

<sup>139</sup>Ж.Болдбаатар., Д.Лүндээжанцан “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” УБ., 2021 он, 93-р тал

байгуулалтын үндэс болгон

хүчирхэг арми, нэр хүндтэй төрийн түшмэдийн тогтолцоог бүрэлдүүлэн тогтоосон нь Хаант улсын төрийн байгууллагын гол агуулга мөн.

Монголчуудын Олон үеийн түүхэнд төрийн гадаад, дотоод хамаг эрхийг хаан ерөнхийлөн барьж түүний шууд удирдлага (хяналт)-ын дор төрийн гүйцэтгэх ба шүүх эрх мэдлийг хаанаас томилогдсон ноёд, түшмэдүүд эрхлэн хэрэгжүүлж ирсэн уламжлалтай. Тэрээр улс орны олон талт асуудал эрхэлсэн төрийн сайд байсан гэж зарим эрдэмтэд<sup>140</sup> үзжээ. Мухулай бол хараахан ерөнхий сайд биш, харин хааны тэргүүн шадар сайд байжээ. Түүнчлэн Чингис хааны зарлигаар Боорчи, Зэлмэ, Наяа нарыг цэргийн хэргийг эрхлэх төрийн сайдын тушаалд томилжээ. Мухулай, Боорчи, Зэлмэ, Шихихутуг, Сорхоншир, Сүбээдэй, Зэв, Борохул, Хара Хирүгэ, Чуу мэргэн (Елюй Чуцай) нар Чингисийн үнэнч есөн өрлөг шадар сайд нар нь байв.

Чингис хааны үндэс суурийг нь тавьсан нүүдэлчдийн эзэнт гүрэн Өгэдэй хааны үед төгөлдөржин тогтсон бол Гүюг ба Мөнх хаадын үед Монгол гүрэн нүүдэл ба суурьшмал иргэншил хосолсон дэлхийн хэмжээний эзэнт гүрэн болон хөгжсөн ажээ.

Шигтгээ III. Чингис хааны “Их Засаг” хууль нь түүний байгуулсан эзэнт гүрний амьдралд асар их үүрэгтэй байж, монголчуудын болон эзлэгдсэн бусад ард түмний амьдралд бүх талаар нөлөөлж, дэлхий дахины үндсэн гол хууль цаазын үүргийг удаан хугацаагаар гүйцэтгэж иржээ. Жишээлбэл, Оросын Вант улсуудын хувь заяаг гартаа атгаж байсан Алтан ордны улсад энэ хуулиас өөр бичигдсэн хууль байгаагүй юм гэж Оросын эрдэмтэн В.А.Рязановский бичсэн байна. “Их Засаг” хууль Цагадайн Улсад XV-XVI, Зүчийн Улсад XVI зуун хүртэл мөрдөгдөж байв.

“Их засаг” хууль нь монголчуудын ахуй амьдрал, ёс суртахуун, ертөнцийг үзэхүй, зан заншлыг үндэслэн бүтээгдсэн хууль байсан учир Их Монгол Улс феодалын бутрал, Юань гүрэн, Манжийн ноёрхол, Богд хаант Монгол Улс, БНМАУ, Монгол Улс зэрэг монголын буурал түүхийн бүхий л үед төрийн хууль цаазын бодлого, үйл ажиллагааны чухал эх сурвалж нь болсоор иржээ.

Монголын төр дэвшил, бутрал хөгжлийнхөө үе болгонд хууль эрх зүйгээр улс орныхоо эв нэгдэл, нийгмийн харилцааг зохицуулах талаар чармайж ирснийг түүхийн ой санамжаас сэргээн харваас ийн буюу.

Монголын төрөөс газар нутгаа хамгаалах талаарх бодлого, үйл ажиллагаа

Үндэсний ой санамжийг хадгалж өвлүүлж ирсэн өмнөх өв түүх, уламжлалаас “Монголын төрөөс газар нутгаа хамгаалах талаарх бодлого, үйл ажиллагааг” авч үзэхдээ монголын түүх, цэргийн шинжлэх ухаантай холбоотой энэхүү судалгааг түүх, цэрэг, геополитик, улс төр судлалын зэрэг шинжлэх ухааны уулзвар дээр өргөн хүрээнд авч үзэхдээ үндэсний ой санамжтай холбон оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Улс, үндэстнийхээ гадаад, дотоод халхлалт, хамгаалалтыг Чингис хааны хэрхэн бий болгосон монголчууд яагаад дайн хийв, газар нутгаа хэрхэн хамгаалав, төрийн бодлого үйл ажиллагаа нь юу байв гэдэг талаар судлав.

Монголчуудын өвөг дээдэс, анхны нүүдэлчдийн төрт улс Хүннү, Сяньбийн үеэс өмнөд хөрштэйгөө хил хязгаараа тогтоож, эрх тэгш хилийн худалдааны төлөө тэмцэж байсан нүүдэлчдийн төрийн бодлогын талаар эрдэмтэн судлаачид олонтоо дурдсан нь бий. Энэ удаа Монгол төрийн халхлалт, хамгаалалтын тогтолцооны

<sup>140</sup>Ч.Далай “Монголын түүх: Их Монгол Улс” (1206-1260) Дэд дэвтэр. УБ., 1994 он, 57-р тал

бодлогыг энэ удаад Чингис хааны үеэс эхлэн өгүүлэхийг зорьсон юм. Энэ нь Монгол төрийн бодлогыг түүхэн уламжлалаас нь салгаж тасалсан бус XII зуунаар хязгаарлан үзсэн болно.

Чингис хаан Монгол үндэстнээ нэгтгээд зогсохгүй цөөхөн хүнтэй улс үндэстнийхээ гадаад, дотоод халхлалт, хамгаалалтыг бүрэн хангах зорилгоор үндэстэн улс байх стратегийн ач холбогдолтой тулгуур газруудын хамгаалалтын суурийг тавьж, баталгаажуулан урт хугацааны үндэстний аюулгүй байдлаа хангах батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны үндсийг буюу төрийн хар хайрцагны бодлого алтан аргамжийг ч гэдэг тавьж өгсөн.

Монгол төрийн “хар хайрцагны бодлого”-ыг манай эрдэмтдийн бүтээлээс<sup>141</sup> харахад энэ нь юуны түрүүн улс орныхоо тусгаар тогтнол, газар нутгаа хамгаалах, дээр нь үндэс угсаа, соёл иргэншил, байгаль орчноо хамгаалах цаашилбал төрийн албан хаагчдын залгамж чанарыг хадгалах талаарх бичигдсэн, бичигдээгүй гадаад, дотоод төрийн бодлого, үйл ажиллагааны нэгдэл гэж ерөнхийлөн тайлбарлаж болохоор ажээ.

Эдгээрээс “Газар нутаг, хил хязгаарын аюулгүй байдлаа” хангаж ирсэн арга хэлбэрийг тодруулбал хятад болон бусад суурин иргэд хот, суурин газраа цайз, хэрмээр, нутаг дэвсгэр, хил хязгаараа урт хэрэм барих замаар голдуу хамгаалж ирсэн бол нүүдэлчин улс орнууд харьяат аймгуудаа төвийн болон баруун, зүүн гар болгон хувааж халхлалт, хамгаалалтыг зохион байгуулж байжээ.

*МЭӨ 198 онд Модунь шаньюйгийн үеийн Хүннү, Хятад улсын хооронд гэрээ байгуулж, “Цагаан хэрмээс хойших нум агсагчдын улс нь Шаньюйн зарлиг дагаж, Цагаанхэрмээсурагших түшмэдийн бүсмалгай өмсөгчид суудаг орон нь харин над захирагдана. Хань улс, Хүннү улс хоёр бол мөр зэрэгцэх хүчирхэг улсууд юм” гэжээ. Энэхүү гэрээ ёсоор Хүннү, Хятад улсын хоорондын хил Цагаан хэрмээр тогтоогджээ. Хүннү, Хятад улс энэхүү гэрээгээр зарим үед тодотгон баталж хоёр зуу гаруй жил мөрдсөөр иржээ.*

Тэр цагаас хойш “Газар бол улсын үндэс”<sup>142</sup> хэмээх томъёолол монгол төрийн бодлогын амин сүнс болж иржээ.

Монгол төрийн хар хайрцагны үндэс угсаа, газар нутгаа хамгаалах бодлогыг Чингис хаан хэрхэн үндэслэж, залгамжлагчид нь яаж үргэлжлүүлэн өнөөг хүргэсэн болохыг энэхүү судалгааны ажлаар зарим хэсгийг нь ч болтугай тодруулах гэж чармайлаа.

Энэхүү зорилтын хүрээнд монгол үндэстний хувьд геополитикийн үүднээс стратегийн ач холбогдолтой тулгуур газар, орныг тодорхойлох оролдлого хийсэн юм.

“Хамаг монголын гол нутаг гурван голын эхээ Их хоригоор, нүүдэлчдийн уламжлалт голомт Орхон, Туулын бэлчрээр төвлөрсөн хаан төрийн түшиг Голын түмнээ дотоод хамгаалалтын тойргоор, Их Монгол Улсаа гадаад хамгаалалтын стратегийн ач холбогдолтой газар орнуудаар хамгаалах төрийн бодлогыг үндэслэж, бүрэн хэрэгжүүлэн өнөөг хүргэсэн төдийгүй үндэстнийхээ аюулгүй байдлыг

<sup>141</sup>Энэ дашрамд тэмдэглэхэд Монголын төрийн хар хайрцаг хэмээх далд бодлогын талаар тусгайлан судлах явдал зарим шалтгаанаар хойшлогдсоор өнөөг хүрсэн юм.

<sup>142</sup>Сы Ма цын “Историчекие записки”



хангахын төлөө дэлхийг эзэгнэж байсныг Чингис хааны геополитик<sup>143</sup> байжээ” гэж тодорхойлсон байдаг.

1. Монголын халхлалт, хамгаалалтын тогтолцоо бүрэлдэж, бэхэжсэн нь *Их Монгол Улсаа байгуулах үе (1206 он хүртэл)*

Улс гүрнүүд ялангуяа суурин иргэншилтэй улс орнууд нутаг дэвсгэр, хил хязгаараа урт хэрэм барих замаар халхлалт, хамгаалалтын шугам, зааг бий болгож хамгаалж байсан түүхийн жишээ олон бий бөгөөд үүнд: Хятадын Цагаан хэрэм, Ромын эзэнт гүрний хойд хилийн хамгаалалтын баруун, зүүн хотуудаас тусгаарласан зурвасыг дурдаж болно. Тэдгээр улсууд хот, суурин газраа цайз, хэрмээр хамгаалж ирснийг илэрхийлэх олон түүхэн байгууламжууд өнөөдөр ч байсаар байна.

Нүүдэлчдийн хувьд энэ нь өөр байсан бөгөөд монголын нутаг дэвсгэр дээр оршин байсан нүүдэлчин улс гүрнүүд харьяат аймгуудаа төвийн болон баруун, зүүн гар болгон хувааж, халхлалт, хамгаалалтыг зохион байгуулж ирсэн байдаг.

Чингис хаан энэхүү уламжлалыг дагахын сацуу түүнийг улам боловсронгуй болгож, тархай, бутархай Хамаг Монголын овог, аймгийг нэгтгээд зогсолгүй шинээр бий болгосон улсынхаа аюулгүй байдлыг дотоод талаас төдийгүй гадаад талаас хангах бүхий л арга хэмжээг дэс дараатай, алсыг харж хийж чадсан билээ. Юуны түрүүн өөр хоорондоо өрсөлдөн тэмцэлдэж байсан овог, аймгуудыг нэгтгэн байх үедээ хаан төрийн төдийгүй улс үндэстний тулгуур “голын түмэн”-ийхээ аюулгүй байдлыг хангах зорилготой, улс орныхоо хил хязгаар дотроо “дотоод хамгаалалт”-ын тойрог, хүрээг нүүдэлчдийн улсын онцлогт тохируулан бий болгосон байдаг. Үүний дараа гадаад талын аюулгүй байдлаа батлан хамгаалах зорилготой, дэс дараатай, олон үе шаттай, үргэлжилсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд Монгол үндэстний аюулгүй байдлын “гадаад халхлалт, хамгаалалт”-ын тойргууд бий болгож, бэхжүүлжээ. /Зураг №1/

Чингис хаан төвийн түмнээс бусад нь хамаарах хамаарлыг нэмэгдүүлсэн төдийгүй гадаад халхлалт, хамгаалалт, дотор хамгаалалт хишигтний зохион байгуулалтыг сэдэж, практикт гүйцэлдүүлсэн. Чингэхдээ Монгол орны газар зүйн онцлог, бартаа саад буюу Алтай, Хөвсгөл, Хэнтий, Хянганы их уул нурууд, Сибирь, Алс дорнодын их ой хөвч, Монголын их хээр тал, говь цөлийг ч энэхүү зорилгодоо ашигласнаар улс орны “дотоод хамгаалалт”, “гадаад халхлалт, хамгаалалт<sup>144</sup>”-ын тойргийг бүрдүүлжээ.

Ер нь нүүдэлчдийн нутгийн уламжлалт төв хэсэг нь Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулс болон Монголын их говиор газар зүйн хувьд хамгаалагдсан байдаг бөгөөд нүүдэлчдийн төр засгаас өөр олон арга, хэлбэрээр түүнийг хамгаалж байсныг түүхийн баримтуудаас харж болно. Энэ талаар Л.Гумилев<sup>145</sup> -ын бүтээлүүдэд тодорхой өгүүлсэн байдаг.

Монгол үндэстэн, улс орны “дотоод хамгаалалт”, “гадаад халхлалт, хамгаалалт”-

<sup>143</sup>Геополитик-энэ үг XIX зууны дунд үед “Хүчтэй улс орныг буй болгох алсын хараатай бодлого”-ыг нэрлэж тухайн гүрний газар зүйн байрлалтай холбож улс төрийн бодлогоор удирдлагын оновчтой тогтолцоо ...дэлхийг захирсан их гүрэн болох стратеги... гэх

<sup>144</sup>Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” УБ., 1966 он, 652-р тал. “халхлах-далдавчлан хаах, далдлах, харагдахгүй байлгах.., хамгаалах 1. Сэргийлж сахих, харгалзан сахих..., 2. Өмөөрөх..., хамгаалалт хамгаалал бий, хадгалалт хамгаалалт” гэсэн байдаг.

<sup>145</sup>Л.Н.Гумилев “Хүн гүрэн” УБ., 2000 он



ын тойрог, “дотор хамгаалалт” хишигтний талаар цаашид өгүүлэх учраас энэхүү шинэ тодорхойлолт дээр тогтож, тайлбарлая.

Чингис хааны “дотоод хамгаалалт”-ыг нүүдэлчдийн уламжлалыг ерөнхийдөө дагасан, хаан төр, голын улсаа хамгаалах болон цэрэг дайны ажиллагаа гадагшаа явуулах зорилготойгоор овог, аймгуудыг мянгатын хэлбэрт оруулж, томилгоожуулан байрлуулсан, газар нутаг, удирдлага зохион байгуулалтын иж бүрэн тогтолцоо гэж болно.

Харин “гадаад халхлалт, хамгаалалт”-ын тойрог нь монголчууд өмнө тэр болгон амьдарч байгаагүй ч харийн довтолгооноос сэргийлэн хамгаалахад ач холбогдолтой, зам тээвэр, худалдааны чухал зангилгаа газар орныг зориудаар эзлэн авч, тэрхүү нутагт амьдарч байгаа үндэстэн, угсаатныг удирдан хянах зорилгоор шилжүүлэн суулгасан тодорхой үүрэгтэй монгол угсааны овог, аймгуудын амьдарч байсан, одоо байгаа зааг хязгаар, тодорхой нутаг дэвсгэр юм гэж томъёолж байна.

Орчин үед гадаад халхлалт, хамгаалалтын энэхүү аргыг их гүрнүүд цэргээ тодорхой бүс нутагт урьдчилан байрлуулах эсхүл өөрийн бүрэн хяналтад байдаг завсрын буюу “БУФЕР-БАМБАЙ”<sup>146</sup> улс байгуулах арга замаар хэрэгжүүлж байдаг нь нууц биш юм. Монгол Улс ч түүхийнхээ урт хугацаанд өсөн тэлж, хүч түрэмгийлж байхдаа бусдыг “жийрэглэж” хүч нь сульдаж доройтсон цагтаа бусдын жийрэг, бамбай болсоор иржээ.<sup>147</sup>

Улс үндэстнийхээ аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа буюу халхлалт, хамгаалалтын талаар түүхэн судалгаа хийхийн тулд тухайн үеийн улс орны гадаад, дотоод орчин, төрийн удирдлага-хаадын үйл ажиллагааг судлах тодруулах нь ойлгомжтой юм. Дээр нь нүүдэлчин улс үндэстний хувьд энэ асуудлыг угсаатны болон овог, аймгуудын байршил, үүрэг зорилготой нь холбон үзэх шаардлага тулгардаг.



Чингис хаан төрийн бодлогоор хааны өргөө, нутгийн төв хэсэг, гол уугуул овог, отог болон геополитикийн үүднээс стратегийн ач холбогдолтой газар орноо орон нутгийн хамгаалалтын зарчмаар буюу нүүдлийн аргаар шинээр байгуулагдсан

<sup>146</sup>“БУФЕР” Бамбай улс хэмээх томъёоллыг улс төр судлалын ухаанд анх 1883 онд хэрэглэсэн гэж “Оксфордын толь бичиг”-т өгүүлжээ. 1) The Oxford English Dictionary (Oxford: The Clarendon Press 1933), Vol.1. p.127, 1158

<sup>147</sup>С.Баяр “Бамбай улсын тавилан стратеги судлал” 1995/1(8), Vol.48, 16-р тал.

мянгатуудыг бүрэлдүүлэгч овог, аймгуудаар халхлах, хамгаалах аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг дэс дараатай, нарийн уялдаатай зохион байгуулж хэрэгжүүлжээ.

Б.Я.Владимирцов, Ж.Баясах нар өөрсдийнхөө бүтээлд: Монгол цэргийн зохион байгуулалтад овгийн өрх цэрэг болон хүрээний үүргийн талаар тодруулж бичсэн байдаг бөгөөд "... хүрээ болон суух нь дайсан этгээд цөмрөн орж ирэхэд шалгарсан арга болдог байсан бөгөөд хожим нь энэхүү хүрээний зохион байгуулалт дээр тулгуурласан мянгатын зохион байгуулалтыг Чингис хаан бий болгожээ".<sup>148</sup> Энэ талаар манай цэргийн түүхчид "Их Монгол Улс Төвийн, Баруун, Зүүн, Ойн түмэн гэсэн засаг захиргааны нэгжид орон нутгийн зарчмаар хуваагдаж, тэдгээр түмэн нь холимог болон овог төрлийн журмаар байгуулагдсан мянгатуудаас бүрдэж байв. Монгол цэргийн байгуулалтын уламжлалт эл орон нутгийн хамгаалалтын зарчим нь нүүдэлчдийг тодорхой газар нутагт байршуулж, тухайн чиглэлийн газар орон дээр байлдааны ажиллагаа явуулахад таатай нөлөө үзүүлж байсан"<sup>149</sup> гэж тодорхойлжээ.

Их Монгол Улсын үед Чингис хаанаас шинээр бүрэлдэн буй Монгол үндэстнийхээ аюулгүй байдлаа хангахын тулд мянгатуудыг зохион байгуулахдаа баримталсан зарчим нь:

-Их Монгол Улсыг байгуулахад оруулсан хувь нэмрийг харгалзсан, -гавьяа байгуулсан овог, аймгийн хүмүүсээр "голын" улсаа голчлон бүрдүүлсэн, -олон жил өөрийг нь эсэргүүцсэн овог, аймгуудыг тараан байрлуулж, дангаар мянгат байгуулахыг хорьсон болох нь харагдаж байна.

Овгийн буюу хүрээний зохион байгуулалтыг эвдэж, мянгатын тогтолцоонд оруулснаар үргэлж салж бутарч байдаг байдлыг өөрчилсөн юм. Наймантай байлдахын өмнө нэгтгэн захирах ёсны төгс ялалтад садаа болж байсан "хүрээн"-ий байгуулалтыг халах буюу дуртай цагтаа байлдаанд орж, дургүй цагтаа жагсаал орхин зайлдаг эртний овгийн байгууллын уламжлалт толгойлогчдын дэглэмийг эвдэж, итгэл туршлагатай нөхөд цэргийн жанждын гарт улсын бүх цэргийг атгуулав. Ингэж 1206 оноос хойш "хүрээ" гэдэг цэрэг захиргааны нэгж бүтэц өөрчлөгдөж, түмт ба мянгатын нүүдэл эхэлсэн билээ.

"Стратегийн ач холбогдолтой тулгуур газар, орон": Чингис хаан хөвгүүд, дүү нараараа овог, аймгуудыг удирдуулан дахин томилгоожуулж илгээсний цаана эзэн хааны маань чухалчлан үзэж байсан стратегийн ач холбогдолтой тулгуур газар, орон гарч ирж байна. Үүнд:

1. Сибирийн хөвч, Байгаль нуурын хоёр эрэг орчим нь нүүдэлчдийн байгалийн хуяг халхавч болсоор ирсэн түүхтэй юм. Энэхүү нутаг нь нүүдэлчдийн үе үеийн аюулгүй байдлын "стратегийн ар тал" байсныг Л.М.Гумилев "Хүн улс" бүтээлдээ тодорхой тэмдэглэсэнтэй зөрөх аргагүй байна. Чингис хаан Их Монгол Улсыг байгуулах тэмцлийн үед Ойрадын толгойлогчид ялагдах бүртээ шишгэдийн ой шугуй руу, Мэргидүүд Байгаль нуурын зүүн эргийн дагуу зугтан зайлдаг байсан нь санамсаргүй хэрэг биш ээ. 1207 онд Ойн иргэд, 1211 онд Ойрадыг дагаар оруулан баруун ба хойд хил, ар талын аюулгүй байдлаа хангаж, цэрэг эдийн засгийн хүчээ

<sup>148</sup>Б.Я. Владимирцов "Общественный строй монголов" Л., 1934

Ж.Баясах "Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг" УБ., 2005 он, 66-р тал.

<sup>149</sup>"Монгол цэргийн түүхийн товчоон" Тэргүүн дэвтэр, УБ., 1996 он, 108-109-р тал.

сэлбэв. Алтан улстай байлдах үеэр Борохул өрлөг бослого гаргасан Түмэдийг дайлан дарах гэж очоод Түмэдүүдэд алагдсан тул, 1216 онд Дөрбэй догшныг илгээж Түмэдийг дарж байсан нь энэхүү газар оронд хэрхэн ач холбогдол өгч байсныг харуулдаг.

2. Хачиуны суусан Хянганаас Ляодуны хойгийн чиглэл ямагт монголын нүүдэлчдийн стратегийн чиглэл байв. 1125 он хүртэл тэр нутагт монголтой хэл, соёл нэгт Киданчууд төр улсаа байгуулан Гуулин улс /Солонгос/ ба Зүрчидүүд, хятадуудтай идэвхтэй харилцаатай байв. Чингис хаан 1211 онд Зүрчидийн Алтан улсыг дайлаар мордохдоо “Ах дүү киданчуудыг чөлөөлөх” уриа дэвшүүлж мордсон бөгөөд мөн онд Бээжингийн дэргэдээс цэрэг илгээснээр 1214 онд Киданы тусгаар тогтнолыг зарлуулсан бөгөөд Киданчууд монголын үнэнч холбоотон болж, Чингис хаан түүний залгамжлагчдад зүтгэсэн билээ. Киданчуудыг чөлөөлөх Чингис хааны урианы цаана Зүрчидийн Алтан улсыг цэрэг эдийн гол бүс Хойд Хятадын нутгаас салгах улмаар хойд нутгаар орж, Алтан улсыг бүслэх стратегийн зорилт нуугдаж байсан юм. Мөн энэ нутгаар Солонгостой холбогдож, Алтан улсыг Солонгосоос салгах бодлогыг Их Монгол Улсын хаад чадварлаг хэрэгжүүлсэн юм. Тиймээс Хянган Ляодун чиглэл нь юуны өмнө монголын нүүдэлчид оршин амьдрахад тохиромжтой нутаг төдийгүй Зүрчид, Хятадын төрд хяналт тавих түшиц газар, далайд гарах гарц байсантай холбоотой байсан гэж үзэх үндэстэй байлаа.

3. Ордос Хөх нуурын чиглэл. Энэ чиглэлд хяналтаа тогтоохын төлөө Хүннү улс, түүнээс хойших нүүдэлчид амь тэмцэн өрсөлдөж ирсэн түүхтэй юм. Энэ чиглэлийг хянаж байх нь: Тангуд, Уйгур, Төв Азид нөлөөтэй байх, Хятад болон Зүүн өмнөд Ази, Ойрх Дорнодыг холбосон Торгоны замд хяналт тогтоох амин эрх ашигтай холбоотой байв.

Дээр үед монгол хэлтнүүд буюу “Тогон” гэж нэрлэгдсэн Муюны зарим аймаг угсаад Ляодуны хойгоос Шар мөрний хөндийд эрт үед нүүдэллэн очсон. 312 онд тэд ахмад Тогоноор толгойлуулан өөрсдийн хагас зэрлэг алаг хээр морьдоороо ар араасаа Шар мөрний хөндийгөөс Хөх нуур луу чиглэсэн<sup>150</sup> гэдэг.

Чингис хааны аян дайн эхлэх үед Тангуд нь стратегийн зорилтоо хэрэгжүүлэх түшиц газар буюу Алтан улсыг баруун талаас нь довтлох хамгийн ашигтай зам болж хувирсан нь үеийн үед монголчуудын төрийн хар хайрцагны бодлогод Хятад Зүрчидийн аюул оршин байсан хийгээд тэдэнтэй тэмцэх стратегийн чиглэл, түшиц газрын төлөө үргэлж чармайж ирсний утга учраа илэрхийлж байгаа юм.

4. Ил тарвагатай Зайсан нуурын чиглэл: Зүчи анхандаа Хибчагууд-ын эргэн довтлохоос сэргийлэн сууж байсан бол Өгэдэй Дундад Азийн морьт цэрэг довтлон орж ирэх замыг хаан сууж байж. Хибчагууд мөхсөн бөгөөд Уйгур, Харлуг, Хар Кидан дагаар орж, Хорезмын хаант улс мөхсөнөөр тухайн үедээ энэ чиглэлд тавих анхаарал суларсан ч гэлээ эл бүс нутаг нь манжийн эзэмшлийн эсрэг тэмцэх сүүлчийн цэг, хасагууд, оросуудтай холбогдох чухал чиглэл болж хувирсан түүхтэй.

Эдгээрийг Их Монгол Улсын хаадын төр улсаа батлан хамгаалах бодлогын стратегийн ач холбогдолтой тулгуур газар, орон хэмээн томъёолж байна.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэвэл, гадагшаа дайн хийж, дайснаа дарах нь төр улсын аюулгүй байдлаа хангах арга мөн боловч дундад зууны Монголын хаад улс үндэстнийхээ аюулгүй байдал, хаант төрийн тогтвортой байдлыг удаан хугацаанд

---

<sup>150</sup>“Дэбтэр-Чжамцо” источник по истории Монголов, Р.Н.Дугаров, Новосибирск, 1983, с.7.

хангахын тулд аюулаас сэргийлэх төрийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, алдаж онож ирсэн сургамжийг нээн харах нь энэхүү судалгааны зорилго юм. Тэр бүх арга хэрэгсэл нь монголчуудын нийгэм ахуй, газар нутаг, геополитикийн онцлогоос урган гарч байсан нь тодорхой юм.

Суурин соёл иргэншилтэй оронд аль нэг хот, суурин газар нь стратегийн ач холбогдолтой бөгөөд Цагаан хэрэм мэт нүсэр байгууламж ч барьдаг бол нүүдэлчдэд геополитикийн үүднээс стратегийн ач холбогдолтой тулгуур чиглэл, газар орон голлодог байжээ.

Энэ нь бүхэлдээ язгуур монголчууд болон хаан төр, засаглалын аюулгүй байдлыг хангах бодлого байжээ.

Энэхүү Чингис хааны аюулгүй байдлаа хангах бодлого нь Монгол төрийн “Хар хайрцагны бодлого” болж, үеэс үед уламжлан хэрэгжиж байжээ.

Чингис хаан болон Өгэдэй, Гүюг, Мөнх зэрэг Их хаадын үед цөөхөн хүн амтай үндэстний хувьд оршин байх аюулгүй байдлын үүднээс дайн байлдаан хийгээд зогсохгүй овог, аймаг угсаатнуудыг дахин зохион байгуулж, батлан хамгаалах эрх ашгийн үүднээс тэднийг стратегийн ач холбогдолтой газар нутгууд болон нутгийн төв хэсэг, гол уугуул овог, отгоо хамгаалах томилгоожуулалт хийж байснаараа улс үндэстэн, төр, иргэдийнхээ аюулгүй байдлыг баталгаатай хангасан төдийгүй улс үндэстэн ирээдүйд оршин байх баталгааг ч хийж чадсан юм.

Хүн ам цөөн, жижиг үндэстний хувьд монголчууд аюулгүй байдлаа хангах зорилгоор тив алгасан дайн байлдаан хийж, өргөн уудам нутагт хяналтаа тогтоосноор бусад улс үндэстнүүд ч хэрэгтэй “энх тайвныг” тэр үеийн соёл иргэншил голлон хөгжиж байсан евроази дэлхийд тогтоосон билээ.

Монголчуудын тогтоосон дэг журмын үед хүн төрөлхтний хөгжилд мэдээлэл солилцоо, техник технологи, эдийн засаг, цэргийн талаар ихээхэн амжилт гарч, монголчууд ихээхэн хувь нэмэр оруулсныг ч түүхчид хүлээн зөвшөөрдөг.

Тэмүжин Хамаг Монголын ханлигийн аюулгүй байдлыг хангах улмаар нэгдсэн Монгол Улсаа байгуулахын төлөө тэмцэж, тархай бутархай аймаг, ханлигийг нэгтгээд зогсолгүй төр улс, газар нутгийнхаа аюулгүй байдлыг дотоод, гадаад талаас хангах улс төр, дипломат, тагнуул, цэргийн бүхий л арга хэмжээг алсыг харж, дэс дараатай хэрэгжүүлж чадсан билээ.

“Хишигтэн” монголын төрийн албаны сургалтын уламжлал,

төрийн албан хаагчдыг сурган бэлтгэх тухайд

Монголын түрүү төр улсын үе 1130-аад оноос эхэлж, 1220-оод оны үе хүрсэн. Хабулыг хаан суух хүртэлх үеийг монголчууд овог, аймгийн зохион байгуулалтад оршиж байв. Монголын дунд үеийн төр, улсын түүх Хабул хааны эх суурийг нь тавьсан Монгол Улсаас эхлэлтэй юм. Монгол Улсын түүхчид Онон, Хэрлэн, Туул гурван голын монголчуудын улсыг “Хамаг Монгол” хэмээн нэрийдэж байв.

Тухайн үед төрийн удирдагч, албаны хүмүүсээ шалгаруулдаг шилдэг уламжлал, ёс хамаг монголчуудад байсан бөгөөд тэд бүгдийг Чингис хаан улам боловсронгуй болгож хатуу чанд сахидаг болгосон билээ. Үүнд: Тухайн үед язгууртнууд Их хуралдай хийж, эзэн хаанаа өргөмжилж өөрсдийн сонголтоо баталгаажуулдаг ардчилсан шинжтэй ёс журам Хамаг монголчуудад уламжилж тогтжээ. “Нууц товчоон”-д бичсэнээр “... Хабул хаан долоон хөвүүнээ байтал, Сэнгүн билгийн хөвүүн Амбагайг Хамаг Монголын хаан болгохоор хэлсэн ажээ.”

Мөн Амбагай хаан мөн Хотулыг хаан болгох гэрээс үлдээж бүгд язгууртнуудын чуулганаас хаан болж байв. Хотул дараагийн залгамжлагчаар өөрийн хүүдээс биш авга Бартанбаатарын хүү Есүхэй баатрыг онцолсон гэдэг.

Хайдугийн хөвүүдийн удамд Тумбинай сэцэн, Сэнгүн билгэ, Бүлгэчү баатар, Бартан баатар, Нэгүн тайжи, Есүхэй баатар гэсэн цэцэн билигтнүүд, эрэлхэг баатрууд ханлигийн зонхилогч олон байсан байдаг. Тэднээс Их хуралдайгаар сонгогдсон нь л хаан болдог улс төрийн тогтолцоо үйлчилж байсан нь тэр хүү зонхилогч болгонд оюун ухаан, баатар зориг, бусдыг дагуулах удирдах зэрэг чадварууд цогцоор заяагаагүй эсхүл ураг язгуур дутагдсан байх магадлалтай.

Энэхүү “хаанаа сонгодог” төрт, ёс нь хамаг монголчууд бусад ханлиг, аймгуудаас тодорч илүү гарах нэг үндэс болсон байдаг.

Тухайн цаг үед Монголд нийгмийн давхраажилтын доторх дээш, дооших урт дурын хүмүүсийн хөдөлгөөн, цэргийн язгууртнуудын Их хуралдай, бусдын шашин үзэл бодолд хандах чөлөөт байдал зэрэг үйл зан, байгальдаа ойрхон чөлөөт идэвхтэй сэтгэлгээ ноёрхож байв.

Монголчуудын олон үеийн түүхэнд төрийн гадаад, дотоод хамаг эрхийг хаан ерөнхийлөн барьж түүний шууд удирдлага (хяналт)-ын дор төрийн гүйцэтгэх ба шүүх эрх мэдлийг хаанаас томилогдсон ноёд, түшмэдүүд эрхлэн хэрэгжүүлж ирсэн уламжлалтай.

Чингис хааны зохион байгуулах, удирдан жолоодох мэргэн ухаан, “Алд бие минь алжааваас алжаатугай, Ахуй төр минь бүү алдраг” алтан сургаал түүний бодож боловсруулсан “Их засаг” хууль нь монгол үндэстэн, монгол төрийн ой санамж, төрийн хүний чиг баримжаа нь болсоор иржээ<sup>151</sup>.

Хишигтэн, хэвтүүл нар нь дайны үед түмэн буюу 10 000 хүнээс бүрддэг. Одоогийн байнгын армийн корпус, дивизийн хэмжээний томоохон, бүрэн зэвсэглэсэн, сургагдсан нэгтгэл байсан бөгөөд тайван цагт зөвхөн хааны өргөөг жилийн турш өдөр, шөнөгүй ийм том бүрэлдэхүүнээр хамгаалж байх нь эдийн засгийн хувьд хэмнэлтгүй, байгаль экологийн хувьд оршин байх боломжгүй хэрэг. Тиймээс хишигтэн мянгатууд тайван болон дайны үеийн зохион байгуулалттай байсан бололтой.

Хишигтэн цэрэг нь тайван цагт дөрвөн ээлж болж, ээлж бүр гурав хоногоор хааны ордыг сахин хамгаалах үүрэгтэй байв. Тэгэхдээ төрийн зарга шүүхэд ажиглагчаар оролцох, ордны гэрийн хүүхэд, гэрийн хүмүүс, малчдыг эрхлэн захирах, ордны гэр тэрэг, туг хэнгэрэг, дөрөө жад, зэр зэвсгийг хадгалах, түгээх, ав хоморгод оролцож нутаг сонгох зэрэг дотоод ажил үйлс эрхлэх үүрэгтэй байлаа. Дайн байлдааны цагт дээр өгүүлсэнчлэн улсын цэргийн “Их гол” болдог агаад түүний дотор Архай, Хасарын шилдэг мянган “Өтгөс баатад” тэргүүлэн тулалдах ёстой байв.

Дотор мянган нь их хааны хувийн алба татлага, элчин харилцаа буюу өртөөлөг /улаа/, зоог хүнс /шүүсэн/ сур татлага /аргамж/ болон бас бус хэрэглэгдэхүүн зүйлсийг нийлүүлдэг байжээ<sup>2</sup>.

Гол мянган нь хааны амь насыг хамгаалж, ордны дотоод ёс явдлыг журамлан сахиулахаас гадна байлдааны үед хаалт болон шаламгайлан оролцох үүрэг бүхий байжээ<sup>152</sup>.

<sup>151</sup> Ж.Болдбаатар “Монгол улсын түүх” УБ., 2006 он, 488-р тал

<sup>152</sup> Д.Гонгор “Халх товчоон” I дэвтэр, ШУАХ., УБ., 1970 он, 93-95-р тал; Рашид-ад-Дин “Сборник



Чингис хаан хишигтэн цэргийг бүрдүүлэх, нөхөн хангах журмыг дараах маягаар хуульчлан тогтоожээ. Үүнд:

-гадаад, дотоод түмт, мянгат, зуут, аравтын ноёд, урт дурын /сул чөлөөт/ хүний хөвгүүдээс билиг эрдэм, шил сайтайг ялган элсүүлэх;

-тэгэхдээ мянганы ноёны хөвүүд 10 нөхөр, нэг дүү; зуутын ноёдын хөвүүн 5 нөхөр, нэг дүү; аравтын ноёдын хөвүүд 3 нөхөр, нэг дүүгээ тус тус дагуулан ирэх;

-хишигтэн цэрэгт элсэх нөхцөлтэй хүн элсэхээс бэрхшээвэл хол газар цөлж яллах;

-сайн дураараа хишигтэн цэрэгт элсэх ардыг эс хориглох журамтай байв.<sup>153</sup>

Хишигтэн цэрэг нь хааны бие, аураг ордыг хамгаалах үүрэгтэйгээс гадна Чингис хааны зарлиг болгосончлон Их Монгол Улсын цэргийн “Их гол” болж байв. Хишигтэн цэрэг ийнхүү “Их гол” болохынхоо хувьд онцгой эрх дархтай байсан бөгөөд “Гадаад зуут, аравтын ноёдоос ...хишигтэн хөтөч эрхэм тул гадаад мянгатын ноёд ...хишигтэнтэй тэмцэж хэрэлдвэл мянганы ноёныг шийтгэдэг” байжээ<sup>154</sup>.

Д.Гонгорын өгүүлснээр “...эхэн үедээ *дотор* буюу “Гол мянганд хааны буюу Бөртэгийн хувийн зуут гэж байсан ба гол мянганд дээрх зуутаас гадна Чингисийн алтан ургийнхан болон Сөнидийн (Сөнөд) Ил төмөрийн зуут, Дөрөвний Юркийн зуут, Жалайрын Улдай хорчийн зуут, Хэрэйдийн албат овгийн Албакарын зуут, Хулан хатны ах Мэргидийн Жемал хожийн зуут, Татарын Есүн-туагийн зуут, Есүлэн хатны Кингидайн зуутуудаас гадна түүхнээ нэр тэмдэглэгдээгүй хоёр зуут оролцож байжээ<sup>1</sup>.

Хишигтэн эхлээд хааны бие, орд өргөөний аюулгүй байдлыг сахин хамгаалах, цэрэг харуулын үүрэг гүйцэтгэж байв. Тулгар төр байгуулагдсанаас хойш “хишигтэн” нь бүтэц, үүрэг ажиллагааны хувьд өргөжиж, улс орны доторх дэг журам сахиулах, үймээн самуунаас сэргийлэх онцгой үүрэг хүлээж байснаа удалгүй улс орны засаг захиргааны хэргийг бүхэлд нь хариуцах нэг ёсны Засгийн газрын үүргийг гүйцэтгэх болжээ<sup>155</sup>.

Чингис хаан болон Өгэдэй хааны хишигтний бүтэц, бүрэлдэхүүн зохион байгуулалтын “нууцыг” шинжлэн үзвээс тухайн цаг үеийн төрийн удирдлагын буюу төрийн албаны үндсэн тогтолцоо харагдах юм.

Академич Ш.Бира “...Чингис хааны хувьд хишигтэн нь зөвхөн тооны хувьд нэг түм хүртлээ өссөн төдийгүй мөн бүтэц, үйл ажиллагааны хувьд ч ихээхэн өөрчлөгдөн өргөжиж, хааны дэргэдэх цэрэг захиргааны эрх дарх бүхий байгууллага болон хувирчээ. Хишигтэн зөвхөн хааны бие, түүний ордыг хамгаалах үүрэг бүхий бус харин улсын засаг захиргааны хэргийг хариуцсан нэг ёсны Засгийн газрын үүргийг биелүүлж байсан” хэмээн бичсэн нь бий. “Хишигтэн”-д төрийн сайд нараас эхлээд бичээч, зарлигч, заргач, торгууд, хэвтүүл, хорчин, гөрөөч, хөтөч, хоньч, буурч зэрэг албан тушаалтнууд бүгд багтаж байв.

Дотор мянган нь их хааны хувийн алба татлага, элчин харилцаа буюу өртөөлөг /улаа/, зоог хүнс /шүүсэн/ сур татлага /аргамж/ болон бас бус хэрэглэгдэхүүн зүйлсийг (татвар гэсэн үг) нийлүүлдэг байжээ<sup>2</sup>.

---

летописей” Т.1 кн.2. М.,1952, с.166, 266-274

<sup>153</sup>“Монгол цэргийн түүхийн товчоон” Тэргүүн дэвтэр, УБ., 1996 он, 108-109-р тал.

<sup>154</sup>“Монгол цэргийн түүхийн товчоон” Тэргүүн дэвтэр, УБ., 1996 он, 109-р тал.

<sup>155</sup> Ж.Болдбаатар “Монгол улсын түүх” УБ., 2006 он, 99-р тал.

Хишигтэн нь монголын бүх ноёд жанжин, аймаг, хүрээдийн удирдагчдын нуган үрсээс бүрдэж байсан нь тэднийг төрийн бодлого, цэргийн хэрэгт нэг талаасаа сургах төдийгүй цаад талаараа улс гүрний нэгдэл, төрийн эвийг бэхжүүлсэн Чингис хааны алсыг харсан төрийн бодлогын нэг хэсэг байсан юм.

Товчхондоо төрийн түшээдийг угсаа гарвал сайтай идэр залуучуудыг цэргийн хэрэгт сургах, сахилга бат хариуцлагыг биеэр эдлүүлэх, төрийн хэргэлчин харилцаа, татвар гааль, төрийн сайд нараас эхлээд бичээч, зарлигч, заргач хүртэлх албан тушаалд томилж сургадаг нүүдэлчдийн ахуй орчинд тохирсон өвөрмөц төрийн албаны тогтолцоог бий болгож төлөвшүүлсэн нь Их хааны аугаа ялалтын нэг үндэс болжээ гэж үзэж болно.

Европ зүгээс Италийн жуулчин Папын элч Плано Карпини Монголд ирээд “Тэд хоорондоо маргаж хэрэлдэнэ гэж бараг үгүй, зодолдох, өвөр зуураа дайтах, хоорондоо муудалцах, бие биеэ алж шархдуулах явдал үгүй, үнэт зүйл дээрэмдэх, хулгай хийх гэж байхгүй гэж бичсэн тухай тэмдэглэсэн байдаг. Өмнөд Сүн улсын элч Пэн да, Сюй тин нар Монголын эзэнт гүрэнд ирээд “Их засаг” хууль маш хатуу... хүн алсан, хулгай хийсэн, садарлан самуурсан, худал хэлсэн этгээдийг цаазлан цээрлүүлдэг гэж тэмдэглэсэн байдаг нь хууль хатуу хэрэгждэг байсныг илтгэдэг.

Төрийн хүний баримтлах ёстой зарчмууд “МНТ”-д үйл явдал, сургаал зэргээр бичигдэж тэр нь “үеэс үед”, “цуснаас цусанд” уламжлагдан залгамжлагдаж, ард түмний дунд амнаас ам дамжин хэлэгдэж, ахас ихэс нь дүүгээ сургаж, ачлалт багш нь шавьдаа өвлүүлдэг хэвшмэл-хэлц үгнүүдээр Үүнд:

1. Эрүүл биед Саруул ухаан оршино. -Эрүүл монгол хүн
2. Эдээр биеэ чимэхээр Эрдмээр биеэ чим. -Боловсролтой Монгол хүн
3. Эзэн хичээвэл Заяа хичээнэ. -Бүтээлч
4. Хүн ахтай дээл захтай. -Ёс суртахуунтай хүн
5. Санаа зөв бол Заяа. -Зөв, Зөв хандлагатай
6. Дэм дэмдээ Дээс эрчдээ. -Хамтач хүн
7. Иргэн баян бол Улс баян. -Баян хүн
8. Эрхийг сурахаар Бэрхийг сур. -Ноён нуруутай монгол хvн
9. Хvн болох багаасаа Хvлэг болох унаганаасаа. -Эх оронч хvн зэргээр монголчуудын зүйр цэцэн үгэнд улс төрийн гүн ухааны тодорхой утга шингэж, уламжлагдаж ирлээ.

Энд төрийн үлгэр дуурайллын тухай голлон хэлж байна. Төр дуурайллаа хэчнээн алдана, нийгэм төчнөөн хэмжээгээр эмх замбараагүй байдалд орно. Их Богд Чингис “Хэрэв хаан болчхоод хааны явдлаар явж эс чадваас хаан болж юу хиймүй, шившиг!” гэж айлдсан нь наанаа эзэн хааны тухай ярьж байгаа боловч цаад чанартаа төрийн үүрэг хариуцлага, үлгэр дуурайллыг тодорхойлсон үг юм.

Ингэхдээ овог, аймгийн хуучин хүрээний тогтолцоог эвдэж, мянгатын хэлбэрт оруулж, удирдлагыг өөртөө үнэнч байдлаар төдийгүй гол нь хувийн чадвар авьяасаар тодруулж томилж байсан нь улс үндэстний дотоод аюулгүй байдлыг хангахад ихээхэн хувь нэмрээ оруулсан.

Мянгатын тогтолцоо нь улс үндсээ батлан хамгаалах, аян дайнд мордоход үлэмж хэмжээний цэргийг богино хугацаанд шуурхай зохион байгуулах, ард олноос алба татвар авах зэрэгт нэн тохиромжтой цэрэг, засаг захиргааны нарийн чанд зохион



байгуулалт байв<sup>156</sup>.

Тэр үед Монголд нийгмийн давхраажилтын доторх дээш, дооших урт дурын хүмүүсийн хөдөлгөөн, цэргийн язгууртнуудын Их хуралдай, бусдын шашин, үзэл бодолд хандах чөлөөт байдал зэрэг үйл зан, байгаль дэлхийдээ ойрхон чөлөөт идэвхтэй сэтгэлгээ ноёрхож байв.

---

<sup>156</sup> Ж.Болдбаатар., Д.Лүндээжанцан “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” УБ., 1997 он, 57-р тал

## Хоёрдугаар бүлгийн дүгнэлт

Өнөөдөр хөгжингүй орнуудад бүх түвшиндээ төрийн аливаа шийдвэр нийгэмд авч ирэх үр дагавар ялангуяа нийгэмд бий болгож, төлөвшүүлж байгаа эсвэл төлөвшүүлэхийг зорьж байгаа нийтийн үнэт зүйлд төвлөрөх ёстой гэж үзэж, үнэт зүйлээр удирдах тухай ярьдаг. Улс орны, нийгмийн, хувь хүний түвшинд тогтоодог болжээ. Аливаа улс орон өөрсдийн “Нэн тэргүүний эрх ашгийг хэрхэн авч үзсэнээс ихээхэн хамааралтайгаар үндэсний үнэт зүйл нь тодорхой болж үүнийгээ нийтээр хүлээн зөвшөөрч эрхэмлэснээр үндэстэн, угсаатны хэв шинж, төлөвшлийг буй болгодог байна. Монголчуудын хувьд Үндэсний ой санамж нь Монгол угсаатан бүрэлдэж эхэлсэн үе буюу эртний улсуудаас үүдэлтэй. Үндэсний ой санамжийг хадгалж өвлүүлж ирсэн өмнөх өв түүх, уламжлалаас бидний төслийн судлаачдаас<sup>157</sup> дараах дөрвөн зүйлийг тусгайлан онцлон авч үзэж өв түүхийн үнэт зүйл эрхэмлэх зүйлс гэж үзэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, “Монголын нууц товчоон” үндэсний ой санамжийн дээд шүтээн”,

Хоёрдугаарт, “Их засаг” буюу монголын хууль эрх зүйн уламжлал,

Гуравдугаарт, Монголын төрөөс газар нутгаа хамгаалах талаарх бодлого, үйл ажиллагаа,

Дөрөвдүгээрт, “Хишигтэн” төрийн албаны түүхэн уламжлалыг монголын “Өв түүхийн үнэт зүйл эрхэмлэх зүйлүүд” гэсэн дөрвөн зүйлээр тусгайлан авч үзэж судалгаа хийсэн. Монголчууд “Нууц товчоон”-оо төрийнхөө эхэнд өөрсдөө бичиж үлдээж чадсанаараа энэ цаг үед үндэстэн улс байх нэг гол тулгуураа олж, үндэсний ой санамжийн гол эх суурь үндсээ бий болгосон юм.

Чингис хааны үүсгэн байгуулсан Их Монгол Улс “төр”, “улс” гэдэг ухагдахууныг жинхэнэ байх ёстой утгаар нь дэлхийн олон үндэстэнд ойлгуулж өгчээ. Их хуралдай, Сэцдийн зөвлөл, Их засаг хууль зэрэг нүүдэлчдийн ардчиллын өвөрмөц бүрдлүүдийг анх бий болгож өвлүүлсэн нь бидний ой санамжийн эрхэм шүтээн болох учиртай. Чингис хааны аюулгүй байдлаа хангах бодлого нь Монгол төрийн “Хар хайрцагны бодлого” болж, үеэс үед уламжлан хэрэгжиж байжээ.

Чингис хаан болон Өгэдэй, Гүюг, Мөнх зэрэг Их хаадын үед цөөхөн хүн амтай үндэстний хувьд оршин байх аюулгүй байдлын үүднээс дайн байлдаан хийгээд зогсохгүй овог, аймаг угсаатнуудыг дахин зохион байгуулж, батлан хамгаалах эрх ашгийн үүднээс тэднийг стратегийн ач холбогдолтой газар нутгууд болон нутгийн төв хэсэг, гол уугуул овог, отгоо хамгаалах томилгоожуулалт хийж байснаараа улс үндэстэн, төр, иргэдийнхээ аюулгүй байдлыг баталгаатай хангасан төдийгүй улс үндэстэн ирээдүйд оршин байх баталгааг ч хийж чадсан юм.

---

<sup>157</sup> БСШУС-ын сайдын А/146 тоот тушаалын хавсралт жагсаалтын 11-г үндэслэн “Үндэсний ой санамж, үнэт зүйлсийг сэргээн тодорхойлох замаар үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нь” захиалгат төслийн удирдагч ҮБХИС-ийн харьяа Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төвийн дарга, асан Ч.Сосорбарам. “Монгол үндэсний ой санамжийн түүхэн уламжлал” Академич Ж.Болдбаатар, доктор (Ph.D), дэд профессор

# ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛЧУУДЫН ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ, ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

## 3.1 Монголчуудын үндэсний ой санамж, үнэт зүйлсийн төлөв байдлын шинжилгээ

Үндэсний ой санамж, үнэт зүйлсийн тухай ойлголт, үнэлэмж, өнөөгийн байдал, эдгээр нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хэрхэн нөлөөлөх талаарх иргэдийн болон нийгмийн салбаруудын төлөөлөл болсон экспертүүдээс судалгаа авч, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийлээ.

Судалгааг гүйцэтгэхдээ анкетийн асуулгыг Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн иргэдийг хамруулан 1907 хүнээс, нийгмийн салбаруудаас төлөөлөл болгон 18 хүнээс үндэсний ой санамж, үнэт зүйлсийн тухай ойлголт, үнэлэмж, өнөөгийн байдал, эдгээр нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хэрхэн нөлөөлөх талаарх экспертийн судалгаа Судалгааны асуумжийн асуултыг Үндэсний ой санамж, үндэсний үнэт зүйлс, нийгмийн үнэт зүйлсийн тухай ойлголт, нөлөөлөгч хүчин зүйлс, үндэсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөө арга замыг тодорхойлох үүднээс суурь судалгаанууд, үндсэн бичиг баримтуудад тулгуурлан боловсруулсан. Судалгааны мэдээлэл цуглуулахдаа асуулга судалгаа, ганцаарчилсан ярилцлагын аргыг хэрэглэсэн.

Судалгааг дараах 3 агуулгын хүрээнд авсан.

- Үндэсний ой санамжийн талаарх ойлголт, үнэлэмж
- Иргэдийн үнэт зүйлсийн баримжаалал
- Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд үндэсний ой санамж, үнэт зүйлсийн үзүүлэх нөлөө, уялдаа холбоо, арга зам:


Дээрх судалгааны үр дүнгээс тус тайланд дараах судалгаануудыг түүвэрлэн орууллаа.

### 1. Үндэсний ой санамжийн талаарх ойлголт, үнэлэмж:

Олон нийт “Үндэсний ой санамж” гэдгийг үндэсний хэл, соёл гэж ойлгох нь хамгийн түгээмэл байгаа бол нийгмийн ухааны чиглэлийн, үндэсний түүх соёлын талаарх мэдлэг, туршлага бүхий, мэргэшсэн оролцогчид түүх, туршлага, үндэсний хэл соёл, зан заншил, уламжлал, төрт ёс, хууль цааз зэргийг тус ойлголтод илүү хамааруулан тайлбарлаж байв.


Олон нийтийн энэ талаарх ойлголтыг задлан харвал, хамгийн багадаа 3 хүн тутмын нэг нь зан заншил, уламжлал, нийгмийн ёс суртахуун, ухамсар, амьдрах хэв маяг, дадал зуршил, түүх туршлага, 4 хүн тутмын нэг нь төрт ёс, хууль цааз гэсэн ойлголтыг “Үндэсний ой санамж” гэсэн ойлголтод багтаан хариулсан.

“Үндэсний ой санамж” хэмээх ойлголтод дараах зүйлүүдийн алийг илүү хамааруулан үзэж байна вэ? гэсэн асуутад дараах байдлаар хариулжээ.




“Үндэсний ой санамж”-д хамаарах ойлголтыг нэрлэсэн байдлыг судалгаанд оролцогчдын насны бүлгээр харьцуулж харвал, үндэсний хэл соёл, зан заншил, уламжлал, амьдрах хэв маяг, дадал зуршил гэж хариулсан нь төдийлөн ялгаа алга. Харин 60-аас дээш насныхан төрт ёс, хууль цааз, 18-29 насны залуучууд түүх туршлага, сэтгэлгээний арга ухаан гэсэн ойлголтыг “Үндэсний ой санамж” гэсэн ойлголтод хамааруулан ойлгож байгаа нь бусад насныхантай харьцуулахад өндөр б “Үндэсний ой санамж”-ийг сэргээн тодорхойлох нь хэр зэрэг ач холбогдолтой болохыг тодруулахад иргэдийн 70.4% буюу 10 хүн тутмын 7 нь маш их ач холбогдолтой гэжээ. Харин 10 хүн тутмын нэг нь ач холбогдолтой эсэхэд хариулж чадахгүй байна.


Та “Үндэсний ой санамж”-ийг сэргээн тодорхойлох нь хэр ач холбогдолтой гэж бодож байна вэ? гэсэн асуултад дараах байдалтай хариулжээ.



Та “Үндэсний ой санамж”-ийг сэргээн тодорхойлох нь хэр ач холбогдолтой гэж бодож байна вэ? (Насны бүлэг, хүйсээр)



Таны бодлоор нийгэм дэх “Үндэсний ой санамж”-ийн түвшинг дээшлүүлэхэд ямар арга хэлбэрүүдийг ашиглавал илүү үр дүнд хүрэх боломжтой вэ? гэсэн асуултад



Матриц Таны бодлоор нийгэм дэх “Үндэсний ой санамж”-ийн түвшинг дээшлүүлэхэд ямар арга хэлбэрүүдийг ашиглавал илүү үр дүнд хүрэх боломжтой вэ? гэсэн асуултад

№	Арга хэлбэр
1	Нийгмийн сэтгэл, оюун санаа руу цацагдаж байгаа мэдээллийн эмх замбараагүй урсгалыг эх оронч үзэл бахархал, үндэсний соёлын өвөө сэргээн түгээх үтгaar агуулгажуулах
2	Амьдарч буй нийгэм, монгол хүн өөрийгөө аль нэг туйлшралгүй олон талаас үхаж ойлгон сэтгэлгээ, бодол эргэцүүлийг өдөөх, утгвар хөтөч болох буддын шашны философи, дэлхийн сонгодог ба шилмэл уран зохиол, урлагийн бүтээлүүдийг хүн ардад хүргэж сурталчилан таниулах
3	Иргэдийн боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, хэвлэл мэдээлэлтэй тогтмол харилцаатай байж тэднийг чадавхжуулах
4	Улс үндэстний түүхийг аливаа нөлөөлөл (улс төр, гадаад орны гэх мэт)-өөс ангид бодитой байлгахад төр засаг анхаарах
5	Үндэсний ой санамж нь хамтын ой санамжийн хэлбэр тул нийгмийн бүлгүүд (улс төрийн намууд, ТББ, төрийн байгууллагууд гэх мэт)-ийн түүхэн ой санамжийн уялдаа холбоог сайтар хангах, нэгдсэн мэдээллийн санг үүсгэх, түүхийн мэдээллийн судалгааг нэгтгэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх.
6	Үндэсний ой санамж нь үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх "түлхүүр" хэрэгсэл болгох зэргийг хэрэгжүүлэх.
7	Төрийн "хар хайрцаг"-ны бодлогыг тодорхойлох.
8	Үндэснийхээ өв соёл, түүх, ёс заншил, ялангуяа эх хэлээ бүрэн бүтнээр нь хойч үедээ өвлүүлэх
9	Албан ба албан бус сургалтыг хослуулж ашиглаж "Монгол хүн" гэсэн хичээл орох нь оновчтой арга зам
10	Боловсрол, цэргийн анги салбарын сургалтын программд оруулах
11	Хүүхэд багачуудад зориулсан контентуудийг бэлтгэх
12	Зөвхөн шүтэн бишрэх, бэлгэдэн дээдлэх биш өдөр тутмын хэргэлээ талаас эзэмшүүлэх

“Үндэсний ой санамж”-д чухал байр суурь эзэлж буй үнэт зүйлийг тодорхойлоход тухайн улс, үндэстний түүхэн үеэс хамгийн сэтгэлд ойр, бахархал төрүүлдэг үеийг иргэд илүү сонирхож, судалдаг байна.


Энэ тухай тодруулах зорилгоор судалгаанд оролцогчдоос “Та Монголын түүхийн дараах үеүдээс аль үеийн түүхийг илүү их сонирхдог вэ?” гэж асуухад Хамаг Монгол болон Их Монгол Улсын үе гэж 3 хүн тутмын нэг нь хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Өөрөөр хэлбэл, Хамаг Монгол болон Их Монгол Улсын үе нь Монголчуудын хувьд түүхэн ач холбогдол бүхий, бахархал дүүрэн цаг үе байсан бөгөөд түүхэн цаг хугацааг сонирхох сэдлийг төрүүлжээ.

Та Монголын түүхийн дараах үеүүдээс аль үеийн түүхийг илүү их сонирхдог вэ?




Монголын нууц товчоо нь өнөө үед мэдэгдэж буй Монголын соёлын анханд тооцогдох түүхийн болон уран зохиолын бичгийн дурсгал юм. Тиймээс тус бүтээл нь Монголчуудын үндэсний ой санамж бүрэлдэн тогтоход чухал эх сурвалж гэж судалгааны багийн зүгээс үзэж байгаа тул дараах асуултыг асуусан. Үр дүнгээс харвал, судалгаанд оролцогчдын 82.5% буюу 10 хүн тутмын 8 нь хамгийн багадаа 1 удаа “Монголын нууц товчоо”-г уншсан байна. Энэ нь тус бүтээл Үндэсний ой санамж бүрдэхэд гол эх сурвалж болсныг харуулж байна.


Та Монголын нууц товчоог хэдэн удаа уншсан вэ?



“Монголын нууц товчоонд өгүүлснээр “Өтгөс дээдсийн үг сонсч: Анд хүн амь нэг Аль алианаа үл дэвчилдэн Амь биений арчаа больюу хэмээн амраглах ёсон тийм Эдүгээ бас андлалдая” хэмээн хэн андгай тангараг өргөдөг вэ?



“Монголын нууц товчоонд өгүүлснээр “Өтгөс дээдсийн үг сонсч: Анд хүн амь нэг Аль алинаа үл дэвчилдэн Амь биений арчаа больюу хэмээн амраглах ёсон тийм Эдүгээ бас андлалдая” хэмээн хэн андгай тангараг өргөдөг вэ? (Монголын нууц товчоог уншсан давтамжаар)



Тус асуултад хариулсан үр дүнг Монголын нууц товчоог уншсан давтамжаар харьцуулж харвал, давтамж нэмэгдэхтэй зэрэгцэн зөв хариулсан дүн нэмэгдсэн дүнтэй байгаа бол уншаагүй хүмүүсийнх бага байна. Энэ нь Монголчуудын “Үндэсний ой санамж”-ийг сайжруулах зорилгоор чухал түүхэн баримт сэлтийг төрөл бүрийн хэлбэрээр (ном бүтээл, кино, контент... гэх мэт), олон давтамжтайгаар нийтэд хүргэх нь үр дүнтэй гэдгийг дахин баталж байна.


## 2.Иргэдийн үнэт зүйлсийн баримжаалал:

Нийгэмд, тухайн улс үндэстэнд нийтээрээ хүлээн зөвшөөрдөг, оюун санаа, үйлдэл, үйл ажиллагаандаа эрхэмлэн сахидаг, дагаж мөрддөг нийтлэг зүйлүүдийг л үнэт зүйлс хэмээн ойлгож болох юм.

Иргэн буюу хувь хүний үнэт зүйлийг нэрлэсэн байдлаас харвал Монголчуудын хувьд гэр бүл, эх орон, эрүүл мэнд хамгийн чухалд тооцогдож байна.

*Таны амьдралд хамгийн чухалд тооцогдох 3-н үнэт зүйлсийг нэрлэнэ үү?*






3. Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд үндэсний ой санамж, үнэт зүйлсийн үзүүлэх нөлөө, уялдаа холбоо, арга зам:

Үндэсний ой санамж бүрдэхэд иргэдийн эх ороноо хайрлах сэтгэл, эх орны үнэ цэнэ, тусгаар тогтнолоо хамгаалах, эх орныхоо өмнө хүлээх иргэний хариуцлага зэргийг үнэлэх зорилгоор асуулга асуухад судалгаанд оролцогч 3 хүн тутмын нэг нь эх орон гэдэг бол утга учир бүхий амьдралын үндэс, эрхийг нь хангаж, давуу эрх олгож, оршин амьдрах боломжийг бүрдүүлсэн орон зай гэж үзэж байна.


Таны амьдралд эх орон ямар нөлөө үзүүлдэг гэж Та үзэж байна вэ?



Эх орныхоо өмнө хүлээх иргэний хариуцлагын талаарх байр суурийг тодорхойлох зорилгоор “Та цэргийн алба хаах журамт үүргийг дэмждэг үү” гэж асуухад 10 хүн тутмын 8 нь дэмжиж байна.




Та цэргийн алба хаах журамт үүргийг дэмждэг үү? (Насны бүлэг, хүйсээр)



17 хүртэлх насны залуучуудын хувьд тус үүргийн дэмжих хандлага хамгийн бага байсан бөгөөд дэмжихгүй хандлага хамгийн өндөр байна. Мөн тус хариултад хэлж мэдэхгүй байна гэж байр сууриа илэрхийлсэн нь бусад насныхантай харьцуулахад өндөр байна. Энэ нь залуучууд цэргийн алба хааж, улс эх орноо хэрэгцээтэй цагт хамгаалах журамт үүргээ биелүүлэх эсэхэд эргэлзээтэй байр суурь байдаг болохыг харуулж байна.

Та Монгол Улсын төрөөс үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар явуулж буй бодлого, үйл ажиллагаанд хэр сэтгэл хангалуун байна вэ?



Судалгаанд оролцогчид Үндэсний аюулгүй байдал, Үндэсний үнэт зүйлсийн уялдаа холбоог сайжруулахад төрийн тусгайлсан бодлого хамгийн чухал гээд бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт энэ талаарх агуулгыг оруулж өгөхөд анхаарах хэрэгтэй гэж дийлэнх нь үзжээ.

Таны бодлоор үндэсний аюулгүй байдал, “Үндэсний үнэт зүйлс”-ийн уялдаа холбоог сайжруулахад доорх арга замуудаас аль нь илүү үр дүнтэй вэ?



Нийгмийн ухааны чиглэлийн, үндэсний түүх соёлын талаарх мэдлэг, туршлага бүхий, мэргэшсэн оролцогчид Үндэсний аюулгүй байдал, “Үндэсний ой санамж”-ийн уялдаа холбоог сайжруулахын тулд шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийж, үр дүнг төрийн бодлого, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгаж, холбогдох байгууллагуудын (төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл.. гэх мэт) хамтын ажиллагааг сайжруулж, бүхий л хэлбэрийн мэдээллийн эх сурвалж, боловсролын байгууллагаар дамжуулж ойлголт өгөх хэрэгтэй. Мөн Үндэсний ой санамжийг бүрдүүлэгч түүхэн үнэ цэнэ бүхий биет болон биет бус соёлын өвийг хамгаалж, хадгалан баяжуулах, холбогдох дата өгөгдлийн сан бүрдүүлж, үндэсний аюулгүй байдал судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх нь чухал хэмээн онцолжээ.

1. Олон нийт “Үндэсний ой санамж” гэдгийг үндэсний хэл, соёл гэж ойлгох нь хамгийн түгээмэл байгаа бол нийгмийн ухааны чиглэлийн, үндэсний түүх соёлын талаарх мэдлэг, туршлага бүхий, мэргэшсэн оролцогчид түүх, туршлага, үндэсний хэл соёл, зан заншил, уламжлал, төрт ёс, хууль цааз зэргийг тус ойлголтод илүү хамааруулан үзжээ.

2. Иргэдийн үнэт зүйлсийн баримжаалал иргэн буюу хувь хүний үнэт зүйлийг нэрлэсэн байдлаас харвал Монголчуудын хувьд гэр бүл, эх орон, эрүүл мэнд хамгийн чухалд тооцогдож байна.

3. Монгол Улсын төрөөс үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэж явуулж буй бодлого үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус хүмүүс сэтгэл хангалуун хүмүүсээс даруй 2 дахин илүү байна.

4. Үндэсний аюулгүй байдал, “Үндэсний үнэт зүйлс”-ийн уялдаа холбоог сайжруулахад төрийн тусгайлсан бодлого хамгийн чухал гээд бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт энэ талаарх агуулгыг оруулж өгөхөд анхаарах хэрэгтэй.

5. “Үндэсний ой санамж”, “Үндэсний үнэт зүйлс”-ийн уялдаа холбоог дээшлүүлж, Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд төрийн байгууллага болон боловсролын байгууллага чухал нөлөөтэй гэж үзжээ.

### 3.2. Үндэсний ой санамж ба Үндэсний аюулгүй байдал

Үндэсний ой санамж нь үндэсний аюулгүй байдалтай яаж холбогдохыг (нөлөөлөх) энгийнээр хэлбэл эх орон, газар нутаг, тусгаар тогтнол, хэл, соёлын өвөө хамгаалж ирсэн түүхэн туршлагыг ой санамжаасаа тодруулах явдал юм.

Улс орны өнөөгийн дотоод зөрчил бэрхшээлийг ч эдгээр туршлага, сургамжтайгаа холбон дүгнэх шаардлагатай. Мөн үндэсний ой санамж ба оюуны санааны дархлаандаа тулгуурлан өнөөгийн дэлхий дахин, бүс нутаг, хөрш орнууд, гадаад улсуудын геополитикийн бодлого, болзошгүй аюулгүй байдлын төсөөллийг ч үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дагуу судлан тооцох хэрэгтэй ажээ.

Бид эхний ээлжид үндэсний аюулгүй байдалд ой санамжийн нөлөөллийг тодруулна. Ингээд түүхэн болон өнөө цагийн үндэсний туршлага, сургамжаас жишээ татаж, тэдгээрт тулгуурлан аюулгүй байдлын шинэ нөхцөл байдал дахь монгол орны геополитикийн асуудлыг ч сөхөх болно. Түүнчлэн ой санамж ба төрийн бодлогын “залгамжлах” чадварын асуудлыг ч хөндөх болно.

#### Нэг. Үндэсний ой санамж

Судлаачдын судалгаа, гадаадын энциклопед, сайтуудын мэдээллээс нэгтгэн “үндэсний ой санамж-national memory-национальное память” гэдэг ойлголт нь үндэсний “туршлага-experience-опыт”, “соёл-culture-култур” гэсэн хоёр үндсэн хэсэг, агуулгаас бүрддэг<sup>158</sup> байна.

- Үндэсний “туршлага” гэдэг ойлголтод төр (хаад)-ийн түүх, төрийн бодлого, төрийн алба, архив, шинжлэх ухаан, мэдээллийн сангууд зэрэг тээгчдээс бүрдэх учиртай бөгөөд түүнийг “төрийн ой санамж” гэж нэрлэж болох юм.
- “Соёл” гэдэг ойлголт тухайн үндэсний номын сан, бичиг, ургийн бичиг, шашин, соёл урлаг, дуу хөгжим, идээ ундаа, домог туульс, хувцас зэрэг биет болон биет бус тээгчдээс бүрдэж, тухайн үндэсний онцлогийг харуулдаг бөгөөд “нийгмийн ой санамж” гэж нэрлэж болох юм.

Үндэсний ой санамж урд цагийн хувьд түүх, архив, соёлоор, эдүгээ цагийг төрийн бодлого, шинжлэх ухаан, мэдээллийн сангууд, ирээдүй цагийн хэлхээст геополитикийн төсөөлөл, стратегийн төлөвлөлт гэх зэрэг ойлголтуудаас бүрдэх учиртай. Аль ч цаг үед хууль эрх зүйн баримт бичгүүд ой санамжийн чухал суурь болно. Учир нь ард иргэдийн дунд янз бүрийн хэлбэрээр “аандаа” өвлөгдөн байдаг олон төрлийн соёлын өв нь тухайн улсын нийгмийн амьдралд оршин хөгжиж, устаж байхгүй болж байдаг ажээ. Эд бүгд нийлээд “National identity” буюу үндэсний ижилсэл түүхэн онцлогийг ч илтгэн харуулдаг, эргээд үндэсний үнэт зүйлийг тодорхойлоход ч оролцдог байна.

Б.Даш-Ёндон “Үндэсний ой санамжийн асуудлыг судлахад “Үнэт зүйл”, “Түүхэн сургамж”, “Оюун санааны дархлаа”, “Үндэсний аюулгүй байдал” гэсэн ойлголтууд яригдах учиртай” гэсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Д.Бум-Очир Б.Андерсон<sup>159</sup>, Г Аллпорт<sup>160</sup>

<sup>158</sup>Ой санамж (оросоор память, англиар tetogy)-ыг байгаль, нийгмийн шинжлэх ухаанууд (тухайлбал, хүний анатоми, физиологи, сэтгэл зүй, мэдрэл судлал, социологи, антропологи, философи, логик) өөр өөрсдийн судалгааны объект болгон нарийвчлан судалдаг байна.

<sup>159</sup>B .Anderson. Imagined communities. 1983

<sup>160</sup>G.Allport Personality&social encounter. 1960

зэрэг барууны судлаачдын бүтээлээс эш татаж “Хүмүүсийг юу нэгтгэж үндэстэн болгодог вэ” гэсэн асуултад хариу өгөхдөө Андерсоны бичсэнээр нийгмийн байгуулал, ухамсар, ухамсрын бүлэг, оюун санаа гэсэн ойлголтуудын хүрээнд хүмүүс бие биеэ таньдаггүй ч нэг үндэстэн гэх ухамсарт тулгуурлан үндэстэн болж нэгддэг. Алпортынхоор үнэт зүйл, зан төлөв, үндэсний ижилсэл нь бүлэг хүмүүсийн онцлог ч болдог мөн тэднийг нэгтгэж байдаг гэжээ. Ингээд тэр бээр эхлээд оюун санаа, тэгээд үнэт зүйл, эцэст нь үзэл санаа (суртал) гэсэн дарааллаар нийгмийн нэгдмэл үнэт зүйл бүрддэг гэсэн санааг гаргажээ<sup>161</sup>.

Д.Бум-Очир үндэстнийг нэгтгэдэг зүйлс нь төр, улс, хэл, соёл, түүх, угсаа, шашин, иргэншил, ДНХ... дээр үндэслэсэн үндэсний үнэт зүйл, үндэсний ухамсар юм гээд “үндэстний ижилслийг бүрдүүлэгч үнэт зүйлс”, “үнэт зүйлсээрээ нэгдэгч оюун санаа” гэсэн тодорхойлолтууд талаар илтгэлдээ дурджээ<sup>162</sup>.

Доктор (Ph.D) Д.Энхцэцэг<sup>163</sup>: “Үндэсний ой санамж бол тухайн ард түмний урт удаан оршин тогтнох үндэс суурь болдог. Үндэсний Аюулгүй Байдлын баталгаа болдог, нийгэм түүхийн олон талт үйл явц, үнэт зүйл болдог. ...хэлэлцэж байгаа асуудал нь чухал, өргөн дэлгэр асуудал юм.” гэсэн.

Доктор (Ph.D), дэд профессор А.Пунсаг<sup>164</sup> “Түүхч миний хувьд үндэсний ой санамж бол өнгөрсөн зүйлийг хэлж байгаа байх. Чингис хаан бол манай ой санамж, бидний үнэт өв гэж үзэл санааны талаас нь үзэж болох юм. ...“Нууц товчоон” бол бидний ой санамж мөн, түүх нь ч мөн, үнэт зүйл мөн гэж боддог. “Нууц товчоон”-д монголчууд төр барих ёс, түүх бүтээсэн агуу үйлсийг тодорхой тэмдэглэсэн.

Доктор Б.Хэрлэн<sup>165</sup> хэлэлцүүлгийн үеэр “Үндэсний ой санамж бол эрт, эдүгээ, ирээдүйн гурван цагийн хэлхээс дээрх нийгмийн ухамсар юм” гэсэн тодорхойлолт хийсэн нь “Хүн төрөлхтний оюуны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн нь шинжлэх ухаан, урлаг, шашин бөгөөд эдгээр нь оюуны үйлдвэрлэлийн дүрсүүд төдийгүй нийгмийн ухамсрын хэлбэрүүд юм, энэ гурав дээр эрх, улс төр, ёс суртахууны ухамсар нэмэгддэг”<sup>166</sup> гэх философийн ойлголттой ойролцоо санаа бөгөөд үндэсний ухамсар, үндэсний ой санамж нь философийн хувьд төсөөтэй судлагдахуун болохын жишээ бололтой.

Үндэсний ухамсар бол тухайн ард түмний өнгөрсөн нэгдсэн түүхээ бүтээгч хамтын субъект гэдгээ ойлгосон мэдрэмж, тусгаар тогтносон улс байх эрх, эрх чөлөөгөө дээдэлсэн ухамсар, эх орноо хайрлах сэтгэл бүхний цогц ойлголт юм. Үндэсний бахархал үндэсний ухамсрыг сэргээн дэвжээх нь бидний өмнө нэн тулгамдсан асуудал мөн.

Учир нь үндэсний ой санамж гэх энэхүү ойлголт, үг хэллэг нь урд өмнө манай улсад тэр болгон хэрэглэгдэж, судлагдаж байгаагүй учир олон талаас нь судлах зүйн хэрэг юм. Хэлэлцүүлэг, ярилцлагын явцад ой санамжийг “өв санамж” гэж

<sup>161</sup> Д.Бум-Очир “Оюун санааны нэгдмэл байдал ба үндэсний нэгдмэл үнэт зүйлс” -“Соёлын бүтээлч үйлдвэрлэл-2022” Форум (2022.11.22)-ын үндсэн илтгэл

<sup>162</sup> Д.Бум-Очир “Оюун санааны нэгдмэл байдал ба үндэсний нэгдмэл үнэт зүйлс” -“Соёлын бүтээлч үйлдвэрлэл-2022” Форум (2022.11.22)-ын үндсэн илтгэл

<sup>163</sup> Д.Энхцэцэг /МУИС-ийн Түүхийн тэнхимийн багш, профессор/. ҮБХИС-ын эрдэм шинжилгээний хурал (2022.10.18)-ын илтгэл

<sup>164</sup> А.Пунсаг /ШУА-ийн Түүх угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан/ ҮБХИС-ын эрдэм шинжилгээний хурал (2022.10.18)-ын илтгэл

<sup>165</sup> Б.Хэрлэн ҮБХИС-ын эрдэм шинжилгээний хурал (2022.10.18)-ын илтгэл

<sup>166</sup> Г.Чулуунбаатар, Д.Даш-Ёндон “Монголын нийгмийн өөрчлөлт” УБ., 2013 он, 94р тал

нэрлэх (доктор Ц.Цолмон) ч санал ч гарсан.

Доктор Н.Жалбажав ой санамжийг оюун санааны дархлаатай шууд холбон судалгаандаа авч үздэг.

Ерөнхийдөө үндэсний “ой санамж” гэдэг нь агуулгаараа тухайн үндэстний ижилсэл-онцлог, үндэсний ухамсар-ёс суртахуун, оюун санааны дархлаа, үндэсний үнэт зүйлс зэрэг судлагдахуунуудын үндэс цөм болж, тэдгээрийг холбож өгдөг суурь ойлголт юм байна гэсэн дүгнэлт хийж болох бололтой.

Эдгээрээс харахад үндэстний түүх, соёл, ижилсэлдээ тулгуурлан үндэсний ой санамжаа сэргээж байж, үндэсний үнэт зүйлсээ зөв тодорхойлж чадна. Үүний дараа л үндэсний ухамсар сэргэж, үндэстний оюун санааны дархлаа бэхжин улмаар үндэсний ёс суртахуун, хууль дээдлэх үзэл олон нийтэд дэлгэрэх жамтай юм байна.

Бид шинэ монгол хүний үнэт зүйлсийг шинээр тодорхойлж, нийгэм судлаачид, философичид, соёл хэл судлаачид, түүхчид, төрийн түшээд, цэргийнхэн хамтран нэгдээд нэг байр сууринд хүрэх нийгмийн шаардлага тулгамдаж байна. Ийм ч учраас бид энэ төслийг хэрэгжүүлж байгаа билээ.

Энэ мэт асуудлыг бүхэлд нь цогцоор харж судлах шаардлага судалгааны байгууллагуудын өмнө тулгамдаж байгаа бөгөөд бүхий л судалгаа шинжилгээний байгууллагуудын хамтын оролцоо үүнд чухал байсаар байх болно.

Улс орон, үндэсний үнэт зүйлээ тодорхойлсноор, түүндээ тулгуурласан нийгмээ нэгдэн нягтруулах аливаа бодлого, шийдвэр гаргаж чадах бөгөөд цаашлаад энэ нь улс орон хөгжлийн бодитой зөв замаа сонгоход баримжаа болдог. Үндэсний үнэт зүйл нь нэг төрлийн "хамгаалах" үүргийг гүйцэтгэж, улс үндэстний оюуны дархлааны суурь үндэс болдог талаар дээрх судлаачид санал нэгтэй бичжээ.

Ерөнхийдөө одоогийн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтууд болон манай судалгааны багийн эрдэмтдийн үндэсний ой санамжийн талаарх нэгдүгээр бүлгийн судалгааны шинэхэн тодорхойлолтууд хоорондоо агуулгаараа нийцэж байна гэсэн дүгнэлт хийсэн болно.

#### Үндэсний аюулгүй байдал

Үндэсний аюулгүй байдал нь улс үндэстнүүдийн түүх, соёл иргэншлийн хувьд түүхийн ямар ч нөхцөл байдалд үндэсний онцлох шинж чанараа хадгалах, хамгаалах, дахин сэргээх чадавх, хүн ам, төрөлх хэл, соёл уламжлал, үр удам, төрөлх газар нутгаа хадгалан хамгаалах чадвар, үндэсний уламжлалаа баяжуулан хөгжүүлэх, оюун санаа, соёл иргэншлийн орон бусдаар хүлээн зөвшөөрүүлэх зэрэг үзүүлэлтүүдээр тодорхойлогдож иржээ.

Ерөнхий сайд А.Амар агсан “Үндэсний эрх чөлөө хэмээх нь чухам өөрийн улс төр, өөрийн газар шороондоо бүрэн эрхтэй эзэн нь болж чадаад өөрийн үндэсний зан суртлаа дагаж, бусад ямар ч этгээдийн хавчилтгүйгээр өөрийн хэргийг өөрсдийн аль тохирч бололцох заншил байдалдаа зохицуулан явуулж чадах эсэхэд харгалзах явдал” хэмээн бичсэн байдаг.

#### Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, эрх зүйн заалтууд

Монгол Улс 1992 оноос хойш шинэ Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа үндэсний язгуур ашиг сонирхол буюу үндэсний эрх ашгаа илэрхийлэх болсон байдаг.

Монгол Улсын "Үндсэн хууль"-ийн:

Нэг. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг

хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

2010 оны Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд:

- 1.1.1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ.
- 1.1.2. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.
- 1.1.3. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн.
- 1.1.4. Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн.
- 1.1.5. Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна.
- 1.1.6. Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь Монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хуульд:

- 3.1. “Үндэсний Аюулгүй Байдал” гэж /цаашид “үндэсний аюулгүй байдал” гэнэ/ Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.
- 3.2. “Үндэсний язгуур ашиг сонирхол”-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх ЧӨЛӨӨ баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

Бид энэ удаа энэхүү хэрэгжиж байгаа үзэл баримтлал, хуулийн талаар хэлэлцэхгүй, харин түүхэн хөгжлийн ой санамж талаас ярих болно.

Хүн төрөлхтний түүхэнд янз бүрийн хүчин зүйлүүдээс шалтгаалж, үндэсний ухамсар, сэтгэхүй, үнэт зүйлс өөрчлөгдөж, үндэстэн нэгдмэл байх нөхцөл сарниж, улмаар үндэсний аюулгүй байдал алдагдан бусдын эрхшээлд орж, улс үндсээрээ устсан гашуун түүх олон бий.

Монголчууд түүхэн тодорхой шалтгаанаар өөрийн үндэсний ой санамжаа бүдгэрүүлж, аливаа шинэ зүйлсийг шууд дуурайдаг, өөрийн ухаанаа уралдуулж байж шинэ зүйлийг нутагшуулдаггүй, бусдын үгээр явж ирсэн нь ямар алдаанд хүргэдэг болохыг өнөөдөр судлаачид, олон нийт мэдэрч эхэлж байгаа билээ.

1990 онд монголчуудад өөрийн түүх, үзэл бодол оюун санаагаа цэгцлэх, өөрийнхөөрөө бодох тунгаах, ирээдүйгээ төсөөлөх боломж, таатай нөхцөл бий болсон. Эв хамтын үзэл суртлаа нүд ирмэх зуур таягдан хаясан хэдий ч тэрхүү цаг үеийг ашиглан өөрийн толгойгоор бодож, хийх зүйлээ амжиж ухааралгүй дахиад л тухайн үед дэлхий дахинд ноёрхож байсан шинэ үзэл суртлыг шууд хүлээн авч иргэний ардчилсан, чөлөөт зах зээлийн нийгэм байгуулахаар шуударсан билээ. 30 жилийн дараа олон нийт бүгд санаснаар болоогүйг ухаарч бүх юмыг шүүмжилж, тэрсэлдэж эхэлж байна. Улс төр нийгмийн тогтвортой байдал алдагдах аюул занал



дотоод, гадаадаас ч өндөр байна.

Доктор С.Дулам эрхэмлэх зүйлсийн талаар “Бага хаадын туршилтад ороод эе эвийг хичээдэг эрхэм чанараа гэсэн Манжийн туршилтад ороод зэрэг дэвийг үл тоодог эрхэм чанараа гэсэн коммунизмын туршилтад ороод дээшээ хов зөөдөггүй эрхэм чанараа гэсэн, Нео-либериализмын туршилтад ороод эд хөрөнгөд шунадаггүй эрхэм чанараа гэсээр байна” гэсэн нь буруугаа бусдад тохсон мэт боловч товчхоноор онож хэлжээ.

Ж.Штиглиц<sup>167</sup> “...Монгол нь цочир эмчилгээ, эрс хурдан хувьчлалын бодлогын бүтэлгүйтлийн нэг жишээ юм. Либералчлал, хувьчлалыг хэт хурдан хийснээс ихээхэн хохирол амссан. “...Баялгийн хясланг ерөнхийд нь байгалийн асар их баялагтай орнууд ихэнхдээ хүмүүс нь ядуурдаг, улс нь өсөж, хөгждөггүй, баялгийн өгөөж харьцангуй цөөн хүнд ноогддог гэдгээр тодорхойлж болно. Харин хөрш Хятад болон Вьетнам энд амжилтын тод жишээ болно. Өнөөдөр хүн амын орлогыг худалдан авах чадвар хятадад... 250 хувийн өсөлтөд хүрчээ. Хятад өнөөдөр мөнгөнийхөө ханшийг доогуур хэмжээнд барих, экспортын бүтээгдэхүүнээ өрсөлдөх чадвартай байлгахын ...тулд маш их хүч, чармайлт гаргаж байна. Харамсалтай нь хөгжиж буй орнууд үүнээс суралцахгүй байна”.

Ийм учраас Монгол үндэстний ой санамж хир гүнзгий байна вэ?, өөрийн гэсэн төрийн бодлоготой байсан уу, өнгөрснөөс юуг уламжлал, сургамж гэж үздэг, үзэх вэ, өнөөдрийн төр ямар шүү мэдлэг мэдээлэлд тулгуурлаж аюулгүй байдлын болон хөгжлийн бодлогын шийдвэр гаргаж байна вэ, Монгол Улсын алсын хараа, хөгжлийн бодлого ямар байна вэ, үнэт зүйл нь юу вэ гэдэг талаар судлах, хариулах шаардлага байгаа юм.

Монголчуудын 95 хувь нь бичиг үсэгтэй, гадаадад боловсрол эзэмшсэн сайн боловсон хүчинтэй, оюун ухааны чадавх дээгүүр IQ сайтай<sup>168</sup>, гурван сая иргэнтэй 60 сая малтай, харьцангуй том 1.5 сая илүү м квадрат газар нутагтай, хүн ам сийрэг суурьшсан, “Монгол Улс яагаад гуч гаруй тэрбум долларын өрөнд орчихоод сууж байна вэ? Газрын доорх баялгийнх нь ашгийн дийлэнх нь гадаадынханд ноогдож байна вэ? Яагаад хэрэглээгээ бүтээдэггүй хэрэглэгч улс болчхов оо? Яагаад Монгол Улс зөвхөн гадаадын банкнуудаас зээл авч байж амь тариа тариулсан мэт түр амь орж оршин тогтнодог ийм хөгжлийн загвартай болчхов оо? Яагаад боловсролтой, чадвартай залуус нь гадаад руу дүрвээд байна вэ? гэж эрдэмтэд судлаачид, улс төрчид, иргэд асуудал тавих боллоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Ерөнхий сайд байхдаа “...Тогтвортой улс төр, тогтвортой бодлогогүй, сахилга, хариуцлага алдагдсан, дураараа авирладаг байдал газар авсан, тооцоо судалгаагүйгээр их хэмжээний өр тавьж, үр дүнгүй зарцуулсан, хүнд суртал, дарамт их байснаас олон мянган аж ахуйн нэгж хаалгаа барьсан, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдсан зэрэг нь монголчууд бидний өмнө тулгарсан зовлон. Зовлонгийнхоо шалтгааныг олсон учир засаж залруулах үүднээс шударга ёс тогтоож, төрийн албаны бүх шатанд сахилга, хариуцлагыг чангатган, хатуу шаардлага тавьж ажиллаж байна”<sup>169</sup>.

<sup>167</sup>“Хөгжил ба байгалийн баялаг судалгаа” форум дээр хэлсэн үг

<sup>168</sup>Монгол Улс багийн дүнгээр “Ой тогтоолтын дэлхийн аварга боллоо” (2018.05.14)... өндөр чансаатай 21 орны 130 гаруй тамирчин харааны болон сонсгөлыг сорьсон ой тогтоолтын 10 төрлөөр нийт 90 медалиас 57 медалийг нь хүртэн багийн дүнгээр 22531 оноо цутуулан үнэмлэхүй ялалт ...

<sup>169</sup>У.Хүрэлсүх Увс аймгийн иргэд, хөдөлмөрчидтэй уулзах үедээ хэлсэн үгээс

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ "...уул уурхай, тэр дундаа нүүрс тойрсон далд эдийн засаг тэдний төлөөллийг хангасан улс төр, бизнес, хууль хяналтын байгууллагын бүтэн сүлжээ амь бөхтэй оршин тогтнож байна. Нүүрс болон зэсийн судсыг авлигаас бүрэн чөлөөлөхгүйгээр Монгол Улс хөгжил дэвшлийн тухай, иргэдийн баян, ядуугийн ялгаа хэт гүнзгийрсэн орлогын тэгш бус байдлыг арилгах тухай, ард түмний сонголт мөнгөнөөс ангид байж, шударга төр засаг байгуулах тухай, Үндсэн хуульдаа тунхагласан хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоох тухай ойлголт байх ямар ч боломжгүй нь гашуун бөгөөд бодит үнэн билээ. Иймд. Нэг. Орлогын тэгш бус байдлыг арилгах, хоёр. Иргэний төлөөлөх эрхийг хангах, гурав. Хариуцлагын тогтолцоог чангатгах талаар хууль эрх зүйн өөрчлөлтүүдийг Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлж байна”<sup>170</sup> гэсэн.

Г.Занданшатар “Монгол Улс нутаг дэвсгэр, баялгаараа дэлхийд эхний 20 дугаарт багтдаг. Нэг хүнд ногдох газар нутаг, мал сүргийн тоогоор дэлхийд тэргүүлдэг хэр нь гурван хүний нэг нь ядуу амьдарч байна.”<sup>171</sup>

УИХ-ын дарга, гишүүн асан Д.Лүндаажанцан "...Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын Үндэсний хөгжлийн үзэл баримтлалыг баталсан. Харамсалтай нь гарч ирсэн Нам, Засгийн газар нь хэрэгжүүлэхгүй байгаагаас Монгол Улс хөгжихгүй байна. ...Сахилга бат УИХ-аас эхлэх ёстой.”

Ж.Андерсон “Ихэнх тохиолдолд монголчууд том шийдвэр гаргахынхаа өмнө тооцоо судалгаа төдийлөн сайн хийдэггүй, эрсдэлээ тооцдоггүй. Улс төрд гарсан өөрчлөлт бүх зүйлийг өөр тийш нь эргүүлчихдэг. Нэг засгийн газар гараад л хөгжлийн чиглэлийг нэг тийш нь залдаг бол, дараагийн засгийн газар нь чиглэлээ бүрэн өөрчилдөг. Тэгэхээр бодлогын орчин тогтвортой байх, том хэмжээний зээл, төслийг эхлүүлэхийнхээ өмнө эрсдэлийг сайн тооцох нь Монгол Улсад зайлшгүй шаардлагатай гэж би үздэг”<sup>172</sup>.

Америкийн нэрт түүхч, Монголын ардчиллын талаар ном бичсэн Моррис Россabi “...Монголын шунахай олигархи удирдагчдыг хятадууд гартаа бүрэн оруулж монголын ашигт малтмалын лицензийн 70 хувь, эрчим хүч, төмөр зам, авто зам зэрэг бүтцийн салбарыг хянаж эхлээд байна...” гэлээ.

УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан “Нэг Засгийн газрын амьдрах хугацаа 1.8 жил гэхээр, яаж бид хөгжих вэ”. ШУА-ийн Дэд Ерөнхийлөгч асан Т.Дорж төрийн бодлого боловсруулах талаар “Шинжлэх ухааны байгууллагуудыг юунд ч оролцуулахгүй байна гэсэн. Эдгээрээс дүгнэхэд, Монголын өнөөгийн бүх бэрхшээл, хямралын үндсийн үндэс нь засаглалын чадамж төрийн ой санамжийн чадавхтай холбоотой бөгөөд энэ нь манай зонхилох улс төрчдийн мэдэгдэл төдийгүй гадаад, дотоодын судалгааны төвүүд, бусад байгууллагын судалгаагаар нотлогдож байна.

Төрийн ой санамж охорхон байвал төрийн удирдлага, төрийн албаны тогтолцоо төлөвшихгүй улс орноороо хүний үгээр буруу тийшээ будаа тээх, төр

<sup>170</sup>Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ УИХ-ын нэгдсэн чуулганд үг хэллээ” (2022.12.15)

<sup>171</sup>Г.Занданшатар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монголын эдийн засгийн форум: Монгол Улс. 2016 оны байдлаар хүний хөгжлийн индексээр 188 орноос 92, аз жаргалын индексээр 140 орноос 136, өрсөлдөх чадварын индексээр 138 орноос 102, Логистикийн гүйцэтгэлийн индексээр 160 орноос 108, амьдралын чанарын индексээр 192 орноос 107, байгаль орчны багц үзүүлэлтээр 140 орноос 111, бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр 190 орноос 64 дүгээр байр тус тус эзэлсэн байна.

<sup>172</sup>Монголчууд том шийдвэр гаргахын өмнө судалгаа хийдэггүй, эрсдэлээ тооцдоггүй. -“Зууны мэдээ” сонин, 2018 оны 7 сарын 18,

засаг шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлаж шийдвэр гаргадаггүй бол зорилго зорилт нь хэрэгждэггүй түр зуурын болж эдийн засгаа сүйрүүлэх, мэдээллийн технологид суурилсан сангүй бол авлигад идэгдэх, иргэд төрөө дээдлэхгүй байж нийгмийн ёс суртахуун доройтох эрсдэл өндөр байдаг байна.

Үндэсний түүх нэгдмэл болж чадаагүй бол нийгмийн зөрчил, сөргөлдөөнийг дагуулдаг, шашны асуудлаа шийдээгүй улс үндэстэнд хүчирхийлэл тасардаггүй, дайн байлдаанд ч хүргэдэг жамтай.

Засаглалын чадамж нь үндэсний ой санамжийн нэг бүрэлдэхүүн төрийн ой санамжаар өөрөөр хэлбэл төр хир зэрэг өөрийн ухаанаар сэтгэдэг, шийдвэр гаргадаг нөхцөл, боломжоор хамгийн гол нь төрийн түшээдийн мэдлэг чадвараар тодорхойлогдох учиртай.

Монголчууд бид ухаант хүмүүс мөн л юм бол эдгээрийн учрыг одоо олж тогтоож арилгах цаг нь болжээ. Уг нь монголчуудын оюун ухааны чадавх дээгүүр болохоо тэмцээн уралдаанаар дэлхийд нэгэнт танигджээ<sup>173</sup>.

Тэгээд ч төрийн тэргүүн асан хүмүүс, түшээд, эрдэмтэн судлаачид сүүлийн үед хөгжлийн асуудлуудыг хөндсөн ном, нийтлэлүүд ихээхэн бичдэг болжээ<sup>174</sup>. Төрийн түшээд: Ерөнхийлөгч асан П.Очирбат “Ардчилсан социалист үзэл баримтлал”, Б.Багабанди “Гуравдагч зам сайн засаглал”, Н.Энхбаяр “Том төрөөс ухаалаг төр лүү”, “Ардчиллын үзлийг тээгч үндэсний асуудал”, Ц.Элбэгдорж “Үндэсний эв нэгдлийн асуудал”, Намын дарга асан Б.Даш-Ёндон “Сэтгэл бодрол, философи”, УИХ-ын дарга асан Д.Лүндээжанцан “Эрх мэдлийн хуваарилалт”, Академич С.Нарангэрэл “Чингис хааны сүр хүч” зэрэг бүтээлүүд хэвлүүлжээ. Гэвч нэгдсэн байр сууринд хүрэх байтугай хэн ч эдгээрт шүүмж бичээгүй байна.

Судлаач Ж.Бор, Д.Баатар... “Бид төр нийгмийн асар өндөр уламжлалтай атлаа бусдаас хуулбарлах гэж оролдох, бусдыг сармагчин мэт дуурайх шаардлага бий гэж үү?” гэсэн бол Японы эрдэмтэн Н.Икеда “Агуу ой санамж бүхий Их Монголын ухамсрыг дахин сэргээх...” гэсэн нийтлэл бичсэн байдаг.

Л.Түдэв<sup>175</sup> “Эцэст нь монголчууд онцгой ухаан сийлж чадах тухай хоосон магтаал цувуулсангүйгээ учирлая. Хүний оюун ухааны хэмжүүрийг аль эрт тогтоосон бөгөөд монгол хүний тархи нь 1382 грамм байдаг ажээ. Тэр нь цагаан арьстных 1330 грамм, хар арьстных 1280 грамм байдгаас 52 граммаар илүү (IQ) гэсэн үг юм. Хэрвээ ирэх зуунд байгалийн онцгой үзэгдэл болохгүй бол хүн төрөлхтөн оюун ухаанаа шүтнэ. Тэгвэл монголчууд гарцаагүй түрүүлнэ. Тэдний тархи хамгийн том” нь гэж Герман эрдэмтэн О.Форте бичжээ.

Судлаач П.Дэлгэржаргал “Сэтгэлгээний нэгдмэл байдал улс орны хөгжлийн хамгийн үнэтэй зүйл, энэ бол “тусгаар тогтнолоос” үнэтэй зүйл. Сэтгэлгээний адилсалгүй бол улс орон хөгжихгүй энэ бол харин алдагдвал бараг сэргээгдэх боломжгүй.”<sup>176</sup>

Зохиолч Зундуйн Дорж монголчууд “хэл, хил, мал” гуравтайгаа байхад Монгол

<sup>173</sup>Монгол Улс IQ-аар дэлхийд 6-д, багийн дүнгээр “Ой тогтоолтын дэлхийн аварга боллоо” (2018.05.14) 08 сар “... өндөр чансаатай 21 орны 130 гаруй тамирчнаас багийн дүнгээр 22531 оноо цуглуулан үнэмлэхүй ялалт “...Дэлхийн казинод орохыг хориглосон монгол хүүхэд”.

<sup>174</sup>Ж.Бор., Д.Баатар “Монголчууд бидэнд хуулбарласан нийгэм хэрэгтэй гэж үү? Н.Жалбажав “Төрийн бодлогын тулгар асуудалд” гэх мэт.

<sup>175</sup>“Монгол түмний эрхэмлэн шүтэх дээд оюун санаа” -“Зиндаа” сэтгүүл, 2017.10.09, №02/502

<sup>176</sup>П.Дэлгэржаргал “Тусгаар тогтнолоос илүү сэтгэлгээний нэгдмэл байдал хамгийн үнэтэй нь” Упаанбаатар, 2012.06.07

монголоороо байна” гээд газар шорооны төлөө тэмцэж байлаа.

Доктор Н.Жалбажав “Монгол хүн, монгол оюун ухаан, монголын түүх, монгол өв соёл, монгол урлаг, монгол ёс заншил, уламжлал бол улс эх орны бахархал, үнэт зүйл байх ёстой.”

Доктор Б.Даш-Ёндон “Монгол үндэстэн өөрийгөө болон хүсэл зорилгоо ухаарч, өөрийнхөө төлөө идэвхтэй тэмцэх цаг тулж ирлээ<sup>177</sup>”.

Ерөнхийдөө уламжлалаа судлах, хадгалах өвлүүлэх талаар монголчуудын хоёр янзын байр суурь ил тод харагддаг. Даяаршлын өнөө цагт монголоороо үлдэхийн тулд уламжлалаа түгээн дэлгэрүүлж, өвлүүлэх нь зүйтэй гэж үзэж байхад бусдын адил байх нь илүү дээр гэх байр суурь бас бий. Бидний судалгааны үр дүнгээс харахад ахмад үе уламжлалын үнэт зүйлсийг чухалд тооцож байхад харин залуу үе уламжлалыг тийм чухал биш гэж үзсэн байна.

Өнөө үеийн залуус хүн өөрийнхөө амьдрал, сайн сайхан байдлын төлөө өөрөө л хариуцлага хүлээнэ гэсэн ойлголттой төлөвшиж байна. Энэ байдал дэлхий нийтийн хөгжлийн хандлага индивидуалист соёлыг хөхүүлэн дэмжсэн шинжтэй байгаатай холбоотой. Хувь хүний хариуцлага, хувь хүний идэвх санаачилга, оролцоог хангахыг дэмжсэн үзэл санаа төрийн бодлогуудад шингэж байна.

Энэ бол даяаршлын эринд Монгол Улс, монголын соёл иргэншлийн тусгаар байдал, өвөрмөцөөр оршин нийт хүмүүн төрөлхтний “өнөр бүлийн өнгө булаалдах цэцгийн мандлын нэгэн сор нь байх” гэсэн Д. Лүндээжанцангийн хэлсэн үг нь зэрэг нь бүгд үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэх оюуны дархлааны тухай цаад утга бүхий бодол санааг шингээсэн юм.

Ёс суртахуун бол үндэсний ухамсар, ой санамжийн “чөмөг”, ноён нуруу нь гэж үзэх нь ч бий. (Л.Түдэв., С.Нарангэрэл). Ч.Лодойдамба “Ерөөс харьяат иргэнийхээ сэтгэл оюуны, ноён нурууг хугарч нугарах элдэв нигуураас хамгаалж, үндэсний ухамсар, ой санамжаа бэхэлж байх нь төрийн байнгын үүрэг нь бус уу.”

Төрийн хамгаас чухал үүрэг нь иргэндээ, эх орондоо, шударга хөдөлмөр, авьяас билгээрээ сэтгэл хангалуун аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх хэрэг мөн.

Манай нийгэмд сайн ажиллавал сайхан амьдрах бололцоо бий гэсэн хүмүүс 1998 онд 25.3 хувийг эзэлж байсан бол 2013 оны үед нэмэгдээгүй байсан байдаг<sup>178</sup>. Давхраажилтыг судалж, иргэдийн орлогын хэт тэгш бус байдлыг арилгах, дунд давхаргыг бий болгох талаар олон асуудал байгааг одоогийн төр засгийн удирдлага хүлээн зөвшөөрч ярих болжээ<sup>179</sup>.

Бидний судалгаа хийж эхлэхэд “Сант марал сан” 2018-ийн хийсэн судалгаагаар иргэдийн 87.3 хувь нь төрдөө, улс төрчдөд итгэх итгэлгүй болсон байсан.

Өнөөдөр гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн бидний нийгмийн харилцаа, үнэт зүйлс ихээхэн өөрчлөгдөж баян ядуу, хот хөдөө цаашлаад улс төрийн үзэл бодол, нийгмийн гарал байдал, шашин шүтлэг зэргээрээ ялгаа зааг ихээхэн гарах болжээ. Энэ нь яваандаа үнэт зүйлсийг бүдгэрүүлж, нийгмийн оюун санаа, эв нэгдэлд эрсдэл үүсгэж болзошгүй юм.

<sup>177</sup>Б.Даш-Ёндон “Үндэстэн өөрийгөө ухамсарлахын учир” -”Манай Монгол” сэтгүүл, 1999 он, №3, 274-р тал

<sup>178</sup>Г.Чулуунбаатар., Д.Даш-Ёндон “Монголын нийгмийн өөрчлөлт” УБ., 2013 он, 185-р тал

<sup>179</sup>Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ УИХ-ын нэгдсэн чуулганд үг хэллээ. (2022.12.15)

Аливаа үндэстэн өөрийн болон бусдын түүхийн сургамжаас байнга суралцаж, түүхийн алдаа оноогоо дэнсэлсэн ой санамжтай байж түүндээ түшиглэн үндэсний үнэт зүйлсээ тодорхойлж нэг зорилго алсын хараатай нэг үндэстэн байж, төр засаг нь бодитой мэдлэг, мэдээлэлд тулгуурлаж аюулгүй байдлаа хангах, улс орны хөгжлийн бодлого шийдвэрээ гаргадаг байж хөгждөг жамтай ажээ.

Хэдийгээр Монгол Улс ардчиллын замаар эргэлт буцалтгүй орж, хүн ард нь хүний эрхээ бодитой эдэлж, даяаршлын үр шимийг ахуй амьдралдаа хангалттай хүртэх болсон хэдий ч өнөөгийн Монголын Улс төр, эдийн засаг, нийгмийн байдал иргэдийнхээ сайн сайхан амьдрал, улс орны аюулгүй байдлыг хангах хэмжээнд хангалттай хүрээгүй байгаа нь үндэсний ой санамжаа сэргээж түүнийг үндэсний аюулгүй байдлаа хангах үйл ажиллагаанд илүү үр дүнтэй ашиглах шаардлага байгааг харуулж байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Ийм цаг үед үндэсний ой санамж нь түүхээсээ сайн оноо туршлага, муу алдаа сургамжаа тодруулах нь чухал юм.

Хоёр. Туршлага, сургамж

А. Туршлага

Үндэсний ой санамж нь үндэсний аюулгүй байдалтай холбогдохдоо юуны түрүүн улс орны тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, үйл ажиллагааны туршлагаа таньж мэдэх шаардлага тулгардаг.

Чингис хааны удирдан жолоодох мэргэн ухаан “Алд бие минь алжааваас алжаатугай, Ахуй төр минь бүү алдраг” алтан сургаал түүний үндэслэсэн “Их засаг” хууль нь монгол үндэстэн, монгол төрийн бодлогын чиг баримжаа нь болсоор иржээ.

“Чингисийн удмын ноёд бол төр ёсны гүн ухааны томьёоллуудтай “төрийн уламжлалтай нийгэм”-ийн удам дамжсан засаглагчид, төр, цэргийн зүтгэлтэн нар байсан бөгөөд оюуны соёл, үндэсний тусгаар тогтнол, эх оронч үзлийн ой санамжийг тээгчид байсан юм. Жишээ нь:

1. Чингис, Өгэдэй, Гүюг, Мөнх, Батмөнх нарын хаад нутгийн төв хэсэг, гол уугуул овог, отгоо төдийгүй стратегийн чухал газар орнуудыг нүүдлийн аргаар халхлах, хамгаалах нүүдэлчдийн төрийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж гадаад, дотоод, дотор талын хамгаалалтын арга хэмжээг тухай бүрдээ авч хэрэгжүүлж чадаж тэр хэмжээгээр улс орны аюулгүй байдал баталгаажиж байжээ.

2. Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан “Монголын нууц товчоон” түүний үргэлжлэл болох Хувилайн хааны үеийн “Нууц товчоон”, Хулагу хааны үеийн “Судрын чуулган”, дундад зууны алтан ургийнхан голдуу бүтээсэн “Алтан товч”-ууд, Гүүш Лувсанданзангийн “Алтан товч”, Гомбожавын “Чингис эзний алтан ургийн түүх Гангын урсгал нэрт бичиг оршибай” (1725), Халхын Галдан туслагчийн “Эрдэнийн эрих”<sup>180</sup> (1810/1), “Эртний монголын хаадын үндэсний их Шар тууж оршвой”<sup>181</sup> зэрэг XVII-VIII зууны үеийн монгол хэлний сурвалж бичгүүд, 1911 оны үндэсний эрх чөлөөгөө сэргээсэн богино үед хийсэн бүтээсэн “Монголын нууц товчоон”-ы Цэнд гүний хөрвүүлэг, 1921-1937 оны хооронд цагаан ястан А.Амар

<sup>180</sup>Галдан “Эрдэнийн эрих хэмээх түүх болой” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал”.

Хэвлэлд бэлтгэсэн Ц.Насанбалжир; монгол бичгээс хөрвүүлж, эхүүдийг харьцуулан тулгаж, оршил бичиж, тайлбар хийсэн Ж.Гэрэлбадрах., Д.Бүдсүрэн., П.Бямбахорол. Улаанбаатар, 2006 он

<sup>181</sup>“Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршвой”. -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-VII” монгол бичгээс харгуулан хөрвүүлж, тайлбар, хавсралт хийсэн Ц.Шагдарсүрэн., Э.Мөнх-Ундрал. Улаанбаатар, 2006 он

нарын бүтээсэн түүхийн номууд, Ц.Дамдинсүрэнгийн орчин цагийн “Монголын нууц товчоон”, 1990 оноос хойших сэргэн мандлын үеийн бүтээлүүд бүгд нийлээд “Монголын нууц товчоон” үеийн үед алтан урагтан, сэхээтнүүдээр дамжин тасалдалгүй амьд хөгжиж ирснийг батлан харуулж, монголчуудын үндэсний ой санамж тасраагүй үргэлжилж байгааг илтгэх жишээ болж байдаг.

Түүх сөхвөл, Эзэн Чингис хаан “Мөнх тэнгэрийн хүчин доор” уриан дор дэлхийг эзэгнэх, улс орныхоо аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг эхлүүлж, амжилттай хэрэгжүүлж байсан бол түүнийг залгамжилсан дараагийн хаад, удирдагчид Богд эзэн Чингис хааны үйл хэрэг, сургаал хуулийг үргэлжлүүлэх зорилготой төрийн бодлогоор иргэдээ манлайлан удирдаж иржээ.

Дэлхийн аугаа хүн Чингис хааны үндэслэсэн Монгол төрийн бодлого Юань гүрний үед хэтэрхий том үндэстнийг захирах болсноос үүдэн монгол үндэсний эрх ашиг “хаягдах” хандлагатай болж, “Ляо дуны хойгийн монгол захиргааг болих, далайд гарах гарцаа алдсан” гэх мэт олон сургамжтай үйл явдал өрнөсөн бол улс төрийн бутралын үед үндэсний ой санамж ихээхэн суларсан байдаг.

Юань гүрний үед төрийн хууль, журмаа суурин иргэнийг захирах үүднээс хуучин Тан, Сүн улсын хууль цаазыг өөрчилж, монголын хууль цааз болон монгол төрийн үзэл баримтлалыг нийцүүлсэн Их Юань улсын нэвтэрхий хуулийг дагаж байсан нь улс төрийн бутралын үеийн нүүдэлчин монголчуудад илт таарахгүй болсон байсан. Энэхүү хуулиудаа шинэчлэх үйл ажиллагаа удааширсан нь дотоодын зөрчил самуунаас болсон юм.

Манжийн эрхшээлийн үе бол цаг үе гадаад, дотоодын олон хүчин зүйлээс болж монгол түмний Голын улс болох Халхын ханлиг тусгаар тогтнолоо алдсан болохыг хүн болгон мэдэж байх ёстой үйл явдал юм.

Үндэсний ой санамж манжийн хараат болсноор идэвхгүй болж бүдгэрсэн билээ. Манж чин улсын үед монголчууд гадаад ертөнцөөс тусгаарлагдан газрын мухарт “харанхуй бөглүү” байсан ч “хил, хэл, мал” гуравтай байсныхаа ачаар тэсэж үлдсэн ч гэдэг.

1911 онд Халхын хан, ноёд хятадуудын хүсэж байсан шиг Халхын ханууд хоорондоо эрх мэдлээ булаалцалдалгүй Богд гэгээний тэргүүлэл дор эрх чөлөөний тэмцлээ хийж амжилтад хүрсэн нь “Төрийн нарийн бодлого хэвээр” оршсоор байсны нэг баталгаа мөн.

1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн “Шашин, үндсээ аврах” уриа үнэт зүйлсээр иргэдээ дагуулсан бол, 1921 оны хувьсгалчид “тусгаар тогтнолоо сэргээх “уриагаар эхэлж 1924 оны үндсэн хуулиар “Эв хамт нийгмийг байгуулах”, “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн” гэсэн уриа-үнэт зүйлстэй болсон нь 1990 он хүртэл үргэлжилсэн билээ.

1990 оноос ардчилал, хүний эрхийг эрхэмлэсэн уриа эрхэмлэх зүйлсийг “Үндсэн хууль”-иар тунхаглаж үндэсний эрх ашиг, тусгаар тогтнолоо эрхэмлэсэн гадаад бодлогоо монгол төр хэрэгжүүлж ирлээ.

Монгол үндэсний түүх дэлхийн бусад улс гүрнээс өвөрмөц бөгөөд энэ нь монголчууд нүүдэлчин ахуйгаа энэ зууныг гартал бүрэн хадгалж ирсэн, сүүлийн зуунд л суурьшиж эхэлсэн, хөрш улс гүрнүүдтэй харьцуулбал цөөхөн хүн амтай үндэстэн байсаар ирсэн ч түүхэн үүрэг нь харьцангуй өндөр байсан зэрэгтэй холбоотой юм. Эдгээр өвөрмөц онцлог нь аюулгүй байдлаа бататган сахих өвөрмөц



арга барилыг шаардсаар ирснийг эх орончдын намтрууд харуулдаг.

Түүхээсээ ялангуяа эх орончдоосоо суралцаж, тэднийгээ ой санамждаа үргэлж хадгалах, олон нийтэд сурталчлах нь үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэх нэг чухал үйл ажиллагаа билээ.

Үндэсний ой санамж түүхэн баримт, туршлагаас манай улс төрчид суралцах төдийгүй олон нийт мэдэрч, мэдэж байх шаардлага жижиг үндэстний хувьд байсаар байгаа юм. Да лам Цэрэнчимэдийн монголоо гэсэн хатуу байр суурь, өөрийн толгойгоор бодож өөрөө өөртөө эзэн байх ёстой гэсэн монгол төрийн хүний тэмцэл өнөөдрийн монгол төрийн түшээдэд ус, цас мэт хэрэгтэй жишээ билээ.

Монголын Түр Засгийн газрын анхны дарга буюу ерөнхий сайдаар Түшээт хан аймгийн Чуулганы дарга, түшээ гүн Чагдаржав томилогдож, Монгол Улсын анхны төсөв санхүүг бүрдүүлэх, захиран зарцуулах, зэвсэг хэрэгсэл худалдан авах, улсын сангийн орлогыг нэмэгдүүлэх, татварын бүрдүүлэлтийг цэгцлэх, байгалийн баялгаас олох орлогыг нэмэгдүүлэх, худалдааны бодлогод шинэчлэл хийж улс орноо маш богино хугацаанд улс шиг улс болгохын төлөө амсхийх чөлөөгүй зүтгэсэн билээ.

Г.Чагдаржав нь 1906 онд Цэций Таван толгойн нүүрсийг манжуудад ашиглуулахаас түдгэлзэх бичиг өгч байв. 1911 оноос хойш Да лам, Г.Чагдаржав нар алтны концесс зэрэг эдийн засгийн асуудлаар Монголын эрх ашгийг хамгаалан тэмцэл хийж байгаад амь эрсэдсэн билээ.

Өнөөгийн Таван толгойн нүүрсний хулгай, 33 тэрбум долларын гадаад өр тавиад байгаа монголын шинэ үеийн улс төрч түшээдийн хувьд Да лам Цэрэнчимэд, Г.Чагдаржав нарын гааль, татварын талаарх үйл хэрэг, ёс суртахуун эх оронч үзлийн үлгэр жишээ мөнөөс мөн билээ.

Богд гэгээн Монгол Улсыг дахин сэргээн байгуулах үеэс “Төрийн түшээдийг томилохдоо хөрөнгө орлогын мэдүүлгийг авах үйл ажиллагаа”-г эхлүүлж байв.

Богд хаант Монгол Улсын шинэ тулгар яамдын сайд, дэд сайдууд “дотоодод болбоос туйлын үнэн шударгыг илэрхийлэн, гадаадад болбоос аюулт дайсныг аянга цахилгаан мэт буцалтгүй улсын сүрийг бадруулан хаан эзний өмнөөс шашин, төрийн тул зүтгэхэд хялбарыг эрэхгүй, бэрхээс зайлахгүй, эдүгээгийн байгуулсан төрийн тул энэхүү батлан тогтоосон тангараг сахилгыг нүдний цөцгий, зүрхний тольт мэт хичээнгүйлэн хайрлана” хэмээх тангаргийг өргөдөг байжээ.

Чингисийн удмын “цагаан ястнууд<sup>182</sup>”-аар дамжин ирсэн төрийн бодлогын ой санамж 1937 оны тэднийг хоморголон устгаснаас<sup>183</sup> болж тасрахаа дөхсөн ч Ерөнхий сайд асан А.Амар, Х.Чойбалсан, төрийн түшээ Ж.Самбуу, С.Лувсан нараар дамжин янз бүрийн хэлбэрээр улс төр, үзэл суртлын орчинд дасан зохицон өнөөдрийг хүрсэн байх магадлалтай.

Чингис богдын удам угсааг хүйс тэмтрэх, үндэсний сэхээтнийг хомроглон устгахын жинхэнэ эзэд нь харийнхан байсан бөгөөд цаад далд санаа зорилго нь

<sup>182</sup>Ярилцсан. Б.Анхцэцэг, MNN: 2013.03.01. Аюурын Самбуу /Биологийн ухааны доктор, профессор, Буриад Улсын Шинжлэх Ухааны Гавьяат зүтгэлтэн/ “Алтан ургийнхны удам монголын агуу нэгэн угсаа мөн” сэдвээр монгол хүний гений зарим асуудлын талаар ярилцлага хийв. “...Цагаан ястан гэж ...Алунгоо хатны хөвгүүдийн шууд удам угсаа, Чингисийн алтан ургийн үүсэл суурь болсон хүмүүсийг хэлдэг. ...Чингисийн төрөл садан болох алтан ургийнхан л их эзний үүсгэсэн эзэнт гүрний харь уудмыг эзэмшин захирахаар тарж тархан суурьшсан, тэд шинэ нутагтаа олон жил өнөржих өргөн боломжийг олсон өндөр зиндааны эрхмүүд байсан билээ.”

<sup>183</sup>Ч.Дашдаваа “Бүрэн эрхт төлөөлөгч Сергей Миронов” Упаанбаатар, 2014 он.



монголчуудын үндэсний ухамсар, бахархал, эв нэгдлийн үзэл санаа, тусгаар оршин тогтнох, хөгжин дэвжих хүсэл эрмэлзэл, чадавхыг нухчин дарах, үгүй ядахдаа л сулруулах хэрэг байсан нь шинэхэн түүхийн баримтаар ил болсоор байна.

Үндэсний ой санамж бол ерөнхий ой санамжийн нэг тусгай хэлбэр бөгөөд чухамдаа хамтын ой санамж юм<sup>184</sup> гэж эрдэмтэд үздэг. Энэхүү хамтын ой санамжийг бүрдүүлэгч түүхэн хүмүүсийн судлах нь үндэсний ой санамжийн үндэс, суурийг тавих нэг үйл ажиллагаа юм.

Өнөөдөр улс төрийн ээдрээтэй цаг үед ч ой санамжаа таслалгүй үргэлжлүүлж байсан төр, нийгмийн салбаруудад уламжлал, шинэчлэлийг зөв хослуулан үйл ажиллагаа нь амжилттай хөгжиж байна.

Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч “Үндсэн хууль” дээр гараа тавьж байгаад ард түмэн, төрдөө тангараг өргөдөг (гадаад орнууд шашны Библи, Коран судруудаа ашигладаг) бол цэргийн албан хаагчид үүргээ биелүүлээгүй бол “төрийн цээрлэл хүртэнэ” хэмээн цэргийн тангаргаа өргөдөг ёс журамтай. Түүнчлэн УИХ гишүүд болон эмч зэрэг тусгай үүргийн олон төрийн албан хаагчид тангараг өргөдөг болж төрийн албаны ёс зүйн дүрмүүдтэй болсон нь төрийн ой санамж, уламжлалын сайн зүйл мөн.

Өнөөдөр бид монголчуудын өвөг дээдэс энэхүү түүх, соёлыг бидэнд хэрхэн хадгалж, хөгжүүлж, өвлүүлж үлдээсэн түүхэн сургамжийг үндэсний ой санамжид тулгуурлан судалж байнга дүгнэж байх нь үндэсний аюулгүй байдлын төрийн бодлого боловсруулах үйл ажиллагааны суурь дэвсгэр болох ёстой юм.

Монголын төрийн түшээдийг туршлага, үйл ажиллагааг ой санамждаа хадгалж байхын сацуу үнэлж дүгнэж байх нь үндэсний ой санамжаа ашиглан төрийн удирдлагын чадавх чадамжийг дээшлүүлж, хариуцлагатай болгох нэг арга хэлбэрч байж болох юм.

Монгол үндэстнийхээ алс холыг харсан төрийн алтан аргамжийн бодлогыг Их Чингис хаан маань жинхэнэ ёсоор нь үндэслэж, хойч үедээ өвлүүлэн үлдээсэн нь бидний өвөг дээдсийн оюун ухаанаар дамжин өнөө үед ирсэн билээ. Энэхүү бодлогыг орчин цаг үетэйгээ нийцүүлэн сэргээж, Монгол Улс Үндэстнээ хөгжүүлэх төрийн үйл хэрэгт ашиглах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Монгол Улсын аюулгүй байдлаа хангах талаарх сүүлийн үеийн төр, засгийн чармайлтууд. Монгол Улс аюулгүй орших эсэх нь Орос-Хятадын харилцааны байдал, төлөвөөс шууд хамааралтай. Орос-Хятадын стратегийн түншлэлийн суурь хүчин зүйлс хэврэг байх талтай ч олон улсын тавцан дээрх өнөөгийн хүчний тэнцвэр энэ түншлэлийг тодорхой хугацаанд хадгалж, урагшлуулах шалтгаан болсоор байна.

Эдүгээ дэлхий шинэ “хүйтэн”, “халуун” дайны босгон дээр, эхлэлийнх нь шатан дээр байна. Манай хоёр хөрш бусад их гүрнүүдтэй дайсагналцаж байна. Дайсагнаж буй бүх улстай нь манай улс шат шатны түншлэлийн харилцаатай байгаа нь улам алсын хараатай үндэсний эрх ашгаа тэргүүнд тавьсан үндэсний аюулгүй байдлын бодлого хэрэгтэй болохыг илтгэж байна.

Цар тахлын нөлөөнд хамгийн их нэрвэгдсэн аж ахуйн нэгжүүд, ажил олгогчид, жижиг дунд бизнес эрхлэгчдээ дэмжих цогц арга хэмжээг Засгийн газар цар тахлыг даван туулах төлөвлөгөөнд тусгаж, үе шаттай шуурхай хэрэгжүүлэхээр ажиллаж

<sup>184</sup>James V. Wertsch National Memory and Where to Find It. DOI:10.1093/oso/ 9780190230814.003.0012

байна.<sup>185</sup>

Оюун санааны хөрш Энэтхэг Улсаас нефть шатахууны үйлдвэр барихаар тусламж авч ажлаа эхлүүлсэн. Эрхүүгээс Монголын нутгаар дайруулан БНХАУ хүртэл хийн хоолой тавих техник, эдийн засгийн үндэслэлийг хийхээр ОХУ-тай тохирсон нь чухал төсөл болох юм.

Төмөр, гангийн үйлдвэр, цемент, арьс шир, ноос боловсруулах үйлдвэр барих талаар бүтээн байгуулалтын томоохон төсөл, ажлууд өрнөх боллоо.

“Оюутолгой” төслийн хөрөнгө оруулагч, хувь эзэмшигч “Рио Тинто”, “Туркойз Хилл Ресурсес” компаниудаас Ерөнхий сайдын нэр дээр захидал ирүүлсэн. Уг захидлаар Засгийн газрын эзэмшлийн 34 хувьд ногдох нийт 2.3 тэрбум ам.долларын өрийг тэглэх, “Дубайн гэрээ”-г цуцлах, аудит оруулах, “Оюутолгой” төслийн гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх, 2023 оны эхний хагас хүртэлх нэмэлт зардлыг гадаадын хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцах, “Оюутолгой” ХХК-ийн засаглалыг сайжруулах, Монгол Улсын Эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулах, татварын актуудын биелэлтийг хангуулах цаашид нэг мөр ойлгож, дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрүүлж, хэрэгжүүлэх зэргээр Засгийн газрын саналыг хүлээн зөвшөөрсөн. Энэ талаарх УИХ-ын тогтоолын төслийг УИХ хэлэлцээд байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 12 сарын 7-ы өдөр хийсэн мэдэгдэлдээ “Чингис бондын 1.5 сая долларын зээлийн төлбөрийг хийлээ” гэжээ.

Үндсэн хуульд тусгасан өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй байх зарчим 1990-ээд оны эхэнд өрнөж байсан Монгол Улс байнгын армитай байх шаардлагатай эсэх тухай маргаанд цэг тавьж улмаар улс орны батлан хамгаалах тогтолцоо, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх эрх зүйн чухал үндэс болсон байна.

Аюулгүй байдлын салбарт олон талын хамтын ажиллагаа хөгжүүлж, монгол цэрэг олон улсын энхийг сахиулах, энхийг дэмжих ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн нь олон улсын хэмжээнд Монгол Улсын байр суурийг бататгах, цэрэг улс төрийн хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна<sup>186</sup>.

Улсын хилийг хуулиар бататгах үндсэн хуулийн зарчмын хүрээнд УИХ-аас Хилийн тухай хуулийг гаргаж улмаар хоёр хөрш оронтойгоо хилээ хамтран шалгаж, хилийн шугамаа тогтоон хилийн дэглэмийн гэрээнүүдийг байгуулсан<sup>187</sup> нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй байдлыг хамгаалахад томоохон алхам болжээ. Хил дээр үе үе гардаг иргэний сэдэлтэй, гэмт хэргийн шинжтэй зөрчлүүдийг эс тооцвол Монгол Улс хөрш орнуудтайгаа хилийн маргаантай асуудал байхгүйн зэрэгцээ хил хамгааллын чиглэлээр амжилттай хамтран ажиллаж байна.

## Б. Сургамж

<sup>185</sup> Монгол Улсын Ерөнхий Сайд лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ “Хаана хүрэхээ харахгүй бол тэнд хэзээ ч хүрэхгүй” The Economist, 2021

<sup>186</sup> Монгол Улсын Зэвсэгт хүчин нь анх 2002 онд цэргийн 2 ажиглагч офицерыг илгээснээс хойш өнгөрсөн хугацаанд дэлхийн 13 улс, мужид явагдсан 17 энхийг дэмжих ажиллагаанд давхардсан тоогоор 19 мянга гаруй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн байна. Өнөөдрийн байдлаар НҮБ-ын 13 энхийг сахиулах ажиллагаанд дэлхийн 119 орон цэрэг, цагдаагийн алба хаагч илгээж байгаагаас Монгол Улс 24 дүгээр байрт жагсаж байгаа нь хүн ам, зэвсэгт хүчний боломжтой харьцуулахад томоохон үзүүлэлт юм.

<sup>187</sup> “Монгол Улс Оросын Холбооны Улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын гэрээ” (2007); “Монгол-Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ” (2010)

Үндэсний ой санамж дахь аюулгүй байдал геополитикийн сонгодог сургамж төмөр замын бодлого юм. “Нарийн төмөр замаар танк орж ирэх юм уу” гэдэг улс төрчид монголд олон бий. “Хятадын төмөр замын үндэсний үзэл”-ийг 1894 онд Хятадын хувьсгалч Сүн Ят сен төмөр замыг “амьдралын судас” гэж нэрлээд үүнийг геополитикдоо ашиглах талаар номлож эхэлсэн байдаг. Сүн Ят сений “Jianguo Fanglue” (Үндэстнийг хөгжүүлэх стратеги) гэх ном нь төмөр замын үндэсний үзлийн талаарх ном бөгөөд 1912 онд Хятадын анхны Ерөнхийлөгч Сүн Ят сен болоод түүнийг хэрэгжүүлэх гэж байсан түүхтэй. Сүн Ят сен “Төмөр зам улсыг нэгтгэж, батлан хамгаалах чадварыг сайжруулна. Бүгд Найрамдах Хятад улсын мөхөл, сэхэл нь энэ арга хэмжээн дээр тогтоно” хэмээжээ. Сүн Ят сен “Төмөр зам барих асуудалтай хамтад нь шинээр суурьшигчдын асуудлыг шийдвэрлэх, төмөр замын дагуух газар нутгийг өөрийн болгох, колоничлох талаар анхаарахыг” зөвлөжээ. 1913 онд хятадууд Богд хааны засгийн газарт Бээжин-Жанчхүү-Бугат-Хүрээ гэсэн чиглэлийн нарийн төмөр зам тавих зургийг өгч, хэрэгжүүлэхийг шаардсан байдаг. Тэр цагт монголчууд “үндэсний эрх ашиг” гэдэг ганцхан хэмжүүрээр асуудлыг харж, татгалзсан хариу өгч чадаж байсан.

Сүний энэ бодлогыг Хятадууд Төвөд, Шиньжан, Манжуурт хан үндэстнийг суурьшуулахдаа ашиглаж, асар их туршлага хуримтлуулаад байгаа билээ. Төвөд рүү тавьсан өндөр хурдны төмөр зам нь эдийн засгийн хувьд ямар ч ашиггүй боловч геополитик, хан үндэстний суурьшлын хувьд өндөр ач холбогдолтой төсөл юм.

Ганц Монгол ч биш БНХАУ-тай хил залгадаг Мьянмар, Вьетнам, Лаос, Киргиз, Казахстан улсууд төмөр замын царигийн асуудалд өөрсдийн хатуу бодлого баримталдаг. Хятадыг тойрсон улсууд бүгд хятадтай эдийн засгийн харилцаатай байх, хятадын аварга зах зээлээс боломжоороо өөрсдийн өгөөжийг хүртэх эрмэлзэлтэй.

Вьетнам Улс гэхэд хятадын 1435 мм-ийн царигийг бус өөрсдийн 1000 мм-ийн царигийг хилийн худалдаандаа байлгах бодлогыг хатуу хэрэгжүүлдэг байх юм. Казахстан тодорхой хугацаанд хятад руу нарийн царигтай төмөр замаар худалдаа хийж үзээд, төд удалгүй больж, 1520 мм-ийн царигаа баримтлах болсон ажээ. Одоогоор Хятадын төмөр замын царигийг зөвшөөрсөн ганц улс болох БНАСАУ-ын эдийн засаг өнөөдөр Хятадын хяналтад оржээ.

БНХАУ-ын батлан хамгаалах үзэл баримтлалд “Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа хятадын иргэдийн эрх ашгийг хамгаалахын тулд цэрэг, зэвсгийн хүчийг ашиглана” гэж тов тодорхой заасан байдаг.

Доктор Э.Булаг бичихдээ<sup>188</sup> “Хятад хана хэрмээр өөрийгөө хамгаалж, тусгаарлагч улсаас тэлэх бодлогоо төмөр замаар хэрэгжүүлэгч улс болон хувирч байна. Иймээс төмөр зам барих нь улс төр, эдийн засгийг хамарсан геостратегийн асуудал болсон”

Хаалган-Хүрээг холбох төмөр зам тавихыг хятадын цэргийн эрхтнүүд 1920-оод онд ч хөөцөлдөж байв. Германы түүхч В.Хайссиг чухам Өвөр Монголд төмөр зам тавьснаар л хятадууд зам дагуу суурьшиж үржсэнийг баримттай бичжээ.<sup>189</sup>

Сталин 1937 онд БНМАУ-д цэрэг оруулснаа японы цэрэг монголоор дамжин Сибирийн төмөр замыг гэнэт таслахаас сэрэмжлэх зорилготой” гэж тайлбарлажээ.

<sup>188</sup>Р.Батсайхан /Харилцааны судлагч/ “Монголын эрх баригчдын эндүүрэл ба эмгэнэл” wikimon.mn 2019

<sup>189</sup>В.Хайссиг "Шар гүрэнтэй хаяа залгасан нутаг" Улаанбаатар, 2014 он

Квантуны арми Хянганы Солун хотоос Халуун рашаан хүртэлх төмөр замыг БНМАУ-ын хилд тулган тавьсан нь цэрэг стратегийн шахалт, өдөлт байсан.

ЗХУ-Хиагт-Улаанбаатарын 400 км урт төмөр замыг 1947-1949 онд тавьсан бол Улаанбаатар-Замын-Үүдийн хэсэг 1956 оноос ашиглалтад оржээ.

Одоо Хятадын тал манай улстай хиллэх найман боомт бүхий газрууддаа төмөр замын сүлжээ байгуулаад байна. Хятадын тал өөрсдийн сонирхож буй чиглэл, стандартын дагуу төмөр зам тавихаар манай улсад нэгэнт бий болгосон эдийн засгийн бусад салбарын давуу байдлаа ашиглан шахалт үзүүлэхийг эрмэлзэж байна. Эдүгээгийн манай өмнөд хилд тулган тавьсан төмөр замын хэд хэдэн шугам нь чухамхүү өдөөгч даралт шахалт<sup>190</sup> мэт.

Монголын төмрийн хүдэр, нүүрсний нөөцөд хятадууд хөрөнгө оруулалтаа нэгэнт хийсэн, одоо хямд өртгөөр тээвэрлэх сонирхолтой. Үүнийг нь ашиглан Монгол Улс төмрийн хүдэр, нүүрсээ богино хугацаанд өндөр ашигтайгаар зарья гэвэл мэдээж нарийн царигтай төмөр замтай байх нь илүү дээр. Гэвч үүнийг төрийн бодлогын төвшинд зөвшөөрөх тохиолдолд Монгол Улс хятадын төмөр замын сүлжээний нэг хэсэгт багтаж, эдийн засгийн болон бусад харилцаагаар хэт хурдацтай интеграцчилалд орох болно гэсэн үг. Энэ нь үндэсний аюулгүй байдалд асуудал үүсгэхээс гадна үүнээс ч илүү урхагтай зүйл нь гэвэл бид өнөөдөртөө эдийн засгийн үр ашиг хүртэж болох ч энэ ашгаа хөгжил болгон жолоодох потенциал маань хараахан бүрдээгүй байгаа явдал<sup>191</sup>. Уг нь Таван толгой, Оюутолгой, Цагаан суварга зэрэг стратегийн ач холбогдол бүхий орд газруудын ашигт малтмалыг ямар маршрутаар тээвэрлэн, хэнд нийлүүлэх тухай асуудал бол өргөн утгаараа далайд гарцгүй, хоёр гүрний дунд орших орны хувьд энэ нь геополитикийн амин чухал асуудал юм.

Р Болд “Соёл иргэншлийн гэгдэх XXI зуунд ч төмөр зам бусдыг шийтгэх хэрэгсэл хэвээр байгаа бололтой. Ашиг сонирхол мөнх гэдэг шиг их гүрнүүдийн бодлогын мөн чанар хэзээ ч өөрчлөгдөхгүй харин хэлбэр, арга нь л өөрчлөгдөх бөгөөд энэхүү өнгө аясын өөрчлөлт л бусдыг хууран төөрөгдүүлдэг билээ. Төмөр замын бодлогыг ашигтай, ашиггүй гэдгээр бус улс төр, стратеги, хөгжлийн сонирхлоо харгалзан төр тодорхойлох бөгөөд эдийн засгийн хохиролтой байлаа ч төмөр зам тавих тохиолдол байдаг. Алдагдалтай тавьсан ч ашигтай ажиллуулдаг болгох нь эдийн засагчдын үүрэг юм”<sup>192</sup> гэсэн бол Өвөр Монгол гаралтай Кембрижийн монгол судлаач У.Булаг “Монгол Улс холбогдохоосоо эмээхээсээ илүү хөршийн асар том замын сүлжээнд дарагдахаас болгоомжилж байна”<sup>193</sup>.

Мөн геополитик гэхээр төмөр замаар цэрэг ороод ирэх л асуудал гэж явцууруулах нь энэхүү асуудлыг санаатай бүдгэрүүлж байгаа улс төр, эдийн засгийн явцуу бүлэг эсхүл гадаадын нөлөөнд орсон хүмүүсийн зориудын явуулга мөн. Уул уурхайн холбооны Дамба шиг “мэргэжилтнүүд” нөгөө талаас буюу нарийн төмөр зам тавихгүй бол болохгүй гэх нь яагаад ч юм элбэгшив.

<sup>190</sup>2002 оны арван нэгдүгээр сард БНХАУ “техникийн шалтгаанаар” монголтой холбосон төмөр замаа сарын хугацаатай хаах мэдэгдэл ирүүлж, холр хоногийн дараа нээж билээ. Энэ хугацаанд Замын-Үүд, Эрээнд манай 700 гаруй иргэн саатаж, “Нарантуул”-ын барааны зах нимгэрэн, ойр орчмын арав гаруй аймгийн хангалт мэдэгдэхүйц суларсан байв.

<sup>191</sup>Ч.Сосорбарам “Үндэсний хөрөнгөтнүүд ба аюулгүй байдал” УИХ-ын АБГББХ-ны хэлэлцүүлэгт тараасан судалгаа. УБ., 2016 он

<sup>192</sup>Болд.Р “Монголын геополитикийн зарим асуудлууд” Удирдлагын академи. УБ., 2018

<sup>193</sup>УБулаг “Хятадын төмөр замын үндэсний үзэл ба Монгол”

Тэртэй тэргүй хил дээр буулгаад байхад авахгүй байгаа нүүрсийг<sup>194</sup> шороон замаар, хар замаар, төмөр замаар тээвэрлэв үү гэдгээс биш хятадын том бодлогоор худалдан авах нь ойлгомжтой. Харин нарийн царигаар барихаар болбол нүүрсний зах зээл хятадын хяналтад илүү орно гэх Х.Баттулга сайд зэрэг хүмүүсийн болгоомжлол алсаа бодсон зөв баймаар юм. Ингэхгүй бол хязгаар нутгаа (Өмнөговь, Сүхбаатар, Дорнод, Говь-Алтай, Ховд) хөрш том гүрний дэд бүтцэд оруулаад өөрийн улсын төв рүүгээ холболгүй үлдээвээс хязгаар нутгийн тусгаар тогтнолын асуудлыг өнөөдрийн өөхнөөс болоод худалдсан хэрэг болно.

Нарийн царигийн төмөр зам тавьсны маргаашаас хятадаас мөнгө бөөн бөөнөөрөө урсан орж ирэхийг ухуулах монголын улс төрчдийн төсөөлөл хэтэрхий гэнэн, туйлын богинохон ажээ. Монголын зүтгүүрийг хятадын нутаг дээгүүр далай хүртэл явуулах ч бүтэшгүй үлгэр. Гаднын зүтгүүр байтугай автомашиныг нутаг дээгүүрээ явуулахгүй хуультай улс.

Нарийн төмөр замаас татгалзах хамгийн эхний шалтгаан бол хятад иргэдийн суурьшил бий болох явц юм. Эдийн засгийн нөлөөлөл, хяналт болох дараагийн том шалтгааныг ойлгохгүй байгаа улс төрчид, эдийн засагчдыг геополитик мэддэггүй гэхэд ч багадна!

Эдгээр сургамж төрийн ой санамжид үргэлж байж байх ёстой бөгөөд нөгөө талаас эдгээрийг зогсоож, зөв шийдвэр болгож чадаж байгаа нь монголын төрийн уламжлал, нийгмийн оюун санааны дархлаа монголчуудад бүр алга болчихоогүй оршин байгааг харуулсан хэрэг явдал болсон билээ.

Монголчуудын түүх ялангуяа улс төрийн бутралын үеийн түүхийг түүхчид, аюулгүй байдлын судлаачид бодитой бичиж, түүхэн сургамж талаасаа төрийн бодлогодоо тусгах, улс төрчид ойлгож мэдэж байх шаардлага байсаар байна.<sup>195</sup>

Гурав. Үндэсний аюулгүй байдлын дотоод таатай нөхцөл ба болзошгүй зөрчил

Өөрийн орны түүхэн сургамжуудыг тухайн цаг үедээ тохируулан эргэн харах боломж олгодог үндэсний ой санамждаа тулгуурлан ирээдүйг бодитой төсөөлөх, аливаа гэнэтийн зүйлд хариу өгөх чадвар түүнийг бий болгох оюун санааны дархлаатай болох нь манайх шиг улсад энэ цаг үед тулгамдсан асуудал болжээ.

Үндэсний аюулгүй байдал нь гадаад аюулгүй байдал ба дотоод аюулгүй байдал гэсэн хоёр талтай бөгөөд тэдгээрийн харилцан хамаарлын цогц системээр баталгааждаг.

Дотоод аюул занал *улс төрийн аюул занал*: Дотоодын улс төрийн тогтворгүй байдал, засаглалын хямрал, терроризм, хүний эрхийн зөрчлүүд гэх мэт.

*Нийгмийн аюул занал*: Үндэстний олонх цөөнхийн зөрчилдөөн, зохион байгуулалттай гэмт хэрэг, хил дамнасан мансууруулах бодисын наймаа, хууль бус худалдаа, олныг хамарсан хяналтгүй цагаачлал, өвчний тархалт гэх зэрэг асуудлууд багтдаг.

Эдгээрээс хатуу засаглал, хяналт ихтэй хоёр их хөршөөр хүрээлэгдсэн байдал нь Монгол Улсын хувьд терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, хил дамнасан

<sup>194</sup>35 сая долларын үлдэгдэл өрөө төлөх гэж “Эрдэнэс таван толгой” хил дээр нүүрсээ буулгаад цаадуул нь авахгүй байна.

<sup>195</sup>Ч.Сосорбарам нар “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын түүхийн он цагийн товчоон” Улаанбаатар, 2022 он.



мансууруулах бодисын наймаа, хууль бус худалдаа, олныг хамарсан хяналтгүй цагаачлал зэрэг асуудлууд харьцангуй эерэг нөхцөл орчныг бүрдүүлдэг.

Хэрвээ төрийн эдийн засаг, нийгмийн бодлогод нийгмийн бүлэг, давхарга, үндэстэн, ястны хувьд нийгмийн материал баялгийн хуваарилалт, хөрөнгө оруулалт, татварын бодлого зэрэгт шударга ёсны зарчим алдагдах, хүн амын дунд үндэс угсаа, шашин шүтлэг, хэл соёлын өчүүхэн төдий ч ялгаварлах хандлага гарах, газар авбал урьдчилан тооцоолох аргагүй уршиг тарих, салан тусгаарлах, санаа бодол, үйл ажиллагаа үржин төлжих хөрс нь болдгийг Испани (Барселона), Их Британи (Шотланд, Умард Ирланд), Хятад (Шинжаан, Уйгар), Украин (Донбасс), Ойрх дорнодод өрнөн буй үндэсний асуудал, зөрчил тэмцэл харуулж байна<sup>196</sup>.

Америкийн эрдэмтэн судлаач Жан Баден Улс орныг дайнгүйгээр эзлэн авч болох таван зүйлийн тухай хэлсэн байдаг. Үүнд:

- удирдлагыг гартаа авах,
- улс төрийг гартаа авах,
- эдийн засаг, дэд бүтцийг эзлэн авах,
- хүн амыг уусгах,
- зэвсэгт хүчнийг чадваргүй болгох зэрэг болно.

Иймэрхүү болзошгүй гадаад нөлөөлөл нь улс төрийн тогтворгүй байдал, засаглалын хямрал, хүний эрхийн зөрчлүүдээр дамжин илрэх магадлал ихэсжээ.

«Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал»-ын 4.2.3-т “Монгол Улсын иргэд, иргэний нийгмийн байгууллагууд үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж, энэхүү үзэл баримтлалыг чанд мөрдлөг болгож, тэдгээрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоно” гэж заажээ.

Эх орон, ард түмнээ хайрлах, төрт ёсоо хүндэтгэх иргэн бүрийн сэтгэл зүй үндэсний аюулгүй байдлыг хангаж, хамгаалахад чухал нөлөөтэй. Энд монгол үндэстний өөрийгөө гэсэн оюун санааны дархлааны асуудал гарч ирнэ<sup>197</sup>.

Дотоод зөрчлийн түүхэн сургамж. Улс үндэстнээ хамгаалж ирсэн өвөг дээдсийн ухаан “төрийн хар хайрцагны бодлого” алдагдаж, монголчууд дотроосоо зөрчилдөөд эхлэх үедээ төрийн аюулгүй байдал нь суларч бүр тусгаар тогтнолоо алдаж байсан түүхэн сургамжууд олон байдаг. Түүхийн сургамжаас суралцаж өнөөгийн байдлыг мэдэж судалж байх нь төрийн үүрэг, ой санамжийн чухал хэсэг билээ.

Нийгмийн оюун санаанд ч зарчмын гэмээр өөрчлөлтүүд гарлаа. Иргэдийн ертөнцийг үзэхүй, амьдрах хэв маяг, үнэт зүйлсийн чиг баримжаа үндсээрээ өөрчлөгдөн улс төрийн олон ургалч үзэл дэлгэрч олон төрөл шашин шүтлэг чөлөөтэй нэвтэрч, нутагшин байна.

Даяаршил мэдээллийн гэгдэх энэ эрин зууны өнөөдрийн цаг үед ойрын болон дунд ирээдүйд манай улсын тусгаар тогтнолд учирч болзошгүй хамгийн их аюул нь гадаадын цэргийн шууд түрэмгийлэл гэхээсээ илүүтэйгээр өөрийн орны дотоод улс

---

<sup>196</sup>Н.Жалбажав “Үндэсний эв нэгдлийг хангах, эе эвээ хичээх сэтгэлгээг төлөвшүүлэх арга зүйн үндэс” -“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал: Хүн амын оюуны дархлааны асуудал” эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар, 2019 он

<sup>197</sup>Б.Даш-Ёндон “Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэдийн ухамсарлалын үүрэг” -“Монгол Улсын үндэсний аюулгүй байдал: Хүн амын оюуны дархлааны асуудал” эрдэм шинжилгээний хурал Улаанбаатар, 2019 он

төр, эдийн засаг, шашин, угсаатны байдал<sup>198</sup>-аас үүдэх магадлал байгаа юм.

Манай орны түүх, өнөөгийн улс төр, эдийн засаг, нийгмийн байдлыг шинжвээс ястан угсаатны, эрлийзүүдийн шашны зөрчил тэмцлийн эх сурвалж бодитой байгаа нь харагддаг. Хэдийгээр Монгол Улсын хүн амын 90 гаруй хувь монголчуудаас бүрддэг, нэг шашинтай гэдэг ч биднийг хуваах гадаад, дотоодын хүчнүүдийн чармайлт болон өөрийн төрийн бодлогын чадамжаас (өөрийн толгойгүй бусдыг дагадаг, шууд дуурайдаг) шалтгаалан дээрх гурван хүчин зүйлийн өрнөлөөс ойрын ирээдүйд бий болох дотоод тогтворгүй байдал бий болох магадлал байсаар байна. Эдгээрээс тоймчлон дурдвал:

Олон ястны улс болсон нь гадаадын бодлого байсан. Орос Хятадын Монголын хүчийг дотроос нь сулруулах зорилготой гаднын салган тусгаарлах ажиллагааны үр дүнд монголын олон угсаатнууд бий болсон гэх асуудлыг *эрдэмтэн Л.Мөнх-Эрдэнийн шинэхэн судалгаа*<sup>199</sup> тодруулжээ. Үүнд: Чингисийн угсааныхан монголыг “Монгол Улс”, “Монгол орон”, “Монгол нутаг”, “Монгол овогтон” гэж харж байсан юм. Улс төрийн бутралын дараа улс төрийн ач холбогдол нь алдагдсан учир Халх, Цахар гэх мэтээр Монголын ханлигуудыг Ил, Ховд, Хөхнуур зэрэг Дайчин Улсын үеийн засаг захиргааны хэсгүүдтэй нэгэн адил үзэх болсон байдаг.

Дайчин Улсын хүрээнд Гадаад Монголын хүн амыг бүхэлд нь нэгэн адилаар монголчууд гэж ангилж, нэрлэж байсан Монголын нэгдэл, нийтлэг монгол ижилсэл сэргэсэн юм. Гэтэл Орос, Хятад хоёр Халх, Ховдын хязгаарт автономи эрх олгох замаар Монгол Улсыг бүрэн эрхийг хязгаарлахын хамт Хятад Өмнөд Монголыг, Орос Тагнын Урианхайг салган авахаар шийдсэн байна.

Коминтерны төлөөлөгч М.Амагаев нарын боловсруулсан хөтөлбөр (1925 оны гуравдугаар сарын Бүгд хурал дээр) “БНМАУ-ын дотор халхчууд ба бусад үндэстний бага аймгууд хоорондоо аливаа тусгаарлан үзэх явдлыг бүрмөсөн халж ялангуяа бусад үндэстний бага буурай аймгуудын тухай халхчуудын зүгээс дээрэнгүйлэн үзэх мэтийг бусад үндэстний бага буурай аймгуудыг ялгаварлахгүй жинхэнэ ардын эрх чөлөөг хүндэтгэх”<sup>200</sup> гэж зүтгэсний улмаас БНМАУ-ын хязгаарт багтсан олон угсааны ардад өөрөө засах эрхтэй болгохыг чармайх болсон байна<sup>201</sup>. Ийнхүү Монгол Улс ч олон үндэстэн, ястны улс (multi-ethnic) болжээ.<sup>202</sup>

1928 онд Борис Владимирцовын “Зүгээр л монголчууд гэж байхгүй. Харин Халхчууд, Харчинчууд, Буриадууд, Цахарууд гэх мэт л бий ...бие биеэсээ ...ялгардаг төрөл бүрийн овог аймгууд...” гэх үзэл монгол судлалд ноёлох болов. Өөрөөр хэлбэл Монгол Улсад монголчууд биш харин Халхууд, Дөрвөдүүд, Дарьгангачууд, Дархадууд оршин суудаг болж хувирсан байна.

Өнөөдөр ч Монгол Улсад үндсэрхэх, нутгархах үзэл бодол цухалзсаар байдаг. Унасан газар, угаасан ус, яс үндэс, угсаа гурвалаараа бахархах нь эрүүл ухаантай

<sup>198</sup> Ч.Сосорбарам “Монголын гадаад орчин дахь аюулгүй байдлын болзошгүй төсөөллүүд” / Possible scenarios\*/ “Олон улс судлал” сэтгүүл, Улаанбаатар, 2004 он

<sup>199</sup> Л.Мөнх-Эрдэнэ “Монголын тусгаар тогтнолын ёгт үр дагавар: Монголчуудыг монголжуу, Монгол Улсыг өлөн ястны болгосон нь” илтгэлийг 2011 оны арван хоёрдугаар сарын 9-12 өдрүүдэд Улаанбаатар хотноо болсон “Монголын тусгаар тогтнол ба монголчууд” олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьжээ.

<sup>200</sup> МАХН-ы тогтоол шийдвэр. 1956 өн, 113-р тал

<sup>201</sup> МАХН-ын дөрөвдүгээр их хурал. 1978 өн, 113-р тал

<sup>202</sup> Л.Мөнх-Эрдэнэ “Монголын тусгаар тогтнолын ёгт үр дагавар: Монголчуудыг Монголжуу, Монгол Улсыг өлөн ястны бөлгөсөн нь” нийтлэл



хүн бүрд заяагдсан мэдрэмж ухаарал. Гэхдээ энэ нь голдирлоосоо хальж бүлгэрхэн явцуурах, бүтээн байгуулалтын бодлого тодорхойлох, боловсон хүчнийг шилж сонгох зэрэг төрийн бодлогын зүйлд нөлөөлөх, түүхийг мушгин гуйвуулах хэмжээнд хүрвэл уршгийг нь тааварлах аргагүй. Бөхөө барилдуулахдаа хүртэл ихэд нутгархан талцах болсон нь өөгшүүлэх зүйл огт биш. Ерөөс онцгойрох, ялгарах зүйлээрээ түрүү барих нь орон гэрээ бусниулах нигууртайг эцэг дээдэс маань сургаж, сургамжилсан байдаг нь цөөнгүй<sup>203</sup>.

Түүхэн зөрчлийн үлдэгдэл буюу төвтэйгөө тэрсэлдсэн уламжлалт сэтгэлгээний үлдэгдэл зарим хязгаар нутагт байсаар байж болзошгүй нь заримдаа ажиглагддаг бөгөөд өчүүхэн зөрчлийг ч өсгөн дэвэргэх боломж их үндэстнүүдэд үргэлж байдаг. Жишээ нь: Гурван улсын гэрээний дараа баяд дөрвөдийн зарим ноёд, бэйл Нацагдоржийн удирдлага дор хуйвалдаж Хятадын пүүсээр дамжуулан Шиньжан мужийн захирагчтай холбоо тогтоон бэлэг сэлт, цалин пүнлүү шагнуулаад баруун хязгаарыг Монгол Улсаас салган Шиньжан мужид нийлүүлэх гэсэн урвагчдын хэргийг Баруун хязгаарын сайдаас тагнуулын аргаар илрүүлэн шалган тогтоож, үйлдлийг нь таслан зогсоож байв<sup>204</sup>. Хаант Орос Халхаас Ойрадыг салгаж авахаар 1912 онд Халимаг Дамбийжанцаныг илгээсэн ч гэдэг<sup>205</sup>.

1911 онд ч, 1921 онд ч баруун хязгаарын зарим хэсэг салан тусгаарлах үйл иймэрхүү ажиллагаа оролдлогыг Монголын төр Хатанбаатар Магсаржав нарыг илгээн удаа дараа таслан зогсоож байв.

1925 оноос Коминтерны хүрээнд Бүгд Найрамдах Дөрвөд Ард Улс (БНДАУ) байгуулах төсөл эрчимтэй яригдаж, Бүгд Найрамдах Дөрвөд Ард Улсын удирдах бүрэлдэхүүнийг Шижээ, Бадрах, Баасанжав, Санж, Бямбаа, Жүрмэд, Содов нарын дөрвөдүүдээр байгуулахаар шийдэж байв.

1928 онд Коминтерны удирдагч Григорий Зиновьев<sup>206</sup> 1928 онд Батурин, Шмераль, Кинг, Черномордюк нарын бүрэлдэхүүнтэй Коминтерны бүлгийг Улаанбаатарт илгээв. Шижээ 1929 онд хуучны Ховдын хязгаар, Дөрвөд 2 аймгийг нийтэд нь Дөрвөдийн автономит аймаг болгох санал гаргасан байна. Гэвч Шижээгийн санаачилж, Бадрахын хүчлэн зүтгүүлсэн тогтоолын төсөл олонхын хүчтэй эсэргүүцэлд өртөн унажээ.<sup>207</sup>

<sup>203</sup> Н.Жалбажав “Үндэсний эв нэгдлийг хангах, эе эвээ хичээх сэтгэлгээг төлөвшүүлэх арга зүйн үндэс” -“Монгол Улсын үндэсний аюулгүй байдал: хүн амын оюуны дархлааны асуудал” эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар, 2019 он

<sup>204</sup> Тагнуулын Ерөнхий Газарын түүх. Тэргүүн дэвтэр (1922-2012). 2012 он, 16-р тал

<sup>205</sup> Хоёр тэмээтэй бадарчны дүрээр ирсэн Дамбийжаа Оросын Засгийн газрын санхүүжилтээр алт мөнгөн гулуузаар гулгиж асан гэдэг Бүх монголчуудыг нэгтгэх зорилго бүхий эх орончдын нэрт төлөөлөл Д.Сүхбаатар Ойрадыг салган Орост өгөх гэсэн Дамбийжааг оростой ярилцалгүй дур мэдэн тонилгосныхоо шанг өөрийн амиар төлсөн гэх орос монгол судлаачид эдүгээ гарч ирж буй нь бодит үнэн илэрдэг жамтайг нотолж буй жишээ мөн.

<sup>206</sup> Коминтерн 1924, 1928 оны эргэлтүүдийг (Мөнх-Эрдэнэ 1999; Дашдаваа 2003, 2008) зохион байгуулсан бөгөөд энэ явцдаа Тагна Урианхай, Өвөр Монгол тэр ч байтугай БНМАУ-ын доторх нэр бүхий 30-аад нэгж, хэсгийг бие даасан үндэстэнд тооцож тэднийг өөртөө засан тохинох буюу Тагна Урианхайн тусгаар тогтнолыг зөвшөөрсөн ба “Олон угсааны ардад өөрөө засах эрхтэй болгохыг баталсан” нь “Тагна Урианхай тусгаар улс болоод байхад Чандманийн аймаг тусгай улс болоход үл болох газаргүй” (МАХН-ын долоодугаар их хурал, 1980: 167) гэсэн үзлийг дэвэргэсэн

<sup>207</sup> Амар, Гэндэнгийн талд Ерөнхий сайд Жигжиджав цаашлаад Элдэв-Очир, Содном, Чойжил, Гомбосүрэн, Дэמיד, Мэнд, Нанзад, Цэдэн-Иш, Дамдинсүрэн гэсэн халхчууд багтаж байсан бол Ө.Бадрахын талд Шижээ, Лааган, Загд, Борбанди, Заяат, Өлзийтогтох, Чимид, Нацагдорж, Цэндсүрэн, Жамсран гэсэн голдуу ойрадууд нэгдэж байлаа.

Шижээ<sup>208</sup>, Бадрах, Лхүмбэ нар 1932 оны 2-р сард татвар нэмэгдүүлэх санал гаргасан нь 3-р сард 11 аймагт ардын бослого нэгэн зэрэг гарахад хүргэв. 1932 оны 4-р сард Сталин Коминтерны удирдлагыг эрс зэмлээд Шижээ, Бадрах нар огцорч ЗХУ руу нэг ёсны цөллөгт явжээ.

Энэ бодлогын дагуу Монголоос эхлээд Туваг салгаж БНТУ гэгчийг 1921 онд байгуулаад 1944 онд ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулсан байдаг.

Орос, Украины түүх, өнөөдрийн тэмцэл, зөрчлөөс харах суралцах зүйл манай улсад их байгаа бөгөөд манайд иймэрхүү байдал үүсэх баруун зүүний хуваагдлын түүхэн уламжлал бий.

Манай зарим судлаачид<sup>209</sup> 1990 оноос хойших монгол үндэстний дотоод дахь ястнуудын улс төрийн ухамсар, сэтгэл зүйд багаар ч гэсэн зарим өөрчлөлт, шинэ зүйл ажиглагдаж байгааг судлууштай гээд Буриадууд улс төрийн хэлмэгдэлд илүү өртсөн гэсэн түүхэн гомдлоо зүй ёсоор дэлгэн тавьж байгаа, монголын түүхэнд гүйцэтгэсэн баатарлаг түүхээрээ бахархах болж байгааг Баруун Монголын зарим ястнаас харж болно. Энэ нь онцгойрох, тусгаарлах үзэл үйлдэл огт биш бөгөөд ястнууд өөрсдийн онцлог, түүхэнд байсан хийгээд эдүгээ байгаа бодит байдлаа ухамсарлан илэрхийлж буй эрүүл саруул үзэгдэл юм гэх нь бий.

Баян-Өлгий аймгийн газар нутгийн шинэчилсэн зураг үйлдэж, бүх газар, усны нэрийг казахчлахаар<sup>210</sup> удирдлагууд нь зэхэж байсан байдаг. Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын 43 сургуулийн хоёр нь л монгол хэлээр сургалтаа явуулдаг.<sup>211</sup> УИХ-ын гишүүн асан Сайран, Жекей нарын тагнуулын хэргүүд энэ асуудал хэчнээн гүн гүнзгий болохыг батлан харуулж байдаг.

Түүхийн хувьд олон асуудал бий болж байна. Жишээ нь: “Алтан ордны улсын 750 жилийн ойг тэмдэглэх санал Казакстанаас Орос, Туркменистан, Турк, Монгол зэрэг улсад тавьсан” гэж доктор Д.Анхбаяр сонинд ярилцлага өгсөн байдаг<sup>212</sup>.

Монголын төрийн түүхийн олон алдаа гадаад, дотоод олон шалтгаанаас болсон болохыг бид ямагт санаж явах учиртай. Сүйрсэн, сүйрэх шахсан түүхийн дээрх бэлээхэн олон жишээ байгааг тодруулах буюу үндэсний аюулгүй байдлын үүднээс судлах, бодитой дүгнэх шаардлага байсаар байна.

Үндэсний эв нэгдэл

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.3.3. Үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийн баталгаа болсон үндэсний эв нэгдэл, нийгмийн зөвшилцлийг бэхжүүлж, улс орон, нийгмийг хагалан бутаргах, дотоодын зөрчил, тэмцэлд хүргэх аливаа үйл явдлаас урьдчилан сэргийлнэ.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.3.4. Иргэдийг үндэс угсаа,

<sup>208</sup> 1930 онд болсон МАХН-ын VIII их хурлаар Шижээ нь бүр Төв Хорооны гурван нарийн бичгийн даргын нэгээр сонгогдов.

<sup>209</sup> “Монголын нийгмийн өөрчлөлт” 312-р тал

<sup>210</sup> Бүх газар, ус, байгууллага нь Бесбогда, Беркут, Көпкөл, Жайлау, Кузеу, Тамаша зэрэг нэр, хаягтай албан байгууллага бүгд харь үгээр бичигдэх болжээ.

<sup>211</sup> Монгол Улсын тусгаар тогтнол Баян-Өлгий аймагт алдагджээ. [wikimon.mn](http://wikimon.mn)

<sup>212</sup> “...1269 онд Хубилай хааны эсрэг Өгэдэйн ач хүү Хайду бослого гаргаж, хуучин Өгэдэйн улсыг сэргээн байгуулахдаа Цагадайн улсыг Зүчийн улстай хувааж авах зорилгоор Таласын чуулган хийсэн. Ч.Сосорбарам нар “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын он цагийн товчоон” УБ., 2022 он, 104-р тал Гэтэл Казахстан Улс таласын чуулганаар Алтан ордны улс тусгаар тогтнолоо зарласан... Энэ улс бол Их орд гэж Казахын улс юм. Казахын ард түмний тусгаар төгтнөлөө зарласан үйл явдал гэж тэмдэтэсэн нь байж болшгүй... түүхч Д.Анхбаяр

шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлан гадуурхах, нутгархах үзлийг дэврээх, энэ шалтгаанаар хүний эрх, эрх чөлөөг зөрчих улмаар үндэсний эв нэгдлийг сарниулж, дотоодын тогтворгүй байдалд хүргэж болох илрэлтэй хатуу тэмцэл хийнэ.

Гадаад талаас зэр зэвсгийн хүчээр монголыг эзэлсэн түүх байхгүй гэж хэлэх бүрэн үндэс байгаа бөгөөд харин гадаад хөршүүдийн улс төрийн явуулгаар өөр хоорондоо тэмцэлдэж бутарч байсан нь талаарх олон түүхэн үйл явдлуудыг ой санамжаасаа сэргээн бодож байх ёстой.

Соёл иргэншлийн хувьд монголчууд орчин үеийн даяаршлын шинэ нөхцөлд дасан зохицохын тулд уламжлал, шинэчлэлээ хэрхэн хослуулах вэ? гэдгээс ялангуяа шашны энэхүү эрсдэлтэй нөхцөл байдлаас дотоод аюулгүй байдлын “таатай нөхцөл” ихээхэн хамаарах болжээ.

Дээрх болзошгүй хямралын гурван нөхцөл байдал дээр нь эдийн засгийн бие даасан хөгжил чухал асуудал болон тавигдаж байна. Уул уурхайн авилгал, дотоодын үйлдвэрлэлээ сэргээж чадахгүй зах зээлээ алдаж байгаа зэргийг засах талаар ухаан санаагаа уралдуулж, хийх ажил монголчуудад өчнөөн байна. Ингэхээр оюун санааны дархлааны талаар ярих хэрэгтэй болдог.

Дөрөв. Ой санамж ба оюуны санааны дархлаа

Түүхэн ой санамж бүдгэрснээс ард түмэн нэгдэн нягтрах үйл явц саармагжиж, үүнээс үүдэн нийгмийн ёс суртахуун, үнэт зүйлсийн чиг баримжаа өөрчлөгдөж, үндэсний аюулгүй байдлыг сулруулахад хүргэдэг.

Ой санамж, оюуны санааны дархлаа, үндэсний үнэт зүйл болон үндэсний аюулгүй байдал зэрэг нь нарийн уялдаа холбоотой нийгэм, философийн ухааны судлагдахуунууд юм.

Үндэсний ой санамж үндэстний оюуны санааны дархлаа хоёр нэг юмны хоёр тал бөгөөд үндэсний ой санамжаа хөгжүүлэхгүй бол оюуны дархлаа бий болохгүй.

Үндэсний үнэт зүйлээ үндэсний ой санамж дээр тулгуурлан зөв тодорхойлж чадвал үндэсний өвөрмөц байдлыг илэрхийлж, оюуны дархлааны мөн чанарыг агуулж мөн төрийн үйл ажиллагааны чиг баримжаа болдог.

Товчхондоо үндэсний үндэсний ой санамж бүрэн сэргэсний дараа л үндэсний үнэт зүйлсээ тодорхойлж чадах бөгөөд эдгээрт тулгуурлан үндэсний оюун санааны дархлаа бэхжих зүй тогтолтой гэдэг.

Үндэсний оюун санааны дархлаатай болсноор улс орны аюулгүй байдал, нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлогоо өөрийн толгойгоор дэлхий дахины хөгжилтэй уялдуулан авч явах чадвартай болж хөгжлийн зам нь тогтвортой байх болно.

Улс орон үндэсний онцлох шинж чанараа хадгалах, хамгаалах, дахин сэргээх чадавх, хүн ам, төрөлх хэл, соёл уламжлал, үр удам, төрөлх газар нутгаа хамгаалах чадвар, соёл иргэншлээ бусдаар хүлээн зөвшөөрүүлэх зэрэг нь оюуны санааны дархлаатай шууд холбогдох учиртай.

Их Эзэн Богд маань хаа очсон газраа суу ухаантай хүмүүстэй уулзаж хэлэлцэж байсан түүхэн баримтууд олон бөгөөд хэлэлцэж сонссоны дараа өөрийн ухаанаар асуудлыг дүгнэж, монголчуудын эрх ашгийн үүднээс шийдвэр гаргаж чадаж байсандаа монголчууд дэлхийд тэргүүлэгч үндэстэн болж байсан. Ийм учраас Дональд Трамп “Бүрэн итгэл, тодорхой байдал, үр дагаврын мэдрэмж болон хувиршгүй тууштай чанар зэрэг нь түүний (Чингисийн) хамгийн чухал зэвсэг байжээ” гэж их хааны онцгой чанарыг тодорхойлсон байна.”

Доктор Н.Жалбажав одоо үед байдал эрс өөрчлөгдөж:

“Ташуураараа хамгаалж явсан орноо

Тархиараа хамгаалах цаг ирлээ”

“Тархиараа хамгаална” гэдэг өрнөдийн нэр томъёогоор хэлбэл “диалектикийг дианетикаар” солино гэсэн үг юм. “Дианетика” хэмээх нь “сэтгэлийн эрүүл мэндийг” хамгаалах орчин үеийн шинжлэх ухааны нэр юм. Гэхдээ манай мэргэн өвөг дээдэс

“Биеийн бөхөөр нэгийг ялна

Сэтгэлийн бөхөөр мянгыг ялна”

гэж баруун зүгт одоо их моод байгаа энэхүү “дианетика” ухааны гол судсыг эрт дээр үед тодорхойлжээ.

Диалектикаар бол хүн амын олон цөөн, газар нутгийн их бага ямар нөлөөтэй гэж үздэгийг өмнө ярьсан. Дианетикаар бол хүн амын эрүүл мэнд, газар нутгийн цэвэр унаган төрх, эрдэм ухааны хүч тэнхээ нь үндэсний аюулгүй байдлын гол баталгаа байх болно.”

Эдгээр үндэстний онцлог ижилсэл адилтгал, үндэсний ой санамж, оюун санааны дархлаа, ёс суртахуун зэрэг нь философи, нийгэм, түүхийн өөр хоорондоо холбоотой судлагдахуунууд юм. Аль нэгийг нь тусад нь дагнан судлах, бүрэн тодорхойлох боломжгүй байж болно.

Өнөөгийн олон улсын харилцаа төвөгтэй болж ялангуяа манай хөрш хоёр их гүрэн аюулгүй байдлаа хангах хөгжлийн бие даасан байдлынхаа төлөө цэрэг улс төр, эдийн засгийн эрс тэс алхмууд хийх болсон, үр дүнд нь дэлхийн хүчний харьцаа тэргүүлэгч орнуудын хувьд ч өөрчлөгдөж магадгүй энэ цаг үед үндэсний оюун санааны дархлаагаа бэхжүүлэх нь тун чухал хүчин зүйл болоод байна.

Үндэсний оюуны дархлаатай байна гэдэг нь монгол үндэсний эрх ашгийн үүднээс гадаад, дотоод орчноо үнэлэн дүгнэх өөрийн чадавх, чадварыг хэлэх буй заа. Юуны түрүүн хоёр хөршийн аюулгүй байдлын бодлогыг мэддэг, үйл ажиллагааг бодитой үнэлж дүгнэж, ойлгодог болох ёстой.

Ингэж төрийн болон соёлын ой санамжид тулгуурлан бий болдог үндэсний оюун санааны дархлаа нь төрийн ирээдүйг харсан аюулгүй байдал, хөгжлийн бодлогын үндэс суурь болдог учиртай.

Үндэсний оюуны санааны дархлаа төрийн алтан болон

хар хайрцагны бодлого төрийн бодлогын залгамжлал

Хүннү, Сяньби, Жужан, Түрэг, Уйгар зэрэг нүүдэлчин улс гүрнүүд нь эхэн үедээ Хятадын нөлөөнд төдийлөн автаж байгаагүй бөгөөд төрийн хар хайрцагны уламжлалт бодлогыг чанд баримтлан Хятадын эсрэг тэмцэж байв. Чингэхдээ маш нарийн ухаан сийлж Хятадын арга баширт хариу өгдөг байв. Хан улсаар өөрийгөө хүлээн зөвшөөрүүлж хилээ баталгаажуулж чадсан нь Хүннү улсын цэрэг, улс төр, дипломатын томоохон амжилтад тооцогддог.

Хятадын уламжлалт нарийн арга явуулгад автаж, монголын нутагт байсан нүүдэлчдийн төр, улс гүрнүүд салан бутарч байсан түүхийн зарим цаг үеүдийн талаарх Түрэгийн үеийн хөшөөн дээр бичиж үлдээсэн анхааруулга их бий. Түрэгийн их хаан Билгээгийн дүү цэргийн их жанжин Культегины гэрэлт хөшөөн дээр “Хятад улстай ойртон дотносвол хууртаж мөхөх аюултай, үг нь уран арга нь нарийн” хэмээн сэрэмжлүүлэн бичсэн зэрэг нь үүний нэг нотолгоо юм. Ингэж чулуун дээр бичиж үлдээсэн сургамжууд, сургаалууд нүүдэлчдийн түүхийн ой санамжид баттай

хадгалагджээ.

Хятад суурин соёл, бичиг, Күнзийн гүн ухааны сэтгэлгээнээс зайлсхийх гэж монголчууд төрийн бодлогоор төвөдөөс шашнаа, соёлын олон зүйлийг Химайлай нурууг давуулан энэтхэгээс авч ирсэн уламжлалт түүх бидний оюун санааны дархлааг илтгэн харуулдаг гэж болно.

Монголчууд дотроосоо зөрчилдөөд эхлэх үедээ төрийн аюулгүй байдал нь суларч бүр тусгаар тогтнолоо алдаж байсан түүхэн сургамжууд ой санамжийн чухал суралцах хэсгүүд билээ.

Орчин үед олон улсын жишгээр, ардчиллын зарчмаар бичигдсэн "Үндсэн хууль" болон олон төрлийн төрийн бодлогын үзэл баримтлал, хууль тогтоомж ардчилсан Монгол Улсад бий<sup>213</sup>. Өнөөдрийн төрийн бодлого "Үндсэн хууль" түүнд нийцүүлсэн улс үндэсний үзэл баримтлал, хуулиудаар голлон тодорхойлогдох болсон.

Энэ цаг үед улс орныг хөгжүүлэх урт хугацааны дунд хугацааны хөтөлбөр, тогтвортой хөгжлийн стратегиа Засгийн газар боловсруулж УИХ-аар хэд хэдэн удаа баталж байсан хэдий ч сонгуулийн үр дүнд засаг солигдоод тэдгээр нь хэрэгждэггүй зогсдог, урьдах засгийн үйл ажиллагааг үгүйсгэдэг, хөршүүдээс хамааралтай байдаг орчин, нөхцөл сүүлийн 30 жил үргэлжилж байна.

Товчхондоо намууд төлөвшөөгүй буюу МАН-ын үзэл социал демократ, зүүний нийгмийн хамгааллын хандлагатай ч хөрөнгөтнүүд ихтэй бол АН нео-либерал, либерал, прагматик, консерватив гээд олон алаг цоохор үзэлтнүүдийн эвсэл бөгөөд энэ хоёр намаас төрийн тэргүүн болсон эрхмүүд урьдах болон дараагийн хүнээ шүүмжлэх, хэрэг төвөгт орооцолдуулах нь наад захын хэрэг болж хэвшжээ. Жишээ нь: "Нүүрсний хэргийг" хятадын төрийн мэдээллээр ил болгож улс төрчидтэйгөө тооцоо хийнэ гэх мэдээлэл нийгэмд ихээхэн газар авч байна. Ингэхээр төрийн бодлогын залгамж чанар тун төвөгтэй болж байгаа юм. Ийм учраас үндэсний ой санамж буюу түүхийн сургамжуудад тулгуурлан бүтээгдсэн жижиг улсын төрийн тусгай залгамжлагддаг нууц бодлого буюу "төрийн хар хайрцагны бодлого эсхүл алтан хайрцагны бодлого"-той болж байж, аюулгүй байдлын төрийн бодлогын залгамж чанар сайжирч, зөв хэрэгжинэ гэх улс төрчид, судлаачид бий болсон байна. Жижиг орны хувьд хэзээ ч төрийн бодлого нь үргэлж залгамжлагдаж чаддаг, улс төрийн намуудыг ч зохицуулдаг "төрийн ямар нэг нарийн бодлого" байхаас өөр аргагүй мэт. Энэ тухай түүх сөхвөл Рашид-ад-Дин, Эрэнжен Хар Даваа нар Чингис хааны эхлүүлсэн "тумгай алтан хайрцаг" буюу хүнд үзүүлдэггүй төрийн нууц дэвтэр байсан гэдэг. Коммунизмын үед Намын их, бүгд хурал, Төв Хорооны нууц тогтоол, шийдвэрүүд байсан. (Гэхдээ ЗХУ-ын цэргийг Монголд оруулах асуудлыг шийдсэн хурлын протокол, төрийн шийдвэр олддоггүй гэдэг). Цэдэнбал даргын "тэмдэглэл", улаан харандаагаар цохсон тагнуулын мэдээнүүд байв. 1990 оноос хойших үед анхны Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат (Ерөнхий сайд асан М.Энхсайхан) "төрийн хар хайрцагны бодлого" гэх хэдэн хуудас эдийн засгийн статистик тоотой цаас л надад дамжиж ирсэн гэж олон нийтэд мэдээлж байсан бол шинэ Ерөнхийлөгч Х.Баттулга нэгэн албаны уулзалт дээр "Надад үлдээсэн төрийн хар

---

<sup>213</sup>Ерөнхийдөө 2020 оноос цааш 750 орчим хууль, тогтоомж Монгол Улсын нийгэм, эдийн засгийн харилцааг зохицуулна. Мөн Монгол Улс нийтдээ 300 орчим өгөн улсын өгөн талт гэрээ, көнвенцөд нэгдэн өржээ. УИХ төрөөс баримтлах 30 бөдлөгө, 3 стратеги, стратеги төлөвлөгөө, 7 үндсэн чиглэл, 14 хөтөлбөрийг төгтөөлөөр баталсан байна.



хайрцагны бодлого гэхээр бичсэн юу ч уламжилж ирээгүй” гэжээ. Энэ талаар академич Ж.Болдбаатар “Монгол төрийн бодлогын нэг уламжлалт шинж бол холч голч шинж юм. Үүнийгээ “Их малгайн бараа харах” хэмээн томъёолж, “Төрийн хар хайрцаг”-ны бодлого гэдэг нь нийтэд задруулбал монгол үндэстний язгуур эрх ашигт хохирол учруулж болох гүнзгий эргэцүүлэл, бодомж, мэдээ баримтаа нууцлан, төрийн маш, онц чухал нууцын зэрэглэлд хамруулан чандлан хадгалж, хаан, төрийн тэргүүн халагдан солигдох үед дамжуулан уламжилж байдаг хэлбэрийн хувьд явцуу мөртөө агуулгаараа гүнзгий, цартай улс төрийн үйл ажиллагаа байсан учраас жирийн олон тэр ч байтугай төрийн өндөр албан тушаалтан, түшмэл нарт айдас, найдварын аль алиныг төрүүлж байв. Үндэсний ой санамжийн хамгийн гол амин сүнс нь төрийн хар хайрцагны бодлогод хадгалагдаж байх ёстой.

Хар хайрцагны бодлогыг холын ба ойрын гэж ангилан үздэг. Хар хайрцагт байх хамгийн гол бодлого бол хоёр их хөрштэйгөө тэнцвэрийг нь олж ухаалаг харилцах, жишээ нь: Шинэ засгийн газар байгуулагдаад Ерөнхий сайд, шинэ Ерөнхийлөгч сонгогдоод хоёр их хөршийнхөө хэнийд эхэлж айлчлах вэ? гэдгээс эхлэх хэрэгтэй болов уу. Энэ бүхнийг Үндэсний аюулгүй зөвлөлөөр ярилцаж, хар хайрцагаараа хадгалахыг хадгалж, ил гаргахыг гаргаж байх хэрэгтэй.”

Доктор (Ph.D), профессор А.Пунсаг “...бид төр барих ёсыг гаднаас бадарчлах шаардлага байхгүй, монгол хүн дэлхийд төр барих ёсыг тогтоож өгсөн гэж боддог.

Чингис хааны төрт ёсны үндсэн зарчмын агуулга бол “Хулгайчгүй, худалчгүй нийгэм хамгийн сайхан нийгэм”<sup>214</sup> байна. Бид өнөөдөр энэ асуудлыг авч үзэж байгаа нь чухал, үндэсний ой санамжтай ард түмэн бол ҮАБ-тай байна, улс үндэстэн оршин тогтнохын үндэс суурь юм. Хүннүгээс нааш бодоход 2000 гаруй жил мартаагүй учир манжийн эрхшээлийг түлхэн унагаасан, өнөөдөр дэлхий дээр монгол гэдэг агуу улс оршин байгаа гэж боддог. Цаашид нарийн судалгаа хийгдэх байх, судлах цаг нь болсон, судлахдаа монголын хөрсөнд буулгаж, үр хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх вэ гэдэгт анхаарах хэрэгтэй.

ҮАБЗ-ын шинжээч Н.Хангай “Үндэсний мэдээллийн сан гэдэг бол үндэсний ой санамжийн гол архив юм. Манайхан төрийн “хар хайрцагны бодлого”, зарим нь “албан хайрцагны бодлого” гэж яриад байна. Төрөөс Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал гэж байгаа, энэ нь төрөөс ямар бодлого баримтлах вэ гэдгийг төрийн эрх барих дээд байгууллагаас баталсан байгаа юм. Миний ойлгож байгаагаар “Хар хайрцагны бодлого”<sup>215</sup> гэдэг нь монголоо гэсэн хүн бүрийн дотор байх сэтгэл юм.”

Доктор Б.Даш-Ёндон монголчууд тодорхой шалгуураар (нийтлэг хэл, газар нутаг, соёл, улс төрийн байгууламж, эдийн засаг гэх мэт) үзвэл бүүр Чингис хааны үед үндэстэн болж төлөвшсөн байна. Энэ хувьд нь үзвэл эдүгээг хүртэл монголчууд бидний амьдралд шинэчлэл, уламжлалыг хосолсон залгамж чанарын хууль үйлчилсээр байна. Одоогийн манай Монгол бол “Даяар Монголын ариун голомт” мөн. Энэ дөрвөн үг Монгол Улсын ард иргэд бидний үндэсний ой санамжийн агуулга, учир холбогдлыг тодорхойлж байх ёстой. Энэ дөрвөн үг Монгол үндэстэн өөрийгөө ухамсарлахуйн гол үндсэн чиглэлийг зааж байна. Үндэстэн өөрийгөө зөв

<sup>214</sup> А.Пунсаг /ШУА-ийн Түүх угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан/ -“ҮБХИС-ын эрдэм шинжилгээний хурал” (2022.10.18)-ын илтгэл

<sup>215</sup> Н.Хангай “ҮБХИС-ын эрдэм шинжилгээний хурал” (2022.10.18) дээр хэлсэн үг



ухамсарласан тэр дүр төрх нь үндэсний ой санамжийн “алтан хайрцаг”, тухайн үндэстэн ямагт “дотроо бодож явах” ёстой тэр зүйл нь.

Зарим судлаачид алтан хайрцагны бодлого гэвэл нээлттэй ил тод байх, хар хайрцагны бодлого гэвэл нууц орших нь зүйтэй байх гэгцгээдэг. Судлаач Батлан Хамгаалахын сайд, элчин сайд асан Ц.Цолмон “Алтан хайрцагны бодлогод ил байдаг, олон нийт мэдэж байх ёстой хэсгийг, хар хайрцагны бодлогод олон нийт, бусад улс орнууд мэдэж байх шаардлагагүй тэр хэсэг мэдээллийг багтаасан байвал ямар вэ?” гэсэн санал хэлэлцүүлгийн үеэр гаргаж байв.

Тэгэхээр хар хайрцагны гэдэг агуулга нь энэхүү төрийн нууц ой санамж нь олон нийт, гадаадад ил тод биш тул түүнээс хэн ч иш татдаггүй байх эрх зүйн чадамжтай байх ёстой. Өнөөдөр монгол төрийн бодлого ямар байх нь буюу бүр тодруулбал даяаршлын үед аливаа шинэ зүйлсийг монгол хөрсөн дээр нэвтрүүлэхдээ өөрийн ухаанаар уламжлал, шинэчлэлийн хослуулан байж шийдвэр гаргах чадамж нь төрийг удирдагчид, төрийн албаныхны мэдлэг, чадвар буюу монгол үндэстний оюуны дархлаанаас шалтгаалах нь зүйн хэрэг.

Стратегич, түүхч Эдвард Луттвак<sup>216</sup> “Ямар ч улс өөрөө өөртөө л найдах ёстой. Хэн нэгэн тусална гэсэн ойлголт байхгүй. Тиймээс хэчнээн жижиг улс байсан ч цэрэг арми нь хүчтэй байх ёстой, өөрийнхөө хүчинд дулдуйдах ёстой, өөрөө л бүхнийг шийдэж өрсөлдөөнд, олон улсын ертөнцөд амьдрах ёстой” гэснийг давтан хэлэх ёстой.

Энэ цаг үеийн “Төрийн алтан аргамжийн бодлого” гэдэг нь товчхондоо төрөөс улс орноо “өөрийн толгойгоор” жолоодох чадвар, гадаад талаасаа аюулгүй байлгах, дотооддоо эвтэй байх, залуу үеэ эх оронч хүмүүжлээр хүмүүжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааг удирдах төрийн түшээдийг мэдээллээр хангах, удирдлагын залгамж байдлыг хангах төрийн цогц үйл ажиллагаа байна.

---

<sup>216</sup>Эдвард Луттвак “Монгол Улс их гүрнүүдийн дунд “уран нүүдэл” хийх лстой болж байна” -“Өнөө цагийн дэлхийн гесплителикийн хандлага” лекц. Б.Жаргалмаа, IKON.MN 2019.06,

### 3.3 Даяаршил, үндэсний аюулгүй байдал түүний оюуны дархлаа

Даяаршлын эринд эрдэмтэн судлаачдын анхаарлыг татаж, улс үндэсний болон соёл иргэншлийн аюулгүй байдалд нөлөөлж буй глобал буюу нийтлэг шинжтэй олон асуудал, хувьслын шинэ хандлага шил шилээ даган гарсаар буй. Тухайлбал, Аливаа улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийн нөөц боломж дэлхийн эдийн засгийн зах зээлийн конъюнктур, чиг хандлага, тухайн улс орны олон улсын эдийн засгийн хамтын нийгэмлэгт эзлэх байр суурь нэр хүнд, экспортын чадавх зэргээс үлэмж хамааралтай болж байна. Товчоор хэлэхэд, улс орны тусгаар тогтнол аюулгүй байдал эдийн засгийн хүчин зүйлээс улам бүр хамааралтай болж байна. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд дэлхийн болон бүс нутгийн банк, санхүүгийн төв, байгууллагуудын нөлөө, үүрэг онцгой идэвхжиж байна. Эдийн засгийн нөөц боломжийг нано, био, IT технологи, хими, гений инженерчлэл, үйлдвэрлэл, удирдлагын шинэ технологи, эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг хэрхэн нутагшуулж эзэмшиж байгаагаар тодорхойлох боллоо. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан, технологийн ололт, инновацад суурилсан хөгжлийн бодлого, үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нэн чухал үндэс нь болж байна.

Даяаршлын нөлөөн дор нийгэм улам бүр нээлттэй болж улс үндэстний хувьд иргэншил, соёл урлаг, шинжлэх ухаан, технологийн ололтууд хил хязгааргүй нэвтэрч, үндэсний, локал, дэлхийн соёл иргэншлүүдийн ялгаа зааг, уялдаа холбооны үр дагавар нарийн төвөгтэй болж даяаршихуй болон дангааршлын диалектика дианетик (Л. Түдэв) нь үндэсний аюулгүй байдлыг хангах чухал асуудал болж байна.

Мэдээллийн технологийн ололт нь улс үндэстэн, бүс нутаг, олон улсын хил хязгаараас үл хамааран нийт хүмүүнлэгийн хүртээл болж хүний бүр анхдагч хэрэглээний зүйл болж байна. IT өргөн ашиглагдах болсон цаг үед хүмүүс хаана, ямар ч улс оронд байна ялгаагүй өөр хоорондоо чөлөөтэй харилцан төвөг саадгүйгээр шаардлагатай мэдээ, мэдээллээ олж ашиглах боломжтой болжээ.

Даяаршлын эринд хүмүүнлэгийн харилцааны зах хязгааргүй тэлэлт, соёлын харилцан “уусалт, шингэлт” мэдээллийн хүчирхэг давлагаанд хөл алдлалгүй үндэснийхээ соёл иргэншлийн өвөрмөц, дахин давтагдашгүй онцлог, үнэт зүйлсээ хадгалан хамгаалах нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой болж байна.

Эдүгээ хүнийг нийгэм эдийн засгийн хөгжлийн төвд тавихгүй, хүний хөгжилд хүрэлцэхүйц хөрөнгө оруулалт хийхгүй бол үндэсний соёл иргэншлийн үнэт зүйлсээ хадгалан хамгаалах, аюулгүй байдлаа бэхлэх боломжгүй болсон цаг үе юм. Ийм учраас энэ цаг үед төрийн аюулгүй байдлыг хангах болон нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлогын төвд “Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалттай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлэх” зорилт тавигдаж байна<sup>217</sup>. Монгол хүн, монгол оюун ухаан, монголын түүх, монгол өв соёл, монгол урлаг, монгол ёс заншил, уламжлал бол улс эх орны бахархал, үнэт зүйл байх ёстой. Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа болсон монголоо гэсэн зүрх

<sup>217</sup>“Алсын хараа-2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал” УБ., 2019 он, 61-р тал  
137

сэтгэлтэй монгол хүнийг хүмүүжүүлэх их үйлсийг бид цалгардуулах учиргүй” (Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх).

Энэ бол даяаршлын эринд Монгол Улс, монголын соёл иргэншлийн тусгаар байдал, өвөрмөцөөр оршин нийт хүмүүн төрөлхтний “Өнөр бүлийн өнгө булаалдах цэцгийн мандлын нэгэн сор нь байх” (Д.Лүндээжанцан)-ын нэгэн баталгаа, үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэх оюуны дархлааны тухай цаад утга бүхий бодол санааг шингээсэн үг юм.

Нийгмийн тогтвортой хөгжлийн алхам бүр, бүтээн байгуулалтын арга хэмжээ бүр байгаль эхээ хайрлан хамгаалах эко тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн бодлого, хандлагатай ухаалгаар нийцүүлэх, уялдуулах нь улс орны ирээдүйн хөгжлийн стратеги, аюулгүй байдлаа бэхжүүлэх арга зам болж байна. Төв Азийн чулуурхаг, нөхөн сэргээгдэх чадвар муутай эмзэг хөрс цаг уурын дулаарлын нөлөөнд хамгаас түрүүнд өртөж эвдэрч цөлжин нуур, цөөрөм, гол горхи, булаг шанд олноор ширгэж шургаж байна. Ундны усны хомсдолд орох ч аюул нүүрлэж байна. Энд байгалийн давагдашгүй хүчин зүйлийн зэрэгцээ нөхөн сэргээлтгүй уул уурхай, бэлчээрийн мал сүргийн хяналт зохицуулалтгүй өсөлт, ой мод, ургамал, ан амьтанд хайр гамгүй ханддаг байдал, тариалангийн талбайн хөрсний доройтол зэрэг шунахайралдаа хөтлөгдсөн үйлдэл, бодлого төлөвлөлтийн буруу зэрэг хүний хүчин зүйлтэй холбоотой орчны доройтлыг улам лавшруулж буй олон учир шалтгаан ч байна. Учир иймд байгаль эхээ, уул усаа амилуулан шүтэж хайрлан хамгаалах, халдах, хандах хорио цээрийг тогтоон мөрдүүлдэг. Энэ арга ухаанаа нийт иргэн, үр хойчдоо ухааруулан мэдрүүлж, амьдрал ахуйгаа байгаль эхтэйгээ зохицуулж ирсэн монгол уламжлал хэзээ хэзээнээс чухал болж байна. Байгаль орчноо хамгаалах хууль тогтоомжоо ч тэгшилж чамбайруулах шаардлага ч байна.

Нийгмийн дэвшлийн үндсэн нэг гол шалгуур нь улс үндэсний эв нэгдэл, нийгмийн (социал) тогтвортой байдал юм. Даяаршил нь хөгжил дэвшлийн хурдасгуур хүчин зүйлийн зэрэгцээ улс хоорондын хөгжлийн зөрүүг төдийгүй улс орны дотоодод “Нийгмийн социал ялгарал, баян ядуугийн ялгаа, тэгш бус байдал улмаар ашиг сонирхлын зөрчлийг өдөөгч болох эрсдэл дагуулдаг байна. Сайн сайхны зэрэгцээ ажилгүйдэл ядуурал, хар тамхи бусад мансуурах бодисын тархалт, халдварт өвчин тахал, байгаль орчны доройтол, ардчиллын гажуудал, терроризмын аюул занал хүний эрхийн элдэв нуугдмал зөрчил зэрэг муу муухай үзэгдлүүд даяарших хандлагатай болж байна. Эдгээр үзэгдлүүд улс орны нийгмийн тогтвортой байдал, үндэсний эв нэгдэл зэрэг аюулгүй байдлыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлүүдийг сулруулдаг, нэг ёсондоо “төвөөс зугтаагч” задлагч хүчний уршиг нөлөөтэй ажээ.

Учир иймд баялгийн хуваарилалтын шударга ёсыг хэлбэрэлтгүй баримтлах, ажилгүйдэл ядууралтай тууштай тэмцэх, хүн амын чинээлэг, дунд давхаргыг дэмжих зэрэг эдийн засаг, нийгмийн арга хэмжээний сацуугаар нийт иргэний эх оронч үндэсний ухамсар, үндэсний ой санамж, бахархлыг төлөвшүүлж хөгжүүлэх, улс, үндэсний үнэт зүйлсээ дэлгэрүүлж бэхжүүлэх нь үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэхэд шийдвэрлэх хүчин зүйлийн нэгэн болж байна. Өөрөөр хэлбэл улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын оюуны дархлааг бүрдүүлж бэхлэх нь хэзээ хэзээнээс илүү чухал болж байна.

Даяаршлын эринд “Үндэсний аюулгүй байдал” ба Үндэсний соёл иргэншлийн аюулгүй байдал” гэсэн ойлголт ухагдахууныг ялгаж зааглахад тун нарийн няхуур

хандлага чухал юм. Үндэсний аюулгүй байдлыг үндэсний болон олон улсын түвшинд харьцангуй нарийн сайн судалсан, нэлээд олон улс орон аюулгүй байдлаа хангах өөр өөрийн хууль, үзэл баримтлалтай байна.

Монгол Улс “Үндэсний аюулгүй аюулгүй байдлын үзэл баримтлал”-аа 1994 онд баталж 2010 шинэчлэн мөрдөж байгаа бол “Үндэсний аюулгүй байдлын тухай” хуулиа 2001 оноос хэрэгжүүлж байна. Эдгээрт үндэсний аюулгүй байдлыг “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ” гэж тодорхойлжээ.

Судлаачийн хувьд энэ тодорхойлолт нь аюулгүй байдлын мөн чанарыг бус харин ач холбогдол, үр дагаврыг баримталсан мөн улс, үндэсний аюулгүй байдлын гол зүйл болсон монгол хүний аюулгүй байдлаас хөндий, “хүнийшсэн” тодорхойлолт гэж үзэж байгаа болно. Аюул эрсдэлээс сэргийлэгдсэн хамгаалагдсан байж чадсанаар л оршин тогтнох, хөгжих нөхцөл байдал бүрдэнэ гэж үзэж байна.

Соёл, иргэншил түүний аюулгүй байдал, үнэт зүйлсийн судалгаа харьцангуй шинэ, нэгдмэл ойлголтод хүрэх асуудал чамгүй ажээ.

Хүн төрөлхтөн өөрийн хөгжлийнхөө таван сая жилийн туршид сайндаа л дөч гаруйхан бие даасан соёл иргэншлийг үүсгэж бүрдүүлсэн бөгөөд тэдгээр нь дараах “амьдралын орчил”-ыг тухайлбал үүслийн, хөгжлийн, нэгдлийн, түгээмэлчлэлийн, үеэ өнгөрөөсөн гэх мэт үеүдийг туулж өнгөрүүлсэн байдаг<sup>218 219 220</sup>.

Энэ нь монголын соёл иргэншилд ч мөн хамаатай юм. Тухайлбал: Монгол бол уламжлалт нүүдлийн соёл иргэншлийн өв сонгодог хэлбэрээрээ хадгалагдаж үлдсэн дэлхийн цөөхөн орны нэг юм. Энд нүүдлийн соёл иргэншил орчин үеийн суурин соёл иргэншлийн үндсэн хэв маягуудтай хослон хөгжиж байна.

Орчин үеийн монголын соёл иргэншил нь дэлхийн соёл иргэншлийн идэвхтэй сүлжээний нөлөөн дор оршиж байна. Энэхүү асуудлыг авч үзэх үндсэн хэсэг нь соёл иргэншил дэх нийтлэг шилжилтүүдийг зөв зүйтэй ойлгох явдал юм<sup>221 222 223 224</sup>.

Бидний ойлголтоор хүн төрөлхтөн түүхэндээ таван үндсэн соёл иргэншлийн хувьсгалыг туулжээ. Тухайлбал,

- антропологийн хувьсгал,
- газар тариалан газар эзэлбэрийн хувьсгал
- хотжилтын хувьсгал
- оюуны хувьсгал
- шинжлэх ухаан технологийн хувьсгал

Соёлын бүх бүс нутгууд нь, тэнд оршин тогтнож байсан болон тогтнож байгаа нийгмийн тогтолцоонууд нь эрт орой хэзээ нэг цагт өөрийнхөө анхны буюу шинээр байгуулагдсан хэлбэрүүддээ эдгээр хувьсгалын шатыг дамжин өнгөрсөн аж.

<sup>218</sup>Comparing Nations and Cultures: Readings in a Cross-Disciplinary Perspective. Alex Inkles, Masamishi Sasaki, Prentice Hall, 1996.

<sup>219</sup>A Framework for Comparative study of Civilizations. Shintaro Ito, J. Comparative Civilizations Review, 36. 1997.

<sup>220</sup>Ц.Доржсүрэн “Умард Хүннү” (Северная Хунну). УБ., 1961 он

<sup>221</sup>K. Stephen., Sanderson. Social Transformations: A General Theory of Historical Development. Blackwell Publishing Inc., Cambridge. Mass., 1995.

<sup>222</sup>The development of sedentary and nomadic civilizations. 700 B. C. to A. D.

<sup>223</sup>The third Wave: Democratization in the late twentieth century Samuel Huntington. University of Oklahoma Press. 1996.

<sup>224</sup>Ц.Доржсүрэн “Умард Хүннү” (Северная Хунну). УБ., 1961 он

Антропологийн хувьсгалын үр дунд хүн өөрийн бодгаль шилжилтийн шатнаасаа гарч хөдөлмөрийн багаж зэвсэг хийж эхэлжээ. Түүнтэй хамт хүмүүсийн хоорондын харилцааны чухал хэрэгсэл хэл үүсэж хөгжсөн. Газар тариалангийн хувьсгал бол өөрийн үндсэн шинж чанараараа аж ахуйн хувьсгал байсан бөгөөд түүний ачаар хүнсний үйлдвэрлэл хөгжилтэй болсон. Хөгжилтийн хувьсгалын тухайд гэвэл тэр нь нийгмийн тогтолцоо дахь хувьсгал байсан. Оюуны хувьсгал нь үзэл бодлын үүднээс шашны, философийн гэх янз бүрийн үзэл санаа үүсэх эхлэлийг тавьсан бөгөөд тэр нь дэлхий дахины хэмжээн дэх хүний оюун санааны цаашдын өсөлт хөгжлийн тохиол болж өгсөн.

XVII-XX зуунд хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжилд шинэ хувьсгал гарсан бөгөөд түүний үр дүнд аж үйлдвэрийн нийгмийн үндэс тавигдаж, сансарт гарах зам нээгдэж, цөмийн технологийн болон компьютерын үйлдвэрлэл хөгжиж, тэр бүхний ачаар хүн төрөлхтөн орон зай, цаг хугацааны хил хязгаарыг даван туулах оргон боломж бий болж, шинэ эрин зууны болон орчин үеийн мэдээллийн соёл иргэншлийн эхлэлийг тавьсан билээ.

Гараад буй XXI зуун дэлхийн соёл иргэншлийн хөгжилд үзүүлэх өөрийн нөлөөний хүчээрээ онцгой өвөрмөц онцлогтой юм. Чухамхүү энэ зуунд дэлхийн даяаршил, мэдээлэл зүй, шинжлэх ухаан, технологи, хүрээлэн буй орчин болон байгальд хандах шинэ чиг хандлагыг хөгжүүлэх нөхцөлүүд бүрдэх болно.

Дээр дурдсан хүчин зүйлүүд өнгөрөгч зуунуудын дэлхийн соёл иргэншилд нөлөөлж байсан дайн, аж үйлдвэр, эдийн засгийн интеграци зэрэг тэр хүчин зүйлүүдээс агуулгаараа ч, нөлөөллөөрөө ч илүү давамгайл шинжтэй, ихээхэн баялаг юм. Шинэ нөхцөл дэх соёл иргэншлийн хөгжлийн эдгээр шинэ шинэ хандлага, зүй тогтлуудыг суллахын тулд соёл иргэншлийн онолын үзэл баримтлалыг боловсруулах явдал онцгой чухал болж буй нь мэдээж билээ.

Нийгмийн оюун санааны түүхэнд “Соёл иргэншил гэдэг ойлголтын үндсэн агуулгын талаар янз бүрийн үзэл бодлыг дэвшүүлж байсан, одоо ч дэвшүүлсээр байна. Тэдгээрийг өөр өөр эрин зууны сэтгэгчид дэвшүүлж байлаа. Энэ асуудлаар эдүгээ шинжлэх ухааны судалгаанууд өргөн далайцтайгаар хийгдэж байна. ЮНЕСКО-оос 1994 онд хэвлэн гаргасан “Culture and Civilization” (“Соёл ба иргэншил”) гэсэн номд жишээ нь “соёл иргэншил” гэдэг ойлголтыг энэ үгийн явцуу утгаар өөрөөр хэлбэл “хотжилт” гэсэн ойлголтоос гаралтай тэр үгийг яг махчилсан орчуулгаар ойлгож болохгүй хэмээн өгүүлжээ. Цааш нь тэнд бидний судалж буй энэ ойлголт өөрийн утга санаагаар илүү өргөн агуулгыг илэрхийлж байна гэжээ. Тэр нь нийгмийн (социальный) амьдрал, удирдлага, эрх зүй, соёл, бичиг үсэг, боловсрол, технологи, шинжлэх ухаан, урлаг энэ бүхний эв зохицолт хослол юм. Хар ухаанаар тунгаавал энэ бол хүмүүн түүний олонлог болсон гэр бүл, угсаатан, улс үндэстний оршин аж төрөх орчин, хэв маягийг бүхэлд нь агуулсан ухагдахуун гэх үндэстэй байна. Ингэж уг нэр томъёоны үндсэн гол ач холбогдлыг тодорхойлж болно гэх үндэстэй байна.

Бид энэ тодорхойлолтыг орчин үеийн соёл иргэншлийн шинжлэх ухааны судалгаануудын үр дүнг нэгтгэж дүгнэсэн, тун зөв оносон тодорхойлолт гэж үзэж байна.

Соёл иргэншлийг судлах шинж их ухааны гурван бие даасан үзэл хандлага

байдаг<sup>225</sup>. Үүнд:

- Формацийн үзэл хандлага
- Дэлхийн тогтолцооны үзэл хандлага
- Иргэншлийн үзэл хандлага эдгээр юм.

Сүүлийн үед эрдэмтдийн анхаарал соёл иргэншлийн ирээдүйн хувь заяаны асуудлуудад улам бүр төвлөрөх болов. Энэ салбарын эрдэмтэд даяаршил болон дангааршлын хүрээг хамарсан (сценарийг) бүтээцгээж байна.

Бид дараах зургаан сценарийг харьцуулах үндсэн дээр энэ талаар өөрсдийн бодол санаа, байр сууриа илэрхийлэх оролдлогыг хийлээ<sup>226</sup>. Үүнд:

1. Нэгдэх сценарийн мөн чанар нь дэлхий нийтээрээ нэг л соёл иргэншилд тухайлбал, барууны соёл иргэншилд шилжих, бусдыг бүгдийг нь соёл иргэншлийн үеэ өнгөрөөсөн “үзмэр” болгон “музей”-д өгөх санал тавьж буйд оршиж байна. Бидний бодлоор энэхүү үзэл баримтлал нь өрөөсгөл шинжтэй бөгөөд тиймээс янз бүрийн хүн зоны нэгтгэлүүдийн оновчтой хөгжлийн ирээдүйн хувь заяаг хангалттай тусгаж чадахгүй юм.

2. Уламжлал, шинэтгэлийг хосолсон соёл иргэншлийн хөгжлийн сценарийг өөрөөр хэлбэл, зугуухан хувьслын “хосолсон зам”-ыг дэвшүүлж байна. Энэ сценари нь соёл иргэншлийн хөгжлийн логикийг илүү нарийн тусгаж байна гэж үзэж байна.

3. Гурав дахь сценари нь локал соёл иргэншлүүдийн хөгжил дэх алив өөрчлөлтийг гаднын шахалт тулгалтаар хийгдсэн хэмээн үзэхгүй байх, учир нь тэдгээрийн олонх нь ямар ч ноёрхогч буюу давамгайлагч соёл иргэншлийн эсрэг “дотоод дархлаа”-тай байдаг гэж үздэг. Энэ сценариар соёл иргэншлүүд нь эдийн засгийн даяаршлын болоод хөгжлийн “хөлийг тушдаггүй” харин эсрэгээр нийт дэвшилд тусалж, түүнийг дэмждэг. Бидний үзэж буйгаар энэхүү сценари нь нэг их үнэмшилтэй биш юм. Учир нь тэр нь энэ тэр соёл иргэншлийн онцлогийг харааныхаа гадна үлдээж, бүх зүйлийг хийсвэрээр “Соёлын дотоод дархлаанд” л хамаатуулдаг байна.

4. Дөрөв дэх сценари нь локал соёл иргэншилд засвар оруулж ч, “боловсронгуй болгож” ч болохгүй. Учир нь тэр нь өөрийнхөө байгаагаараа л оршин тогтнох чадвартай гэдэг үүднээс ханддаг. Ямар ч соёл иргэншил өөрөө өөртэйгөө зөрчилддөггүй. Бидний үзэж буйгаар соёл иргэншлийн ирээдүйн талаарх энэхүү үзэл нь мөн л төдийлөн оновчтой биш юм. Учир нь энэ үзэл соёлын хязгаарлагдмал, явцуу түгжигдмэл байдлыг номлодог.

5. Тав дахь сценари нь соёл иргэншлийн хөгжил болоод өөрчлөн хувиргах асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагагүй. Харин биотехнологийн болон мэдээллийн хөгжилд л аль болох илүү анхаарал тавих хэрэгтэй хэмээн өгүүлдэг. Энэ үзэл баримтлалын зарим нотолгоо нь анхаарал татаж байна. Бүр наанадаж хэлэхэд л энд соёл иргэншлийн хөгжилд хамгийн хүчтэй нөлөө үзүүлж буй тэр хоёр хүчин зүйлийг тэргүүн зэрэгт тавьж байна гэж бид үзэж байна.

6. Эцэст нь, зургаадугаар сценари нь барууны соёл иргэншлийн нолрхолд цаашид анхаараад байх шаардлагагүй. Учир нь тэр аль хэдийнээ үеэ өнгөрөөсөн, харин “соёлуудын нэгдэн нийлэх талбар”-ыг бий болгоход тэгэхдээ дорнын соёл

<sup>225</sup>Cultures and Civilizations, Integral Study of the Silk Roads. UNESCO Publishing, 1994.

<sup>226</sup>B. Enkhtuvshin., M. Tumorjav., G. Chuluunbaatar. Nomadic: Civilizations, cultures and development // International Symposium on Nomads and Use of pastures today, Collection of abstracts, Ulaanbaatar, 1999.



иргэншилд голлон анхаарч, түүгээр л дамжуулан бусад соёл иргэншилд нөлөө үзүүлж болно гэж тунхагладаг. Бидний бодлоор энэ хувилбар мөн л соёл иргэншлийн хөгжлийн ирээдүйг бүрэн хэмжээгээр төлөөлж чадахгүй. Учир нь тэр нь соёлын эрт дээр үеийн уламжлалт хоёр хэв маягийг бие биеийнх нь эсрэг сөргүүлэн тавьж байна. Ийнхүү соёл иргэншлийн хөгжлийн ирээдүйн талаар дэвшүүлж буй төрөл бүрийн сценариуд ийм байна.

Одоо энэ дээр өгүүлсний дагуу монголчуудын соёл иргэншлийн хөгжлийн үндсэн зааг хязгааруудыг авч үзэхэд сонирхолтой байна. Монголчуудын аж ахуй эрхэлж байсан технологи болон аж амьдралын хэвшил нь манай эриний өмнөх хоёр дахь мянганаас эхэлсэн эртний түүхтэй билээ. Монголын соёл нь нүүдлийн соёл иргэншилтэй салшгүй амин холбоотой юм. Нүүдэлчин монголчууд хүн төрөлхтний түүхэнд асар их үүрэг гүйцэтгэсэн.

Тухайлбал: Монголчууд буулгаж барихад тун амархан гэр хэмээх өвөрмөц дугуй орон сууц болон хасаг тэрэг бүтээсэн. Мөн тэрчлэн мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах, үндэсний хувцас олж шидэх технологийг бий болгосон. Монголчууд тэмээ, адууг тээврийн хэрэгсэл болгон ашиглаж байсан Евроазийн нүүдэлчдийн нэг түүхэн гавьяа бол Ази, Европыг холбосон алдарт “Торгоны зам”-ыг тэд гаргасан бөгөөд тэр нь өрнө, дорнын соёлын солилцоо болон түүний харилцан холбоотой хөгжилд өргөн боломжийг нээсэн явдал юм. Аж амьдралын нүүдлийн хэв маяг гарч ирсэн явдал анхны хөдөлмөрийн том хуваарь үүсэх нөхцөлийг бүрдүүлж, цэргийн зэвсэг бүтээх болон түүнийг боловсронгуй болгох үйлст хувь нэмэр оруулсан билээ. Тэд хэлний шинэ шинэ бүлгийг үүсгэхэд маш чухал үүрэг гүйцэтгэсэн.

Бидний өвөг дээдэс орчин цагийн шуудан холбоо, бараа бүтээгдэхүүний солилцооны арга технологи, мөнгөн тэмдэгт бүтээн оюуны болон биет соёлыг цогцлоон хот (Хархорин) сүндэрлүүлсэн төдийгүй эрхшээсэн олон улс үндэстний соёл иргэншлийг бүтээсэн гавьяатай.

Окада Хидэхиро “Чингис хаан Монгол хэмээх үндэстний эцэг болой. Тэгээд ч зогсохгүй Чингисийн үр хойчис Азиас Европ хүртэл тархан суурьшиж, олон төр улс байгуулж, өрнө дорнын ертөнцийг холбосноор дэлхийн түүхийн чиглэл өөрчлөгдсөн хүн төрөлхтөн XIII зуунаас эхлэн шинэ цаг үетэй золгосон юм. Энэхүү шинэ эриний үүдийг нээсэн хүн бол Чингис хаан. XIII зуунд Чингис хааны байгуулсан эзэнт гүрэн XIV зуунаас хойш олон шинэ улсыг төрүүлсэн нь өнөөгийн дэлхийн голлох улсууд болжээ. Хятад, Солонгос, Энэтхэг, Турк, Орос, Төв Азийн Турк хэлээр ярилцагч Исламын улс орнууд цөм Монголын эзэнт гүрнийг залгамжилсан төр улсууд билээ... Ийнхүү Чингис хааны Монголын эзэнт гүрэн зүүн талдаа Солонгосын хойг, хятадаас баруун талдаа Газрын дундад тэнгис хүрсэн бараг бүх улс орныг бий болгожээ. Чингис хаан дэлхийг бүтээсэн ажгуу”<sup>227</sup>.

Даяаршил, шинжлэх ухаан, мэдээллийн технологийн эринд үндэсний соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах, өвөрмөц дахин давтагдашгүй өнгө төрхийг хадгалан хамгаалах, хөгжүүлэх, нүүдлийн болон суурьшлын иргэншлийн зөрчлийг зохицуулах зэрэг нь монголын соёл иргэншлийн нэн чухал зорилт юм.

Эрдэмтэн судлаачдын олонх нь даяаршил бол хөрөнгө капиталжуулах хүч техник технологи, оюун санааны үнэт зүйлийн хил хязгааргүй шилжилт хөдөлгөөн юм<sup>228</sup>.

<sup>227</sup>“Чингис хаан түүний үр сад” 2019 он

<sup>228</sup>Л.Түдэв “Даяаршил ба дангааршил” өгүүлэл

Төрийн уян хатан зохицуулалттай болон хөгжил дэвшлийг хурдасгах улс хоорондын харилцан итгэлцлийг бэхжүүлэх хүчин зүйл байх магадлалтай. Зөнд нь орхивол улс үндэстний соёл иргэншлийн өвөрмөц онцлог тусгаар тогтнол бие даасан байдлыг цэвэршүүлэх алдагдуулах улс хоорондын хөгжлийн ялгаа зөрөөг улам лавшруулах, зөрчил тэмцлийг хурдасгах нигууртай гэж үзэх жишээтэй. Нөлөөллийн хувьд хоёрдмол процесс гэдэгтэй олноороо санаа нийлдэг байна. Даяаршил бол зэрэгцэн орших, харилцан нэвчих, зөрчилдөх, тэмцэлдэх процесс гэж тайлбарладаг байна.

Л.Түдэв аругайн үзэл баримтлалаас<sup>229</sup>

“Дэлхий болбоос нэг л гүрэн хүн төрөлхтөн болбоос түүний иргэд” гэсэн үзэл санаа таван тивийн гурван өнгө арьстны оюун ухааныг бүрэн эзэмдэж авах XXI зуунтай бид бүгдээрээ золгон учирлаа.

“The earth is but one country and mankind its citizens” гэж даяаршлын гол хэлээр дээрх үзэл санаа илэрхийлэгдэж байна. Хорьдугаар зууны хорвоог хоёр туйлд хүртэл даяаршуулсан Октябрийн хувьсгалын гол хүч болсон оросуудын хэлээр “Земля есть только одна страна и человечество есть её граждане” гэж тодорхойлж байна. Гэвч ийм хэлбэрийн томъёолол гарахаас зуун жилийн тэртээ “Орон бүхний үгээгүйчүүд нэгдэгтүн” гэсэн уриаг германчууд дэвшүүлэн гаргаж билээ. Уриа нь хэдийгээр дэвшилттэй ч өрөөсгөл талтайгаа нуух аргагүй. Шууд тулгасан шинжтэй байсан тул хүн төрөлхтөн нийтийг хамаарч чадсангүй. Гэхдээ аль эрт дивангараас эхэлсэн даяарших үйл явцыг нэг хэсэгтээ түргэтгэхэд уухай болж өгсөн нь ойлгомжтой юм. Харин өнөө үед бол нисэх онгоц юм уу галт тэргээр баян хүн ч хөл залгуулдаг, ядуу хүн ч хөл залгуулдаг болчихсон нь даяаршлыг хэмжих хэмжүүрийг зэр зэвсэг ч биш, эд хөрөнгө ч биш хэмээн баттай ойлгуулж өгөв. Хүн сүргийг нэгэн их гэр бүлд нэгтгэх гэсэн эрмэлзлээ зэр зэвсгийн хүчээр хэрэгжүүлэх оролдлого хорин зууны уртын урт замд нэг биш удаа гарсан амуй.

Сулхарнай жанжингаас эхлээд Чингис хаан хожим нь Наполеон, саяхан Адольф Гитлер хүртэл цөм л хүн төрөлхтний цоохор гэр бүлийг нэгэн тоононы дор хураан төвхнүүлэхээр аян дайн хийж зэр зэвсэг хангинуулж, тулалдаан дунд насаа өнгөрүүлж байсан нь түүх болон улирчээ. Тэдний дотроос Чингис хаан л ганцаараа дэлхийн талыг нэгэн тоононы дор нэгтгэж чадсан нь тэр үедээ даяаршлын дээд амжилт юм.

Даяаршлын үйл явц хэдийгээр зогсолтгүй урагшилж байсан ч гэсэн зэр зэвсгээр юм уу хүч түрэмгийлэх аргаар бүтэх хэрэг биш гэдгийг хорин зууны урт түүх харуулж өглөө. Хорин зууны буйлсан ялтан нь дайн болж түүхнээ жигшигдлээ. Улс гүрнүүдийн байтугай үндэстэн ястан, отог омгийн хооронд зогсоо зайгүй дайтаж хөнөөлцсөн хорин зуун өнгөрөхүйд түүнтэй зэрэгцээд параллель шугамаар даяарших үйл явц аажим зугуухан ч гэсэн зогсолтгүй урагшилсаар байлаа. Харин XX зууны сүүлчийн хагасаас даяаршлын үйл явц хурд хүчээ авч амнаас ам дамжин айлаас айлд халдварлан их түргэн тархах боллоо. Үүний гол нууц, гол хөдөлгөх хүч нь шинжлэх ухаан техникийн ололт буюу оюуны хувьсгал юм.

Хүн ард, улс гүрнүүдийг өөр хооронд нь зааглаж байсан орон зай, цаг хугацааны хүчин зүйлийг шинжлэх ухаан, техникийн нээлтүүд эргэлт буцалтгүй өөрчилж чадлаа. Дуунаас хурдан нисэх онгоцтой болсноор хүн төрөлхтөнд газрын хол, усны

<sup>229</sup>Л.Түдэв. “Даяаршил ба дангааршил” өгүүлэл

урт гэдэг ойлголтыг даван туулах бололцоо олдлоо. Өглөө Улаанбаатарт явж байсан хүн орой Москва юм уу Лондонд байж байдаг боллоо.

“Холыг ойртуулж, хоёрыг уулзуулдаг” хэмээх холбоо харилцааг шинжлэх ухаан, техникийн дэвшлийн хүчээр мөн л орон зай, цаг хугацааг хүн мэдрэхгүй болтлоо хөгжүүлж чадлаа. Өчигдөрхөн л хөмөрсөн тогоон дор байгаа мэт явсан монголчууд хүртэл өнөөдөр гэрээсээ юм уу малынхаа бэлчээр дээрээс гар утсаараа Дорнын Токио, Өрнийн Нью Йоркод суугаа хүүхэдтэйгээ өөрөө шууд утасдаад ярьчихдаг болсон нь гайхмаар мөртөө бодит ахуйн үзэгдэл болон хувирч байна.

Сүүлийн хэдхэн жилд гэхэд л эхлээд пейжер дараа нь үүрэн утас, сансрын холбооны гар утас гэхчилэнгээр холбоо харилцааны даяаршсан хэрэглүүр хойно хойноосоо манайд нэвтрэн орж ирснээр манайхны холбоо барих мэдээлэл дамжуулах чадавх гайхмаар түргэн өслөө.

Саяхан Москва, Прагаар дамжуулж байж дэлхийтэй холбоо барьдаг асан монголчууд өөрсдөд нь аюул учрахад шууд олон улсын сонорт хүргэх чадвартай болсон гэсэн үг. Ийнхүү холбоо харилцааны үйлс шинжлэх ухаан техникийн ололтын ачаар сүүлийн 10-20 жилд 10 сая дахин хурдаа нэмж, мэдээллийн хурд нэг сая дахин түргэслээ.

Шинжлэх ухаан, техникийн дэвшил ийнхүү даяарших үйл явцыг түргэсгэх бодит хүчин зүйл болон хувирлаа. Хоцрогдон орхигдохыг хүсэхгүй л бол даяаршлын ийм маягийн эргүүлэгт татагдан орохоос зайлах газаргүй боллоо. Даяарших үйл явцыг удаашруулж байсан орон зай, цаг хугацааны хоёр гол хүчин зүйл одоо нэгэнт тэрхүү мөн чанараа алдан шинжлэх ухаан техникийн ололтод ороогдон автагдлаа. Ийм нөхцөлд урьдын байтугай өчигдрийн олон ойлголт хуучраад өөрчлөгдөхөөс аргагүй болов. Тэрхүү хуучирсан ойлголт буюу хатуу хэв (стереотип) хэмээх баримтлалуудын дотор улсын хил хязгаар, үндэсний мөнгөн тэмдэгт, төрийн сүлд, туг, далбаа болон үндэсний ёс заншил гэх мэтийн хөдөлшгүй тогтсоор ирсэн зүйлсийг даяаршлын үйл явц саармагжуулан аажмаар үгүйсгэх читэлдээ орсныг Европын Нэгдсэн Холбоонд багтан орсон 16 улс орны өнөөгийн дүр төрх бэлхнээ харуулж байна.

Европын Холбоонд эртний уламжлалт соёлтой Англи, Франц, Герман, Испани, Итали гэх мэтийн орнууд нэгдэн орсон бөгөөд тэдгээрийн хооронд хил хязгаарын нарийн зааггүй бас визгүй зорчдог, үндэсний мөнгөн тэмдэгтийн оронд евро мөнгө гүйдэг болсон байна. Евро парламентын ордон гэж том дугуй танхимтай нүсэр их шилэн өргөөг Страсбургт байгуулжээ. Түүн дээр дүгрэглүүлэн байрлуулсан 16 цагаан таван хошуу бүхий хөх далбаа намирч байдаг нь Европын Нэгдсэн Улсын бэлгэдэл юм.

“Азийн Нэгдсэн Улс” гэдгийг товчилбол АНУ буюу Америкийн Нэгдсэн Улс гэдэгтэй андуурахаар хураамал үсэг болно. “Арабын Нэгдсэн Улс” гэвэл мөн л тэр мэт хураамал үг болно. Латин Америк хэмээх тэртэй тэргүй даяаршиж бараг цөмөөрөө нэг хэл (испани)-ээр ярьж бичдэг болчихсон бас нэгэн даяаршлын баг улс байж л байна. Юуны урьд ийм бүсчилсэн хамтлагаар дамжин бүх дэлхийн даяарших үйл явц хэрэгжиж болохгүй гэх нотолгоо одоогоор байхгүй бөгөөд болох магадлалыг европын холбоо харуулж байгаа ажээ. Даяарших үзэгдлийг монголчууд бидний өвөг дээдэс эзэн Чингис хаанаас ч эрт өмнийн цагт урьдчилан хэлж байсан нь туульст үлджээ.

“Эмээл минь хаан ширээ буюу  
Энэ дэлхий харьяат улс мину”

гэж бүүр Хүннү Улсын үеэс морьтон монгол ярьдаг байсан нь даяаршлын уухай яриагүй мөн ажээ.

“Эр биеийн чадлаар  
Зэр зэвсгийн хурцаар  
Толгойтныг бөхийлгөж  
Тойгтныг сөтгөж явсан”

тэр цаг домог болон улирсан бөгөөд эргэлт буцалтгүй орхигдсоныг өнгөрсөн зуунд Аарийчүүд түүний өмнөх зуунд Францууд биеэр мэдэрч зүрхээрээ ойлгожээ. Харин даяарших үзэл санаа бөхсөнгүй, даяарших арга билэг төгөлдөржсөөр өнөөгийн өндөрлөгт ирснийг хүн төрөлхтөн ухаарсаар болой.

Даяарших үзэл санаа өнгөрсөн зууны тавиад онд их хүчтэй болж ирснийг “космополитизм” гэж нэрлээд ялангуяа тэр үеийн Зөвлөлт Холбоот Улсад ихээхэн шүүмжилж тогтоол шийдвэрээр дарж хориглосон билээ. Гэвч даравч дардайсаар зууны төгсгөл рүү улам хүчээ авч “глобализм” гэдэг нэрээр нийтэд илэрхий үзэл баримтлал болон түгэн тархаж газар авсаар байна. Үнэн чанартаа “Эх оронгүйжүүлэх үзэл” гэж тэр үед шүүмжлэгдэж байсан боловч төрөл арилжаад “Хүмүүст ганцхан л бөмбөрцөг дэлхий заяажээ тэр нь нэг л гүрэн, хүн төрөлхтөн бол түүний иргэд” гэсэн няцаахад хэцүү ойлголт болон хувирсан юм. Глобализм буюу дэлхийших, даяарших үзэл гэгч мөн чанартаа “Эх оронч үзлийн” эсрэг биш юмаа гэхэд түүнийг ихээхэн саармагжуулах утга чанартай ойлголтын нэр болоод байгаа билээ.

Эх оронч үзэл гэдэг нэр томьёо нь бодитой, хийсвэр хоёр зүйлийн хослол үг юм. “Эх орон” бодитой оршмуй. “Үзэл” бол хийсвэр шинжтэй тээгдэж явдаг. “Эх орон” бол хэзээд бодитойгоор байсаар, оршсоор байдаг. “Үзэл” бол хийсвэр учраас бодитын тусгал болж хоёрдогч чанараар сэтгэлд орших тул хийсэж ч болно хадагдаж ч болно. “Эх орон” гэж бид бүхний өргөмжлөн ярьдаг тэр бодит зүйл маань ердөө л “газар” гэсэн уугуул нэртэй билээ. Газар шороонд ургамал ногоо ургаж, ус нуур тогтож, хүн амьтан идээшдэг билээ. Газар шороо байхгүй сан бол тэр бүхэн орох орон, оочих усгүй, тэгээд л оршин тогтнох аргагүй болно гэсэн үг.

Бид хэр их газартай билээ? Нэг сая таван зуун жаран зургаан мянга таван зуун хавтгай дөрвөлжин километр газар нутаг өнөөгийн Монгол Улсын 2 сая 538 000 иргэдийн эрх мэдэлд байгаа билээ. “Ийм их шороонд тийм цөөхөн хүн яана даа!” гэж саяхан Турк Улсын нэгэн сайд уулга алдсан юм. Нээрээ ч цөөхөн монголчууд бидэнд элбэгхэн газар шороо шүү! Бид бүхнээсээ хоёр мянганы тэртээ салж баруун зүг одсон Түрэгүүд одоо манай газар нутгийн тал хувьд арай хүрэхгүй (779 мянган 460 хавтгай дөрвөлжин километр) газар нутаг дээр жаран таван саяулаа аж төрж байна. Туркийн нэг иргэнд алгын чинээ газар ногдож байхад манай нэг хүнд алд дэлэм газар юу ч биш. Бүх малтайгаа хүн амаа нийлүүлээд тоолоход ч Түрэгийн хүн амын тал хувьтай тэнцвэл их юм. Энэ бол нэг талаар баян ч нөгөө талаар ядуу гэсэн үг.

“Манай зорилго бол энэхүү түүхэн чухал асар том газар нутаг дээр нөлөөгөө хадгалж байх явдал мөн. Энэ бол 800 мянган малчин аж төрдөг энэ оронд социализм байгуулахаас илүү чухал. Газар нутаг нь хүн амаас илүү их ач

холбогдолтой” гэж 1929 оны нэгдүгээр сарын хоёрны өдөр Монголын тухай Чехословакийн иргэн Богумир Шмераль Коминтернд илтгэжээ.<sup>230</sup> Ийм үзэл монголоос бусад гадаадын хүн бүрд биш гэхэд дийлэнх олонхын сэтгэл санаанд үе үе орж ирдэг нь нууц биш.

Диалектикийн сургаалаар бол газар нутгийн их бага нь нийгмийн хөгжлийг хурдасгах буюу удаашруулах хүчин зүйл мөн. Өргөн уудам газар нутагт дэд бүтэц буй болгоход маш их хүч хөдөлмөр, зардал хөрөнгө шаарддаг тул хөгжлийг удаашруулах хүчин зүйл болно. Өргөн уудам газар нутагт тариа ногоо тарих эрдэс баялгийг нь ашиглахад үлэмжийн их бололцоотой тул хөгжлийг хурдасгахад түлхээс өгнө. Гэвч хүний оролцоогүйгээр хурдасгуур ч удаасгуур ч аль аль нь утгагүй зүйл болон хувирна.

Диалектикийн сургаалаар бол хүн амын олон цөөн нь нийгмийн хөгжлийг хурдасгах буюу удаашруулах хүчин зүйл мөн. Хүн ам ихтэй улс орон хөдөлмөрийн хүчээр дутахгүй тул их зорилтыг шийдэж, том бүтээн байгуулалтыг хийж чадах бөгөөд чингэснээрээ түргэн хөгжих бололцоотой. Ам бүл цөөнтэй улс орон ажлын хүч дутагдаж санаа байвч сачий хүрэхгүйн гачигдалтай тулгарах учир хөгжил дэвшил нь удааширч бусдаас хоцорч мэднэ. Монголчууд бид хүн бүл цөөн, газар нутаг өргөний улмаас хөгжлийг удаашруулах энэ хоёр хоймсон хүчин зүйлийн дарамт дор байсаар ирлээ. Гэхдээ өргөн уудам газар нутагтаа эзэн болсоор хорин зууныг элээв. Түүний нууц нь хэн бүхэнд илэрхий энгийн зүйл юм.

Монголчууд орос, хятад шиг газрыг эдлэгч байсангүй харин газрыг эзэмшигч байсаар ирлээ. Тариа, ногоо тарьж болох тохмын чинээ газрыг ч үлдээлгүй хэдэн зуун дамжин тариалсаар тэр л газартайгаа хадагдан суурьшсан хятад юм уу орос хүнтэй огт адилгүй монгол хүн газрынхаа шимийг шууд биш дам аргаар хүртэж ирсэн билээ.

Өргөн уудам газар нутагтаа таван хошуу малаа бэлчээрлүүлэн тарга тэвээрэг авхуулан, өсгөж үржүүлээд мах, цагаан идээ, арьс ноосыг нь хэрэглэх аргаар буюу газрыг малаар дамжуулан эдэлж заншсан билээ. Хүн бүл цөөн ч гэсэн мал олонтайн буянаар өргөн уудам нутагтаа малын бэлчээр даган жигд тархан байрлаж эх орон, газар шороондоо хүрэлцэхүйц эзэн болсоор буурал түүхийн он жилүүдийг элээсэн амуй. Тариалан эрхлэхэд тааламжгүй, эрс тэс уур амьсгалтай говь, хээр, уул нуруу хосолсон энэ ё газар нутагт суурин иргэд идээшихэд амаргүй байсан бас нэгэн хүчин зүйл ч эх орны маань аюулгүй байдлын хамсаа болсоор ирсэн буюу. Гэвч ХХ зууны хоёрдугаар хагас ялангуяа урган гарч буй хорин нэгдүгээр зуун нь байгалийн үзэгдлээс хараат бус эсвэл байгаль цаг уур, газар орны ямар ч нөхцөлийг харгалзахгүйгээр өөрийн ашиг сонирхолд зохицуулан ашиглаж чадах эринийг эхлүүлж байгаа тул хуучин бүх ойлголт, түүнээс уялдсан арга барилууд үнэн хэрэг дээрээ огтхон ч анзаарагдахгүй, анзаарагдавч сөрөг ажиллагаатай тулгарч түүнд автагдахаас аргагүй нөхцөл байдлын эрин зуун болно.

Даяаршил нь тусгаар тогтнол гэдгийг бүрэн биш гэхэд дээд зэргээр саармагжуулах түгээмэл чанартай үзэгдэл юм.

Тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал гэдэг үзэл баримтлалд хоёр онцгой хүчин зүйл байдаг. Тэр нь аюулгүй байдал халдлагад өртөж, дархан эрхийг

---

<sup>230</sup>Оросын шинэхэн түүхийн баримт бичгийг хадгалан судлах төв (РЦХИДНИ)-ийн фонд 495, опись 154, дело 380, лист 2-70

хохироох хүртэл нөлөөлдөг үзэгдэл билээ. Өөрөөр хэлбэл аюулгүй байдалд гадаад, дотоод хоёр түрэмгийлэл ямагт заналхийлж байдаг нь мэдээж.

Гадаад түрэмгийллээс сэрэмжилж газар нутаг дээрээ хилийн дээс тавьж хөрш орнуудтайгаа хэлэлцэн тохирч демаркацийн баталгаажуулалт нэгэнт хийсний хувьд манай улс хил хязгаарын хууль эрхийн хамгаалалттай орон. Тиймээс гаднаас хил зөрчин түрэмгийлэх, зэвсэглэн халдах аюул заналыг ёс суртахуун, хууль эрхийн хувьд сэрэмжлэн хориглосон харин газраар хийдэг түрэмгийллийн тухай ойлголт одоо үед өрөөсгөл болжээ.

Өнөө үед хаяа хадрахаасаа тооноор өнгийх аюул илүүтэй болсон гэдгийг саяхан дэлхийн хүчирхэг гүрэн АНУ-д тэнгэрээс буюу тооноор нь халдсан зэрлэг явдал бэлхнээ харуулж байна. Агаарын довтолгооноос пуужингаар хамгаалах онол баримтлал ч цоорхойтой гэдэг нь харагдлаа. Цэрэгжлийн сургуультай зэвсэгт хүчин биш ердөө л энгийн хувцастай зорчин явагчид л тооноор орж ирээд голомт самарч мэдэх аюул нэгэнт буй болчихжээ. Нөгөө талаар газар биш огторгуйн хий буюу бид бүхний амьсгалдаг хамгийн даяаршмал хэрэгцээ болох агаар маань гадаад түрэмгийллийн хэрэгслүүр болон хувирч байна. Хорт бодис, цацраг идэвхт болон бусад төрлийн цэнэг тээсэн бохир агаар бол аль ч улсын газар дээрх хил хязгаар гэгчийг үл тоомсорлон чөлөөтэй нэвтэрч хүмүүсийн хамар амаар шууд орж “хэлж ирдэггүй хийсэж ирдэг” аюулын зэргэмжид очжээ. Бид ийм агаарыг мэдэрч түүнээс зугтааж чадах сан билүү?

Хүнд үргэлж онгорхой байдаг эсвэл байн байн онголзож байдаг хоёр сүв бий. Нэг нь хамар нөгөө нь ам. Хамраар хортой хоргүй, бохир цэвэр алин боловч агаар л юм болохоор чөлөөтэй нэвтэрдэг. Амаар бол харин хоол, ундны зүйлс нэвтрэх бүрэн эрхтэй. Бид ямар ус ууж, ямар хоол хүнс хэрэглэж байгаа билээ? Бид кола, пепсигээс эхлээд төрөл бүрийн амталсан ус, яс, буурцгийн гурилаас эхлээд гоймон, печень, бялууг хүртэл зүсэн бүрийн гурилан бүтээгдэхүүн, чангаанзнаас эхлээд алим, жүрж, аршийн нударгыг хүртэл янз янзын жимс ногоо, бохиноос эхлээд гаатай, гаагүй эсэн бусын чихэр мэтийг дэлгүүр, зах, ТҮЦ-ээс хүртэл авч амандаа хийдэг билээ. Гадаадын шошготой л бол бүр ч амтархан идэж ууж сурчээ. Гэтэл хүнсний бүтээгдэхүүнийхээ 30 хувийг гадаадаас импортолдог тийм улсыг бусдаас хараат улс гэж үздэг ажээ. Монгол Улс хүнсний бүтээгдэхүүнийхээ гуч биш далаад хувийг гадаадаас авдаг. Тэр дотор нь спиртийн зүйл нэлээн хувь эзэлдэг орон юм. Тэгэхээр бусдаас хоёр дахин хараат улс гэхэд няцаах арга олдхоггүй байна. Уул нь будаа, хатуу цай зэрэг цөөхөн зүйлээс бусдыг буянт малынхаа шимээр бас ч жараад он гэхэд дотоодынхоо гурилын хэрэгцээг атрынхаа ургацаар хангадаг байсан цаг бий билээ. Малынхаа ашиг шимийг өвөг дээдсийнхээ арга ухаанаар бүрэн ашиглаж дээр нь газрынхаа ашиг шимийг дан ганц малаар дамжуулж авдгаа тариалангаар шууд хүртэх арга билэгтэй хослуулж чадвал бид хүний царай харахгүй өргөө гэртээ эзэн байх сан. Өнөө үед хүнсээр эзлэх бодлого биш юмаа гэхэд үйл явц нь даяаршлын далбаан дор илэрхий түгээж байгаа учраас “хүнсний аюулгүй байдал” бол үндэсний аюулгүй байдлын гол цөм болж мэдэх юм. Хүнсээр дамжиж элдэв өвчин халдана гэж өрөөсгөл ойлговол гэнэдэх буй заа. Одоо үед хүнсээр дамжуулан нэг хэсэг хүнийг байтугай бүхэл бүтэн ястан, үндэстнийг сувайруулан үргүй болгох нь гарвал зүйн (генетика) ухааны ололтын хувьд тун ч хялбархан зүйл болжээ.

“Эх орон” гэдэг маань газар шороо юм бол “эх оронч үзэл” хэмээх нь хүний



сэтгэлд тээгдэн явдаг хийсвэр ойлголт. Хүн байхгүй бол эх оронч үзэл юунаас ундрах билээ? Эх орон гэдэг бодит зүйлийн хувьд диалектикийн хуулиар тодорхойлогдож болдог бол эх оронч үзэл нь диалектикийн хуульд багтахгааргүй хийсвэр, нарийн бас хувьсамтгай үзэгдэл учраас үүнд диалектикийн ухаанаар хандахаасаа урьдаар “дианетикийн” зарчим барихыг цаг үе маань шаардаж байна. “Хаана сайхан амьдрал байна, тэнд эх орон байна” гэж одоогийн зарим залуусын ярьдаг үгийг бяцхан өөрчилбөл “хаана хүн байна, тэнд эх орон байна” гэж хэлж болох юм. Хүнгүй зэлүүд газар бол хэний ч биш байдаг. Тэгвэл бид хэдүүлээ билээ?

Зууны (XX) эхээр нэг хавтгай дөрвөлжин километр газарт ганц монгол хүн ногдохгүй тийм цөөхүүлээ байлаа. Зууны төгсгөлд тэр хэмжээний газар дээр эр, эм хоёулаа бас нэг хүүхэд тээсэн шигээ зогсож байх болов. Гэвч энэ тоо гурвуулаа байхаар төлөвлөгдсөндөө хүрсэнгүй. Хүн амын маань өсөлт элдэв шалтгаанаар сааран саарсаар сүүлийн арван жилд төр засгийн дөрвөн өндөрлөгийн удирдагчдын гарын үсэг зурсан тогтоолын дагуу ураг хөндөлтийн журмаар гурван зуун мянгаас доошгүй хүүхэд эхийнхээ хэвлийд алагдлаа. Архидан танхайрсны балгаар, аваар осол, зодоон нүдээн, аллага таллагаар хэдэн арван мянган хүн амь насаа алдлаа.

Амьдралын түвшин буурч, ядууралд орсны гайгаар балчир насны болон өндөр насны хүмүүс цаг бусаар хорвоог орхисоор дайны дараах үеийнхний “ээлж” төрөл арилжих “дэдлайн”-д тулж ирлээ. Хүн амын зүй бусын хорогдол нь үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдалд учирч буй хамгийн ноцтой хохирол юм.

Манай үндэстэн залуу зандан цагтаа хорвоогийн талыг эзэрхэж Улаан тэнгисээс Шар тэнгис хүртэл өргөн дайдад морин дэл дээгүүр шуугиулж явсан хэдий ч нэг хоёрхон зуун өнгөрсний дараа хорвоогийн шороон түмэн хүний далайд чимээгүйхэн живж далд орсон гунигт түүхтэй билээ.

“Номхон далайд биш  
Хүмүүн далайд живсэн  
Өвөг дээдээс минь хөөрхий еэ!  
Өнөөгийн бидэнд сургамжтай яа!”

Хилийн чанад сайхан амьдрал бэдрэн явсан хүмүүсийн тоогоор сүүлийн 10 жил нь шинэ монголын түүхэнд “гиннесийн үзүүлэлт” боллоо.

Даяаршил бол хүнийг хэрэглээний далайд живүүлэн адилтгаад зогсохгүй хүнийг хүнд нь живүүлж чадна. Хэзээний содон монголчууд одоо өрнө, дорнын ижил хувцастай, ижил унаатай, ижил сууцтай, ижил хэрэглээтэй хүмүүстэй улам бүр төстэй болж байгаа нь дээрхийн баримт мөн биз ээ.

Хүн амын эрүүл мэнд бол үндэсний аюулгүй байдлын нэгэн баталгаа мөн. Хорьдугаар зуунд эрүүлжиж сэргэсэн монгол хүн хорин нэгдүгээр зуунд ахин эмгэг хуучинд баригдах ёсгүй. Эрүүл мэндийн олон баталгааны гол нэг ноён нуруу нь экологийн аюулгүй байдал. Тэгвэл энэ үзүүлэлт хүн амын маань гуравны нэг нь төвлөрөн суурьшсан нийслэл Улаанбаатар хотод нэлээн түгшүүртэй хэмжээнд байгааг нийтээр мэдэрдэг боловч агаар, ус, хөрсний бохирдолтыг сэрэмжлэх ажил төдий л үр дүнд хүрэхгүй байна. Хүнийг аажуу зугуухнаар хөнөөгч үл үзэгдэх, үл баригдах эрлэг болох дуу шуугианы хувьд Улаанбаатар хот сүүлийн жилүүдэд “солиормоор” хэмжээнд хүрчээ. Утаа, тоос, хог шороо, хорт хий, бузар үнэр танар нь зэвсэг бариагүй мөртөө үндэсний маань аль сортоотой хэсгийг аажмаар хөнөөж, “Нийслэл” хэмээх гол нэртэй урьд цагт хүн чулууны хонхор гэгдэж байсан энэ хонхор

одоо хүн хөнөөхийн цех болон хувирч мэдэх тул үндэсний аюулгүй байдлын бодлого энэ чиглэлд хүчтэй тавигдмаар байна.

Ардын хувьсгалаас өмнөх жилүүдэд манай ард түмэн хүн бүл цөөнтэй ч гэсэн урд зүгээс өнгөлзсөөр байсан хуйхуй нар, хар цэргүүдтэй цахиур буу, ташуур хоёроороо тулалдаж нэг бус удаа ялалт байгуулж явсныг түүх мэдэх билээ. Тэгвэл одоо үед байдал эрс өөрчлөгдөж

“Ташуураараа хамгаалж явсан орноо  
Тархиараа хамгаалах цаг ирлээ.”

“Тархиараа хамгаална” гэхээр урьд цагийн луухаанууд шиг толгойгоороо мөргөж дайрахыг хэлж байгаа гэж бүү бодогтун. “Тархиараа хамгаална” гэдэг өрнөдийн нэр томъёогоор хэлбэл “диалектикийг дианетикаар” солино гэсэн үг юм. “Дианетика” хэмээх нь “сэтгэлийн эрүүл мэндийг” хамгаалах орчин үеийн шинжлэх ухааны нэр юм. Гэхдээ манай мэргэн өвөг дээдэс

“Биеийн бөхөөр нэгийг ялна  
Сэтгэлийн бөхөөр мянгыг ялна”

гэж баруун зүгт одоо их моод байгаа энэхүү “дианетика” ухааны гол судсыг эрт дээр үед тодорхойлжээ.

Диалектикаар бол хүн амын олон цөөн газар нутгийн их бага ямар нөлөөтэй гэж үздэгийг өмнө ярьсан. Дианетикаар бол хүн амын эрүүл мэнд, газар нутгийн цэвэр унаган төрх, эрдэм ухааны хүч тэнхээ нь үндэсний аюулгүй байдлын гол баталгаа байх болно.

Эрүүл мэндийн хувьд бид өвөг дээдэстэйгээ харьцуулбал яс хэврэг, бие сул болж байгааг ярьдаггүй юмаа гэхэд хүн амын маань зургааны нэг буюу зургаа долоо дахь аль нэг иргэн маань сэтгэцийн гажигтай гэсэн оноштой байгаа нь үндэстнийхээ хувь заяаг боддог хүн болгоны “толгойн өвчин” болоод байна. Чухам яагаад, хэн ийм болгочхов гэдэгт хариу эрэх хэрэг алга. Бид өөрсдөө л ийм болчихлоо. Хорьдугаар зууны сүүлийн хагаст сэхээтнүүд байтугай ажилчид маань тувт архидлаа. Шимийн архи биш этилийн спиртээр архидлаа. Сүүн тэжээлтэн байснаа махан тэжээлтэн боллоо. Морин дэл дээр явдаг байснаа модон сандалд хадаатай боллоо. Салхи даган нүүж, бууж явснаа шавар тагзад хотжин бүглээ. Биеийн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийг хослуулан бүх нийтийн эрүүл ахуйг төлөвшүүлэхэд урьдын цалгар байдлыг хэвээр үргэлжлүүлбээс үндэсний маань аюулгүй байдал хэн ч хүрээгүй байхад аяндаа өөрөө нурдаг элсэн баримал шиг үйрэн унахгүй гэх газар алга

“Сайн юмыг харваас нүдний гэм арилмуй  
Сайхан номыг уншваас сэтгэлийн гэм сарнимуй”

гэсэн хуучны үг бий. “Хуучны үгийг хууль болгож яв!” гэж их эзэн Чингис хаан сургажээ. Үндэсний аюулгүй байдлын бас нэг чухал баталгаа бол эрдэм ном, оюуны чадавх юм. Ард түмнийхээ оюуны хүчин чадлыг дээшлүүлэхэд л эдийн засгийнхаа хүчин чадлыг дайчлах цаг болжээ.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг” ахин хянан шинэчилж “Үндсэн хууль” боловсрол, эрүүлийг хамгаалах, экологи, иргэний болон эрүүгийн хуулиудаар баталгаажуулж өгөх хэрэгтэй байна.

Үндэсний аюулгүй байдал улсын тусгаар тогтнолыг “Өрх гэрийн тусгаар тогтнол” аюулгүй байдлаас эхэлж үндэсний гол чухал үйлдвэрүүдийг өөд татаж бүтээгдэхүүнийг нь экспортын түвшинд хүргэж “Өрх бүр үйлдвэр, хүн бүр

үйлдвэрлэгч” уриа дор нийгмийн гол хүчийг бэлэнчлэн импортлох биш бүтээн экспортлогч болгох ойрын болон хэтийн төлөвтэй урт хугацааны зорилтот программ хийж хэрэгжүүлэх нь чухал байна.

Дэлхийн гурван өнгө арьстны (хар, шар, цагаан) олонх болох монголжуу, (монголоид) арьс угсаатны Өлгий нутгийнх нь хувьд мөн Төв Азийн ус болон салхины хагалбар, мөнх цэвдгийн урд үзүүр, хулан тахийн уугуул нутаг усных нь хувьд Монгол оронд ахимсын эрх дарх олгож ахимсын бүс (хор үл хүргэх) болгон олон улсад зарлуулах саналыг боловсруулан Рио Де Жанейрогийн тунхаглалд багтсан орнуудын засгийн газрын тэргүүнүүдийн уулзалтыг эх орондоо зохион байгуулан хэлэлцүүлж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Ерөнхийлөгч Н.Багабандийн ивээл дор нийтлэгдэж эхэлсэн “Манай Монгол” сэтгүүлийг аюулгүйн зөвлөл албан ёсныхоо хэвлэл болгож, санхүүжүүлэн улмаар тус сэтгүүлийн радио болон теле хувилбар, кино мэдээний хэлбэрээр тус тус тогтмол гаргадаг болгохын хамт англи, герман, франц, хятад болон испани, солонгос, япон хэлээр нийтлэн интернэтээр тараах арга хэмжээ авах нь чухал юм.

“Төрийн минь сүлд!”, “Төрийн сүлд өршөө!” гэдэг монгол суртахууныг ахин сэргээж, одоогийн төрийн сүлдийг олон үгтэй, хийсвэр дүрслэлийг нь өөрчлөн цөөн үгтэй, амьдралд ойр бас бишрэл төрөхүйц болгохын хамт өрхийн тэргүүнд төрийн Сүлд, далбааг өргөө гэртээ залах эрх олгож, Монгол Улсын “Төрийн дуулал”-ыг монголын радио, телевизээр өглөө үдэш манай алдартай дуучдаар үгээр нь дуулуулах мөн биеийн тамир спортын тэмцээн, аливаа их бага хурал, сургуулиудын хичээлийн нээлтээр сүлд дуугаа үгчлэн дуулдаг байх нь чухал юм.

Монгол хэл, босоо бичиг, уртын дуу, ардын туульс, хөөмий, малчны ухаан, морин хуур, монгол бөх, морин уралдаан, сур харвалтыг үндэсний бахархал болгон зарлаж, бүх төрлийн сурах бичигт “Эх орон” гэдэг бүлэг тусгайлан оруулж бүх үеийн монгол эх орончдыг алдаршуулах, эх орноо шүтэх шүтлэгийг буй болгох үүнд урлаг, утга зохиолыг дайчлах хэрэгтэй.

Дэлхийн газар хуваарилалтын олон улсын хууль гарахаас өмнө газрын тухай үндэсний хуулиа маш холч бодлогоор боловсруулан бүх ард түмний плебесцитээр батлуулж, олон улсын анхаарал, сонорт хүргэх шаардлагатай байна.

Засаг төрийн ямар ч хэлбэр тогтоход хэлбэрэлтгүй уламжлан мөрдөгдөх чадвар, эрх дархтай үндэсний хөтөлбөрийг “Даяаршлын нөхцөл дэх эх орон” нэрийн дор боловсруулан мөрдөх саналтай байна.

## Гуравдугаар бүлгийн дүгнэлт

Монголчууд түүхэн тодорхой шалтгаанаар өөрийн ой санамжаа бүдгэрүүлж, сэргээх гэж хүч тавилгүй, аливаа шинэ зүйлсийг шууд дуурайдаг, өөрийн ухаанаа уралдуулж нутагшуулдаггүй, бусдын үгээр явж ирсэн нь ямар алдаанд хүргэдэг болохыг өнөөдөр бүгд мэдэрч эхэлж байна.

Ерөнхийдөө үндэсний “ой санамж” гэдэг нь агуулгаараа тухайн үндэстний онцлог, үндэсний ухамсар, оюун санааны дархлаа, үндэсний үнэт зүйлс зэрэг судлагдахуунуудын үндэс цөм болж, тэдгээрийг холбож өгдөг суурь ойлголт юм байна.

Аливаа үндэстэн өөрийн болон бусдын түүхийн сургамжаас байнга суралцаж, төрийн үйл ажиллагааны алдаа оноогоо дэнсэлсэн ой санамжтай байж түүндээ түшиглэн үндэсний үнэт зүйлсээ тодорхойлж, нэг зорилго алсын хараатай нэг үндэстэн байж, төр засаг нь бодитой мэдлэг, мэдээлэлд тулгуурлаж төрийн бодлого шийдвэрээ гаргадаг байж хөгждөг жамтай.

Үндэсний аюулгүй байдал нь гадаад аюулгүй байдал ба дотоод аюулгүй байдал гэсэн хоёр талтай бөгөөд тэдгээрийн харилцан хамаарлын цогц системээр баталгааждаг.

Гадаад талдаа олон улсын харилцааны тодорхойгүй байдал, системийн хямрал, хөрш орны дотоодын дайн, мөргөлдөөний байдал, эдийн засгийн хямрал, өр зээлийн асуудлаас болж манай улсад үзүүлэх дарамт шахалт ирэх магадлал өсөж байна.

Дотооддоо дотоодын улс төрийн тогтворгүй байдал, засаглалын хямрал үүсэх нөхцөл байдал баялгийн тэгш бус хуваарилалт ядуурал, авлигал, үндэстний олонх цөөнхийн зөрчилдөөн, шашны асуудлаас болж аюул үүсч болзошгүй.

Авлигал, хээл хахууль, улс төрчдийн туйлшрал тэдгээрийн бодлогогүй үйлдэл, эсхүл эдийн засгийн хямрал үүсгэх, ястан угсаатныг зөрчилдүүлэх зэргээр зарим хөршийн шууд болон шууд бус далд нөлөөллөөс үүдэн Монголын ардчилал сулран замхарч, төр улс нь хүчин мөхөстөж, дотоодын эмх замбараагүй байдал /failed or failing state/ үүсэх нөхцөл, шалтгаан өнөөдөр бодитой байна. Үүнийг далимдуулан тус улсын газар зүйн байрлалаас үүдэн цэргийн хүчээр журам дэг тогтоох нэрийн доор тодорхой улсын цэргийн хүчин орж ирэх нь магадлал бодитой оршин байгааг манай түүхэн туршлага, сургамж сануулж байдаг. Өнгөт хувьсгал гаднаас хийх шашин, мэдээллийн бүхий л нөхцөл байна.

Хоёр хөрш зэвсэглэлээр шургуу хөөцөлдөж, цэргийн хүчээ бэхжүүлж, дайн байлдаан хийх болсон энэ цаг үед цэргийн аюул багассан гэж шууд ярьдаг монголын судлаачид олон болсон нь цаг үеэ ойлгохгүй эсхүл гаднын нөлөөнд орсныг харуулдаг. Монгол Улс батлан хамгаалах төсвөө аль болох чадахаараа нэмэх ёстой. Хөрш болон “гуравдагч хөрш”-ийн зарим улс, холбоодтой аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хамтын ажиллагааг хүрсэн түвшинд барих, магадгүй гүнзгийрүүлэх ч шаардлага байна.

Улсын архив, шинжлэх ухаан байгууллагууд, мэдээллийн сангууд хөгжихийн хирээр улс орны тусгаар, тогтнол, үндэсний аюулгүй байдал улам бүр баталгаажих болно. Ялангуяа мэдээллийн сангууд нь авилагтай тэмцэх, төрийн удирдлага, албан хаагчдын үйл ажиллагааг ил тод, үндэслэл мэдээлэлтэй, шуурхай болгох иргэний ардчилсан нийгмийн шаардлага хэрэгжих гол үндэс суурийг тавих үндэсний

ой санамжийн хэрэгсэл мөн.

Улс орны мэдээллийн сангуудын тогтолцоо тэдгээрийн аюулгүй байдал үндэсний ой санамжийн нэн чухал хэсэг.

Цаашид нэн тэргүүнд үндэсний ой санамждаа тулгуурлан Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд 1. Төрийн албаны тогтвортой байдлыг одоогийн хуулийн дагуу хэрэгжүүлэх, 2. Шашны талаар төрийн бодлого, үйл ажиллагааг тодорхой болгох шашны зөвлөлийг бодитой ажиллуулах, 3. Хүн ам, татвар, гааль<sup>231</sup>, эрүүл мэндийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, архивыг цахимжуулахад төсөв хөрөнгө хуваарилах зэрэг төрийн зохицуулалт, үйл ажиллагаа тулгамдаж байгааг манай судалгаа харуулж байна.

Төрийн албаны саяхан шинэчлэгдсэн хуулийг хэрэгжүүлэх, аюулгүй байдлын салбарт ажилладаг албан хаагчдын талаар улс төржихгүй байх асуудал чухал юм.<sup>232</sup>

Үнэт зүйлээр жигүүрлэсэн, эх оронч үзэлд тулгуурласан нийгмийн оюун санааны дархлаагаа бий болгох нь энэ цаг үед үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хамгийн чухал тулгамдсан асуудал мөн.

Дэлхийн аюулгүй байдлын тогтолцоо систем өөрчлөгдөж болзошгүй, олон улсын байдал нэн тодорхойгүй болж байгаа энэ цаг үед улс, үндэстний тогтнох гол үндэс, хүч чадал нь “Хүн амын нийгмийн сэтгэл зүй дайныг сөрөн тэсвэрлэх чадавх юм” гэж дэлхийн эрдэмтэд үзэж байна.

Товчхондоо эх оронч үзэл аюулгүй байдлаа хангах, болзошгүй дайн байлдаанд ялах гол хүчин зүйл болохыг улс төрчид, судлаачид хэлж, ард түмний эв нэгдэл, үндэсний ухамсар үнэт зүйлсийн ач холбогдол улам өндөр байлгахыг цаг үе шаардаж байна.

Үндэсний аюулгүй байдал, эх оронч үндэсний үзлийн төлөвшил нь үндэсний ой санамж, үндэсний үнэт зүйлс, нийгмийн оюун санааны дархлаа зэрэг асуудлуудын зангилаан дээр оршдог.

Бид өнөөдөр үндэсний эрх ашгаа тооцон өөрийн оюун бодлоор гаргаж чаддаг, олон нийтийг нэгтгэн чиглүүлэх чадвартай төр засагтай болж байж л ард олны нийгмийн сэтгэл зүй дээшилж, төр засаг нь “Үндэсний эрх ашгаа хамгаалан зоригтой дуугарч” чаддаг төдийгүй өөрийгөө хамгаалах чадвартай улс, орон болно.

---

<sup>231</sup> Нүүрсний хулгайн хэрэг эхлэх үеэр гаалийн мэдээллийн сан устсан гэх мэт ноцтой мэдээлэл гарах болсон. Иргэний мэдээллийн сангийн аюулгүй байдал ойлгомжгүй байгаа...

<sup>232</sup> Судлаачийн хувьд 1996 оноос төрийн албаны шинэчлэлийн явцад оролцож, ЕТГ, ҮАБЗ, УИХ, Засгийн газрын аппаратад төрийн албыг сэлгэн хашиж ирсэн 30 жилийн туршлагаасаа эдгээр саналыг хэлэх нь зүйтэй гэж үзлээ.

## ДҮГНЭЛТ

Үндэсний ой санамж бол түүх туршлага гэдэг дээр төслийн баг санал нэгдсэн. Төслийн судлаачдаас дараах дөрвөн зүйлийг тусгайлан онцлон авч үзэж өв түүхийн эрхэмлэх зүйлс (үнэт зүйл) гэж үзэж байгаа юм. Үүнд: Монголын түүхийн өв уламжлалаас

Нэгдүгээрт, “Монголын нууц товчоон” үндэсний ой санамжийн дээд шүтээн Хоёрдугаарт, “Их засаг” буюу монголын хууль эрх зүйн уламжлал

Гуравдугаарт, Монголын төрөөс газар нутгаа хамгаалах талаарх бодлого, үйл ажиллагаа

Дөрөвдүгээрт, Төрийн албаны түүхэн уламжлалыг монголын “Өв түүхийн үнэт зүйл эрхэмлэх зүйлүүд” гэсэн дөрвөн зүйлээр тусгайлан авч үзэж судалгаа хийлээ.

Аливаа нийгэмд нийтээр хүлээн зөвшөөрсөн, дагаж мөрдвөл зохих нийгмийн зан үйлийн хэм хэмжээ, үнэт зүйлийн чиг баримжааг нийгмийн гишүүдэд эзэмшүүлэхгүйгээр ямар ч нийгмийн систем тогтвортой, хэвийн хөгжиж чадахгүй гэж нийгэм судлаачид үздэг.

Нөгөө талаас хүн нийгэмд үйлчилж байгаа эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээ, нийтээр хүлээн зөвшөөрч дагадаг үнэт зүйл, эрхэмнэлийг амьдрал, үйл ажиллагаандаа баримтлах тал дээр төслийн багаас тодорхой санал гаргах оролдлого хийж байна.

“Эрхэмлэн хүндэтгэдэг үзэл бодол, итгэл үнэмшлийн цогц” гэдэг агуулгаар үндэсний хэмжээнд зөвшилцсөн зөвхөн нэг нийтлэг үндэсний “Үнэт зүйл”-тэй байх нь зүйтэй бөгөөд дээр нь өв түүх төрт ёсны, өв соёл нийгмийн одоогийн “Үнэт зүйлс” гээд байгаа нэршлийг “Эрхэмлэх зүйл” гэх саналтай байна. Үүнд: Нийтлэг нэг үндэсний үнэт зүйл “МОНГОЛ МОНГОЛООРОО ХӨГЖИХ” гэсэн нийтлэг нэг үнэт зүйлийг (манай төслийнхний тодорхойлолт) та бүгдэд санал болгож байна.

“Монгол монголоороо” гэсэн нь цаанаа монгол хүнийг цөм болгож, түүх, төрт улс, соёл, уламжлалаа хүндэтгэн, дангааршил, ондоошлын харьцааг зөв байлгах санааг, “хөгжих” гэсэн үг нь даяаршилд зохицох, ардчиллыг эрхэмлэх, мэдээллийн шинжлэх ухаанд суурилах гэсэн утга, агуулгатай юм. Ер нь ардчиллыг “Хууль дээдлэх” гэдэгтэй холбож ойлгож байх нь зөв билээ. “Монгол” гэдэг үгийг дэлхийд Чингисийн монгол гэж ойлгодгийг ч тэмдэглэх нь зүйтэй.

Үндэсний ой санамж, үнэт зүйл нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх чухал ойлголт оюун санааны дархлааг бий болгох угтвар нөхцөл тул тэдгээрийг зөв тодорхойлж, олон нийт ялангуяа хүүхэд залуучуудыг нийгмийн хөгжлийн чиг баримжаагаа олоход нь чиглүүлэг болох чухал асуудал юм.

Өнөөдөр хөгжингүй орнуудад бүх түвшиндээ төрийн аливаа шийдвэр нийгэмд авч ирэх үр дагавар ялангуяа нийгэмд бий болгож, төлөвшүүлж байгаа эсвэл төлөвшүүлэхийг зорьж байгаа нийтийн үнэт зүйлд төвлөрөх ёстой гэж үзэж, үнэт зүйлээр удирдах тухай ярьдаг. Улс орны, нийгмийн, хувь хүний түвшинд тогтоодог болжээ. Аливаа улс орон өөрсдийн “Нэн тэргүүний эрх ашгийг хэрхэн авч үзсэнээс ихээхэн хамааралтайгаар үндэсний үнэт зүйл нь тодорхой болж үүнийгээ нийтээр хүлээн зөвшөөрч эрхэмлэснээр үндэстэн, угсаатны хэв шинж, төлөвшлийг буй болгодог байна. Монголчууд “Нууц товчоон”-оо тулгар төрийнхөө эхэнд өөрсдөө бичиж үлдээж чадсанаараа энэ цаг үед үндэстэн улс байх нэг гол тулгуураа олж, үндэсний ой санамжийн гол эх суурь үндсээ бий болгосон юм. Их Монгол Улс: Чингис



хааны үүсгэн байгуулсан Их Монгол Улс “төр”, “улс” гэдэг ухагдахууныг жинхэнэ байх ёстой утгаар нь дэлхийн олон үндэстэнд ойлгуулж өгчээ. Их хуралдай, Сэцдийн зөвлөл, Их засаг хууль зэрэг нүүдэлчдийн ардчиллын өвөрмөц бүрдлүүдийг анх бий болгож өвлүүлсэн нь бидний ой санамжийн эрхэм шүтээн болох учиртай. Чингис хааны аюулгүй байдлаа хангах бодлого нь Монгол төрийн “Хар хайрцагны бодлого” болж, үеэс үед уламжлан хэрэгжиж байжээ. Чингис хаан болон Өгэдэй, Гүюг, Мөнх зэрэг Их хаадын үед цөөхөн хүн амтай үндэстний хувьд оршин байх аюулгүй байдлын үүднээс дайн байлдаан хийгээд зогсохгүй овог, аймаг угсаатнуудыг дахин зохион байгуулж, батлан хамгаалах эрх ашгийн үүднээс тэднийг стратегийн ач холбогдолтой газар нутгууд болон нутгийн төв хэсэг, гол уугуул овог, отгоо хамгаалах томилгоожуулалт хийж байснаараа улс үндэстэн, төр, иргэдийнхээ аюулгүй байдлыг баталгаатай хангасан төдийгүй улс үндэстэн ирээдүйд оршин байх баталгааг ч хийж чадсан юм.

Үндэсний аюулгүй байдал нь улс үндэстнүүдийн түүх, соёл иргэншлийн хувьд түүхийн ямар ч нөхцөл байдалд үндэсний онцлох шинж чанараа хадгалах, хамгаалах, дахин сэргээх чадавх, хүн ам, төрөлх хэл, соёл уламжлал, үр удам, төрөлх газар нутгаа хадгалан хамгаалах чадвар, үндэсний уламжлалаа баяжуулан хөгжүүлэх, оюун санаа, соёл иргэншлийн орон бусдаар хүлээн зөвшөөрүүлэх зэрэг үзүүлэлтүүдээр тодорхойлогдож иржээ.

Үндэстний түүх, соёл, ижилсэлдээ тулгуурлан үндэсний ой санамжаа сэргээж байж, үндэсний үнэт зүйлсээ зөв тодорхойлж чадна. Үүний дараа л үндэсний ухамсар сэргэж, үндэсний оюун санааны дархлаа бэхжин улмаар үндэсний ёс суртахуун, хууль дээдлэх үзэл олон нийтэд дэлгэрэх жамтай юм байна. Улс орон, үндэсний үнэт зүйлээ тодорхойлсноор, түүндээ тулгуурласан нийгмээ нэгдэн нягтруулах аливаа бодлого, шийдвэр гаргаж чадах бөгөөд цаашлаад энэ нь улс орон хөгжлийн бодитой зөв замаа сонгоход баримжаа болдог. Үндэсний үнэт зүйл нь нэг төрлийн "хамгаалах" үүргийг гүйцэтгэж, улс үндэстний оюуны дархлааны суурь үндэс болдог

Өнөөдөр гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн бидний нийгмийн харилцаа, үнэт зүйлс ихээхэн өөрчлөгдөж баян ядуу, хот хөдөө цаашлаад улс төрийн үзэл бодол, нийгмийн гарал байдал, шашин шүтлэг зэргээрээ ялгаа зааг ихээхэн гарах болжээ. Энэ нь яваандаа үнэт зүйлсийг бүдгэрүүлж, нийгмийн оюун санаа, эв нэгдэлд эрсдэл үүсгэж болзошгүй юм.

Аливаа үндэстэн өөрийн болон бусдын түүхийн сургамжаас байнга суралцаж, түүхийн алдаа оноогоо дэнсэлсэн ой санамжтай байж түүндээ түшиглэн үндэсний үнэт зүйлсээ тодорхойлж нэг зорилго алсын хараатай нэг үндэстэн байж, төр засаг нь бодитой мэдлэг, мэдээлэлд тулгуурлаж аюулгүй байдлаа хангах, улс орны хөгжлийн бодлого шийдвэрээ гаргадаг байж хөгждөг жамтай ажээ.

Хэдийгээр Монгол Улс ардчиллын замаар эргэлт буцалтгүй орж, хүн ард нь хүний эрхээ бодитой эдэлж, даяаршлын үр шимийг ахуй амьдралдаа хангалттай хүртэх болсон хэдий ч өнөөгийн Монголын Улс төр, эдийн засаг, нийгмийн байдал иргэдийнхээ сайн сайхан амьдрал, улс орны аюулгүй байдлыг хангах хэмжээнд хангалттай хүрээгүй байгаа нь үндэсний ой санамжаа сэргээж түүнийг үндэсний аюулгүй байдлаа хангах үйл ажиллагаанд илүү үр дүнтэй ашиглах шаардлага байгааг харуулж байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Үндэсний ой санамжийг сэргээх нь үндэсний үнэт зүйл, ухамсар, бахархлаа шинээр тодорхойлж эх оронч хүмүүжлийн асуудлыг шинээр авч үзэх үндэс анхдагч хүчин зүйл нь болох юм.

Төрт ёсны баялаг уламжлалтай, нүүдлийн болон суурин соёл иргэншил хосолсон, геополитикийн өвөрмөц байршил бүхий өргөн уудам нутаг дэвсгэртэй, бүл цөөн монголчууд эх оронч хүмүүжлийн өнө эртний түүхэн уламжлалтай улс билээ.

Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа болсон Монголоо гэсэн зүрх сэтгэлтэй Монгол хүнийг хүмүүжүүлэх их үйлсийг бид цалгардуулах учиргүй” гэсэн Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн үг гүн утга учиртай билээ.

### **А. Хууль, эрх зүйн орчин**

Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны **эх үндэс** болно”<sup>233</sup> гэж тодруулсан байдаг.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын эхний бүлгийн 1.1.6.-д Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын гурав дугаар бүлэг

3.3.3.2. Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна” гэж аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим болгон тодорхойлсон байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.4. Соёл иргэншлийн аюулгүй байдал бүлэг

3.1.4.3. Хүүхэд, залуучуудад түүх, соёл, зан уламжлалаа гүнзгий таниулах, эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх ажлыг нийгэм, гэр бүл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

3.3.3. Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх дэд бүлэг

3.3.3.1. Нийгмийн ёс суртахуун, сэтгэл зүйн төлөвшил, үнэт зүйлсийн нэгдмэл байдлыг хангах нь үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, зөвшилцлийг хангах суурь болно.

### **Б. Хийгдэж байгаа ажлууд:**

Дэлхийн улс орнууд боловсролын бодлогоо шинжлэх ухаан технологийн хөгжил дэвшил, эх оронч үзэл, ирээдүйд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицон амьдрах чадвартай иргэнийг бэлтгэх зорилгоор аюулгүй амьдрах ухаан,

<sup>233</sup>(1.2.1) “Эх оронч үндэсний үзлийг дээдлэх” гэсэн хэсэг

цэрэгжилтийн бэлтгэл сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлж эхлээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2002 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг оюун ухаан, ёс суртахууны хүрээнд төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулж, мөрдөх тухай" 190 дүгээр зарлиг гаргаж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хэсэгчлэн тусгагдсан үндэсний эх оронч үзлийг иргэд, ялангуяа залуу үед төлөвшүүлэх зорилго, зорилтыг цогцолбороор хэрэгжүүлэх талаар "Монгол Улсын иргэдэд эх оронч үзэл төлөвшүүлэх хөтөлбөрийг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, улс төрчдийн төлөөлөл, холбогдох яамдын санал, санаачлагад тулгуурлан боловсруулж, мөрдөж ажиллахыг ..." Засгийн газарт чиглэл болгосон байдаг.

Эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх ажлын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгоход чиглэсэн шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд батлан хамгаалах салбарын эрдэмтэн судлаачид эх оронч үндэсний үзэл, түүнийг төлөвшүүлэх арга замын талаар судалгаа явуулж, үндэсний хэмжээний онол, практикийн бага хурал зохион байгуулж, энэ үндсэн дээр эх оронч хүмүүжлийн асуудлаар БХЯ, БСШУЯ болон бусад яам, ЗХЖШ-т хандаж зөвлөмж гаргасны дотор цэргийн албан хаагчдыг эх оронч, үндэсний үзлээр хүмүүжүүлэх асуудлыг дэвшүүлэн тавьсан.

Эдгээр олон ажлын эцэст олон жил дуншсан "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр" Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 200 дугаар тогтоолоор батлагдсан батлагдсан билээ.

Батлан хамгаалахын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан тушаалаар<sup>234</sup> батлагдсан ажлын хэсэг ажиллаж бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт "Монгол Улсын иргэдэд эх оронч үзэл, хүмүүжил олгох боловсролын стандарт, хөтөлбөрт" заагдсан "Бүрэн дунд боловсрол олгох сургалтын хөтөлбөр"-ийн агуулгыг эх оронч үзэл, аюулгүй амьдрах ухаан, цэрэгжилт гэсэн агуулгаар тодорхойлжээ.

Үүнд: 10, 11 дүгээр ангиудад заавал сонгон судлах хичээлээр "Аюулгүй амьдрах ухааны үндэс" хичээл<sup>235</sup>, 12 дугаар ангид "Цэрэгжилт" хичээлийн<sup>236</sup> хөтөлбөрийн агуулгыг боловсруулсан байна.

Энэхүү хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжиж эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх ажлын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгоход чиглэсэн шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд нэгдсэн түүхтэй болох, **үндэсний ой санамжаа сэргээх, түүндээ түшиглэн үндэсний үнэт зүйлсээ тодорхойлж** нэг зорилго алсын хараатай үндэстэн байх нь даяаршилын үед дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал хөшүүрэг дэмжлэг болох болно.

---

<sup>234</sup>2018 оны 5 дугаар сарын 15

<sup>235</sup>3 кредит цаг, сонгон гүнзгийрүүлж судлах хичээлээр 3 кредит цаг судлах нийт 6 кредит цаг судлах агуулгыг боловсруулан танилцуулж байна.

<sup>236</sup>заавал сонгон судлах хичээлээр 1 кредит цаг, сонгон гүнзгийрүүлж судлах хичээлээр 1 кредит цаг судлах нийт 2 кредит цаг судлах цөм

Эдгээр ажлыг үр дүнд Монголын ард түмний оюуны үнэт зүйлсийн үнэлэмж өсч, нийгмийн оюун санаа, ёс суртахууны нэгдэл бэхжиж эх оронч үзлийн онолын нэг суурь үндэс болно гэж үзэж байна.

Нийгэм, дотоод улс төрийн асуудлуудын гол шалтгаан бол, ер нь Монгол Улс нийгэм-эдийн засгийн хувьд ямар замаар хөгжих талаар үндэсний хэмжээнд нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй (улс төр, эдийн засгийн элитүүд нь ч ийм нэгдсэн ойлголт бий болгох, хэрэгжүүлэхээр оролдоогүй)-тэй холбоотой<sup>237</sup>.

Иймд энэ талаар монголчууд нэг адил, үнэт зүйлтэй хөгжлийн бодлоготой болох талаарх сүүлийн үеийн төр засгийн чармайлтаа нэгтгэн “Алсын хараа 2050” үзэл баримтлалын доор улс төрийн бүх хүчнүүд хамтран ажиллах боломж, зарчмыг бий болгох нь зүйтэй.

Саяхан УИХ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг баталсан. Өөрчлөлт оруулах гэж буй гол чиглэл Засгийн газрын сайд нарыг УИХ-аас томилдог байсан бол энэ удаагийн өөрчлөлтөөр Ерөнхий сайдыг л их хурал томилдог. Шинээр томилогдсон Ерөнхий сайд нь өөрийн танхимаа бүрдүүлдэг боллоо.

МАН-ын УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан нар: Үндсэн хуульд өөрчлөлт оруулах эрх мэдлийн хувиарлалтыг оновчтой болгох, засаглалын тогтолцоог сайжруулах шаардлагатай байгаа юм. УИХ нь төрийн эрх барих дээд байгууллага юм бол хууль тогтоох үүргээ биелүүлдэг байх, **хяналт шалгалтын эрхтэй болох**, гүйцэтгэх засаглалаа хэрхэн эрх мэдэлтэй болгож төрийн бодлогыг хэрэгжүүдэг болгох, шүүх засаглалаа хараат бусаар хэний ч нөлөөнд орохгүйгээр шударга үнэнээр шийдэж чаддаг байлгах гэх мэт асуудлыг шийдвэрлэхийг тулд Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлага бий болсныг тэмдэглээд УИХ-ын гишүүдийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх<sup>238</sup> тухай ч Үндсэн хуульд зааж өгөх ёстойг онцолж байв. УИХ -аар **хяналт шалгалтын тухай хууль хэлцсэн**.

2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Цэргийн нэгдсэн холбоо, ҮБХИС, Шихихутаг их сургуулийн Судалгааны хүрээлэнтэй хамтран “Үндэсний ой санамж” хэлэлцүүлгийг зохион байгуулж явуулжээ.

Хэлэлцүүлэгт төрийн болон эрдэм шинжилгээний олонг байгууллагуудын<sup>239</sup> эрдэмтэн судлаачид оролцож, үндэсний ой санамж, үндэсний үнэт зүйлсийг сэргээн хөгжүүлэх талаар санал бодлоо солилцлоо.

Хэлэлцүүлгийн үр дүнгээр “Үндэсний ой санамж” сэдэвт 91 хуудас бүхий эмхэтгэл хэвлүүлэн, судалгааны эргэлтэд орууллаа.

---

<sup>237</sup> Ерөнхийдөө, англи-америк маягийн “жолоогүй” капитализмын замаар явах уу, эсвэл, Умард Европ, Германы жишгээр нийгэм-улс төрийн асуудлыг шийдвэрлэхдээ нийгмийн бүхий л хэсгийн оролцоог хангаж, ашиг сонирхлыг нь тэнцүүлдэг замыг сонгох уу гэдгийг хариулаагүй.

<sup>238</sup> Ер нь зарим хууль тогтоогчдын хариуцлага, ёс зүй тааруухан хэвээр байгааг чуулган, байнгын хорооны хуралдааны ирц, хуралдаа хэрхэн бэлтгэдэг, зөвлөх туслахуудын боловсрол мэдлэг, ажлын хэсэгт гишүүд яаж оролцдоггоос харж болдог. Мөн УИХ-ын гишүүн Энх-амгалан, Бат зандан зэрэг зөвлөх, туслахуудын багаа сайтар ажиллуудаг ашигладаг гишүүн ховор бөгөөд зарим нь залуухан бүсгүйчүүдээр хязгаарлах нь бий.

<sup>239</sup> УИХ-ын Тамгын газар, ҮАБЗ-ийн Ажлын алба, ЗГХЭГ, Төрийн албаны зөвлөл, БХЯ, БСШУСЯ, Стратегийн судалгааны хүрээлэн, Архивын ерөнхий газар, Удирдлагын академи, ШУА болон түүний харъяа Философийн хүрээлэн, Олон улсын харилцааны хүрээлэн, Түүх, археологийн хүрээлэн, Мэдээлэл, харилцааны холбооны газар, СУИС, МУИС, Монголын оюун ухааны академи, Монголын дипломатын академи, Геополитикийн хүрээлэн

Өнөөдөр эдгээр судалгаа шинжилгээний ажлуудыг нэгтгэн дүгнэх, бодитой үр дүнг төр, засгийн түвшинд хүргэх ажил хүлээгдэж байна.

Ийм учраас 2020-2021 онд “Үндэсний ой санамж, үнэт зүйлсийг сэргээх замаар ҮАБ-ыг бэхжүүлэх нь” төслийг Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн (БХЭШХ), Монгол улсын Шинжлэх ухааны академи, философийн хүрээлэн, Удирдлагийн академи, Шихихутаг Их сургуулийн судалгааны хүрээлэн хамтран хэрэгжүүлж дууслаа.

Мөн Монгол Улсын түүхийг шинэчлэх, түүх бодитой сургамжтай байх талаар ажиллах зорилтын хүрээнд БХЭШХ “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын түүхийн он цагийн товчоон” номыг монголын түүхэн сургамжтай үйл явдлуудыг түүхийн болон аюулгүй байдлын онол арга зүйн түвшинд тодорхойлох зорилт тавьж мэрэгжлийн түүхчдийг, аюулгүй байдлын судлаачидтай хамтран ажилласан.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын иргэд, ялангуяа өсвөр залуу үеийнхний эх оронч үзэл, эх орноороо бахархах бахархал ихээхэн өөрчлөгдсөн нь даяаршил, мэдээлэл, техник, технологийн дэвшлийн хурдац хүн төрөлхтний ахуй амьдрал, нийгмийн харилцаанд эерэг, сөрөг ихээхэн нөлөө үзүүлснээс болжээ. Ийм учраас үндэсний ой санамжаа сэргээх, үндэсний үнэт зүйлсээ тодорхой болгох ҮАБ-ын үзэл баримтлалдаа шинээр оруулах шаардлага тулгамдаж байна<sup>240</sup>.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилгаар зохион байгуулагдаж буй “Бидний бахархал”<sup>241</sup> төслийн талаар БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг хэвлэлд өгсөн ярилцлагадаа: Тус төслийн гол зорилго нь эх орны ирээдүй, хойч үе болсон хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хандлагыг төлөвшүүлэх юм. Төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ гэдгийг тодорхойлсон.

Нэгдүгээрт, хүүхэд, залуучуудад эх орноо хайрлан хамгаалах, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүргийг ухааруулан ойлгуулж, эх орон, тусгаар тогтнол, эх хэл, үндэсний түүх, соёлоороо бахархах, дээдлэн хүндэтгэх, газар нутаг, байгаль орчноо хайрлах итгэл, үнэмшлийг төрүүлэх замаар улс орныхоо тогтвортой хөгжлийг хангаж, тусгаар тогтнолынхоо баталгааг нэмэгдүүлэх үндэс бүрдэх;

Хоёрдугаарт, Монгол Улсын язгуур эрх ашгийг бодлогын бүх түвшинд эн тэргүүнд тавих, монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлага, монгол ахуй, өв соёл, зан заншлыг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа эрчимжих суурь үндэс болох;

Гуравдугаарт, нутаг дэвсгэрийн онцлог, боломж, түүхэн уламжлалд тулгуурласан эх оронч үзлийг хүүхэд, залуучуудад төлөвшүүлж, хөгжүүлэх нэгдмэл тогтолцооны эрх зүйн орчин бүрдэх, “Эх оронч үзэл”-ийг төлөвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох;

Дөрөвдүгээрт, ахмад үеэ хүндэтгэх, үлгэрлэн дуурайх, тэдний улс орныхоо төлөө байгуулсан гавьяа, хөдөлмөр, зүтгэлийг сурталчлан, хувь хүн бүрийн оролцоо

---

<sup>240</sup> Ч.Сосорбарам Үндэсний үнэт зүйл, ой санамжийг сэргээх нь эх оронч үндэсний үзлийг дээдлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үндсэн зарчим “Монгол улсын аюулгүй байдлын гадаад орчин.” Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах асуудалд. Онол практикийн бага хурлын эмхэтгэл. УБ., 2006, 263 х., т. 48

<sup>241</sup> төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын захирамжаар улс орон даяар 2022-2023 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

улс орны хөгжилд ямар чухал болохыг ойлгуулах, төрөлх эх орноороо болон монгол хүн болж төрснөөрөө бахархах сэтгэлгээ, төлөвшлийг олгох;

Тавдугаарт, Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх” үндэсний хөтөлбөрт тусгагдсан зарим зорилт, арга хэмжээнүүд биеллээ олж, энэхүү хөтөлбөр бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэх юм.

#### **Дүгнэлт:**

Аливаа улс орны язгуур ашиг сонирхол нь эн тэргүүнд оршин тогтнохын төлөө тэмцэл байсныг хүн төрөлхтний эрт, эдүгээгийн түүх харуулж байна. Улс орны туурга тусгаар оршин тогтнох, үндэснийхээ аюулгүй байдлыг ханган хөгжихийн үндэс нь иргэн бүр төрж өссөн өлгий нутаг, ард түмнийхээ түүх, соёлын их өвийг хайрлан хамгаалах, арвижуулах, зан заншил, төрт ёс, хууль цаазаа эрхэмлэн дээдлэх, эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө авъяас билэг, хүч чадал, эрдэм боловсролоо харамгүй зориулах хүсэл эрмэлзэл, хичээл зүтгэлтэй байх явдал юм. Үүнийг эх оронч хүмүүжил хэмээн томъёолох бөгөөд энэхүү үзлийг өвөг дээдэс, ахмад үе маань төрийн алсын хараа бүхий цэгцтэй, залгамж шинж чанартай бодлого, үйл ажиллагаагаар үеэс үед уламжлан авч ирсэн ажээ.

Үндэсний ой санамжийг сэргээснээр үндэсний ухамсар, бахархал, үнэт зүйлсээ дахин шинэ цаг үедээ тохируулан тодорхойлж нь эх оронч хүмүүжлийн асуудлыг бодитой авч үзсэн.

Монголчууд түүхэн тодорхой шалтгаанаар өөрийн үндэсний ой санамжаа гээж, аливаа шинэ зүйлсыг шууд дууриадаг, өөрийн ухаанаа уралдуулж нутагшуулдаггүй, бусдын үгээр явж ирсэн нь ямар алдаанд хүргэдэг болохыг бүгд л мэдэрч эхэлж, гадаад дотоодын улс төрчид, судлаачид шүүмлэх болсон байдаг.

Аливаа үндэстэн өөрийн болон бусдын түүхийн сургамжаас байнга суралцаж, төрийн үйл ажиллагааны алдаа оноогоо дэнсэлсэн ой санамжтай байж, түүндээ түшиглэн үндэсний үнэт зүйлсээ тодорхойлж нэг зорилго алсын хараатай нэг үндэстэн байж, төр засаг нь бодитой мэдлэг, мэдээлэлд тулгуурлаж төрийн бодлого шийдвэрээ гаргадаг байж хөгждөг жамтай гэнэ.

Ийм учраас Монгол үндэстний ой санамж хир гүнзгий байна вэ? гэдэг талаар судалгааны баг судлаж хариулах оролдлого хийж байна. Энэ хүрээнд Монгол улсын төрийн үйл ажиллагаанд үндэсний ой санамжийг бүрдүүлэгч хэсэг бүр хэрхэн хэрэгжиж байснаас үндэсний аюулгүй байдал бэхжиж, суларч, сэргэж ирснийг өмнөх түүхийн үе болгоноор товчхон бичих оролдлого хийсэн.

Эцэст нь доктор Н.Жалбажавын санал болгож байгаа зөвлөмжийг Та бүгдэд хүргэж байна.



## **МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖИЙГ ХАДГАЛАН ХАМГААЛАХ, ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙД ТӨР, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭД СУДАЛГААНЫ “ОЙ САНАМЖ” БАГААС ХҮРГҮҮЛЭХ ТОВЧ САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

1. Монгол Улсын иргэн, нийгэм, төрийн хадгалан хамгаалах, арвижуулан хөгжүүлэх нийтлэг үнэт зүйлсийг хамтын оюун ухаанаар, шинжлэх ухаанчаар тунгаан тодруулах, баталгаажуулах хөтөлбөр (төсөл) боловсруулж хэрэгжүүлэх.
2. Байгууллага бүр улс, үндэстнийхээ нийтлэг ашиг сонирхолд суурилсан эрхэмдэх (үнэт) зүйлс, хөгжлийн эрхэм зорилго, зорилтууд, тэдгээрээ хамгаалах, хөгжүүлэх, хэрэгжүүлэх тогтолцоотой болох.
3. Төрийн бүх шатны байгууллагын бодлого, үйл ажиллагаанд улс, үндэстнийхээ нийтлэг эрх ашиг сонирхолд нийцсэн байх, улс төржих, нутгархах, алагчлах, онцгойрох (угсаатан ястны хэт аминч, дэврүү, хөөргөн, онцгойрох, тусгаарлах гэсэн утгаар) санаа санаархал оролдлоготой шийдвэртэй тэмцэх зарчмыг тууштай баримтлах.
4. Монголын түүх судлал, бичиглэлийг улс төрийн болон үндэстэн ястны явцуу ашиг сонирхол, өс хонзон, түүхийн хоосон бардамнал зэрэгт автан гуйвуулахаас тууштай хамгаалах. Түүхийг “Монголын нууц товчоо”, “Эрдэнийн эрх”, “Алтан товч” зэрэг үндэсний болон гадаадын эх сурвалжууд, судлаачдын бүтээл туурвил, сан хөмрөгт түшиглэн бодитой үнэн зөв бичих, баяжуулахад идэвх санаачлага, үр бүтээлтэй хөдөлмөрлөж буй эрдэмтэн судлаачид, ялангуяа Монголын түүхийн судлагдаагүй, “хаягдсан, гээгдсэн” цагаан толбыг арилгахад чиглэсэн бүтээл туурвилыг төрөөс тууштай дэмжих.
5. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт дараах асуудлуудыг тусгаж хэрэгжүүлэх:
  - 5.1. Монголын төр, улс, үндэстний соёл иргэншил, зан заншил, хэл соёл, ухамсар сэтгэлгээний түүх, үнэт зүйлсийг өсвөр үе, сурагчдад зааж сургах, өвлүүлэх бодлогыг сургалт хүмүүжлийн нэг тэргүүлэх зорилт болгон шингээж, тогтолцоо, хэлбэр, арга зүй, чанар, үр өгөөжийг нь тасралтгүй сайжруулах.
  - 5.2. “Их Засаг” хууль болон Монгол төрийн хууль цаазын сэтгэлгээний дээжис бүтээлүүдийг судлах, сурталчлах бодлого, зорилтыг сургалтын болон хүний хөгжлийн хөтөлбөрт, төслүүдэд шингээн (тусгаж) хэрэгжүүлэх.
  - 5.3. Монгол төрийн бодлогын үнэт зүйлс болсон шударга ёс, алсын хараа, эе эвийг хичээх сэтгэлгээний түүхэн уламжлал, ач холбогдлыг судлах, сурталчлах тогтолцоо, арга хэлбэрийг зүгшрүүлэх. Энэ зорилтын хүрээнд жил бүр ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Нууц товчоо”-ны шударга ёсны ёс суртахуун, андын нөхөрлөл, эе эвийн сэтгэлгээ, үндэсний эв нэгдэл, аж төрөхүйн монгол арга ухааны сэдвээр эсээ, илтгэл, зохион бичлэгийн уралдаан, тоглолт, тэмцээнийг үндэсний, орон нутгийн хэмжээнд үе шаттай зохион байгуулдаг болох.
  - 5.4. “Аравтын тогтолцоо”, монгол цэргийн урлаг зэрэг Монголын төр, цэргийн байгуулалтын үнэт зүйлс, түүх, өв уламжлалыг судалж эзэмшүүлэх бодлого, зорилтыг ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын түүх, цэрэг, нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлэх.

- 5.4.1. Мөн зорилтын хүрээнд БНХАУ, ОХУ, Энэтхэг, Дорно дахины улс орнуудад хадгалагдаж буй Монгол Улс, Монголын төр, цэргийн эх сурвалжуудыг судлах, монгол хэлнээ хөрвүүлэх, эх орондоо олж авчрах талаар чиглэсэн зорилготой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.
- 5.4.2. Монголын ард түмэн, төр, монгол цэргийн түүх, уламжлалыг лавшруулан судлах, “түүхийн цагаан толбо”-уудыг илрүүлэж арилгах, түүхэн дурсгалт хөшөө дурсгалын зүйлсийг сэргээх, “Монгол цэргийн түүхэн цогцолбор”-ыг байгуулах, хөгжүүлэх талаар идэвх санаачлагатай ажиллаж буй байгууллага, иргэдэд төрөөс бүх талын (санхүүгийн, бодлогын, зохион байгуулалтын г.м.) дэмжлэг, туслалцаа үзүүлэх.
6. Монголын төр, цэргийн түүх, уламжлал, үндэсний ой санамж, эх оронч хүмүүжилтэй холбоотой мэдээлэл сурталчилгааны нэгдсэн сантай болох.
7. Үндэсний батлан хамгаалахын их сургууль болон Монгол цэргийн нэгдсэн холбоог түшиглэн “Үндэсний ой санамж” судалгаа, сурталчилгааны сэтгүүлтэй болох.
8. Эцэг дээдсээс уламжлагдан ирсэн уул, ус, ургамал, амьтанд халдах (ашиглан үр өгөөжийг нь хүртэх), хорио цээр тогтоож ягштал дагаж мөрддөг байгаль эхтэй харьцах, хамгаалах монгол хосгүй арга ухааныг хойч үедээ өвлүүлэхийг боловсрол, соён гэгээрүүлэхийн эрхэм зорилго болгон хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, үнэлж дүгнэх тогтолцоо механизмыг төлөвшүүлэх.
  - 8.1. Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн цогц байдлыг хангах, хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог чангатгах.
  - 8.2. Сурагчид, оюутан суралцагсад, цэргийн алба хаагчдад Монголын ард түмний уул овоо, ус ургамал, ан амьтныг тахиx, хайрлан хамгаалах арга ухааныг судлуулах, эзэмшүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх.
9. Өрх,эр бүл бүрт “Ургийн бичиг”-ээ хөтөлдөг заншил төлөвшүүлэх, ураг, төрөл саднаараа уулзалт, баяр хийдэг үүсгэл санаачлагыг дэмжин түгээн дэлгэрүүлэх.
10. Монгол гэр бүлийн үнэт зүйл болсон ураг барилдуулах, өтгөсөө үдэх, нялхсаа угтах, сайн үйлсийг эрхэмлэх, саарыг жигших, эрүүл аж төрөх ёс заншил, зан үйлийг хойч үедээ өвлүүлэх.
11. Үндэсний бахархалт үйл явдал, төр, үндэсний ойн баяр цэнгэл, эрийн гурван наадам, цагаалах, гадна дотны зочин гийчнийг угтах, үдэх зэргийн утга учир, ач холбогдол, ёс горим, дэг жаяг, хууль тогтоомжийг судлуулах, сурталчлах, тогтолцоог хадгалах, хөгжүүлэх.
12. Монгол Улсын үндэсний ой санамжийн гол зүйл нь Монгол Улсын иргэн байна. Тиймээс Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, төрийн хууль тогтоомжийн төвд монгол хүний аюулгүй байдал, эрх, эрх чөлөө байна.
13. Монгол Улсын нийгэм төр, иргэний үнэт зүйлсийг хуульчлан баталгаажуулах нь үндэсний ой санамжаа хадгалан хамгаалах, бэхжүүлэх нэг чухал үндэс гэж үзэж байна.

## СУДАЛГААНЫ БАГ

## ЭШЛЭЛ АВСАН ЭХ СУРВАЛЖ, НОМ ЗҮЙ

### I. СУРВАЛЖ БИЧИГ

1. “Арван буянт номын цагаан түүх” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-2”. Монгол бичгээс хөрвүүлж, бусад эхтэй харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа., Р.Төрдалай; оршил бичиж, эхийг хавсаргасан Б. Баярсайхан. УБ., 2006 он
2. Галдан “Эрдэнийн эрих хэмээх түүх болой”. -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал”. Хэвлэлд бэлтгэсэн Ц.Насанбалжир. УБ., 1960 он; Монгол бичгээс хөрвүүлж, эхүүдийг харьцуулан тулгаж, оршил бичиж, тайлбар хийсэн Ж.Гэрэлбадрах., Д.Бүдсүрэн., П.Бямбахорол. УБ., 2006 он
3. Гомбованжил “Алтан эрих” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-17”. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хэлхээс хийсэн Д.Бүрнээ. УБ., 2006 он
4. Гомбожав “Чингис эзний алтан ургийн түүх Гангын урсгал нэрт бичиг оршив”. “Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-10”. Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хавсралт хийсэн Б.Баттуяа., Ц.Батдорж., Б.Пүрэвдэлгэр. УБ., 2006
5. Дарма гүүш “Алтан хүрдэн мянган хигээст” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-15”. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хавсралт хийсэн Т.Жамьянсүрэн., Л.Халиун. УБ., 2006 он
6. Жамба “Асрагч нэртийн түүх” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-9”. Хөрвүүлж, тайлбар, зүүлт, нэрийн хэлхээ хийсэн Д.Заяабаатар УБ., 2006 он
7. Жамбадорж “Болор толь” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-21, 22”. 2 дэвтэр. Монгол бичгээс хөрвүүлж, оршил, тайлбар хийсэн С.Цолмон. УБ., 2006 он
8. Лувсанданзан “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-5”. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2006 он
9. “Монголын нууц товчоо” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-2”. Эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2006 он
10. Мэргэн гэгээн Лувсандамбижалцан “Их Монгол улсын үндсэн Алтан товч оршвой”. -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-12”. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хэлхээс хийсэн Д.Бүрнээ. УБ., 2006 он
11. Рашпунцаг “Болор эрих” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-13, 14” 2 дэвтэр. Харгуулан хөрвүүлсэн М.Баярсайхан., Ч.Нэргүй., Д.Бүдсүрэн. УБ., 2006 он
12. Саган сэцэн “Эрдэнийн товч” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-8”. Сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар зүүлт хийсэн М.Баярсайхан. УБ., 2006 он
- 13 “Хаадын үндсэн хураангуй алтан товч” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-5”. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2006 он
14. “Чакраварди Алтан хааны тууж” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-4”. Хөрвүүлж, тайлбар зүүлт, нэрийн хэлхээ хийсэн Д. Заяабаатар. УБ., 2006 он
15. “Чингис хааны алтан товч нэртийн цэдиг” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-3”. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн С.Дашдэжид. УБ., 2006 он

16. “Эрдэнийн эрх” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал” монгол бичгээс хөрвүүлж, эхүүдийг харьцуулан тулгаж, оршил бичиж, тайлбар хийсэн Ж.Гэрэлбадрах., Д.Бүдсүрэн., П.Бямбахорол” УБ., 2006 он
17. “Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршвой” -“Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал-7”. -“Монгол бичгээс харгуулан хөрвүүлж, тайлбар, хавсралт хийсэн Ц.Шагдарсүрэн., Э.Мөнх-Ундрал. УБ., 2006 он

## II. СУДАЛГААНЫ ЗОХИОЛ

1. Амар А “Монголын товч түүх” УБ., 1936 он
2. Баабар “XX зууны Монгол, Нүүдэл суудал. Гарз олз” УБ., 1996 он
3. Баатар Ч. “Тусгаар тогтнол, ардчилсан төрийн төлөвшлийн асуудал” УБ., 2016 он
4. Баатарбилэг Ё. “Монголын түүхийн 800 оны хураангуй бичиг” УБ., 2006 он
5. Бадамхатан С. “Халхын угсаатны зүй” I боть, УБ., 1987 он
6. Базарсүрэн Ж. “Чингис хааны цэргийн зэр зэвсэг” УБ., 2006 он
7. Балжинням Б. “Монголчуудын бүрэн түүхийн товчоон” УБ., 2005 он, 2-р боть
8. Баяр С. «Жаран хоног, Жаран бутархай» УБ., 2021 он
9. Баярсайхан Д. “Монголын түүх бичлэг” (XVII зуун) УБ., 2011 он
10. Бира Ш., Сонинбаяр Ш., Дашбадрах Д. “Өндөр гэгээний намтрууд оршивой” УБ., 1995 он
11. Бира Ш. “БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд” УБ., 1977 он
12. Болд Р. “Монголын аюулгүй байдлын орчин, батлан хамгаалах бодлогын зарим асуудалд” Стратегийн судалгааны хүрээлэн. УБ., 1996 он
13. Болд Р. “Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс” (1910-1973). УБ., 2008 он
14. Болд Р. “Бүрэн эрхээ хязгаарлуулсан тусгаар тогтнол” (1921-1925). УБ., 2021 он
15. Болдбаатар Ж. Үлэмжийн их Чингис хаан. УБ., 2002 он
16. Болдбаатар Ж., Лүндээжанцан Д. “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал”
17. Болдбаатар Ж. “Чингис хаан” (1162-1227) УБ., 1999 он
18. Болдбаатар Ж. “Монгол түмний сод хүмүүс” цуврал УБ., 2020
19. Болдбаатар Ж. “Монголын улсын түүх бичлэг, шинэчлэл, чиг хандлага” УБ., 1997 он
20. Болдбаатар Ж., Энхцэцэг Д. “Чингис хаан Монголын түүх бичлэгт” УБ., 2022 он
21. Бор Ж., Баатар. Д. “Монголын аюулгүй байдал” УБ., 2017 он
22. Бор Ж. “Билгүүн дипломат Чингис” УБ., 1996 он
23. Бор Ж. “Монголын дипломат товчоон” УБ., 1998 он;
24. Бэхбат Х. “Монголын дипломатын академи Туурайн тамга-Алтан цуглуулбар-999” УБ., 2021 он
25. Вернадский Г.В. “Монголчууд ба Орос орон” УБ., 2008 он.
26. “Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц” Бээжин, 1993.04.10.
27. Гангааням С. “Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан тэмцсэн нь” УБ., 1993 он, 71-р тал
28. Гантулга Ц. “Алтайн Урианхайчууд” УБ., 2000 он
29. Гонгор Д. “Халх товчоон” 2 боть, УБ., 1970 он, 1978 он

30. Гумилев Л.Н. “Хүн гүрэн” УБ., 2000 он
31. Гүн-Үйлс Г. Хаадын сан “Их хаадын зарлигийн дээжис, төрт ёс” УБ., 2019 он
32. Гэрэлбадрах Ж. “Монголын нутаг дэвсгэр хил хязгаарын түүх” УБ., 2002 он
33. Далай Ч. “Хубилай болон түүний залгамжлагчдын үед Их хааны ширээ булаацалдсан тэмцэл”, УБ., 1992, 2006
34. Дамдинжав Д. “Гол тоглогч” I, II. УБ., 2020 он
35. Дашбадрах Д. “Манжийн төрөөс Монголын шашны талаар явуулсан бодлого, үр дагавар” УБ., 2008 он
36. Даш-Ёндон Б. “Цаг үе: Сэтгэл бодрол, философи” УБ., 2012 он, 54 -56-р тал.
37. Даш-Ёндон Б. “Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж” эмхэтгэл. 3 боть УБ., 2011 он, I боть, 274-р тал
38. Дэмчигдорж Д. /Дандаа/ Монголын бие даасан эзэнт улсуудын үе (1271-1368)
39. Дэндэв Ё. “Монголын товч түүх” УБ., 1934 он
40. Плано Карпини “Монголчуудын түүх” УБ., 1988 он, 61-62-р тал
41. Жаргалсайхан Б. “Алаг жарны бодрол” УБ., 2015 он
42. Жү Яотин “Чингис хааны түүх шастир” УБ., 2002 он
43. Жүгдэр Ч. “XV-XVIII зууны Монголын нийгэм, улс төрийн гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм” УБ., 1984 он
44. Жүгдэр Ч “Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг” УБ., 1990 он
45. “Манжийн үнэн магад хууль, /Орчуулсан Ц.Цэрэндорж/ УБ., 2009 он
46. “Монгол улсын түүх” 3 боть УБ., 1966 он
47. “Монгол улсын түүх” 5 боть. УБ., 2003 он
48. “Монгол улсын түүх” (онол арга зүйн асуудалд) УБ., 1999 он
49. “Монгол улсын түүх” (XIV зууны дунд үеэс XVII зууны дунд үе) 5 боть зохиол. УБ., 2004 он, 3-р боть
50. “Монгол цэргийн түүхийн товчоон” 2 дэвтэр, УБ., 1996 он
51. Монгол Улс, Үндэсний төв архив, х-М1-М33, д-1,2, 3
52. Монгол Улс, Үндэсний төв архив, х-М168, д-1, (Зарилигаар тогтоосон Гадаад монгол хотон аймгийн ван гүн нарын илтгэл шаштир)
53. “Монгол Татарууд Ази, Европт”
54. ЗСБНХУ-ын ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэн. УБ., 1984 он
55. “Монголын нууц товчоон” УБ., 2005 он
56. “Монголын Юань улс” УБ., 2006 он
57. Ким Жон Рэгийн “Мянган жилийн түүхэн хүн” УБ., 1999 он
58. Ли Куаэн Ю. “Сингапурын хөгжлийн нууц” УБ., 2015 он
59. Лувсандорж Ш. “Монголын түүх” УБ., 2001 он
60. Майдар Д. “Чингис хаан ба монгол гүрэн” УБ., 1990 он
61. Нацагдорж Ш. “Халхын түүх” УБ., 1963 он
62. Нацагдорж Ш. “Монголын феодализмын үндсэн замнал” УБ., 1978 он
63. Нацагдорж Ш. “Манжийн эрхшээлд байсан үеийн халхын хураангуй түүх”. УБ., 1963 он
64. Нацагдорж Ш. “Чингис хааны цадиг” УБ., 1990 он
65. “Төв азийн нүүдэлчдийн угсаатны түүхийн асуудал” Нүүдлийн соёл иргэншил судлах олон улсын хүрээлэн. УБ., 2002 он
66. Нямаа А., Батцэцэг Ч. “Орос дахь монгол угсаатны улсууд” УБ., 1992 он, 12-р

тал

67. Очирбат П. “Монголын төр, тусгаар тогтнолын түүхэн замнал” УБ., 1996 он
68. Пунсаг А. “Тэнгэрийн Их Юань улсын түүхэн тэмдэглэл” УБ., 2010 он
69. Пүрэвжав.Э. “МНТ судлалын чуулган” Боть 2, УБ., 2020 он
70. Пэрлээ Х. “Тооно уулын хятад бичээс” - “Студиа Археологика”, 1960 он, Т. I. №9
71. Пэрлээ Х. “Хэсэг байшингийн монгол бичээс” - “Студиа Монголика”, Т. III. №VI-X
72. Сайшаал “Чингис хааны товчоон” УБ., 2004 он
73. Санждорж М. “Монголын төрийн түүхээс” 3 боть, УБ., 2006 он, 2007 он
74. Сосорбарам Ч. “Монголын түүх ба хар хайрцагны бодлогын...” УБ., 2005 он
75. Сосорбарам Ч. “Чингис хааны геополитик” УБ., 2012 он
76. Сосорбарам Ч. нарын “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын түүхийн он цагийн товчоон” УБ., 2022 он
77. Сүхбаатар Д., Хасбаатар Т. “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хуваарилалтын түүхэн уламжлал” УБ., 2011 он
78. “Төв Азийн нүүдэлчдийн угсаатны түүхийн асуудал” УБ., 2002 он
79. Тагнуулын Ерөнхий газар (1922-2012) Тэргүүн дэвтэр, УБ., 2012 он, 16-р тал
80. Төрмөнх Д. “Миний мэдэх Женко Х. Баттулга” УБ., 2020
81. Тэрбишдагва Д. “Зааг” УБ., 2016 он
82. Урангуа Ж., Хэрээд Ж. “Алтан хан” УБ., 2007 он
83. Урангуа Ж., Энхцэцэг Д. “Монгол хатад” УБ., 2000 он
84. Уолкер С.С. “Чингис хаан” УБ., 2001, Канад, 1933
85. Үржинлхүндэв Г. “Алтан аргамж” сэтгүүл, УБ., 2022 он
86. Хайссиг В. “Шар гүрэнтэй хаяа залгасан нутаг” УБ., 2014 он
87. Хара Дава “Ил товчоо” сонин, УБ., 1992 он, №36-69, 35 нүүр
88. Хишигт Н. “Түмэн засагт хаан” 30-р боть, УБ., 2002 он
89. Хишигт Н. “Ардын хувьсгал-1921” УБ., 2022 он
90. Храпачевский Р.П. “Чингис хааны цэрэг дайны гүрэн” УБ., 2008 он
91. Цогтнаран Х., Гүн-үйлс Д. “Монголын нууц товчоон: Барламал болон хуулмал дэвтрүүд. Оршил, Гаргалгаа” УБ., 2017 он
92. Цэвээн Ж. “Монгол Улсын түүх, түүвэр зохиолууд” Хэвлэлд бэлдсэн С.Идшинноров. УБ., 1987 он
93. Цэдэндамба С. “Монгол улс дахь шашны нөхцөл байдал ХХ-ХХI зууны зааг үе” УБ., 2008 он
94. Цэен-Ойдов Ш. “Чингис богдоос Лигдэн хутагт хүртэл /хаад/” УБ., 2002 он
95. Цэргийн түүх судлалын төв: Бүтээлийн товчоон” БХИС, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн. УБ., 2009 он
96. Чулуунбаатар Ч., Даш-Ёндон Б. “Монголын нийгмийн өөрчлөлт” ШУА-ийн ФСЭХ. УБ., 2013 он
97. Шагдар Х. “Чингисийн цэрэг үүсэл, бүтэц, зохион байгуулалт, байлдах арга ухаан” (1178-1206). УБ., 1996 он
98. Энхцэцэг Д. “Монголын Хутагт хааны учира” УБ., 2007 он
99. Энхбайгаль Б. “Даяаршил ба Монгол Улсад төрийн бодлого боловсруулах явц” - “Бодлогын судалгааны институцийн хөгжил” ССХ. УБ., 2015 он.

### III. ӨРНӨ, ДОРНОД ХЭВЛЭГДСЭН СУДАЛГААНЫ БҮТЭЭЛҮҮД



1. Алтаншаа “Монголчуудын өчигдрийн мөр” ӨМСХХ., 1997 он
2. Аристотель “Политика” (пер С.А.Жебелов) “Сочинения в четырех томах” Т.4, М., 1983, с.481.
3. Балман Гончиг-Жалцан. Краткая история Индий, Китая, Тибета и Монголия РО ИОН, ксилограф
4. Васильев В.П. Полное описание Монголо-Татар “Мэн-дй-вей-лу” -“Труды
5. Владимирцов Б.Я. “Общественный строй Монголов” Л., 1934
7. Владимирцов Б.И. “Чингис хаан” Ленинград, 1934 он /орос хэлээр/
8. Восточного отделения русского археологического общества (ТВОРАО.ч. ЮСПб)”
9. Гарольд Лэмб, Чингисхан Властелан мира, М., Центрполиграф; 2003
10. Гегель Г.В.Ф. “Философия истории” М., 2000, с.447
11. Грумм-Грижмайло Г.Е. Западная Монголия и Урянхайская край. Т.И. Ленинград, 1926
12. Дамба “Умард өний мандал буурал” ӨМАХХ., 1998 он
13. “Дэвтэр-Чжамцо” источник по истории Монголов. Р.Н.Дугаров, Новосибирск
14. Жамцарано Ц. Монгольские летописи XVII века. М-Л., 1936
15. Жорж Лейний “Чингис хаан ба Монголын жолоо” /Genghis khan and Mongol Rule/ 2004 он, 8
16. Козин С.А. “К вопросу о дешифровании дипломатических документов монгольских Ильханов” М., 1935
17. Майский И. “Современная Монголия” Иркутск, 1921 он
18. “Монгол үндэсний нэвтэрхий түүх” Дээд, дунд, доод боть, Бээжин, 1995 он, Хөх хот, 1991 он
19. Мункуев Н.Ц. “Краткие сведения о черных татарах. -“Проблемы востоковедения” 1960, №5.
20. Мэн-гу-ю-му-цзи. Записки о Монгольских кочевьях. Перевод с кит, П.С.Попова, СПб., 1895
21. Намсрай. “Дайчин улсын үеийн Монголын түүх” Хөх хот, 1993
22. Одон “Цагаан гэрийн эмхтгэл” Хайлаар, 1998 он
23. Өмнөд Сүн улсын элч Пэн да., Сюй тин нар
24. Рашид-ад-Дин “Сборник летописей” Т.1, кн.И. М-Л., 1952, /орос хэлээр/.
25. Спиноза. Избр. “Произв. В двух томах” Т.1. М., 1957, с.290
26. Трубецкой Н.С. “Наследие Чингисхана” М., 1999, 42-р тал
27. Урадийн Е. Булаг. “Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзүүд” Кларендон хэвлэл. Охфорд, 1998 он
28. Франсуа Пети де ла Круа (1660-) “Могол тартаруудын анхны эзэн хаан аугаа их Чингис хааны түүх” Парис, 1710
29. Цю Цю сы. “Дунд гурван хилийн монгол ван тайж нарын намтар” /орчуулсан Жамсран/
30. Эрэнжин хар Даваан “Чингис хаан” Белград, 1929 он
31. Alan Жек Ведерфордын “Чингис хаан” /Genghis khan and the making of the Modern World/ 1993,
32. Atwood С.Р 2004. Encyclopedia of Mongolia and the Mongol empire. Facts on Brend, Peter. “The Mongol Empire”. “London” Weidenfeld and Nicolson, 1976
33. Chambers, James. “The Devil’s Horsemen”, “The Mongol Invasion of Europe”. New



- York: Atheneum, 1979
34. Comroff. "Manuel, ed. Marco Polo's Modern People", New York: Livewith. 1928
  35. Curtin, Jeremiah. "The Mongols". Boston: Little, Brown and Company, 1908 Сын "Исторические записки"
  36. Dupuy, Trevor Nevitt. "The Military Life of Genghis Khans". New York: Franklin Watts, Inc., 1969
  37. File library of fold history. New York, NY: Facts On fire.
  38. Jack Weatherford "Genghis Khan and making of the Modern world", Three rivers Press New York., 2004
  39. James V. Wertsch National Memory and Where to Find It DOI:10.1093 /oso/ 9780190230814.003.0012
  40. Johan Elverskog. United States of America., 2008
  41. Hart, B.N. Liddell. "Great Captains Unveiled". New York: da Capo Press., 1996, History, 1994
  42. Lamb, Harold "Genghis Khan", "The Emperor of All Men". New York: Garden City Publishing. Inc., 1927
  43. Mackinder H.J. "The Geographical Pivot of History", The Geographical Journal No.4. April, 1904. Vol. XXIII, p.434
  44. "Mongolian Chronicle of 1662". Australian national University 1990. p.128/
  45. "Mongols and Mamluks" David Morgan. Hebrew University of Jerusalem, 1995
  46. Munkh-Erdene. Lhamsuren (Institute of Social Anthropology, Austrian Academy of Sciences, Vienna, Austria) The 1640 Great Code: an Inner Asian parallel to the Treaty of Westphalia. Central Asian Survey. Vol. 29, No. 3, September 2010, 269-288
  47. Morris Rossabi. "Khubilai Khan His life and times". University of California press. Berkeley, Los Angeles. London
  48. Nehru, Jawaharlal. "Memories of world history", New York: John Day., 1942 зэрэг ном зохиолууд хэвлэгдэж байв.
  49. Nicolle David, The Mongol War Lords. New York, Sterling Publishing Co., 1990
  50. Osprey Military Men at arms series 105 "The Mongols S.R Turnbull", Angus McBride Prawdun, Michael. "The Mongol Empire", Its Rise and Legacy. London: George Allen and
  51. Sanders J.K. "Historical Dictionary of Mongolia" /Scarecrow Pr/, 1996
  52. Sanders J.K. 1996 "Historical Dictionary of Mongolia,
  53. Scarecrow Pr Our Great Qing". "The Mongols, Buddhism and the State in Late Imperial China".
  54. Spuler Bertold, "The History of the Mongols". Los Angeles: University of California Press, 1972
  55. Saunders J.J "The History of the Mongol Conquests", London: Routledge & Kegan Paul, 1971.
  56. Svat Soucek "History of Inner Asia" Cambridge university press, 2000
  57. R. Ernest Dupuy and Trevor N. Dupuy. "The encyclopedia of military history from 3500 B.C to the present". New-York, Cambridge: Harper Collins Publishers, 1993
  58. Rachewiltz M. Go. L de & Krueger J.R. Ulaan B. Erdeni-yin tobci. Sagang Secen. Mongolian Chronicle of 1662". Australian national University 1990. p.128

59. "The age of Gun power". David Christian. Macquarie University.
60. "The history and life of Chinggis Khan". Urgunge Onon. New-York., 1990
61. "The Mongols a history". Jeremiah Curtin. Boston, USA., 1908.
62. "The Mongols" David Morgan. Cambridge MA and Oxford UK., 1992
63. "The outline of history". H.G. Wells. New-York, 1926
64. "World History" Carlton J. H. Hayes, Parker Thomas Moon, John W Wayland. New-York., 1955
65. Цэцэнбилэг Ц. "Проблемы модернизации монгольского общества" УБ.2002 он

#### IV. СУДАЛГААНД ХОЛБОГДОХ ЗЭРЭГ ГОРИЛСОН ГАНЦ СЭДЭВТ БҮТЭЭЛ

1. Гонгор Д. "Халхын үүсэл ба халхын хаант улс" Түүхийн ухаанаар докторын зэрэг горилсон ганц сэдэвт зохиол. УБ., 1967 он
2. Дашбадрах Д. "Монгол Төвөдийн улс төр, шашны харилцаа: (XVI-XVIII зууны эхэн)". Түүхийн ухаанаар доктор (Ph.D)-биН зэрэг горилсон ганц сэдэвт зохиол. УБ., 1997 он
3. Сосорбарам Ч. "Монгол Улсын халхлалт хамгаалалтын тогтолцоо" Түүхийн ухаанаар доктор (Ph.D)-биН зэрэг горилсон ганц сэдэвт зохиол. УБ., 2011 он
4. Чинбат И. "Улс төрийн бутралын үеийн монгол цэрэг: Цэрэг түүхийн шинжилгээ" Түүхийн ухаанаар доктор (Ph.D)-биН зэрэг горилсон ганц сэдэвт зохиол. УБ., 2014 он
5. Чулуун С. "Хар Адуутан". "XVII зууны монголын гадаад ертөнц: Орос, Манж чин улсын харилцааны түүх". *Түүхийн шинжлэх ухааны доктор ^Л)-ын зэрэг горилсон ганц сэдэвт бүтээл. §9. Галдан бошгот ба Оросын элч нарын уулзалт, хууралт. УБ., 2017 он*
6. Энхцэцэг Д. "Монгол дахь улс төрийн бутралын түүхийг нэхэн эргэцүүлэхүй" (XIV зууны II хагасаас XVII зуун). Түүхийн ухаанаар доктор (Ph^УН зэрэг горилсон ганц сэдэвт зохиол. УБ.2009 он

#### Үнэт зүйл ном, нийтлэлүүд

1. "Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал" УБ., 2019 он
2. Баатартогтох Ц. "Үнэлэмжийн философи, Философи эхлэн суралцах" УБ., 2000 он
3. Байгалмаа Г., Жалбажав Н. "Үндэсний аюулгүй байдалд үнэт зүйлсийн үзүүлэх нөлөөлөл" ҮБХИС"ийн эрдэм шинжилгээний хурлын илтгэл. УБ., 2022 он
4. Балжинням Б. "Харгана монголчуудын эрхэмлэж явах сургаалын жагсаалт" - "Зууны мэдээ" сонин, 2019.04.07
5. Батжаргал З. "Национально культурное идентичность как современная проблема (на примере Монголии), 2013.
6. Болдбаатар Ж., Батсайхан Д. "Монгол түмний сод хүмүүс" цуврал №7, УБ., 2017 он
7. Галиндэв Б., *Мөнхзориг Л.*, "Монголчуудыг гедонист үзэл баримтлалтай гэж дүгнэжээ" -"Соёмбо" сонин, 2022.03.18
8. Ганхуяг Д "Систем хийгээд антисистемийн тухай" Sonin.mn. 2018.09.01
9. Голенкова Т. "Даяаршлын нөхцөл дэх шилжилтийн нийгмийн гажиг,

- шилжилтийн нийгэм, шинэтгэл, соёл иргэншлийн асуудлууд” УБ., 2012 он
10. Гомбосүрэн Ц. “Нобелийн шагналтнуудын айлдвар” УБ., 2010 он, 346х.
  11. Гүндсамбуу Х. “Монголчуудын үнэт зүйлсийн тогтолцооны өөрчлөлтийн хандлага” “Ардын эрх” сонин, УБ., 1992 он, №100
  12. Гүндсамбуу Х. “Монголчуудын үнэт зүйлсийн тогтолцооны өөрчлөлтийн хандлага” - “Ардын эрх” сонин, 1992.10.25, №100
  13. Гүндсамбуу Х. “Монголын нийгмийн давхраажилт, хөгжил, хандлага. (XX зуун) - “Менежер” сэтгүүл. 2015 он
  14. Даваадаш Ч. “Монголын нийгмийн шилжилтийн зарим онцлог” УБ., 2017 он
  15. Дагвасүрэн Г “Монголын капитализмыг яаж хүмүүнлэг болгох вэ?” УБ., 2016 он
  16. Данзанхорлоо Д. “Орчин үеийн Монголын нийгмийн шинэчлэлийн үе шат” 1995 он, диссертаци
  18. Даш-Ёндон Д. “Монголын нийгмийн өөрчлөлт” ШУА-ийн ФСЭХ., УБ., 2013 он.
  19. Дэлгэржаргал П. “Тусгаар тогтнолоос илүү сэтгэлгээний нэгдмэл байдал хамгийн үнэтэй нь” УБ., 2012.06.07.
  20. Жалбажав Н. “Үндэсний эв нэгдлийг хангах, эе эвээ хичээх сэтгэлгээг төлөвшүүлэх арга зүйн үндэс” “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, Хүн амын оюуны дархлааны асуудал”-эрдэм шинжилгээний хурал. УБ., 2019 он
  21. Жалбажав Н. “Нийгмийн шинэтгэлийн зарим гажиг” УБ., 2021 он
  22. Жаргалсайхан О. “Хятадын соёлын стратеги ба Монгол Улс” УБ., 2016 он
  23. Зүмбэрэлхам: Сонгуулийн дараа албан хаагч солигддог нь төрийн албыг шилэн байлгахад саад болдог. 2021.03.11 07:05 ярилцсан *Должинжав*
  24. “Монголчуудын сэтгэлгээний өөрчлөлт асуудал, хандлага” ШУА-ийн ФХ., УБ., 2016 он
  25. “Монголчуудын үндэсний үнэт зүйл” МУИС, СУСХ-ийн судалгааны тайлан. УБ., 2015 н
  26. «Монголчуудын үндэсний үнэт зүйл»-ийн СЭЗДС-ийн судалгааны тайлан. УБ., 2015 он
  27. «Монголчуудын үнэт зүйл» СУИС-ийн судалгааны тайлан. УБ., 2019 он
  28. Мөнхзориг М., Галиндэв Б. “Монголчуудыг гедонист үзэл баримтлалтай гэж дүгнэжээ.” - “Соёмбо” сонин. 2022.03.18
  29. “Нийгмийн шинэчлэл: Амьдралын хэв маягийн өөрчлөлт” ШУА-ийн ФСЭХ., УБ., 2001 он
  30. Сосорбарам Ч. “Либерализм ба монголчууд өнөөдөр” УБ., 2002.04.19 №94, 95
  31. Сосорбарам Ч. “Ардчиллын арван жил дэх давхраажилтын өөрчлөлт” - “Өнөөдөр сонин” 1999.12.13-14; - “Өдрийн сонин” 1999.11.20, №218
  32. Сосорбарам Ч “Монголын үндэсний ой санамжийн дээд шүтээн” - “Чингис хааны ертөнц ба Монгол судлал” олон улсын эрдэм шинжилгээний хурал (2022.08.10)-ын илтгэл
  33. Сүрэнчимэг Д. “Байгууллагын соёл ба үнэт зүйл” - “Монголчуудын үнэт зүйл” цуврал лекц. СУИС. УБ., 2018.05.18.
  34. “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”. <https://legalinfo.mn/mn/de->

tail/6163

35. “Үндэсний ой санамж ба үнэт зүйлсийн төлөв байдлын шинжилгээний тайлан” УБ., 2022
36. Хэрлэн Б. “Монголчуудын үнэт зүйлсийг Шварцын аргачлалаар тодорхойлсон нь». Удирдлагын академи. УБ., 2017 он
37. Хэрлэн Б. Монголын нийгэмд үнэт зүйлийн төөрөгдөл бий болоод байна. ярилцсан Н.Дуламсүрэн 2017 оны 10 сарын 18. [sonin.mn](http://sonin.mn)
38. Хэрлэн Б. “Монгол хүний үнэт зүйлс гэх мэт” Эрдэм шинжилгээний хурлын илтгэл. БХИС УБ., 2022 он
39. Цэдэндамба С. Улс төрийн албан тушаалтан хууль бусаар томилгоонд нөлөөлбөл өөрөө огцорно
40. Цэцэнбилэг М. /Соёлын өвийн үндэсний төвийн/ Соёлын өвийн бүртгэл судалгааны төвийн дарга/ “Яаралтай хамгаалах шаардлагатай 16 өв бий” - “Зууны мэдээ” сонин, 2018.05.13.
41. Чоймаа Ш. “Даяаршиж буй дэлхийгээс монголоо авч үлдэх нь чухал” [Eaglenews](http://Eaglenews) УБ. 2017.03.31
42. Чулуунбаатар Г “Өнөөгийн монголын сэтгэлгээ: Философи, улс төр, ёс суртахуун, бодлогын судалгаа. “Монголчуудын сэтгэлгээний өөрчлөлт, асуудал, хандлага”. ШУА, Философиийн хүрээлэн. УБ., 2016 он
43. Ширнэн Б /доктор (Ph.D)/ “Үндэсний ардчилал” монголчуудын хөгжлийн түлхүүр”. “Стратегийн судалгаа” сэтгүүл №82 2022 он,
44. Энхжин С. Монгол төрийн эрдэмт сайд. УБ., 2007 он